



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТҮҮНД
ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ**

АГУУЛГА

1.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	2
2.ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА.....	49
2.1.ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ	49
2.2.ГУРАВДУГААР БҮЛЭГ: АНХДУГААР ЧУУЛГАН.....	65
2.3.ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХУУЛИЙН ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ.....	68
2.4.ТАВДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ: ТОГТООЛЫН ЭЦСИЙН НАЙРУУЛГА ХИЙХ, ЁСЧЛОХ.....	87
2.5.ДОЛООДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ.....	88
2.6.НАЙМДУГААР БҮЛЭГ: ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, МӨНГӨНИЙ БОДЛОГО, ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТӨСӨВ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ.....	92
2.7.ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: УЛСЫН ТӨСӨВ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ	96
2.8.АРАВДУГААР БҮЛЭГ: ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ САНАЛ, ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ, ГАДААД ХАРИЛЦААТАЙ ХОЛБОГДОХ АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ	114
2.9.АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ	123
2.10.АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ: АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ОГЦРУУЛАХ, ЭГҮҮЛЭН ТАТАХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ	127
2.11.АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ, УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГА, ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТЫН ХАРИУ СОНСОХ	134
2.12.АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ИЛТГЭЛ СОНСОХ, ХЭЛЭЛЦЭХ	136
2.13.АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ: БУСАД АСУУДАЛ.....	151
2.14.АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	156

**1.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**
/Шигтгэсэн хувилбар/

2026.05.13
Bold-шинээр нэмсэн
Bold underline-өөрчлөлт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ**
/Шинэчилсэн найруулга/

**6 дугаар зүйл.Хуралдааны тов, дараалал тогтооход
баримтлах журам**

6.12.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлснээс хойш ээлжит чуулганы хугацаанд нэг сарын дотор энэ хуулийн 6.6-д заасан тов, дараалалд тусгана.

7 дугаар зүйл.Хуралдааны ирц

7.1.Хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. **Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд бүрдсэн ирц санал хураалт явуулахаас бусад тохиолдолд хүчинтэй хэвээр тооцогдоно.**

7.2.Улсын Их Хурлын гишүүн хуралдаан эхлэх цагаас өмнө суудлаа эзэлсэн байна.

7.3.Гишүүн ~~өвчтэй буюу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоод томилолтоор явсан, түүнчлэн хурал, зөвлөгөөнд зайлшгүй оролцох шаардлагатай байсан~~ **өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаадад томилолтоор ажилласан** бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй бол хуралдаан тасалсанд тооцно.

7.4.Гишүүн ~~хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид энэ хуулийн 7.3-т заасан шалтгаан, үндэслэлээ бичгээр урьдчилан мэдэгдэнэ.~~

7.4.Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид энэ хуулийн 7.3-т заасан шалтгаан, үндэслэлээ хуралдааны өмнөх ажлын өдөрт багтаан бичгээр урьдчилан мэдэгдэнэ. Урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас чөлөө авах бол шалтгаан, үндэслэлээ хуралдааны өмнө хуралдаан даргалагчид мэдэгдэнэ.

7.7.Гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэхдээ биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/ өөр **өгөгдлөөр** идэвхжих цахим систем ашиглана.

7.10.Ёс зүйн дэд хороо гишүүний нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны ирц, санал хураалтад биечлэн оролцсон байдлын талаар тухайн ээлжит чуулган хаасны дараах долоо хоногт олон нийтэд танилцуулна.

9 дүгээр зүйл.Хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журам

9.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.22, 21.23-т зааснаар хууль, тогтоолын төслийн төрөл, онцлогийг харгалзан тухайн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр Зөвлөл тогтоох ба нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт

хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна **болон асуулт асуух хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр Зөвлөл тогтооно.**

9.2.Тухайн нам, эвслийн бүлэг хуваарилагдсан хугацаанд багтаан асуулт асуух гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн байна.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан хугацаанд багтаан гишүүд ирцэд бүртгэгдсэн дарааллын дагуу асуулт асууна.

~~9.3.Аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүн энэ хуулийн 9.2-т заасан журмын дагуу хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух эсэхээ урьдчилан мэдэгдэнэ.~~

9.4.Энэ хуулийн 9.1, 9.2, ~~9.3~~-т заасан журам нь энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан хууль, тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хамаарна.

9.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гишүүн **нэгдсэн хуралдаан болон** Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуухдаа дараах журмыг баримтална:

9.5.1.гишүүний асуулт асуух хугацаа ~~3 минутаас~~ **4 минутаас** илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах;

9.5.2.хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад асуулт асуухгүй байх.

9.6.Гишүүний асуултад хариулах хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 1 минутаас илүүгүй байна. **Шаардлагатай бол хуралдаан даргалагч гишүүний асуултад бүрэн хариулт өгөх, бусад албан тушаалтнаас хариулт авах зорилгоор нэмэлт тайлбар өгөх хугацааг нэмж өгч болно.**

9.7.Нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд гишүүн хүсэлт гаргасан бол энэ хуулийн 9.5.1, 9.6-д заасан үндсэн хугацааны нийлбэр 8 минутад багтаан харилцан ярилцлагын хэлбэрээр хэдэн ч удаа асуулт асууж, хариулт авч болох бөгөөд нэмэлт асуулт асууж, хариулт авахгүй. Гишүүний нэг удаагийн асуулт, эсхүл хариултын үргэлжлэх хугацаа 4 минутаас ихгүй байна.

9.7.~~9.8~~.Гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх /цаашид “үг хэлэх” гэх/ хугацаа 4 минутаас илүүгүй байна.

9.8.~~9.9~~.Тодорхой асуудлыг хэлэлцэхэд энэ хуулийн 9.5.1, 9.6, 9.7-д ~~9.8-д~~ зааснаас өөр хугацаа заасан бол тусгайлан заасан хугацааг баримтална.

9.9.~~9.10~~.Хуралдаан даргалагч ~~урьдчилан мэдэгдэж~~, дараалалд орсон гишүүдийн нэрсийн дагуу асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх ба асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрс ирцэд бүртгэгдсэн дарааллаар эрэмбэлэгдэнэ. Хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөхийн өмнө энэ зүйлд заасан журмыг баримтлахыг сануулна.

9.10.~~9.11~~.Гишүүн зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд **асуулт асууж**, өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

9.11.Гишүүн асуулт асуух, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэхийг хориглоно.

9.12.Гишүүн асуулт асуух, үг хэлэхдээ бусдын нэр төрийг гутаах, гүтгэх, бусад гишүүн үг хэлж байхад зэрэгцэн үг хэлэх, саад учруулахыг хориглоно.

9.12.**9.13.**Гишүүн үнэн, бодитой, судалгаанд суурилсан мэдээлэлд тулгуурлаж үг хэлнэ.

9.13.**9.14.**Гишүүн асуулт асуух, үг хэлэх эрхээ бусад гишүүнд шилжүүлэхгүй.

9.14.**9.15.**Хууль, тогтоолын төсөл хэлэлцэхэд гишүүний асуултад хууль санаачлагч хариулж тайлбар хийнэ.

9.15.**9.16.**Хууль, тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон, түүнчлэн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон уригдаж ирсэн хүн хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр тайлбар хийж, асуултад хариулна.

9.16.**9.17.**Тайлбар хийж, асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, асуултад товч, тодорхой хариулах үүрэгтэй бөгөөд гишүүн хариултыг хангалтгүй, эргэлзээтэй гэж үзвэл тухайн асуултын хариуг 2 хоногийн дотор бичгээр өгөхийг шаардах эрхтэй.

9.17.**9.18.**Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэдээлэл, санал, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт, гүйцэтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд болон энэ хуульд хэлэлцэх дэгийг тусгайлан зохицуулсан бусад асуудлыг хэлэлцэх үед гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй.

10 дугаар зүйл. Санал хураалт явуулах ерөнхий журам

10.1.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар санал хураалтыг нууцаар явуулна.

10.2.Ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж, нууц санал хураалтыг цахимаар, эсхүл санал хураах хуудсаар явуулна.

10.3.Санал хураалтыг цахимаар явуулахад биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/ өөр идэвхжих цахим систем ашиглана.

10.4.Ил санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна.

10.5.Гар өргөж явуулсан ил санал хураалтын дүнг хуралдаан даргалагч нэгтгэн зарлана.

10.6.Нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг тооллогын комисс боловсруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.

10.7.Нууц санал хураалтыг цахимаар явуулахад санал өгсөн гишүүдийн нэрс хуралдааны цахим системд хадгалагдахгүй.

10.8.Гишүүн санал хураалтад оролцохдоо “зөвшөөрсөн”, эсхүл “гатгалзсан” саналын аль нэгийг өгнө.

10.9.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусад гишүүнд шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.

~~10.10.Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.~~

~~10.11.Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан /картаа сугалсан/ бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно.~~

~~10.12.Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.~~

~~10.13.Нууц санал хураалт явуулахад энэ хуулийн 10.11 дэх хэсэг хамаарахгүй.~~

10 дугаар зүйл.Санал хураалт явуулах

10.1.Хуралдаанд гишүүдийн олонх биечлэн оролцсон тохиолдолд санал хураалт явуулах бөгөөд санал хураалт явуулахын өмнө танхимд байхгүй гишүүнийг санал хураалтын бүртгэлээс хасна.

10.2.Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

10.3.Санал хураалт явуулахын өмнө хуралдааны танхимд биечлэн ирсэн гишүүдийн тоог бүртгэх бөгөөд тухайн бүртгэлээс санал хураалтын дүнг гаргана.

10.4.Хуралдааны танхимд гишүүдийн олонх биечлэн ирээгүй тохиолдолд санал хураалтыг хойшлуулна.

10.5.Санал хураалт эхэлснээс хойш хуралдааны танхимыг орхин гарахыг хориглоно.

10.6.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусад гишүүнд шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.

10.7.Гишүүн санал хураалтад оролцохдоо “зөвшөөрсөн”, эсхүл “татгалзсан” саналын аль нэгийг өгнө.

10.8.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд заасан бол, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар санал хураалтыг нууцаар явуулна.

10.9.Ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж, нууц санал хураалтыг цахимаар, эсхүл санал хураах хуудсаар явуулна.

10.10.Санал хураалтыг цахимаар явуулахад биеийн давхцахгүй өгөгдлөөр идэвхжих цахим систем ашиглана.

10.11.Ил санал хураалтыг цахимаар явуулахад санал хураалтын систем ажиллахгүй тохиолдолд гар өргөж санал хураалтыг явуулна. Энэ тохиолдолд дэмжсэн, дэмжээгүй гишүүн бүрийн нэрээр дуудаж хуралдааны тэмдэглэлд тусгуулж, нэгтгэсэн дүнг зарлана.

10.12.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.3-д заасан ашиг сонирхлын зөрчил үүсэх бол гишүүн хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.

10.13.Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд урьдчилан зарлаж болно.

10.14.Нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулахаас 10 минутын өмнө 1 минутын турш санал хураалтын хонх дуугаргана.

10.15.Энэ хуулийн 10.14-т заасан санал хураалтын хонх дуугарсан бол гишүүд нэгдсэн хуралдааны танхимд хүрэлцэн ирж санал хураалтад оролцох үүрэг хүлээнэ.

10.16.Нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд санал өгсөн гишүүдийн нэрс хуралдааны цахим системд хадгалагдахгүй.

10.17.Нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг тооллогын комисс боловсруулж, комиссын гишүүдийн олонхын саналаар батална.

11 дүгээр зүйл.Мэтгэлцээн явуулах ерөнхий журам

11.1.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.20, 21.21-д заасны дагуу хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн үе шатанд мэтгэлцээн явуулах тохиолдолд энэ зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.

11.2.Мэтгэлцээн явуулах талаар нам, эвслийн бүлгээс ирүүлсэн санал, дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Байнгын хороо хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн дараах үе шатанд мэтгэлцээн явуулна:

11.2.1.хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх үе шатанд төслийн үзэл баримтлалын хүрээнд;

11.2.2.хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийн үе шатанд төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар энэ хуулийн 39.14-т заасны дагуу ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хүрээнд.

11.3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.20-д заасны дагуу нам, эвслийн бүлгээс нэгдсэн хуралдаанаар төслийн талаар мэтгэлцээн явуулах шаардлагатай гэсэн санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх үе шатанд төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулж болно.

11.4.Энэ хуулийн 11.2, 11.3-т заасан тохиолдолд тухайн нам, эвслийн бүлгийг төлөөлж мэтгэлцээнд илтгэх гишүүнийг тухайн нам, эвслийн бүлэг томилж, нэрийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө хуралдаан даргалагчид ирүүлсэн байна.

11.5.Илтгэгч гишүүн мэтгэлцэх шаардлага, үндэслэлээ 10 минутад багтаан танилцуулж, нам, эвслийн бүлгийн байр суурийг илтгэнэ.

11.6.Мэтгэлцээнд гишүүд, хууль санаачлагчаас гадна тухайн салбарын эрдэмтэн, судлаачдыг байлцуулж болох ба гишүүд, хууль санаачлагч, бусад оролцогч баримт, нотолгоонд суурилсан, үнэн, бодитой мэдээлэлд тулгуурлаж асуулт асууж, хариулт өгч оролцоно.

11.7.Хуралдаан даргалагч мэтгэлцээний үргэлжлэх хугацааг тухайн хэлэлцэж байгаа хууль, тогтоолын төслийн цар хүрээнээс хамаарч 2 цагаас илүүгүй байхаар тогтоох бөгөөд гишүүдэд саналаа чөлөөтэй илэрхийлэх, хууль санаачлагч болон илтгэгч гишүүнээс асуулт асуух боломж олгоно. Шаардлагатай тохиолдолд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар мэтгэлцээнийг 1 хүртэлх цагаар сунгаж болно. Мэтгэлцээн дуусмагц хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.

11.8.Байнгын хороо хууль, тогтоолын төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг явуулах хуралдааны явцад гишүүн горимын санал гаргаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуралдаан даргалагч төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хүрээнд энэ хуулийн 11.4, 11.5-д заасан журмыг баримтлахгүйгээр чөлөөт мэтгэлцээн зохион байгуулна.

11.9.Хуралдаан даргалагч энэ хуулийн 11.8-д заасны дагуу зохион байгуулах мэтгэлцээний хугацааг 60 минутаас илүүгүй байхаар тогтоох бөгөөд гишүүд зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан санал гаргасан гишүүн, ажлын хэсэг, хууль санаачлагчаас асуулт асуух, тайлбар авах, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж олгоно. Мэтгэлцээн дуусмагц хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.

13 дугаар зүйл.Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг

13.1.Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

13.1.5.энэ хуулийн 9.15-д **9.16-д** заасан этгээдэд гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх зөвшөөрөл өгөх;

14 дүгээр зүйл.Хуралдааны дэг сахиулах

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан шаардлагыг гишүүн биелүүлээгүй бол хуралдаан даргалагч, **эсхүл Ёс зүйн дэд хороо** түүнд энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

15 дугаар зүйл.Хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлага

15.1.Гишүүн хуралдааны дэг зөрчсөн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:

15.1.1.сануулах;

15.1.2.хуралдаанд үг хэлэх эрхийг хасах;

15.1.3.хуралдааныг орхин гарахыг үүрэг болгох;

15.1.4.хуралдаанд оролцох эрхийг хасах.

15.1.Гишүүн хуралдааны дэг зөрчсөн бол хуралдаан даргалагч, эсхүл Ёс зүйн дэд хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

15.2.Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуулт асуух, үг хэлэх, зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүний үгийг тасалж, **эхний удаа сануулж, дараагийн авах арга хэмжээний талаар анхааруулна сануулах арга хэмжээ авч хуралдааны тэмдэглэлд тусгана.**

15.3.Гишүүн эхний удаа өгсөн энэ хуулийн 15.2-т заасан сануулгыг биелүүлээгүй бол хуралдаан даргалагч гишүүний үг хэлэх эрхийг хасаж, тухайн асуудлын хэлэлцүүлгийн явцад дахин үг хэлэх эрх олгохгүй.

15.4.Гишүүн бусдад саад учруулсан, асуулт асуух, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэж, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэсэн шинжтэй үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүнд урьдчилан сануулахгүйгээр тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасна.

15.4.Хуралдаан даргалагч дараах тохиолдолд гишүүний тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасна:

15.4.1.гишүүн бусдад саад учруулсан, асуулт асуух, үг хэлэхдээ бусдын нэр төрийг гутаах, гүтгэсэн шинжтэй үг хэлсэн;

15.4.2.гишүүн хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахихыг сануулсан шаардлагыг үл биелүүлж, бусад гишүүний асуулт асуух, үг хэлэх, саналаа өгөх эрхэд саад учруулах зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн.

~~15.5.Гишүүн хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахихыг сануулсан шаардлагыг үл биелүүлж, бусад гишүүний асуулт асуух, үг хэлэх, саналаа өгөх эрхэд саад учруулах зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн бол түүнийг тухайн асуудлыг хэлэлцэж дуустал хуралдаанаас гаргана.~~

~~15.6.Энэ хуулийн 15.5-д заасан хариуцлага хүлээсэн гишүүн хуралдааныг нэн даруй орхин гарах үүрэгтэй бөгөөд гишүүн хуралдааны танхимыг ийнхүү орхин гараагүй нь тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасаж хариуцлага өногдуулах үндэслэл болно.~~

15.7.Энэ хуулийн 15.6-д заасны дагуу тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүн Улсын Их Хурлын болон гишүүний нэр хүндийг гутаан доромжилсон, эмх замбараагүй байдал үүсгэсэн болон бусад хэлбэрээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хуралдаан даргалагч тухайн зөрчилтэй нь холбогдуулан уг гишүүний хуралдаанд оролцох эрхийг 3 хүртэл удаа хасаж болно.

15.7.Энэ хуулийн 15.3, 15.4-т заасны дагуу үг хэлэх эрхээ хасуулсан гишүүн Улсын Их Хурлын болон гишүүний нэр хүндийг гутаасан, эмх замбараагүй байдал үүсгэсэн болон бусад хэлбэрээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол Ёс зүйн дэд хороо тухайн зөрчилтэй нь холбогдуулан гишүүний асуулт асуух, үг хэлэх эрхийг 30 хүртэл хоногоор хасна.

15.8.Зөрчил Энэ хуулийн 15.2, 15.3, 15.4, 15.7-д заасан зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэсэн хариуцлага нь нэгдсэн болон тухайн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хамаарна.

~~15.9.Гишүүн энэ хуулийн 15.1.4-т заасны дагуу хуралдаанд оролцох эрхээ хасуулсан тохиолдолд ирцийн бүртгэлээ хасна.~~

15.10.Гишүүн энэ хуулийн 15.1-д заасан зөрчлийг удаа дараа давтан гаргасан бол тухайн асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хөрөө авч хэлэлцэн санал, дүгнэлт гаргана.

15.10.Гишүүн энэ хуулийн 15.2, 15.3, 15.4, 15.7-д заасан зөрчлийг тухайн жилд гурав ба түүнээс дээш удаа гаргасан бол тухайн асуудлыг Ёс зүйн дэд хороо хянан шийдвэрлэх бөгөөд гишүүний албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах хариуцлага хүлээлгэнэ.

15.11.Ёс зүйн дэд хороо гишүүнд дараах тохиолдолд гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн зардлаас бусад гишүүний төсвийн нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлага хүлээлгэнэ:

15.11.1.гишүүн энэ хуулийн 7.3, 7.5, 10.12-т зааснаас бусад тохиолдолд нэг сарын хугацааны нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд оролцоогүй;

15.11.2.гишүүн ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн, эсхүл харьяалагдах Байнгын хорооны, эсхүл дэд хорооны хуралдаанд 5 ба түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй.

15.12.Энэ хуулийн 15.19-д заасан мэдээлэлд үндэслэн Ёс зүйн дэд хороо энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-т заасан асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, гишүүнд хариуцлага хүлээлгэнэ.

15.13.Энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-д заасан хариуцлага хүлээлгэсэн тухай Ёс зүйн дэд хороо тухайн гишүүнд, гишүүний харьяалагдах нам, эвслийн бүлэгт болон Улсын Их Хурлын даргад даруй мэдэгдэнэ.

15.14.Энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-д заасан хариуцлага хүлээлгэсэн Ёс зүйн дэд хорооны шийдвэрийг гишүүн эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш холбогдох баримт, нотолгооны хамт ажлын 3 өдрийн дотор Ёс зүйн дэд хороонд уг шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргаж болно. Ёс зүйн дэд хороо дахин нэг удаа хянан хэлэлцэж, өмнөх шийдвэрийг өөрчлөх, хэвээр үлдээх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана.

15.15.Ёс зүйн дэд хороо гишүүнд энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-д заасан хариуцлага хүлээлгэсэн талаар нэгдсэн хуралдаанд тухай бүрд мэдээлнэ.

15.16.Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоёр ба түүнээс дээш удаа хуралдаанд биечлэн оролцоогүй бол ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс хасах тухай ажлын хэсгийн ахлагчийн ирүүлсэн саналыг ажлын хэсгийг Байнгын хорооноос байгуулсан бол тухайн хорооны хуралдаанд, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан бол нэгдсэн хуралдаанд танилцуулснаар хасагдсанд тооцно.

15.17.Гишүүн хянан шалгах түр хорооны хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гурав ба түүнээс дээш удаа оролцоогүй бол түүнийг түр хорооны бүрэлдэхүүнээс хасах тухай түр хорооны даргын саналыг хуралдаан даргалагч нэгдсэн хуралдаанд танилцуулснаар тухайн түр хорооны бүрэлдэхүүнээс хасагдсанд тооцно.

15.18.Энэ хуулийн 15.16, 15.17-д заасан үндэслэлээр гишүүнийг ажлын хэсгийн болон хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс хассан бол шийдвэр гаргахгүй.

15.19.Тамгын газар гишүүний тухайн долоо хоногийн нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдал болон хуралдааны явцад гишүүнд энэ зүйлд заасан хариуцлага хүлээлгэсэн тухай мэдээллийг Ёс зүйн дэд хороонд дараа долоо хоногийн ажлын эхний өдөрт багтаан тус тус хүргүүлнэ.

17 дугаар зүйл.Цахим хуралдааны дэг

17.11.Цахим хуралдааны дэгээр хуралдаж байгаа үед асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүний саналаар нэг удаа 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах бөгөөд **асуултад хариулах хугацаа 2**

минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байхаар, үг хэлэх хугацаа 3 минутаас илүүгүй байхаар тогтооно. Нам, эвслийн бүлэг, гишүүд шаардлагатай гэж үзвэл саналаа нэгтгэн асуулт асууж, саналаа илэрхийлж болно.

17.4.Гишүүн товлосон цагт цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлэн хуралдаанд оролцох үүрэгтэй. ~~Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр товлосон цагт ирцэд бүртгүүлээгүй бол энэ хуулийн 15.1-д заасан хариуцлага хүлээлгөнө.~~

19 дүгээр зүйл.Улсын Их Хурлын даргыг сонгох

19.3.Улсын Их Хурлын даргыг ~~сонгоход хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд~~ **сонгох нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт гишүүд нэр дэвшигч болон нэр дэвшүүлсэн нам, эвсийн бүлгээс асуулт асууж, хариулт авч, үг хэлсний дараа** ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

20 дугаар зүйл.Улсын Их Хуралд нам, эвслийн бүлэг байгуулагдсан тухай мэдээлэх

20.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.1-д заасан суудал авсан нам, эвслийн гишүүд бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг ~~бүлгийн дарга~~ **жагсаалт, бүлгийн даргыг сонгосон тухай бүлгийн шийдвэрийг** Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлэг байгуулсанд тооцно.

20.2.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрсийг **нэрсийн жагсаалт, бүлгийн даргыг сонгосон тухай бүлгийн шийдвэрийг** нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулна.

21 дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэд даргыг сонгох

21.1.Улсын Их Хурлын дэд даргыг тухайн Улсын Их Хурлын сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, **ийнхүү дэвшүүлснээс хойш 5 хоногийн дотор** ил санал хураалтаар сонгоно.

23 дугаар зүйл.Байнгын болон дэд хорооны даргыг сонгох журам

23.5.Дэд хорооны даргыг Дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, Байнгын хорооны ~~гишүүдийн олонхын саналаар сонгоно~~ **хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоол баталсанд тооцно.**

33 дугаар зүйл.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх

33.1.Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, ~~хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар~~ шийдвэрлүүлнэ.

33.2.Нэгдсэн хуралдаан хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Улсын Их Хурлын дарга тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын нийт гишүүнд яаралтай хүргүүлж, энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцүүлнэ.

33.2.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх үндэслэлийн талаарх Ерөнхий сайдын, эсхүл холбогдох Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонссоны дараа хэлэлцүүлэг явуулахгүйгээр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжсэн тохиолдолд энэ хуулийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй.

34¹ дүгээр зүйл.Хууль зүйн дүгнэлт гаргах болон зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх

34¹.1.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл болон төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар хэлэлцүүлгийн явцад Тамгын газраар хууль зүйн дүгнэлт гаргуулна.

34¹.2.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналд Тамгын газраар зардлын тооцоо болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар дүн шинжилгээ /цаашид “төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ” гэх/ хийлгэнэ.

34¹.3.Хууль зүйн дүгнэлтийг дараах асуудлын хүрээнд гаргаж, Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлнэ:

34¹.3.1.тухайн төсөл, эсхүл төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй санал нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцсэн эсэх, хэрэв тухайн төсөл, эсхүл зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцээгүй бол нийцүүлэх хууль, түүний заалтыг тодорхойлж, үндэслэлийг тайлбарлах;

34¹.3.2.тухайн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт нь хоорондоо, эсхүл зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь төслийн зүйл, хэсэг, заалттай зөрчилдсөн эсэх, хэрэв зөрчилтэй бол түүнийг тодорхойлж, залруулах аргыг санал болгох;

34¹.3.3.тухайн төсөлтэй холбогдуулан хууль хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хууль, зүйл, хэсэг, заалтыг бүрэн хамруулсан эсэх;

34¹.3.4.хамт өргөн мэдүүлсэн төсөл нь тухайн өргөн мэдүүлсэн хуулийн төслийн зохицуулалттай уялдсан эсэх.

34¹.4.Хууль зүйн дүгнэлт гаргахад мэргэжлийн, хараат бус шинжээчийг татан оролцуулж болно.

34¹.5.Хууль зүйн дүгнэлт, төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг Байнгын хорооны хуралдаанд Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан тэргүүн дэд, дэд дарга танилцуулна.

34¹.6.Тамгын газар хууль зүйн дүгнэлт, төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг ажлын 10-15 өдрийн дотор гаргана.

34¹.7.Хууль, тогтоолын төслийн зохицуулах харилцааны цар хүрээг харгалзан Ерөнхий нарийн бичгийн дарга энэ хуулийн 34¹.6-д заасан хугацааг өөрөөр тогтоож болно.

34¹.8.Хууль зүйн дүгнэлт гаргах болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

35 дугаар зүйл. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах

35.1. Хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын дарга холбогдох Байнгын хороонд хуваарилах бөгөөд уг Байнгын хороо төслийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хариуцна.

35.2. Энэ хуулийн 35.1-д заасны дагуу хуулийн төсөл, түүнд хавсаргасан баримт бичгийг холбогдох Байнгын хороонд хуваарилснаас хойш ~~3-хөногийн~~ **ажлын 3 өдрийн** дотор Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлэх ба эдгээр нь олон нийтэд нээлттэй байна.

35.3. ~~Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг~~ **Энэ хуулийн 33.1-д заасан яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэснээс бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хорооны хуралдаанаар** хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө тухайн хуулийн төсөлтэй 7-оос доошгүй хоногийн хугацаанд танилцах боломжийг гишүүдэд олгоно.

35.4. ~~Байнгын хороо хүсэлт гаргасан бол Тамгын газар хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах бөгөөд хууль зүйн зөвлөмжийг дүгнэлтийг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлсэн байна.~~

35.4. Байнгын хороо хүсэлт гаргасан бол Тамгын газар хуулийн төсөлд хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтийг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлнэ. Байнгын хороо хэлэлцүүлгийн явцад хууль зүйн дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бол хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг түр хугацаагаар хойшлуулна.

35.8. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахдаа дараах журмыг баримтална:

35.8.1. хууль санаачлагч илтгэлээ 10 минутад багтаан танилцуулах;

35.8.2. энэ хуулийн 35.5-д заасны дагуу нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол уг санал, дүгнэлтийг 5 минутад багтаан танилцуулах;

35.8.3. энэ хуулийн 35.6-д заасны дагуу санал гаргасан бол уг саналыг 5 минутад багтаан танилцуулах;

35.8.4. Тамгын газраас тухайн төсөлд хууль зүйн зөвлөмж гаргасан бол түүнийг **дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийсэн бол тэдгээрийг Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан тэргүүн дэд, дэд дарга тус бүр** 10 минутад багтаан танилцуулах;

35.8.5. шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч Тамгын газраас хуулийн төсөлд хийсэн зөвлөмжтэй холбогдуулан **хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээтэй холбогдуулан тус бүр** 5 минутад багтаан тайлбар хийх;

35.8.6. гишүүд хууль санаачлагчаас асуулт асуух **ба хуулийн төслийг хамтран санаачилсан гишүүн асуулт асуухгүй;**

35.8.7. шаардлагатай бол тухайн салбарын эрдэмтэн, судлаачийн саналыг сонсох;

35.8.8. гишүүд хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх.

35.8.9. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө хууль санаачлагч хүсэлт гаргасан бол үг хэлэх.

35.9. Хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаггүй гишүүн оролцож, асуулт асууж, үг хэлж болно.

35.10. Гишүүн хуралдаанд асуулт асууж, үг хэлэхдээ баримт, нотолгоонд суурилсан, үнэн, бодит мэдээлэлд тулгуурлах ба энэ журмыг зөрчсөн тохиолдолд хуралдаан даргалагч асуулт, үгийг тасалж болно.

35.11. Энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна. Хэрэв энэ хуулийн 35.7-д заасны дагуу мэтгэлцээн явуулсан тохиолдолд энэ хуулийн 35.8.1, 35.8.2, 35.8.3, 35.8.4, 35.8.5-д заасны дагуу хэлэлцүүлгийг явуулсны дараа ил санал хураалтыг шууд явуулж болно.

35.12. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэхэд гишүүн горимын санал гаргасан тохиолдолд хууль зүйн нэр томъёог жигдлэх зорилгоор хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар багцлан нэг санал хураалт явуулж болно.

~~35.12.~~ **35.13.** Санал хураалтын дүнгээр цөөнх болсон гишүүд үндэслэлээ тайлбарлаж дахин нэг удаа санал хураалгаж болох бөгөөд Байнгын жөрөөны хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар санал, дүгнэлт гаргаж, түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

~~35.13.~~ **35.14.** Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.

35.14. **35.15.** Хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих эсэх асуудлаар цөөнх болсон гишүүн нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

35.15. **35.16.** Байнгын хороо хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:

35.15.1. **35.16.1.** хуулийн төслийн зардлын тооцоо;

35.15.2. **35.16.2.** хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага;

35.15.3. **35.16.3.** хууль зүйн зөвлөмжийн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээний талаарх мэдээлэл;

35.15.4. **35.16.4.** санал хураалтын дүн.

36 дугаар зүйл. Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах

36.1. Хууль санаачлагч хуулийн төслийн үзэл баримтлалын талаар нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулга хийнэ.

36.2.Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна. Хэрэв энэ хуулийн 11.3-т заасны дагуу нам, эвслийн бүлгээс хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд нэгдсэн хуралдаанд мэтгэлцээн явуулах санал, дүгнэлт гаргасан тохиолдолд энэ зүйлийн 36.3, 36.4-т заасан дүгнэлт, саналыг сонссоны дараа мэтгэлцээн явуулна. Мэтгэлцээний дараа нэгдсэн хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.

36.3.Засгийн газар Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 21.13-т заасны дагуу тухайн хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцээгүй, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна. Засгийн газрын дүгнэлттэй холбогдуулан гишүүн асуулт асууж, үг хэлэхгүй.

36.4.Хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 34.2-т **35.6-д** заасан Засгийн газрын гишүүн танилцуулна.

36.5.Хуралдаан даргалагч энэ хуулийн 9.2, 9.3-т заасны дагуу нам, эвслийн бүлгээс болон аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүнээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу **9.2-т заасны дагуу** асуулт, хариултыг зохион байгуулна.

36.6.Энэ хуулийн 36.5-д заасан дараалалд орсон гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж болно. **Хуулийн төслийг хамтран санаачилсан гишүүн асуулт асуухгүй.**

36.7.Нэгдсэн хуралдаанд асуулт асуух, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд багтаан зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч 1 хүртэл цагаар сунгаж болно.

~~36.8.Гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.~~

~~36.9.Гишүүний асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байна.~~

36.10.Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаагаар **тус бүр 4 хүртэл гишүүн** үг хэлнэ. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэхдээ индрээс үг хэлнэ.

36.11.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө хууль санаачлагч хүсэлт гаргасан бол үг хэлж болно.

36.11.**36.12.**Гишүүн хуулийн төслийн үзэл баримтлалтай шууд холбогдолгүй асуудлаар үг хэлбэл хуралдаан даргалагч зөгөөж **гишүүний үгийг таслах** эрхтэй.

¹ Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

36.12.Үг хэлж дууссаны дараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

36.12-36.13.Үг хэлж дууссаны дараа хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл түс бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Энэ хуулийн 35.12-т заасны дагуу Байнгын хорооноос багцлан хураах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар багцлан санал хураалт явуулж болно.

36.14.Энэ хуулийн 36.13-т заасан санал хураалт явуулахад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээгүйд тооцно.

36.13-36.15.Санал хураалтад Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол тухайн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.

36.14-36.16.Санал хураалтад Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

36.15-36.17.Энэ хуулийн 36.14-т 36.16-д заасны дагуу үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг нэг жилийн дотор дахин өргөн мэдүүлэхгүй.

37 дугаар зүйл.Төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах

37.1.Холбогдох Байнгын хороо шаардлагатай бол анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, ~~Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх~~ үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзан 10 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.

37.2.Шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж болно.

37.2.Улсын Их Хурлын дарга шаардлагатай гэж үзвэл хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзан 15 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.

37.3.Тухайн хууль, тогтоолын төслийг хэд хэдэн Байнгын хороонд хуваарилсан бол Байнгын хороод хамтран ажлын хэсэг байгуулж болно.

37.4.Ажлын хэсгийн ахлагчид холбогдох Байнгын хорооноос нэг гишүүн нэр дэвшвэл шууд, нэгээс илүү гишүүн нэр дэвшвэл илээр санал хураалт явуулж, олонхын санал авсан гишүүнийг ахлагчаар томилно.

37.5.Энэ хуулийн 37.1, 37.2, 37.3-т заасан ажлын хэсэгт хууль санаачлагч **болон тухайн төслийг хамтран санаачилсны дараа нэрээ татаж авсан гишүүн** орохгүй.

37.6.Ажлын хэсгийн хуралдааныг ажлын хэсгийн ахлагч товлон зарлаж хуралдуулах ба гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. Хуралдаанаар олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

37.7.Нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар ажлын хэсгийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг хэлэлцэхэд ажлын хэсгийн ахлагч, гишүүн оролцож гишүүдийн асуултад хариулна.

~~37.7.~~**37.8.**Ажлын хэсгийн хуралдаанд холбогдох салбарын мэргэжилтэн, шинжээчдийг татан оролцуулж болох ба Тамгын газрын ажилтнуудыг чиг үүргийнх нь дагуу байлцуулна.

~~37.8.~~**37.10.**Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг энэ хуулийн 135 дугаар зүйлд заасны дагуу хөтөлж, хадгална.

~~37.9.Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхтэй холбоотойгоор энэ зүйлд зааснаас өөр ажлын хэсэг, ажлын хэсгийн доор ажлын дэд хэсэг байгуулажгүй.~~

38 дугаар зүйл.Төслийн талаар олон нийтээс санал авч, хэлэлцэх журам

38.1.Нэгдсэн хуралдаан хуулийн төслийн талаар олон нийтээс санал авахаар шийдвэрлэсэн бол холбогдох Байнгын хороо уг ажлыг анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө дараах журмаар зохион байгуулна:

~~38.1.1.тухайн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэх, сонирхлын бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг аль нэг хэлбэрийг сонгох;~~

38.1.1.тухайн төслийн талаар Улсын Их Хурлын цахим хуудас, төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон харилцаа холбооны хэрэгслээр санал авах, сонирхлын бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах хэлбэрийн аль нэгийг сонгох;

39 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах

39.1.Холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлт гаргана. Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо нам, эвслийн бүлгээс гаргасан саналын дагуу төслийн төдөрхөй зүйл, хэсэг, заалтын талаар энэ хуулийн 11.2.2-т заасны дагуу урьдчилан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хүрээнд **энэ хуулийн 11.2.2-т зааснаар, эсхүл хэлэлцүүлгийн явцад гишүүний гаргасан саналын дагуу энэ хуулийн 11.8-д зааснаар** мэтгэлцээн явуулна.

39.2.Хуулийн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед тухайн Байнгын хороонд харьяалагдсан гишүүн таслах эрхтэй оролцоно.

39.3.Нэг хуулийн төслийг хэд хэдэн Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргахаар хууль тогтоомжид заасан бол тэдгээр нь хуралдаанаа тус тусдаа зохион байгуулж, санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

39.4.Нэг хуулийн төслийг хэд хэдэн Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр хуваарилсан бол Байнгын хороод тухайн хуулийн төслийг хамтарсан хуралдаанаараа хэлэлцэж болно.

39.5.Тухайн асуудал хуваарилагдаагүй Байнгын хороо /цаашид “бусад Байнгын хороо” гэх/, нам, эвслийн бүлэг хуулийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

39.6.Энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу санал, дүгнэлт гаргасан Байнгын хороо, нам, эвслийн бүлэг тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд тэдгээрийг төлөөлөх гишүүнийг томилж, энэ тухай санал, дүгнэлтдээ тусгана.

39.7.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч, энэ хуулийн 39.6-д заасан Байнгын хороо, нам, эвслийн бүлгийг төлөөлөх гишүүн, ажлын хэсгийн гишүүн, холбогдох бусад албан тушаалтан оролцоно.

~~39.8.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч хуулийн төслийн талаар тодруулга, тайлбар хийж болно.~~

39.9.Хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг хуулийн төслийн талаарх тусгайлсан саналаа танилцуулна **төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар танилцуулж, саналын томъёоллыг хэлэлцүүлнэ.**

39.10.Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл бүрээр хэлэлцэнэ.

39.11.Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

~~39.12.Гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.~~

~~39.13.Гишүүний асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 2 минутаас илүүгүй байна.~~

39.14.Гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 39.17-д заасан зарчмын зөрүүтэй саналаа хууль, тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байна.

39.15.Гишүүн, **энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу** бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан бол түүнийхээ үндэслэлийг 5 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлаж болно. **Хууль санаачлагч зарчмын зөрүүтэй саналын талаар 5 минутад багтаан тодруулга, тайлбар хийж болно.**

39.16.Гишүүн холбогдох Байнгын хороонд харьяалагддаг эсэхээс үл хамааран тухайн хэлэлцэж байгаа хуулийн төсөлд энэ хуулийн 4.1.4-т заасан шаардлагыг хангасан зарчмын зөрүүтэй санал ирүүлж болох бөгөөд санал гаргасан гишүүн хуралдаанд оролцсон эсэхээс үл хамааран гаргасан саналыг нь хэлэлцэж санал хураалт явуулна.

39.17.Байнгын хороо гишүүн, нам, эвслийн бүлгээс урьдчилсан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулах бөгөөд энэ тохиолдолд хуулийн төслийн томъёолол хажуугийн саналд тооцогдоно.

39.18.Гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 4.1.4-т заасны дагуу санал хураалгах болсон үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүй.

39.19.Энэ хуулийн 39.16-д заасан зарчмын зөрүүтэй саналын нэг томъёоллоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа олонхын дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны саналд тооцон нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд цөөнх болсон ~~нам, эвслийн бүлгийг төлөөлөх~~ гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд тэмдэглүүлж нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

39.20.Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад ~~санал дэмжигдээгүйд тооцож тэдгээр~~ саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна.

39.21.Байнгын хорооны санал хураалтаар санал нь дэмжигдээгүй цөөнх болсон ~~нам, эвслийн бүлгийг төлөөлөх~~ гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд тэмдэглүүлж, нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

39.22.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн, тухайн Байнгын хорооны гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж олонхын санал авсан, аваагүйгээр нь ~~бүлэглэн~~ нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.

39.23.Хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан төслийн бусад зүйл, хэсэг, заалтад нэг ижил нэр томъёоны, эсхүл найруулгыг жигдлэх өөрчлөлт орохоор бол багцлан нэг санал хураалт явуулж болно.

39.24.Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно.

39.25.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл хууль санаачлагчид буцаах тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулна.

39.26.Нэг асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатанд нэгтгэн 1 төсөл болгож Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар, хэрэв ийнхүү нэгтгэхийг зөвшөөрөөгүй бол тус тусад нь санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

39.27.Холбогдох Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан санал нь улсын болон орон нутгийн төсөв, түүнчлэн санхүү, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд шууд ба шууд бус байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл ~~өлөн нийтийн хэлэлцүүлэг~~, олон нийтээс санал авах ажиллагаа, эсхүл нийтийн сонсгол зохион байгуулж болно.

39.28.Тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан иргэн, байгууллагаас бичгээр болон цахим хэлбэрээр санал ирүүлсэн, Байнгын хорооноос ~~өлөн нийтийн хэлэлцүүлэг~~ олон нийтээс санал авсан, нийтийн сонсгол зохион байгуулсан бол энэ тухай мэдээллийг сонсоно.

39.29.Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан саналтай холбогдуулан тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэсэн, хууль зүйн ~~зөвлөмж гаргуулсан бол~~ дүгнэлт гаргуулсан бол Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан тэргүүн дэд, дэд дарга тэдгээрийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

39.30.Тамгын газар энэ хуулийн 39.28, 39.29-т заасан санал, судалгаа, хууль зүйн зөвлөмжийг Байнгын хорооны хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн үр нөлөөний үнэлгээ, хууль зүйн дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаан болохоос ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд тараасан байна.

39.31.Энэ хуулийн 39.28, 39.29-д заасны дагуу тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэх, хууль зүйн зөвлөмж гаргуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, дүгнэлт гаргуулах, олон нийтээс санал авах, эсхүл нийтийн сонгол зохион байгуулах бол анхны хэлэлцүүлгийг түр хугацаагаар хойшлуулж болно.

39.33.Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:

39.33.1.зарчмын зөрүүтэй саналын үндэслэл, шаардлага;

39.33.2.хууль зүйн зөвлөмж дүгнэлт гаргуулсан бол түүний талаарх мэдээлэл.

39.34.Энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан бол Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, түүний эзгүйд ажлын хэсгийн гишүүн танилцуулна.

41 дүгээр зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах

41.1.Нэгдсэн хуралдаанаар зөвхөн холбогдох Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан хуулийн төслийг хэлэлцэнэ.

41.2.Байнгын хороо, нам, эвслийн бүлэг санал, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байна.

41.3.Нэгдсэн хуралдаанд **Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан** асуулт, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч нэг хүртэл цагаар сунгаж болно. **Асуултад холбогдох Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч, түүний эзгүйд санал, дүгнэлт танилцуулсан гишүүн хариулна.**

41.4.Хуралдаан даргалагч энэ хуулийн 9.2, 9.3-т заасны дагуу нам, эвслийн бүлгээс болон аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүнээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу 9.2-т заасны дагуу асуулт, хариултыг зохион байгуулна.

41.5.Асуулт, хариулт дууссаны дараа Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёол тус бүрээр томъёоллоор дараах журмаар санал хураалт явуулна:

41.5.1.хуулийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд тус бүр 3 хүртэл гишүүн үг хэлсний дараа санал хураалт явуулах;

41.5.2.хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй санал тус бүрээр Байнгын хорооны саналаар саналын томъёолол бүрээр Байнгын хороо дэмжсэн, дэмжээгүйг танилцуулж, үг

зарчмын зөрүүтэй саналыг “дэмжинэ” гэсэн томъёоллоор санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.

41.5.3.хуралдаан даргалагч Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагчийн саналаар тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлэх.

~~41.6.Хуралдаан даргалагч санал хураалт явуулах цагийг урьдчилан төвлөн зарлах бөгөөд санал хураалт явуулахаас 5 минутын өмнө тусгайлан дохио өгч гишүүдэд мэдэгдэнэ.~~

41.7.Гишүүн, нам, эвслийн бүлэг гаргасан зарчмын зөрүүтэй саналаа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татан авч болно.

41.8.Санал хураалт явуулж дууссаны дараа хуралдаан даргалагч хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэх ба энэ талаар санал хураалт явуулахгүй.

41.9.Хуулийн төслийг нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг төслийн хэмжээ, цар хүрээг харгалзан хуралдаан даргалагч тогтоож болно.

41.10.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана.

41.11.Энэ хуулийн 39.24-т заасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг эцэслэн батлах үе шатанд шилжүүлнэ.

41.12.Байнгын хороо энэ хуулийн 39.25-д заасан үндэслэлээр хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

42 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах

42.1.Хуулийн төслийг холбогдох Байнгын хороо дараах журмаар нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ:

42.1.1.нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга бэлтгэх;

42.1.2.энэ хуулийн 42.1.1-д заасан төсөл болон танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараан танилцуулсны үндсэн дээр хуралдаанаар хэлэлцэх;

42.1.3.энэ хуулийн 42.1.1-д заасан **эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон** танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуух.

42.2.Холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно:

42.2.1.нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн;

42.2.2.анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо, эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх жууль зүйн зөвлөмжийг Хууль зүйн Тамгын газрын хууль зүйн дүгнэлтийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо дэмжиж санал, дүгнэлт гаргасан;

42.2.3.нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн.

42.3.Энэ хуулийн 42.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно.

42.4.Гишүүн горимын санал гаргаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хүрээнд энэ хуулийн 11.8, 11.9-д заасныг баримтлан мэтгэлцээнийг зохион байгуулна.

42.4. **42.5.**Байнгын хороогоор хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дүнд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, танилцуулгыг санал хураалгах томъёоллын хамт Улсын Их Хурлын нийт гишүүнд тараана.

42.5.**42.6.**Анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно.

42.6.**42.7.**Энэ хуулийн 42.5-д **42.6-д** заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол тухайн Байнгын хороо уг төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн байна.

42.7.**42.8.**Төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх болон энэ хуулийн 42.5-д **42.6-д** заасан төслийг боловсруулах ажлыг холбогдох Байнгын хороо хариуцан гүйцэтгэнэ.

42.8.**42.9.**Энэ хуулийн 42.5-д **42.6-д** заасны дагуу боловсруулсан төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн батална.

43 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах

43.1.Байнгын хорооноос томилогдсон гишүүн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна.

43.2.Гишүүн энэ хуулийн 9.2,~~9.3~~-т заасан журмын дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асууж болно.

43.3.Байнгын хороо энэ хуулийн 42.4-т **42.5-д** заасны дагуу санал хураалгах томъёолол оруулсан бол уг саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд **тус бүр 3 хүртэл**

гишүүн үг хэлсний дараа хуралдаан даргалагч саналын томъёолол тус бүрийг уншиж сонсгон санал хураалт явуулна.

43.4.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 43.3-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа тухайн хуулийн төслийг эцэслэн батлуулаж **батлах** бэлтгэл хангуулахаар холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.

44 дүгээр зүйл.Хуулийн төслийг эцэслэн батлах

44.1.Байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүнд үндэслэн эцэслэн батлуулаж **батлах** төслийн хувилбарыг бэлтгэж, нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө гишүүдэд тараасан байна.

44.2.Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол эцэслэн баталсанд тооцно.

44.7.Энэ хуулийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн баталсны дараа хуралдаан даргалагч батлагдсан хуулийн агуулга, ач холбогдлын талаар үг хэлж болно.

45 дугаар зүйл.Тогтоолын төслийг хэлэлцэх

45.1.Улсын Их Хурал энэ хуулийн Арван нэгдүгээр бүлэгт зааснаас бусад асуудлаарх **Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн** тогтоолын төслийг хэлэлцэх эсэх, анхны болон эцсийн хэлэлцүүлгийн үе шаттайгаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хуулийн төслийг хэлэлцэх журмыг баримтална.

45.3.Нэгдсэн хуралдаан Байнгын **хорооны, хуульд заасан тохиолдолд дэд** хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргана.

46 дугаар зүйл.Хууль, тогтоолын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулах, ёсчлох

46.1.Энэ хуульд заасны дагуу баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга хийх, ёсчлох ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:

46.1.3.Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх;

46.3.Хуулийн **Хууль, тогтоолын** эцсийн найруулгыг энэ хуулийн 46.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно.

46.4.Энэ хуулийн 46.3-т заасны дагуу ёсчилсон хуулийг **хууль, тогтоолыг** Тамгын газар ажлын 2 өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээнэ.

46.5.Энэ хуулийн 46.4-т заасны дагуу илгээсэн хуулийг **хууль, тогтоолыг** Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

46.6.Монгол Улсын Ерөнхийлөгч энэ хуулийн 46.5-д заасны дагуу хориг тавьсан бол Улсын Их Хурал түүнийг хүлээж авснаас хойш дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжид, ажлын 14

өдрийн дотор нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёр буюу 66.6 хувь нь хоригийг хүлээн аваагүй бол тухайн хууль, тогтоол хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

46.7.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы чөлөө цагт хууль, тогтоолд хориг тавьсан бол уг хоригийг ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш энэ хуулийн 46.6-д заасан хугацаанд ажлын 10 өдрийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

57 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах

57.4.Санал хураалтад Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг дэмжээгүй бол Байнгын хороо тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг тогтоолын төсөлд буцаах үндэслэлийг тусгасан байна.

58 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах

58.4.Гишүүн уг хэлсний дараа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар ~~холбогдох Байнгын хорооны саналаар~~ санал хураалт явуулна.

58.5.Санал хураалтад Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол ~~төслийн төслийг~~ анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.

58.6.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн үзэл баримтлалыг Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

59 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах

59.1.Холбогдох Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

~~59.2.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.~~

59.2.Бусад Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

59.3.Холбогдох Байнгын хороо гишүүд, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн зарчмын зөрүүтэй саналыг нэгтгэн нэгдсэн хуралдаанд оруулна.

59.4.Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлтэй холбогдуулан гаргах санал Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцсэн байна.

59.5.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн талаар гишүүн, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан тайлбар хийж болно.

59.6.Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэхдээ энэ хуульд заасан хуралдааны нийтлэг журмыг баримтална.

63 дугаар зүйл.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэх

63.11.Холбогдох Байнгын хороо нь гишүүн, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналуудыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн, нэгдсэн хуралдаанд оруулна нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.

63.13.Нэгдсэн хуралдаан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх Байнгын хорооны холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн санал хураалт явуулна.

64 дүгээр зүйл.Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх

64.1.Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн батална:

64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно. Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хүргүүлнэ. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар Байнгын хорооны санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэгтгэн, санал хураалтын дүнгийн хамт санал, дүгнэлтэд хавсарган Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хүргүүлнэ. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар тухайн Байнгын хорооны гишүүд болон бусад Байнгын хорооны санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгах;

65 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлэг явуулах

65.1.Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл /цаашид “жилийн төлөвлөгөөний төсөл” гэх/-ийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан хэлэлцэнэ.

65.2.Ерөнхий сайд, эсхүл түүний томилсон Засгийн газрын гишүүн Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд жилийн төлөвлөгөөний төслийг 10 минутад, төрийн аудитын дээд

байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлтээ тус бүр 5 минутад багтаан танилцуулна.

65.3. **Холбогдох** Байнгын хорооны хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлт гарган, түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

65.4. Нам, эвслийн бүлэг жилийн төлөвлөгөөний төслийн талаар санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанд 5 минутад багтаан танилцуулна.

65.5. Гишүүн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно. ~~Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүний асуулт асууж хугацаа 4 минутаас илүүгүй, тодруулах асуулт асууж хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.~~

65.6. Улсын Их Хурал **Нэгдсэн хуралдаанаар** энэ зүйлд заасны дагуу жилийн төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-т заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулна.

65.7. Энэ хуулийн 65.6-д заасан санал хураалтад **санал хураалт явуулахад хуралдаанд** оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол жилийн төлөвлөгөөний төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.

65.8. Хуралдаан **Энэ хуулийн 65.6-д заасан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуралдаан** даргалагч жилийн төлөвлөгөөний төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ. Энэ талаар санал хураалт явуулахгүй.

66 дугаар зүйл. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах

66.1. Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг жилийн төлөвлөгөөний төслийг **эрхлэх асуудлынхаа хүрээнд** хэлэлцсэн бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

66.3. Гишүүд энэ хуулийн 66.2-т заасан ажлын хэсгийн саналтай **танилцуулгатай** холбогдуулан асуулт асууж болно.

68 дугаар зүйл. Мөнгөний бодлого, Монголбанкны Эрдэнэсийн сангийн төсвийн төслийг хэлэлцэх

68.5. Гишүүн тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно. ~~Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүний асуулт асууж хугацаа 4 минутаас илүүгүй, тодруулах асуулт асууж хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.~~

69 дүгээр зүйл. Улсын төсвийн төслийг хэлэлцэх үе шат

69.1. Улсын төсөв /цаашид “төсөв” гэх/ ийн төслийг Улсын Их Хурал намрын ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хэлэлцэж эхлэх ба 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дараах таван үе шаттайгаар хэлэлцэн батална:

69.1.1. төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлтэй танилцах;

~~69.1.2.төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөл нь энэ хуулийн 70.5-д нийцсэн эсэх талаар санал хураалт явуулах;~~

~~69.1.3.төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;~~

~~69.1.4.төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах;~~

~~69.1.5.төсвийн төслийн тав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг эцэслэн батлах.~~

69.1.Улсын төсөв /цаашид “төсөв” гэх/-ийн төслийг Улсын Их Хурал 10 дугаар сарын эхний долоо хоногт хэлэлцэж эхлэх бөгөөд 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн батална:

69.1.1.төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулах;

69.1.2.төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;

69.1.3.төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах;

69.1.4.төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг эцэслэн батлах.

69.2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төсөлд хяналтын сонсгол явуулах бол гурав **хоёр** дахь хэлэлцүүлгийн өмнө төсвийн төслийн цаглаварт нийцүүлэн Төсвийн байнгын хороо сонсгол зохион байгуулж болно.

~~**69⁴ дүгээр зүйл.Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг**~~

~~69⁴.1.Ерөнхий сайд төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг, Төсвийн төгтвортой байдлын зөвлөлийн дарга төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд тус тус танилцуулна.~~

~~69⁴.2.Төсвийн төсөлтэй хөлбөгдүүлэн төрийн аудитын дээд байгууллагын болон Төсвийн төгтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ.~~

~~69⁴.3.Төсвийн төслийн танилцуулгад төсвийн төслийг боловруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдал, гарсан үр дүнг төсвийн төсөлд хэрхэн тусгасан талаар танилцуулна.~~

~~69⁴.4.Нэг дэх хэлэлцүүлэгт Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, Улсын ерөнхий прокурор, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн төгтвортой байдлын зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга,~~

~~Ерөнхий нарийн бичгийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нар өрөлцөнө.~~

~~69⁴.5.Гишүүд энэ хуулийн 69⁴.1-д заасан танилцуулгатай холбогдуулан Ерөнхий сайдаас, энэ хуулийн 69⁴.2-т заасан дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас, төсвийн төсөлтэй холбогдуулан энэ хуулийн 69⁴.4-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.~~

70 дугаар зүйл.Төсвийн төслийн хоёр дахь нэг дэх хэлэлцүүлэг

70.1.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон бусад Байнгын хөрөө төсвийн төсөлтэй танилцаж, хуралдаанаар хэлэлцэнэ.

70.1.Ерөнхий сайд төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг тус тус танилцуулна. Төсвийн төслийн танилцуулгад төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хэрхэн хангаж ажилласан тухай болон гарсан үр дүнг төсвийн төсөлд хэрхэн тусгасан талаар танилцуулна.

70.2.Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.

70.2.Төсвийн төсөлтэй холбогдуулан гаргасан төрийн аудитын дээд байгууллагын болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ.

70.3.Байнгын хөрөө эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар танилцуулга боловсруулж, Төсвийн байнгын хөрөөнд хүргүүлнэ.

70.3.Нэг дэх хэлэлцүүлэгт Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нар оролцоно.

70.4.Төсвийн байнгын хөрөө энэ хуулийн 70.3-т заасан танилцуулгыг хүлээн авч нэгтгэн, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

70.4.Гишүүд энэ хуулийн 70.1-д заасан танилцуулгатай холбогдуулан Ерөнхий сайдаас, энэ хуулийн 70.2-т заасан дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас, төсвийн төсөлтэй холбогдуулан энэ хуулийн 70.3-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.

70.5.Нэгдсэн хуралдаанд Төсвийн байнгын хөрөө танилцуулга хийсний дараа **Улсын Их Хурал энэ зүйлд заасны дагуу асуулт асууж, үг хэлсний дараа** төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна.

70.6.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалтад хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол төсвийн төслийг гурав хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлнэ.

70.7.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалтад хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол төсвийн төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.

71 дүгээр зүйл.Төсвийн төслийн гурав дахь хоёр дахь хэлэлцүүлэг

71.1.Төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд, нам, эвслийн бүлэг төсвийн төслийг хэлэлцэнэ.

71.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг энэ хуулийн 71.1-д заасан эрхлэх асуудлын хүрээг баримтлан, **Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг** Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна.

71.3.Байнгын болон дэд хорооны хуралдаанд гишүүд Байнгын, дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно.

71.4.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төрийн аудитын төв дээд байгууллагын дүгнэлтийг хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж болно.

~~71.5.Бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт гаргана.~~

71.5.Бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт гаргана. Уг санал нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан бүсийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх бол тухайн бүс доторх бусад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах ба бусад тохиолдолд тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэх бол тухайн салбарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зардлыг мөн хэмжээгээр бууруулна.

71.6.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ хуулийн 71.5-д заасан санал тус бүрээр санал хураалт явуулж өлөнхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэгтгэн, санал хураалтын дүнгийн хамт санал, дүгнэлтэд хавсарган Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

71.7.Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар төсвийн төслийн ~~гурав дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага,~~ хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүд, нам, эвслийн бүлгийн гаргасан санал дараах шаардлагыг хангасан байна:

71.7.1.хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн байх;

71.7.2.Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлээгүй байх;

71.7.3.Төсвийн тухай хуулийн² 6.2.6, 29.3, 29.4-т нийцсэн байх.

~~71.8.Нам, эвслийн бүлэг, гишүүн тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно. Санал хураалт явуулахын өмнө тухайн саналтай холбогдуулан Засгийн газрын тайлбарыг сонсож болно.~~

71.8.Нам, эвслийн бүлэг, гишүүн тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр энэ хуулийн 71.5-д заасны дагуу бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно. Санал хураалт явуулахын өмнө тухайн саналтай холбогдуулан Засгийн газрын тайлбарыг сонсоно.

~~71.9.Төсвийн байнгын хороо энэ хуулийн 71.6-д заасан болон Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага, нам, эвслийн бүлгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, нэгдсэн хуралдаанд оруулна.~~

71.9.Төсвийн байнгын хороо төсвийн төслийн талаарх ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулах бөгөөд түүний дараа энэ хуулийн 71.6-д заасны дагуу ирүүлсэн санал, Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан нам, эвслийн бүлгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.

71.10.Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан дэд дарга Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 24.2-т заасан дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулна.

~~71.10.71.11.Төсвийн төслийн гурав **хоёр** дахь хэлэлцүүлгийн шатанд гарсан төсвийн санал Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг баримтлахгүй байх нөхцөлийг үүсгэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар энэ талаар нэгдсэн хуралдаанд тайлбар хийж болно.~~

~~71.11.Нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно.~~

71.11.71.12.Нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүд гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно.

~~71.12.71.14.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 71.9-д заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна.~~

~~[71.13./Энэ хэсгийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)~~

~~71.14.71.15.Нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн гурав **Байнгын хорооны дарга болон ажлын хэсгийн ахлагчийн саналыг үндэслэн хуралдаан даргалагч төсвийн төслийн хоёр** дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно. Чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.~~

² Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

72 дугаар зүйл. Төсвийн төслийн дөрөв дэх гурав дахь хэлэлцүүлэг

72.1. Төсвийн төслийн дөрөв дэх гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны гурав хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, хэрэгжих хугацаа, байршилтай холбоотой залруулгыг хийж, төсвийн төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

72.2. Нэгдсэн хуралдаанаар дөрөв дэх гурав дахь хэлэлцүүлэг явуулахад зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар гишүүд тайлбар хийх, түүнтэй холбогдуулан асуулт асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй.

72.3. Хуралдаан даргалагч төсвийн төслийг ~~тав дахь~~ дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.

72.4. Төсвийн төслийн дөрөв, ~~тав дахь~~ гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хамтатган явуулж болно.

73 дугаар зүйл. Төсвийн төслийн ~~тав дахь~~ дөрөв дэх хэлэлцүүлэг

73.1. Нэгдсэн хуралдаан даргалагч Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсгож, зүйл тус бүрээр нь санал хураалт явуулж батлуулна.

73.2. Шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмын дагуу хэлэлцэн баталж болно.

73.3. Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуульд тодотгол хийх асуудлыг энэ хуулийн 69, ~~69⁺~~ 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

73.4. Төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй холбоотой энэ бүлгээр зохицуулаагүй бусад асуудлыг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмыг баримтална.

74 дүгээр зүйл. Төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэх

74.5. Нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлэг явуулах үед гишүүд энэ хуулийн 74.4.1-д заасан илтгэл болон ~~аудитын~~ дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн энэ хуулийн 74.3-т заасан албан тушаалтнаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд үүний дараа төсвийн гүйцэтгэлийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлнэ.

75 дугаар зүйл. Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг зөвшилцөх

75.3. Дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг дараах байнгын хороо тус тусдаа урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ:

75.3.1.чөлөөт худалдаа, давхар татвар, хөрөнгө оруулалттай холбогдсон олон улсын гэрээний төслийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо;

75.3.2.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн олон улсын гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээний төслийг Хууль зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо;

75.3.3.хүний салшгүй эрх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээний төслийг Хууль зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо.

75.5.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, холбогдох баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хороодын, эсхүл бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.

75.12.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нь Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хороодын санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

~~75.13.Энэ хуулийн 75.9, 75.12-т заасны дагуу хэлэлцүүлсэн олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн гишүүдийн олонхын саналаар энэ хуулийн 75.8.1, 75.8.2, 75.8.3-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.~~

75.13.Нэгдсэн хуралдаан олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, энэ хуулийн 75.9, 75.12-т заасны дагуу гарсан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт бичгээр мэдэгдэнэ.

76 дугаар зүйл.Зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан зөвшилцөх

76.6.Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийн талаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана:

76.6.1.олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг бүхэлд нь зөвшөөрч, олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

76.6.2.баталсан буюу жинхэлсэн олон талт гэрээний эх бичвэрээс бусад олон улсын гэрээний төсөлтэй холбогдуулан зарчмын шинжтэй тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх;

76.6.3.олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх.

76.7.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын санал, эсхүл олон улсын гэрээний агуулга, ач холбогдлыг харгалзан Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэж болно.

76.8.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар энэ хуулийн 76.6.2-т заасан Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийн дагуу олон улсын гэрээний төсөлд засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар олон улсын гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай хэлэлцээ хийж, хэлэлцээний үр дүнг олон улсын гэрээний шинэчилсэн төслийн хамт Улсын Их Хуралд зөвшилцөхөөр дахин ирүүлнэ.

~~76.10.Энэ хуулийн 76.7-д заасны дагуу хэлэлцүүлсэн олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн гишүүдийн олонхын саналаар энэ хуулийн 76.6.1, 76.6.2, 76.6.3-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.~~

76.10.Нэгдсэн хуралдаан олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, энэ хуулийн 76.7, 76.8-д заасны дагуу гарсан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт бичгээр мэдэгдэнэ.

77 дугаар зүйл.Олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, гэрээг урьдчилан зөвшилцөх, хэлэлцүүлэх

77.4.Дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээг ~~Хууль-зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ:

77.6.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төсөл, баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон ~~Хууль-зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн байнгын хороонд, эсхүл бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.

77.9.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийн талаар ил санал хураалт явуулж, гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана:

77.9.1.олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, тухайн олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

77.9.2.гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээний тухайд тухайн олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;

77.9.3.олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх.

77.14.Энэ хуулийн 77.9.2, 77.13-т заасны дагуу хэлэлцүүлэх олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн ~~хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар~~ дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

77.14.1.олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

77.14.2.гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээний тухайд тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хууль батлах;

77.14.3.гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай болон холбогдох бусад хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох бусад хуулийн төсөл эрхлэх асуудалд нь хамаарах Байнгын хороонд шилжүүлэх.

77.13.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын, эсхүл ~~Хууль зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

77.16.Энэ хуулийн 77.14.2-т заасан хуулийн төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

80 дугаар зүйл.Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх

80.1.Засгийн газар гадаад улсыг хүлээн зөвшөөрөх тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

80.4.Засгийн газар гадаад улстай дипломат харилцаа тогтоох, эсхүл цуцлах асуудлаар тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг энэ хуулийн 80.1-д заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

80.5.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

80.6.Энэ хуулийн 80.1, 80.4-т заасан тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

82 дугаар зүйл.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг нь тогтоох тухай тогтоолын төсөл хэлэлцэх

82.1.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална гаргана.

82.2.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

82.3.Нэгдсэн хуралдаан хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, Байнгын хорооноос оруулсан саналын томъёоллоор ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүний олонх дэмжсэн бол тогтоолыг баталсанд тооцно.

82.4.Нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

83 дугаар зүйл.Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хэлэлцэх

83.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг Төрийн байгуулалтын болон Хууль-зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хороод урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

84 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журам

84.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан маргаантай асуудлаар Цэц дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулсан бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:

84.2.1.Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль-зүйн Хууль зүй, хүний эрхийн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь /хэсэгчлэн/ хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах;

84.2.2.энэ хуулийн 84.2.1-д заасны дагуу Байнгын хороод Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн хуульд нийцээгүй гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн заалтад нийцээгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах;

84.2.4.Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль-зүйн Хууль зүй, хүний эрхийн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл нэгдсэн хуралдаанд Хууль-зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны санал, дүгнэлтээр эхэлж санал хураалгах бөгөөд энэ санал дэмжигдээгүй бол холбогдох Байнгын хорооны санал дэмжигдсэн гэж үзэх;

84.3.Хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15-өдрийн 60 хоногийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна.

85 дугаар зүйл.Албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх

85.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан асуудлаар Цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:

85.1.1.Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль-зүйн Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

85.1.4.нэгдсэн хуралдаан энэ хуулийн 85.1.2-т заасан албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа Цэцийн дүгнэлтийг

хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар ~~Хууль зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;

86 дугаар зүйл. Албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх

86.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц дүгнэлт гаргаж ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:

86.1.1. Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор ~~Хууль зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

86.1.3. Цэц Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа дүгнэлтийг зөвшөөрөх эсэх асуудлаар ~~Хууль зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;

88 дугаар зүйл. Цэцэд хүсэлт гаргах

88.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Улсын Их Хурлаас Цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг ~~Хууль зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж саналд дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна.

90 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг хэлэлцэх

90.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг тухайн асуудлыг анх хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан холбогдох Байнгын хороо болон ~~Хууль зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

90.7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар ~~Хууль зүйн~~ Хууль зүй, хүний эрхийн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна.

95 дугаар зүйл. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх

95.3. Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын **хороо болон Өргөдлийн байнгын** хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

95.4. Холбогдох Байнгын **хороо болон Өргөдлийн байнгын** хороо саналыг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 7 хоногийн дотор хэлэлцэж эхэлнэ.

95.5.Байнгын хороо тухайн саналыг хэлэлцэж эхэлснээс хойш 3 сарын дотор дараах байдлаар шийдвэрлэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна:

95.5.1.холбогдох бодлогын баримт бичиг, хууль, тогтоолын төсөл боловсруулах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх;

95.5.2.хууль, тогтоолын хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх;

95.5.3.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах;

95.5.4.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1.11-д заасан асуудлаар санал гаргах;

95.5.5.олон нийтийн хэлэлцүүлэг, Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах.

95.6.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 95.1-д заасан асуудлаар санал гаргасан иргэдийн төлөөлөл болон холбогдох салбарын мэргэжилтнийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд байлцуулж болно.

95.9.Нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс цахим системээр гаргасан нийт өргөдлийн талаарх мэдээллийг Өргөдлийн байнгын хороо ээлжит чуулганы хугацаанд нэг удаа нэгдсэн хуралдаанд хийнэ.

95.9-95.10.Энэ хуулийн 95.8-д заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлттэй **дүгнэлт, 95.9-д заасан мэдээлэлтэй** танилцсаны дараа гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

99 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэх

99.1.**Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн, эсхүл** Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулсан, эсхүл огцорсонд тооцсон бол шинэ Ерөнхий сайдыг томилох асуудлыг энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

100 дугаар зүйл.Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх

100.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд үг хэлж болно.

101 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх

101.3.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, **Ерөнхий сайдыг огцруулах саналаар** ил санал хураалт явуулна.

104 дүгээр зүйл.Цэцийн гишүүнийг томилох асуудлыг хэлэлцэх журам

~~104.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхээс Цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлсэн саналыг хүлээн авснаас хойш энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн тайлан, эрх бүхий этгээдийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.~~

104.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхээс Цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлсэн саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Төрийн байгуулалтын болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар эрх бүхий этгээдийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

104.2.Нэгдсэн хуралдаан Хууль зүйн байнгын хорооны **Төрийн байгуулалтын болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдааны** санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор хуралдаж нэр дэвшүүлсэн байгууллагын танилцуулга, Хууль зүйн байнгын **хамтарсан Байнгын** хорооны санал, дүгнэлтийг сонсож нэр дэвшигч тус бүрээр ил санал хураалт явуулж олонхын санал авсан нэр дэвшигчийг Цэцийн гишүүнээр томилж тухай тогтоол баталсанд тооцно.

105 дугаар зүйл.Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх

105.1.Цэцийн гишүүн бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ анх илгээсэн байгууллагаар уламжлан гаргасныг, эсхүл Төрийн албаны тухай хуульд³ заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэнтэй холбогдуулж гишүүнийг чөлөөлүүлэх саналыг анх илгээсэн байгууллага Улсын Их Хуралд ирүүлсэн бол Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хороо энэ асуудлыг 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна.

105.2.Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол баталсанд тооцно.

106 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулах журам

106.2.Энэ хуулийн 106.1-д заасан танилцуулгыг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт ирүүлсэн бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.

106.4.Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

106.5.Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулахгүй.

107 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх

107.1.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилохын өмнө зөвшилцөхөөр Улсын Их Хуралд саналаа ирүүлнэ.

³ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

107.2.Холбогдох Байнгын хороо энэ хуульд заасан журмын дагуу явуулсан нэр дэвшигчийн сонголын тайлан гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн тайлан, Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

107.2.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 107.1-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

107.3.Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

108 дугаар зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэх журам

108.1.Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг нэр дэвшүүлж, томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан журмыг баримтлан хэлэлцэнэ.

108.2.Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигч болон холбогдох бусад этгээдээс асуулт асууж, үг хэлж болно.

108.3.Нэгдсэн хуралдаан Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх, огцруулах саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.

108.4.Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хороо хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно.

109 дүгээр зүйл.Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх

109.1.Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлнэ.

109.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ хуулийн 109.1-д заасан саналыг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлснээс хойш ажлын 3 өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. ~~Хэрэв нэр дэвшигчийн сонгогч явуулах санал гарсан бол сонголын тайлан гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд сонголын тайланг хавсаргана.~~

~~109.6.Энэ хуулийн 109.1-д заасан нэр дэвшигчийн сонгогч явуулахаар бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Нийтийн сонголын тухай хуулийн 6.3-т заасан үндэслэлээр сонголыг хаалттай явуулж болно.~~

109.6.Гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг энэ хуулийн 8.2-т заасан хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ.

110 дугаар зүйл.Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох

саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх

110.1.Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг 72 цагийн дотор гишүүдэд хүргүүлнэ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо ийнхүү хүргүүлснээс хойш ажлын 3 өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана. ~~Хэрэв нэр дэвшигчийн сонгогч явуулах санал гарсан бол сонгогчийн тайлан гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд сонгогчийн тайлангийн агуулгыг оөрчлөхгүйгээр тусгана.~~

112 дугаар зүйл.Улсын Их Хурлын асуулгын цаг

112.10.Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан гишүүн асуулт асуух, үг хэлэхэд энэ хуулийн 9.17-д **9.18-д** заасныг баримтална.

113 дугаар зүйл.Гишүүний асуулгын хариуг хэлэлцэх

~~113.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:~~

~~113.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асууж;~~

~~113.1.2.холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулгатай холбоотой өөр асуулт асууж.~~

~~**113.1.Гишүүн нэгдсэн хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа Улсын Их Хурлын даргад ирүүлнэ.**~~

~~113.2.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.~~

113.3.Гишүүний асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд дараах журмыг баримтална:

113.3.1.Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх тов, дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан тогтоох;

113.3.2.асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд тухайн асуудлыг хариуцан хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд Улсын Их Хурлын даргад урьдчилан мэдэгдэх;

113.3.3.нэгдсэн хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах ба гишүүд асуулгын хариутай холбогдуулж асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, түүнд хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх **асууж, хариулт авах;**

113.3.4. асуулгад хариулт өгсний дараа асуулга тавьсан гишүүн нэг удаа 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх.

113.4. Асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2, 4 дэх **1, 3 дахь** долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно.

114 дүгээр зүйл. Гишүүний асуултын хариуг хэлэлцэх

114.1. Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх **ээлжит чуулганы хугацаанд ирүүлсэн бол хүлээн авснаас хойш, чуулганы чөлөө цагт ирүүлсэн бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэх** бөгөөд дараах журмыг баримтална:

114.1.1. Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд ~~3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх~~ **асуулт асууж, хариулт авах;**

114.1.2. холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттайгаа холбоотой өөр асуулт асуух.

114.2. Гишүүний асуултын хариуг хэлэлцэх ажиллагааг олон нийтэд мэдээлнэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ИЛТГЭЛ СОНСОХ, ХЭЛЭЛЦЭХ

115 дугаар зүйл. Хуулиар тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээлэл сонсох, хэлэлцэх

115.2. Дараах тайлан, илтгэл, мэдээллийг Байнгын хороо дараах харьяаллаар хэлэлцэнэ:

115.2.1. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайланг Төсвийн байнгын хороо жил бүр;

115.2.2. төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо, **холбогдох бусад байнгын хороо** тухай бүр;

115.2.3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг ~~Хууль зүйн~~ **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд;

115.2.7. Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг ~~Хууль зүйн~~ **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хороо жил бүрийн эхний улиралд;

115.2.8.жөндөрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жөндөрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болон жөндөрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Хүний хөгжил-Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2 жил бүр;

115.2.12.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Хүний хөгжил Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороо жил бүр;

115.2.13.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороо жил бүр тайланг Төсвийн байнгын хороо 3 жил тутам;

115.2.15.Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хоёр жил тутам;

115.2.16.Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг Хүний хөгжил Эрүүл мэнд, нийгмийн бодлогын болон Хууль зүйн Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар тухай бүр;

115.2.19.Хууль тогтоомжийн тухай хуулийн 52.1-д заасны дагуу хийсэн Засгийн газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний нэгдсэн дүнг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо жил бүр;

115.2.20.авлигатай тэмцэх хууль тогтоомжийн биелэлт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх Авлигатай тэмцэх газрын мэдээллийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо жил бүр;

115.2.21.эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо жилд нэгээс доошгүй удаа.

115.3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.2-т заасан мэдээллийг холбогдох Байнгын хороо ~~шаардлагатай гэж үзвэл~~ хэлэлцэнэ.

~~115.4.Энэ хуулийн 115.2, 115.3-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, энэ хуулийн 115.2-т заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.~~

115.4.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.4-т заасны дагуу Тамгын газраас ирүүлсэн дүн шинжилгээг Байнгын хороо гишүүдэд хүргүүлнэ.

115.8.Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14.1.1-д заасан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хаалттай мэдээллийг жил бүрийн 04 дүгээр сарын гурав дахь дөлөө хөногт багтаан намрын ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн хуралдаанаараа сонсоно. Нэгдсэн хуралдааны үеэр гишүүд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

116 дугаар зүйл. Байнгын хорооны хуралдаанаар мэдээлэл сонсох

116.1. Хуульд заасны дагуу, эсхүл Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно.

116.2. Олон нийтийн анхаарал татсан, цаг үеийн тулгамдсан асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах зорилгоор мэдээлэл сонсох саналаа холбогдох Байнгын хорооны дарга Зөвлөлд танилцуулж, энэ хуулийн 6.6-д заасан хэлэлцэх асуудлын тов, дараалалд оруулна.

116.2. **116.3.** Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцэхэд асуулт асууж, үг хэлж болно.

116.3. Байнгын хороо энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно.

116.4. Байнгын хороо энэ хуулийн 116.1, 116.2-т заасан мэдээллийг хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох шийдвэрийн төслийг санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

117 дугаар зүйл. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайлан, хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх

117.1. Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн гүйцэтгэл, үр дүнгийн тайланг хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ.

117.2. Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.2-т 17.1-д заасан шалгуурыг хангаж, хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ.

117.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн ~~тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан~~ тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын 18.2-т 18.1 заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.

117.4. Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

117.4.1. жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл тухайн жилийнхээ зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг бүлэг тус бүрээр болон нэгдсэн дүнгээр;

117.4.2. тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтын хэдэн хувьд хүрснийг бүлэг тус бүрээр;

~~117.4.3.жилийн төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийн талаар.~~

117.4.Байнгын хороо Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.1-д заасан хүрээнд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.1-д заасан хүрээнд гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

117.5.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т 18.1-д заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.

117.6.Энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланг Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.

117.7.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.4-т 18.3-т заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.

117.10.Нэгдсэн хуралдаан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.8, 18.10-т 17.6-д заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Улсын Их Хурал уг тогтоолыг 04 дүгээр сарын 01-ний дотор батална.

118 дугаар зүйл.Урт хугацааны бодлогын баримт бичиг болон Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн ~~явцын болон гүйцэтгэлийн~~ тайлан хэлэлцэх

118.1.Улсын Их Хурал Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг ~~урт хугацааны бодлогын баримт бичгийн явцын тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд~~ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.1-д заасны дагуу хянан хэлэлцэнэ.

118.5.Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороод болон нэгдсэн хуралдаанд энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.3, 20.3-т 19.1, 20.2-т заасан зарчмын дагуу танилцуулна.

118.6.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.7 19.5, 20.7-д заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.

118.9.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.10, 20.12-т 19.6, 20.8-д заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу уг тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулна.

120 дугаар зүйл.Сонсгол зохион байгуулах харьяалал

120.1. Сонголыг дараах харьяаллын дагуу зохион байгуулна:

120.1.2. тухайн жилийн төсвийн төсөл болон төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл, төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх хяналтын сонгол явуулах бол Төсвийн байнгын хороо, эсхүл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, ~~тухайн жилийн төсөв болон жилийн хөгжлийн төлөвлөгөөний уялдааны талаарх хяналтын сонголыг Эдийн засгийн байнгын хороо.~~

120.1.3. улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн төсвийн уялдааны талаарх хяналтын сонголыг Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороо хамтран.

120.6. Байнгын хороо энэ хуулийн 120.4, 120.5-д заасны дагуу сонголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн ~~10.1-д~~ **10 дугаар зүйлд** заасан асуудлаар холбогдох тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

121 дүгээр зүйл. Сонголын бэлтгэл хангах

121.2. Сонгол явуулах сэдэв, он, сар, өдөр, байр, оролцогч, ажиглагчийг бүртгэх ажиллагаа, бүртгэл эхлэх, дуусах хугацаа, саналыг хүлээн авах цахим болон шуудангийн хаяг, холбогдох бусад мэдээллийг агуулсан зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол давтамж, хүртээмжтэйгээр нийтэд мэдээлнэ. **Сонголд оролцогч нь бүртгүүлэхдээ тухайн асуудлыг дэмжсэн, дэмжээгүй, хөндлөнгийн байр суурийн аль нэгийг тодорхой илэрхийлсэн байна.**

~~121.4. Байнгын, дэд хороо хүсэлтийг дэмжиж шийдвэрлэсэн бол хойшлуулах үндэслэл, шалтгаанаас хамааран хойшлуулах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байна. Энэ тохиолдолд сонголын товыг нийтэд зарласан арга хэрэгслээр дахин зарлана.~~

121.4. Сонголд оролцогч нь бүртгүүлэхдээ тухайн асуудлыг дэмжсэн, дэмжээгүй, хөндлөнгийн байр суурийн аль нэгийг тодорхой илэрхийлсэн байна.

121.5. Сонголд тодорхой асуудлаар санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах төрийн байгууллага, албан тушаалтныг оролцуулах бөгөөд албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонголд ирээгүй нь сонголыг хойшлуулах үндэслэл болохгүй.

121.6. Энэ хуулийн 120.3-т заасан ажлын хэсэг, **эсхүл сонголд даргалагч** тухайн асуудлаар сонголд явуулахад шинжээч шаардлагатай гэж үзсэн бол үндэслэл бүхий хүсэлтээ энэ хуулийн 121.1-д заасан Байнгын, дэд хороонд ирүүлнэ. Байнгын, дэд хороо хүсэлтийг дэмжсэн бол Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.7, 9.10-т заасны дагуу шийдвэрлэнэ.

~~121.7. Сонголд оролцох иргэн, хуулийн этгээд, ажиглагч /цаашид “оролцогч” гэх/ сонголд болохоос ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө Байнгын хороо, Хянан шалгах түр хороонд бүртгүүлнэ.~~

121.7. Шинжээч нь тухайн асуудлын талаар тавьсан асуулт нэг бүрээр, тал бүрээс нь бүрэн, бодитой, хараат бусаар шинжлэн судалсан дүгнэлтийг тогтоосон хугацаанд бичгээр гаргаж ажлын хэсэг, эсхүл сонголд даргалагчид хүргүүлнэ.

~~121.8. Сонголд оролцогчийн тооны дээд хязгаарыг сонголд болох танхимын багтаамж, тухайн асуудлын хүрээнийг хамааран сонголд даргалагч тогтооно.~~

121.8. Сонголд оролцогчийн тооны дээд хязгаарыг тухайн асуудлын цар хүрээ, сонголд болох танхимын багтаамжийг харгалзан сонголд даргалагч тогтоох бөгөөд энэ

хуулийн 121.2-т заасан байр сүүрийг илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийг тэнцвэртэй оролцуулах зарчим баримтална.

122 дугаар зүйл. Сонсгол даргалагч

~~122.1. Холбогдох Байнгын болон дэд хорооны хуралдаанаар сонсгол даргалагч /цаашид “сонсгол даргалагч” гэж/ ийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.~~

122.1. Сонсгол даргалагчийг холбогдох Байнгын болон дэд хорооны гишүүдээс хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар сонсгол даргалагч эзгүй бол холбогдох Байнгын, эсхүл дэд хорооны дарга сонсголыг даргална.

123 дугаар зүйл. Сонсголд оролцогч

~~123.1. Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд, шинжээч, ажиглагчийг сонсголд оролцогч гэнэ.~~

123.1. Энэ хуулийн 121.5-д заасан этгээд болон хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд, ажиглагчийг сонсголд оролцогч гэнэ.

123.2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26.1.4-т зааснаас бусад сонсголд тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагыг заавал оролцуулна.

~~123.3. Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагыг сонсголд оролцуулах асуудлыг энэ хуулийн 126.5-д заасан журмаар нарийвчлан зохицуулна.~~

125 дугаар зүйл. Сонсгол даргалагчийн эрх, үүрэг

125.2. Сонсгол даргалагч дараах нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

125.2.4. сонсголын тайланг хянаж, **албажуулах**, эрх бүхий этгээдэд танилцуулах;

126 дугаар зүйл. Сонсгол явуулах журам

126.1. Сонсголыг дараах журмаар явуулна:

126.1.1. сонсгол даргалагч сонсголын зорилго, ирц, дэгийг танилцуулах;

~~126.1.2. сонсгол даргалагч оролцогчийн санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах, асуулт асуух дарааллыг тогтоох;~~

126.1.3. сонсголд дуудаж ирүүлсэн албан тушаалтан нь тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан мөн эсэх талаар тодруулга авах;

126.1.4. оролцогчийн санал, мэдээлэл, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байх;

126.1.5. гишүүн оролцогчөөс асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно;

126.1.6. гишүүн оролцогчөөс асуулт асууж, хариулт авч дууссаны дараа 5 минутад багтаан үг хэлж болно;

~~126.1.7.сонсгол даргалагч сонсож байгаа асуудалтай холбогдуулан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийн агуулгыг уншиж танилцуулан сонсголын тэмдэглэлд тусгуулна;~~

~~126.1.8.сонсгол даргалагч болон гишүүн бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.~~

126.1.Сонсгол даргалагч дараах байдлаар сонсголын дарааллыг тогтооно:

126.1.1.сонсголын зорилго, ирц, дэгийг танилцуулах;

126.1.2.эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл сонсох;

126.1.3.холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны мэдээлэл сонсох;

126.1.4.сонсгол даргалагч энэ хуулийн 126.1.2, 126.1.3-т зааснаас бусад бичгээр ирсэн санал, хүсэлт, тайлбар, мэдээллийн агуулгыг уншиж танилцуулах;

126.1.5.шинжээч томилсон бол шинжээчийн дүгнэлтийг сонсох;

126.1.6.сонсгол даргалагч болон гишүүд сонсголд оролцогчдоос асуулт асууж, хариулт авах;

126.1.7.тухайн асуудлаар дэмжсэн, дэмжээгүй, хөндлөнгийн байр суурийг илэрхийлж оролцогчид үг хэлэх;

126.1.8.гишүүн байр сууриа илэрхийлж үг хэлэх.

126.2.Сонсгол даргалагч болон гишүүн бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

126.3.Энэ хуулийн 126.1.2, 126.1.3-т заасан мэдээлэл, 126.1.5-д заасан дүгнэлтийг тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд танилцуулна.

126.4.Гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.

~~126.5. Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална.~~

126.5.Гишүүн, сонсголд оролцогч байр сууриа илэрхийлж үг хэлэх хугацаа 5 хүртэл минут байна.

~~126.2.~~126.6.Энэ хуулийн 126.1.5, 126.1.6-д 126.1.6, 126.1.7-д заасан үйл ажиллагаанд олонх, цөөнхийн төлөөлөлд ээлжлэн асуулт асуух, үг хэлэх боломж олгоно.

~~126.3.~~126.7.Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй.

~~126.4.~~126.8.Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.

129 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол

129.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтныг ~~томилгох, зөвшилцөх, танилцуулах~~ **томилуулах** саналаа Улсын Их Хуралд албан ёсоор ирүүлнэ. Саналд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэл бүхий нэр дэвшигчийн танилцуулга, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.

135 дугаар зүйл. Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журам

135.1.Чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /цаашид “хуралдааны тэмдэглэл” гэх/-ийг бичгээр болон цахим мэдээлэл тээгчид нэгэн зэрэг дуу, дүрсний бичлэгийн хэрэгсэл ашиглан хадгалах ба хуралдааны тэмдэглэл ~~дэлгэрэнгүй ба товч гэсэн хэлбэртэй байна~~ **дэлгэрэнгүй ба товч тэмдэглэлээс бүрдэнэ.**

135.2.Хуралдааны ~~дэлгэрэнгүй~~ тэмдэглэлд дараах баримт бичгийг хавсарган хадгална:

135.2.1.~~тухайн хуралдаанаар хэлэлцэж асуудлын төлөвлөгөө,~~ хуралдаанд урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;

~~135.2.5.хэлэлцэж байгаа асуудалтай хөлбөгдүүлэн Улсын Их Хурал, гишүүдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал;~~

135.2.5.хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл;

135.2.6.гишүүн хуралдааны тэмдэглэлд тусгайлан тэмдэглүүлэхээр бичгээр гаргасан санал;

135.2.7.гишүүдийн ирцийн мэдээ, **гишүүний хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцоогүйг нотлох баримт бичиг, түүний хуулбар.**

135.3.Хуралдааны товч тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

135.3.1.хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан болон асуудлыг хэлэлцэж эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут;

135.3.2.хэлэлцсэн хууль, тогтоолын төсөл буюу асуудал, түүнийг танилцуулсан албан тушаалтан, хуралдаанд оролцогч, урилгаар байлцсан хүмүүс;

135.3.3.санал хураалтын дүн /тоо, хувиар/, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналын төө **саналыг түүний нэрээр;**

135.3.4.хуралдааны ирцийн мэдээ /тоо, хувиар/, хуралдаанд ирээгүй гишүүний нэр, шалтгаан /томилолттой байсан, хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан/;

135.3.5.гишүүний тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үг;

135.3.6.энэ хуулийн 15.1-д заасны дагуу хуралдааны дэг сахиулахтай холбогдуулан авсан арга хэмжээ;

~~135.3.7.сөнгөгч болон бусад этгээдийг Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцуулсан тухай;~~

135.3.8.нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу авсан завсарлага;

135.3.9.хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлсэн талаарх хуралдаан даргалагчийн мэдээлэл.

135.3.8.дуу болон дүрсний бичлэгт тусгагдах боломжгүй, хуралдааны явцад болсон үйл явдлыг дэс дарааллын дагуу нэг бүрчлэн товч тэмдэглэлд буулгах.

136 дугаар зүйл.Хуралдааны тэмдэглэл ашиглах, хадгалах журам

~~136.4.Хуралдааны тэмдэглэлийг Тамгын газрын архивт хадгалах бөгөөд түүнийг ашиглах, хадгалах нарийвчилсан журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.~~

136.4.Хуралдааны тэмдэглэлийг Тамгын газрын архивд холбогдох журмын дагуу хадгална.

-----oOo-----

2.ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА

2.1.ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<i>Төсөлд 6.12 дахь хэсгийг шинээр нэмсэн</i>	6 дугаар зүйл.Хуралдааны тов, дараалал тогтооход баримтлах журам 6.12.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлснээс хойш ээлжит чуулганы хугацаанд нэг сарын дотор энэ хуулийн 6.6-д заасан тов, дараалалд тусгана.

Тайлбар: Хууль санаалчлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг ээлжит чуулганы хугацаанд тодорхой хугацааны дотор /1 сарын дотор/ тов, дараалалд тусгадаг байх зохицуулалт нэмнэ. Ингэснээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хэзээ тов, дараалалд орох эсэх хүлээлт үүсгэхгүй болно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: ОУ-ын парламентын практикт хуулийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдааны шатанд удаашруулахгүйгээр тодорхой хугацаанд хэлэлцэн шийдвэрлэхэд чиглэсэн нарийвчилсан үйл ажиллагааны зохицуулалтууд нийтлэг хэрэгждэг.

БНИУ (Итали гэх)⁴-д Байнгын хороо нь хуулийн төслийг шилжүүлэн авснаас хойш ихдээ 1 сарын дотор нэгдсэн хуралдаанд бичгээр тайлагнах үүрэгтэй байдаг. Хэрэв энэхүү хугацаанд тайлан гаргаагүй тохиолдолд Танхимын дарга тухайн хуулийн төслийг нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад шууд оруулдаг зохицуулалттай. Энэ нь Байнгын хороодын шатанд асуудлыг удаашруулах эрсдэлийг институцийн түвшинд хязгаарласан байна.

БНСУ (Солонгос гэх)⁵-ын хууль тогтоох үйл явцын үе шат бүрд тодорхой хугацааны хязгаар тогтоосон байдаг бөгөөд хуульд хэсэгчлэн нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг 15 хоног, харин шинээр боловсруулах, бүхэлд буюу шинэчилсэн найруулга, хүчингүй болгох төслийг 20 хоногийн дотор Байнгын хороогоор хэлэлцэж эхлэхийг хязгаартай. Хэрэв хуулийн төслийг Байнгын хороонд шилжүүлснээс хойш 30 хоногийн дотор хэлэлцэж эхлээгүй бол тухайн асуудлыг анхны хэлэлцүүлэгт орсонд тооцохоор зохицуулсан. Мөн нэн яаралтай журмаар хэлэлцэх асуудлыг Байнгын хороо 180 хоног, Хууль зүйн хороо 90 хоногийн дотор шийдвэрлэх үүрэгтэй байдаг нь хууль тогтоох үйл ажиллагааны хугацааны сахилга батыг хангах зорилготой байдаг.

Эстони⁶-ийн Парламент хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эхэлснээс хойш ажлын долоон долоо хоногийн дотор дуусгасан байх шаардлага тавьдаг. Энэхүү зохицуулалт нь парламентын хэлэлцүүлгийг хэт сунжруулахгүй байлгахад чиглэдэг байна.

ХБНГУ (Герман гэх)⁷-ын Бундестагт Байнгын хорооны үйл ажиллагаанд парламентын цөөнхийн хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоо чухал байр суурь эзэлдэг. Хуулийн төслийг Байнгын хороонд шилжүүлснээс хойш 10 долоо хоног өнгөрсөн тохиолдолд намын бүлэг эсхүл гишүүдийн таван хувь нь тухайн асуудлын явцын тайланг шаардах эрхтэй байдаг.

⁴ Italian Chamber of Deputies. (2025). *Rules of procedure of the Chamber of Deputies*.

⁵ National Assembly of the Republic of Korea. (2020). *National Assembly Act*.

⁶ Estonian Parliament (Riigikogu). (2016). *Riigikogu rules of procedure and internal rules act*.

⁷ German Bundestag. (2022). *Rules of procedure of the German Bundestag. Deutscher Bundestag*.

Шинэ Зеланд⁸-д Сонгон шалгаруулах хороо (Select Committee) нь хуулийн төслийг шилжүүлэн авснаас хойш 6 сарын дотор эцсийн тайлангаа танилцуулах үүрэгтэй. Хэрэв тогтоосон хугацаанд тайлагнаагүй бол тухайн төслийг хорооны дараагийн хэлэлцүүлгээс хасаж, нэгдсэн хуралдааны дараагийн шатанд шууд шилжүүлдэг. Энэ нь Байнгын хорооны шатанд асуудлыг удаашруулах боломжийг хязгаарласан зохицуулалт юм.

Харин БНФУ (Франц гэх)⁹-д хуулийн төслийг хангалттай хугацаанд судлах боломжийг бүрдүүлэх зорилгоор “хүлээх хугацаа” тогтоосон байдаг. Анхны хэлэлцүүлгийг төслийг өргөн мэдүүлснээс хойш 6 долоо хоногийн өмнө эсвэл Байнгын хороонд шилжүүлснээс хойш 4 долоо хоногийн өмнө явуулж болохгүй гэж хуульчилсан нь асуудлыг яаралтай бус нарийвчлан судлах нөхцөлийг хангахад чиглэдэг байна.

ОУ-ын парламентын практикт хуулийн төслийг Байнгын хорооны шатанд хэт удаашруулахгүй байх, нэгдсэн хуралдаанд тодорхой хугацаанд оруулах, шаардлагатай тохиолдолд шууд шилжилтийн тогтолцоо мөн парламентын цөөнхийн хяналтыг хангах зэрэг зохицуулалтууд нийтлэг хэрэгжиж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
7 дугаар зүйл.Хуралдааны ирц 7.1.Хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.	7 дугаар зүйл.Хуралдааны ирц 7.1.Хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд бүрдсэн ирц санал хураалт явуулахаас бусад тохиолдолд хүчинтэй хэвээр тооцогдоно.
7.3.Гишүүн өвчтэй буюу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоод томилолтоор явсан, түүнчлэн хурал, зөвлөгөөнд зайлшгүй оролцох шаардлагатай байсан бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй бол хуралдаан тасалсанд тооцно.	7.3.Гишүүн өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаадад томилолтоор ажилласан бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй бол хуралдаан тасалсанд тооцно.
7.4.Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид энэ хуулийн 7.3-т заасан шалтгаан, үндэслэлээ бичгээр урьдчилан мэдэгдэнэ.	7.4.Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид энэ хуулийн 7.3-т заасан шалтгаан, үндэслэлээ хуралдааны өмнөх ажлын өдөрт багтаан бичгээр урьдчилан мэдэгдэнэ. Урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас чөлөө авах бол шалтгаан, үндэслэлээ хуралдааны өмнө хуралдаан даргалагчид мэдэгдэнэ.
-	7.7.Гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэхдээ биеийн давхцахгүй өгөгдлөөр идэвхжих цахим систем ашиглана.
-	7.10.Ёс зүйн дэд хороо гишүүний нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны ирц, санал хураалтад биечлэн оролцсон байдлын талаар Ёс зүйн дэд хорооноос тухайн ээлжит чуулган хаасны дараах долоо хоногт олон нийтэд танилцуулна.

Тайлбар: Гишүүн өвчтэй буюу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоод томилолтоор явсан, түүнчлэн хурал, зөвлөгөөнд зайлшгүй оролцох шаардлагатай байсан бол хүндэтгэн үзэх

⁸ New Zealand House of Representatives. (2023). *Standing orders of the House of Representatives*. New Zealand Parliament.

⁹ French National Assembly. (2025). *Règlement de l'Assemblée nationale*.

шалтгаантай гэж үзэж байгаа бөгөөд эдгээрийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д заасантай нийцүүлж өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаадад томилолтоор ажилласан бол хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзэхээр тусгана. Өвчтэй хүн асрах, хурал, зөвлөгөөнд зайлшгүй оролцох шаардлагатай бол урьдчилан чөлөө авсан байх шаардлага тавигдана.

Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаантай бол шалтгаан, үндэслэлээ хуралдааны өмнөх ажлын өдөрт багтаан ирүүлэх, хэрэв урьдчилан мэдэх боломжгүй гэнэтийн шинжтэй нөхцөл байдлын улмаас чөлөө авах бол шалтгаан, үндэслэлээ хуралдааны өмнө хуралдаан даргалагчид мэдэгдэхээр тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: ОУ-ын парламентын практикт гишүүдийн хуралдааны ирцийг бүртгэх, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан тохиолдолд санхүүгийн болон улс төрийн хариуцлага тооцох тогтолцоо нь сахилга бат, хариуцлагыг хангах чухал тогтолцоонд тооцогддог. Энэхүү зохицуулалтыг улс орнууд харилцан адилгүй хэлбэрээр хэрэгжүүлж байгаа боловч нийтлэг чиг хандлага нь эдийн засгийн хөшүүрэг, ил тод байдал, улмаар улс төрийн хариуцлагын арга хэмжээг хослуулахад чиглэж байна.

Санхүүгийн хариуцлагын зохицуулалт нь парламентын гишүүний албан үүрэгтээ хандах хариуцлагыг дээшлүүлэхэд хэрэглэдэг арга хэлбэр юм. Солонгосын Үндэсний Ассамблейн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй тохиолдолд тусгай үйл ажиллагааны нэмэгдэл тэтгэмжийг тасалсан хоногийн тоотой уялдуулан суутгадаг. Францад гишүүдийн санал хураалтад оролцсон идэвхийг үндэслэн санхүүгийн хариуцлага тооцдог бөгөөд нэг чуулганы хугацаанд нийт санал хураалтын гуравны хоёроос бага хувьд оролцсон тохиолдолд албан тушаалын тэтгэмжийг гуравны нэгээр бууруулж, харин 50 хувиас бага оролцоотой бол илүү нэмэгдүүлсэн хэмжээгээр суутгах зохицуулалт үйлчилдэг. Германы Бундестагт гишүүд хуралдаан бүрийн өмнө ирцийн бүртгэлд биечлэн гарын үсэг зурах үүрэгтэй бөгөөд бүртгэлд хамрагдаагүй эсвэл нэр заасан санал хураалтад оролцоогүй тохиолдолд санхүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Мөн Италид парламентын Товчооноос баталсан журмын дагуу хуралдаан тасалсан гишүүдийн өдрийн нэмэгдэл тэтгэмжээс хасалт хийдэг байна.

Мэдээллийн ил тод байдал, олон нийтийн хяналт нь парламентын хариуцлагын тогтолцооны салшгүй хэсэг бөгөөд нэр төрийн хариуцлага хүлээлгэх үр нөлөөтэй хэрэгсэл болдог. Швейцарын Холбооны Улс (Швейцар гэх)¹⁰-д зөвлөлийн протоколд гишүүний эзгүй байсан шалтгааныг өвчин, гэр бүлийн гачигдал зэрэг нарийвчлан тэмдэглэж, санал хураалтын дүнг нэрсийн жагсаалтаар нийтлэхдээ гишүүн бүрийн ирцийн төлөвийг тодорхой харуулдаг. Австралийн Холбооны Улс (Австрали гэх)¹¹ болон Канад Улс (Канад гэх)¹²-д гишүүдийн ирц, чөлөөний мэдээллийг парламентын албан ёсны протоколд заавал тусган, олон нийтэд нээлттэй байдлаар тайлагнадаг. Үүнтэй адил Шинэ Зеланд Улсад чөлөө авалгүйгээр хуралдаан тасалсан гишүүний нэр болон тасалсан өдрийн мэдээллийг парламентын албан ёсны тэмдэглэлд тусгайлан тэмдэглэн үлдээдэг нь ил тод байдлыг хангах арга хэлбэр юм.

Гишүүд удаан хугацаагаар хуралдаанд оролцоогүй тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээлгэх, бүр цаашлаад мандатыг түдгэлзүүлэх, дуусгавар болгох хүртэл арга хэмжээ авах зохицуулалт зарим улсад хэрэгжиж байна. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (Өмнөд Африк гэх)¹³-ын Үндсэн хуулиар гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 15-аас дээш хоног хуралдаан тасалсан тохиолдолд эргүүлэн татах боломжтой. Мөн намын бүлгүүд гишүүдийн ирцийн бүртгэлийг жил бүр Спикерт хүргүүлж, албан ёсны мэдээлэлд нийтэлдэг. Энэтхэгт ирцийн хяналт тавих тусгай хороо ажилладаг бөгөөд гишүүн 60-аас дээш хоног шалтгаангүйгээр эзгүй байсан

¹⁰ Swiss Federal Assembly. (2016). *Rules governing parliamentary procedures*.

¹¹ Australian House of Representatives. (2025). *Standing and sessional orders*. Department of the House of Representatives.

¹² Canadian House of Commons. (2025). *Standing orders of the House of Commons*. Parliament of Canada.

¹³ The National Assembly of South Africa. (2016). *The Rules of the National Assembly*.

тохиолдолд уг асуудлыг хэлэлцэн, суудлыг сул орон тоо болгох хүртэл арга хэмжээ авах эрх бүхий зохицуулалттай байна.

ОУ-ын туршлагаас харахад парламентын гишүүдийн ирцийн хяналт, хариуцлагын тогтолцоо нь санхүүгийн хөшүүрэг, мэдээллийн ил тод байдал, улс төрийн хариуцлагын тогтолцооны уялдаа холбоонд тулгуурлан бүрэлддэг. Ялангуяа гишүүдийн ирцийн мэдээллийг сонгогдсон тойрог, жагсаалтын мэдээлэлтэй уялдуулан танхимын дэлгэц болон цахим орчинд нээлттэй мэдээлэх нь парламентын ёс зүй, хариуцлагын стандартыг дээшлүүлэх, улмаар төлөөллийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны шинжийг хадгалах чухал нөхцөл болж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
9 дүгээр зүйл.Хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журам	9 дүгээр зүйл.Хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журам
9.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.22, 21.23-т зааснаар хууль, тогтоолын төслийн төрөл, онцлогийг харгалзан тухайн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр Зөвлөл тогтоох ба нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.	9.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.22, 21.23-т зааснаар хууль, тогтоолын төслийн төрөл, онцлогийг харгалзан тухайн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх болон асуулт асуух хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр Зөвлөл тогтооно.
9.2.Тухайн нам, эвслийн бүлэг хуваарилагдсан хугацаанд багтаан асуулт асуух гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн байна.	9.2.Энэ хуулийн 9.1-д заасан хугацаанд багтаан гишүүд ирцэд бүртгэгдсэн дарааллын дагуу асуулт асууна.
9.3.Аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүн энэ хуулийн 9.2-т заасан журмын дагуу хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух эсэхээ урьдчилан мэдэгдэнэ.	-
9.4.Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3-т заасан журам нь энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан хууль, тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хамаарна.	9.4.Энэ хуулийн 9.1, 9.2-т заасан журам нь энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан хууль, тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хамаарна.
9.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гишүүн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуухдаа дараах журмыг баримтална:	9.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гишүүн нэгдсэн хуралдаан болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуухдаа дараах журмыг баримтална:
9.5.1.гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах; 9.5.2.хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад асуулт асуухгүй байх.	9.5.1.гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах; 9.5.2.хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад асуулт асуухгүй байх.
9.6.Гишүүний асуултад хариулах хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 1 минутаас илүүгүй байна.	9.6.Гишүүний асуултад хариулах хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 1 минутаас илүүгүй байна. Шаардлагатай бол хуралдаан даргалагч гишүүний асуултад бүрэн хариулт өгөх, бусад албан

	тушаалтнаас хариулт авах зорилгоор нэмэлт тайлбар өгөх хугацааг нэмж өгч болно.
	9.7.Нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд гишүүн хүсэлт гаргасан бол энэ хуулийн 9.5.1, 9.6-д заасан үндсэн хугацааны нийлбэр 8 минутад багтаан харилцан ярилцлагын хэлбэрээр хэдэн ч удаа асуулт асууж, хариулт авч болох бөгөөд нэмэлт асуулт асууж, хариулт авахгүй. Гишүүний нэг удаагийн асуулт, эсхүл хариултын үргэлжлэх хугацаа 4 минутаас ихгүй байна.
9.7.Гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх /цаашид "үг хэлэх" гэх/ хугацаа 4 минутаас илүүгүй байна.	9.8.Гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх /цаашид "үг хэлэх" гэх/ хугацаа 4 минутаас илүүгүй байна.
9.8.Тодорхой асуудлыг хэлэлцэхэд энэ хуулийн 9.5.1, 9.6, 9.7-д зааснаас өөр хугацаа заасан бол тусгайлан заасан хугацааг баримтална.	9.9.Тодорхой асуудлыг хэлэлцэхэд энэ хуулийн 9.5.1, 9.6, 9.8-д зааснаас өөр хугацаа заасан бол тусгайлан заасан хугацааг баримтална.
9.9.Хуралдаан даргалагч урьдчилан мэдэгдэж, дараалалд орсон гишүүдийн нэрсийн дагуу асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх ба асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрс ирцэд бүртгэгдсэн дарааллаар эрэмбэлэгдэнэ. Хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөхийн өмнө энэ зүйлд заасан журмыг баримтлахыг сануулна.	9.10.Хуралдаан даргалагч дараалалд орсон гишүүдийн нэрсийн дагуу асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх ба асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрс ирцэд бүртгэгдсэн дарааллаар эрэмбэлэгдэнэ. Хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөхийн өмнө энэ зүйлд заасан журмыг баримтлахыг сануулна.
9.10.Гишүүн зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлж үг хэлнэ.	9.11.Гишүүн зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлж үг хэлнэ.
9.11.Гишүүн асуулт асуух, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэхийг хориглоно.	9.12.Гишүүн асуулт асуух, үг хэлэхдээ бусдын нэр төрийг нь гутаах, гүтгэх, бусад гишүүн үг хэлж байхад зэрэгцэн үг хэлэх, саад учруулахыг хориглоно.
9.12.Гишүүн үнэн, бодитой, судалгаанд суурилсан мэдээлэлд тулгуурлаж үг хэлнэ.	9.13.Гишүүн үнэн, бодитой, судалгаанд суурилсан мэдээлэлд тулгуурлаж үг хэлнэ.
9.13.Гишүүн асуулт асуух, үг хэлэх эрхээ бусад гишүүнд шилжүүлэхгүй.	9.14.Гишүүн асуулт асуух, үг хэлэх эрхээ бусад гишүүнд шилжүүлэхгүй.
9.14.Хууль, тогтоолын төсөл хэлэлцэхэд гишүүний асуултад хууль санаачлагч хариулж тайлбар хийнэ.	9.15.Хууль, тогтоолын төсөл хэлэлцэхэд гишүүний асуултад хууль санаачлагч хариулж тайлбар хийнэ.
9.15.Хууль, тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон, түүнчлэн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон уригдаж ирсэн хүн хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр тайлбар хийж, асуултад хариулна.	9.16.Хууль, тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон, түүнчлэн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон уригдаж ирсэн хүн хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр тайлбар хийж, асуултад хариулна.
9.16.Тайлбар хийж, асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, асуултад товч, тодорхой хариулах үүрэгтэй бөгөөд гишүүн хариултыг хангалтгүй, эргэлзээтэй гэж үзвэл тухайн асуултын хариуг 2 хоногийн дотор бичгээр өгөхийг шаардах эрхтэй.	9.17.Тайлбар хийж, асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, асуултад товч, тодорхой хариулах үүрэгтэй бөгөөд гишүүн хариултыг хангалтгүй, эргэлзээтэй гэж үзвэл тухайн асуултын хариуг 2 хоногийн дотор бичгээр өгөхийг шаардах эрхтэй.
9.17.Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэдээлэл, санал, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт, Улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт,	9.18.Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэдээлэл, санал, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт, гүйцэтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар

<p>гүйцэтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд болон энэ хуульд хэлэлцэх дэгийг тусгайлан зохицуулсан бусад асуудлыг хэлэлцэх үед гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй.</p> <p>/Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</p>	<p>хэлэлцэхэд болон энэ хуульд хэлэлцэх дэгийг тусгайлан зохицуулсан бусад асуудлыг хэлэлцэх үед гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй.</p>
---	--

Тайлбар: Гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд асуулт асуух хугацааг зохицуулаагүй зарим хэсэгт нийтлэг хугацааг дагаж мөрдөхөөр тодруулж тусгана. Нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилахаар заасан. Энэ зохицуулалтад өөрчлөлт оруулж нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилж, урьдчилан нэр авахгүйгээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх Зөвлөлийн тогтоосон хугацаанд багтаан зохион байгуулна.

Гишүүн асуулт асуух, үг хэлэхдээ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуудлаар асуулт асуух, үг хэлэхийг хориглохоор тусгана.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 2024	Төслийн заалт
<p>10 дугаар зүйл.Санал хураалт явуулах ерөнхий журам</p> <p>10.1.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар санал хураалтыг нууцаар явуулна.</p> <p>10.2.Ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж, нууц санал хураалтыг цахимаар, эсхүл санал хураах хуудсаар явуулна.</p> <p>10.3.Санал хураалтыг цахимаар явуулахад биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр идэвхжих цахим систем ашиглана.</p> <p>10.4.Ил санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна.</p> <p>10.5.Гар өргөж явуулсан ил санал хураалтын дүнг хуралдаан даргалагч нэгтгэн зарлана.</p> <p>10.6.Нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг тооллогын комисс боловсруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.</p> <p>10.7.Нууц санал хураалтыг цахимаар явуулахад санал өгсөн гишүүдийн нэрс хуралдааны цахим системд хадгалагдахгүй.</p> <p>10.8.Гишүүн санал хураалтад оролцохдоо “зөвшөөрсөн”, эсхүл “татгалзсан” саналын аль нэгийг өгнө.</p>	<p>10 дугаар зүйл.Санал хураалт явуулах</p> <p>10.1.Хуралдаанд гишүүдийн олонх биечлэн оролцсон тохиолдолд санал хураалт явуулах бөгөөд санал хураалт явуулахын өмнө танхимд байхгүй гишүүнийг санал хураалтын бүртгэлээс хасна.</p> <p>10.2.Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>10.3.Санал хураалт явуулахын өмнө хуралдааны танхимд биечлэн ирсэн гишүүдийн тоог бүртгэх бөгөөд тухайн бүртгэлээс санал хураалтын дүнг гаргана.</p> <p>10.4.Хуралдааны танхимд гишүүдийн олонх биечлэн ирээгүй тохиолдолд санал хураалтыг хойшлуулна.</p> <p>10.5.Санал хураалт эхэлснээс хойш хуралдааны танхимыг орхин гарахыг хориглоно.</p> <p>10.6.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусад гишүүнд шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.</p> <p>10.7.Гишүүн санал хураалтад оролцохдоо “зөвшөөрсөн”, эсхүл “татгалзсан” саналын аль нэгийг өгнө.</p> <p>10.8.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд заасан бол, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар санал хураалтыг нууцаар явуулна.</p> <p>10.9.Ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж, нууц санал хураалтыг цахимаар, эсхүл санал хураах хуудсаар явуулна.</p>

<p>10.9.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусад гишүүнд шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.</p> <p>10.10.Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.</p> <p>10.11.Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан /картаа сугалсан/ бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно.</p> <p>10.12.Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.</p> <p>10.13.Нууц санал хураалт явуулахад энэ хуулийн 10.11 дэх хэсэг хамаарахгүй.</p>	<p>10.10.Санал хураалтыг цахимаар явуулахад биеийн давхцахгүй өгөгдлөөр идэвхжих цахим систем ашиглана.</p> <p>10.11.Ил санал хураалтыг цахимаар явуулахад санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд гар өргөж санал хураалтыг явуулна. Энэ тохиолдолд дэмжсэн, дэмжээгүй гишүүн бүрийн нэрээр дуудаж хуралдааны тэмдэглэлд тусгуулж, нэгтгэсэн дүнг зарлана.</p> <p>10.12.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.3-д заасан ашиг сонирхлын зөрчил үүсэх бол гишүүн хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.</p> <p>10.13.Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.</p> <p>10.14.Нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулахаас 10 минутын өмнө 1 минутын турш санал хураалтын хонх дуугаргана.</p> <p>10.15.Энэ хуулийн 10.14-т заасан санал хураалтын хонх дуугарсан бол гишүүд нэгдсэн хуралдааны танхимд хүрэлцэн ирж санал хураалтад оролцох үүрэг хүлээнэ.</p> <p>10.16.Нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд санал өгсөн гишүүдийн нэрс хуралдааны цахим системд хадгалагдахгүй.</p> <p>10.17.Нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг тооллогын комисс боловсруулж, комиссын гишүүдийн олонхын саналаар батална.</p>
--	--

Тайлбар: Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд бүрдсэн ирц санал хураалт явуулахаас бусад тохиолдолд хүчинтэй хэвээр тооцогдоно.

Тухайн өдрийн ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн, эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан /картаа сугалсан/ бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцох одоогийн зохицуулалтыг хасна.

Хуралдаан даргалагч санал хураалт явуулахаас 10 минутын өмнө 1 минутын турш санал хураалтын хонх дуугаргах бөгөөд хонх дуугарснаас хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр санал хураалтад ирээгүй гишүүнийг санал хураалтын бүртгэлээс хасна. Санал хураалт явуулахын өмнө хуралдааны танхимд байгаа гишүүдийн тоог бүртгэж, тухайн бүртгэлээс санал хураалтын дүнг гаргана. Хуралдаанд гишүүдийн олонх оролцоогүй тохиолдолд санал хураалтыг хойшлуулна. Санал хураалт эхэлснээс хойш хуралдааны танхимыг орхин гарахыг хориглоно. Санал хураалтын өмнө хонх буюу анхааруулга өгөх, санал хураалтын явцад хуралдааны танхимыг орхин гарахыг хориглох нь гишүүд санал хураалтад хариуцлагатай оролцох, санал хураалтад оролцоогүй бол хүллээлгэх хариуцлагатай мөн холбогдоно.

Хуульд ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж явуулахаар тусгасан. Гар өргөж санал хураалт явуулах бол гишүүн тухайн асуудлыг дэмжиж байгаа, үгүйг тодорхой илэрхийлдэг

байх шаардлагатай тул хэрэв гар өргөж санал хураалт явуулах бол гишүүн бүрийн нэрээр дуудаж саналыг авч, хуралдаан даргалагч дүнг зарлана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын шийдвэр гаргах үйл явц дахь санал хураалтын үр нөлөө, ил тод байдал нь зохион байгуулалтын болон техникийн нарийн зохицуулалтаас шууд хамааралтай байдаг. ОУ-ын парламентын практик туршлагаас үзэхэд санал хураалтын үйл явцыг боловсронгуй болгох чиг хандлага нь технологийн дэвшил, хариуцлага, ил тод байдлын зарчимд тулгуурлан хөгжиж байна.

Санал хураалтын хэлбэр болон түүний бэлтгэл ажиллагаа нь үйл явцын чанарт чухал нөлөө үзүүлдэг. ОУ-ын парламентууд цахим санал хураалтын системийг ил болон нууц хэлбэрээр өргөн ашиглаж, үйл явцын найдвартай байдал, баталгаажуулалтыг сайжруулж байна. Финланд¹⁴, Швейцарын парламент нь цахим систем нь санал хураалтын дүнг автоматаар тооцоолох, мэдээллийг системтэйгээр архивлах, улмаар үр дүнг танхимын дэлгэцээр шууд дамжуулах боломжийг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ, санал хураалтын томъёоллыг хуралдаан даргалагч урьдчилан уншиж танилцуулах нь үйл ажиллагааны алдаа гаргах эрсдэлийг бууруулах чухал нөхцөл болдог бөгөөд Австрали, Швейцарын туршлага үүнийг нотолж байна.

Нууц санал хураалтын хувьд аюулгүй байдлыг хангах асуудал онцгой ач холбогдолтой. Оросын Төрийн Думын практикт цахим системийг ашиглахдаа гишүүний өгсөн саналын мэдээллийг системийн санах ойд хадгалахгүй байх техникийн шийдлийг хэрэгжүүлдэг. Энэ нь санал хураалтын нууцлалыг баталгаажуулж, парламентын гишүүд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах үндсэн нөхцөл болдог.

Мөн санал хураалтын үйл явц дахь ирц бүрдүүлэлт, цаг хугацааны менежмент нь зохион байгуулалтын чухал бүрдэл юм. Ихэнх улс оронд санал хураалтын өмнө гишүүдийг танхимд цуглуулах, ирцийг эцэслэн тогтоох үйл явцыг тодорхой хугацааны хязгаарт багтаан хэрэгжүүлдэг. Үүнтэй холбоотойгоор хонх буюу дуут дохионы хугацаа улс орон бүрд харилцан адилгүй бөгөөд Австралид нэг минут орчим, Канад улсад гуч хүртэл минут үргэлжлэх жишээтэй. Түүнчлэн, зарим улсын парламент (Австрали, Япон¹⁵) дуут дохио өгснөөс хойш танхимын хаалгыг хааж, гишүүдийн орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах замаар санал хураалтын ирцийг бодитой тогтоох, сахилга хариуцлагыг хангах зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

Хариуцлагын ил тод байдлыг хангах үүднээс гишүүдийн ирцийн мэдээллийг нарийвчлан бүртгэх, олон нийтэд нээлттэй мэдээлэх нь орчин үеийн сайн засаглалын чухал шалгуур болж байна. Швейцарын парламент гишүүдийн ирцийг “тийм”, “үгүй”, “түдгэлзсэн”, “оролцоогүй”, “чөлөөтэй” гэсэн таван ангиллаар бүртгэж, эзгүй байсан шалтгааныг протоколд тусгайлан тэмдэглэдэг. Улмаар энэхүү мэдээллийг гишүүдийн сонгогдсон тойрогтой нь холбоотойгоор дэлгэц болон цахим хуудсаар нийтэд мэдээлэх нь улс төрийн хариуцлагыг бэхжүүлэх арга хэрэгсэл болж байна.

Санал өгөх бүрэн эрхийн хэрэгжилтийн хувьд олон улс оронд гишүүд саналаа биечлэн өгөх зарчмыг чанд мөрддөг. Япон, Эстони, Орос¹⁶ зэрэг улсад гишүүн зөвхөн өөрийн биеэр санал өгөх үүрэгтэй бөгөөд санал хураалтын дараа нөхөн санал өгөх боломжгүй байдаг. Гэсэн хэдий ч зарим улс оронд хүний эрх, нийгмийн хэрэгцээг харгалзан уян хатан зохицуулалтыг нэвтрүүлсэн байна. Их Британи, Австралид хүүхэд асарч буй эцэг, эхчүүдэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санал өгөх боломж олгосон нь жендэрийн мэдрэмжтэй, дэвшилтэт зохицуулалт байна.

ОУ-ын парламентын дэгийн туршлагаас харахад санал хураалтын үйл явц нь нэг талаас техникийн найдвартай байдал, нөгөө талаас олон нийтийн хяналт, ил тод байдлын зарчимд тулгуурлан хэрэгжих шаардлагатай байна. Ирцийн мэдээллийг сонгогчдод нээлттэй, ойлгомжтой байдлаар хүргэх, нууц санал хураалтын аюулгүй байдлыг цахим түвшинд баталгаажуулах зэрэг

¹⁴ Parliament of Finland/Eduskunta. (1999 [2023]). *Parliament's rules of procedure*.

¹⁵ Japanese House of Councillors. (n.d.). *Rules of the House of Councillors*. National Diet of Japan.

¹⁶ The State Duma of the Russian Federation. (1998 [2023]). *Reglament of the State Duma of the Federal Assembly of the Russian Federation*.

арга хэмжээ нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, ардчилсан засаглалын чанарыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>11 дүгээр зүйл.Мэтгэлцээн явуулах ерөнхий журам</p> <p>11.1.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.21-д заасны дагуу хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн үе шатанд мэтгэлцээн явуулах тохиолдолд энэ зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.</p>	<p>11 дүгээр зүйл.Мэтгэлцээн явуулах ерөнхий журам</p> <p>11.1.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.20, 21.21-д заасны дагуу хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн үе шатанд мэтгэлцээн явуулах тохиолдолд энэ зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.</p>
	<p>11.8.Байнгын хороо хууль, тогтоолын төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг явуулах хуралдааны явцад гишүүн горимын санал гаргаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуралдаан даргалагч төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хүрээнд энэ хуулийн 11.4, 11.5-д заасан журмыг баримтлахгүйгээр чөлөөт мэтгэлцээн зохион байгуулна.</p> <p>11.9.Хуралдаан даргалагч энэ хуулийн 11.8-д заасны дагуу зохион байгуулах мэтгэлцээний хугацааг 60 минутаас илүүгүй байхаар тогтоох бөгөөд гишүүд зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан санал гаргасан гишүүн, ажлын хэсэг, хууль санаачлагчаас асуулт асуух, тайлбар авах, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж олгоно. Мэтгэлцээн дуусмагц хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.</p>

Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд мэтгэлцээн явуулах талаар зохицуулалт тусгагдсан бөгөөд энэ нь хуулийн төслийн хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлгийн шатанд нам, эвслийн бүлэг өмнөх өдөр нь мэдэгдэж, Байнгын хорооны хуралдаан дээр илтгэгч гишүүн томилж, санал, дүгнэлт танилцуулах хэлбэрээр зохион байгуулахаар тусгасан байна. Төсөлд хуулийн төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийн шатанд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан мэтгэлцээн явуулах горимын санал гарч дэмжигдсэн бол Байнгын хорооны хуралдааны явцад 1 цагийн хугацаанд мэтгэлцээн зохион байгуулж болохоор тусгана. Энэ зохицуулалтад нам, эвслийн бүлэг илтгэгч гишүүн томилох, санал, дүгнэлт танилцуулахгүйгээр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан санал гаргасан гишүүн, ажлын хэсэг, хууль санаачлагчаас асуулт асуух, тайлбар авах, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж олгоно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Байнгын хорооны хэлэлцүүлгийн шатанд хууль тогтоомжийн төслийн тодорхой зүйл, заалтаар хугацаатай “тусгай мэтгэлцээн” явуулах нь парламентын хэлэлцүүлгийг илүү төвлөрсөн, үр нөлөөтэй болгох нийтлэг тогтолцоо юм. ОУ-ын парламентын практикт энэ төрлийн мэтгэлцээнийг тодорхой хугацааны хязгаарлалттай зохион байгуулж, асуулт хариулт, тайлбар авах боломжийг гишүүдэд олгох замаар бодлогын хэлэлцүүлж байна.

Мэтгэлцээний хугацааг нарийвчлан тогтоох нь парламентын цаг хугацааны нөөцийг үр ашигтай ашиглах үндсэн хэрэгсэл болдог. Германы Бундестагт нийтийн ашиг сонирхлыг хөндсөн “цаг үеийн асуудлаарх мэтгэлцээн” ихдээ 1 цаг буюу 60 минут үргэлжилдэг бөгөөд ЗГ-ын гишүүдийн үг хэлэх хугацаа нэмэгдсэн тохиолдолд мэтгэлцээнийг тодорхой хугацаагаар сунгах

боломжтой байдаг. Энэ нь хэлэлцүүлгийг тодорхой цагийн хүрээнд төвлөрүүлэхийн зэрэгцээ шаардлагатай үед уян хатан зохицуулах боломжийг олгодог. Солонгост хорооны хуралдаанд үг хэлэхийг хүссэн хоёр ба түүнээс дээш гишүүн байгаа тохиолдолд хорооны дарга үг хэлэх хугацааг тэнцүү хуваарилж, нэг гишүүнд 15 минутаас илүүгүй хугацааг олгодог. Харин Энэтхэгийн “Богино хугацааны хэлэлцүүлэг” хоёр цагаас хэтрэхгүй хугацаанд үргэлжилдэг байна.

Хуулийн төслийг зүйл, заалт бүрээр нарийвчлан хэлэлцэх практик нь ОУ-ын парламентын нийтлэг жишигт тооцогдож байна. Шинэ Зеландын парламентын “Танхимын нийт хороо”-ны шатанд хуулийн төслийг хэсэг, зүйл бүрээр авч хэлэлцдэг бөгөөд гишүүн бүр тухайн заалттай холбогдуулан 5 хүртэл минутын хугацаанд хэд хэдэн удаа үг хэлэх эрхтэй байдаг. Солонгосын парламент төслийн үзэл баримтлалын ерөнхий хэлэлцүүлгийг гүйцэтгэж, санаачлагчаас асуулт асууж, хариулт авсны дараа зүйл, заалт бүрээр нь нарийвчлан хэлэлцэж санал хураалт явуулдаг. Германы Бундестагт хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр төслийг зүйл бүрээр нь дарааллын дагуу авч үзэн, зүйл тус бүрийн дараа санал хураалт явуулах зохицуулалт үйлчилдэг.

Мэтгэлцээний явцад асуулт асуух, тодруулга авах тогтолцоог нарийвчлан зохицуулсан байдаг нь хэлэлцүүлгийн чанарыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Эстонийн Рийгикогууд хуулийн төслийн нэг болон хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр гишүүн бүр илтгэгчээс 2 хүртэл аман асуулт асуух эрхтэй байдаг. Канадын парламент 20 минутын илтгэлийн дараа тухайн асуудлаар асуулт асуух, товч тайлбар хийх, хариу авах зориулалттай 10 минутын хугацааг заавал олгодог. Австралид мэтгэлцээний явцад “хөндлөнгөөс оролцох” хүсэлт гарган, зөвшөөрөл авсан тохиолдолд 30 секундийн дотор асуулт эсвэл тодруулга хийх боломжтой байдаг бол Норвегт илтгэлийн үеэр гарсан ойлгомжгүй байдлыг тодруулах зорилгоор нэг минутын “хөндлөнгийн” үг хэлэхийг хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр олгодог.

Мөн тодорхой төрлийн мэтгэлцээнд ердийн дэгийн зарим хязгаарлалтыг хэрэглэхгүй байх тусгай горим ОУ-д нийтлэг хэрэглэгддэг. Канад, Герман зэрэг улсын парламентын практикт “цаг үеийн” эсвэл “яаралтай” мэтгэлцээнд ердийн ажиллагааны журмаар гүйцэтгэх боломжгүй бөгөөд хугацаа, хэлэлцэх хүрээ, санал гаргах журамд тусгай зохицуулалт хэрэглэдэг. Германд цаг үеийн мэтгэлцээний үеэр шийдвэрийн төсөл хэлэлцэхгүй, зөвхөн байр суурь илэрхийлэх зорилготой мэтгэлцээн явуулдаг нь асуудлыг улс төрийн түвшинд шуурхай авч үзэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Байнгын хорооны шатанд тодорхой зүйл, заалтаар хугацаатай тусгай мэтгэлцээн явуулах, асуулт хариулт, тайлбар авах боломжийг нээлттэй үлдээх зохицуулалт нь ОУ-ын парламентын дэгийн сайн туршлага болдог бөгөөд энэ тогтолцоогоор хэлэлцүүлгийг илүү төвлөрсөн, үр ашигтай болгохын зэрэгцээ парламентын бодлогын мэтгэлцээний чанар, гишүүдийн хяналтын боломжийг бодитой нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>13 дугаар зүйл.Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг</p> <p>13.1.Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>13.1.5.энэ хуулийн 9.15-д заасан этгээдэд гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх зөвшөөрөл өгөх;</p>	<p>13 дугаар зүйл.Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг</p> <p>13.1.Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>13.1.5.энэ хуулийн 9.16-д заасан этгээдэд гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх зөвшөөрөл өгөх;</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
14 дүгээр зүйл.Хуралдааны дэг сахиулах	14 дүгээр зүйл.Хуралдааны дэг сахиулах

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан шаардлагыг гишүүн биелүүлээгүй бол хуралдаан даргалагч түүнд энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	14.3.Энэ хуулийн 14.2-т заасан шаардлагыг гишүүн биелүүлээгүй бол хуралдаан даргалагч, эсхүл Ёс зүйн дэд хороо түүнд энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
--	---

Тайлбар: Хуралдааны дэг сахиулахтай холбоотойгоор хуралдаан даргалагчаас гадна Ёс зүйн дэд хороо тус хуульд заасан хариуцлагыг гишүүнд хүлээлгэхээр тусгана. Хуралдаан даргалагч, эсхүл Ёс зүйн дэд хороо ямар хариуцлагыг хүлээлгэх тухай 15 дугаар зүйлд ялган тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын хуралдааны дэг журам, гишүүдийн сахилга батыг хангах асуудал нь хууль тогтоох үйл ажиллагааны легитим шинж чанарыг хадгалах, институцийн нэр хүндийг хамгаалах засаглалын үндсэн хэрэгсэл болдог. ОУ-ын парламентуудын дэгийн шилдэг туршлагаас үзэхэд сахилгын арга хэмжээг шат дараалсан, үр нөлөө бүхий тогтолцооны хүрээнд хэрэгжүүлэх нь нийтлэг хандлага болж байна.

Хуралдаан даргалагч буюу спикер нь танхимын хэвийн үйл ажиллагааг хангах онцгой байр суурь, бүрэн эрх эдэлдэг. Спикер дэгийн асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрхтэй бөгөөд гишүүд түүний заавар, шийдвэрийг дагаж мөрдөх нь эрх зүйн болон ёс зүйн үүрэгт тооцогддог. Парламентын соёлын хувьд хуралдаан даргалагч босох үед танхимд чимээгүй байдал тогтож, гишүүд суудлаа эзлэх нь дэг журмыг хүндэтгэх илэрхийлэл болдог.

Парламент нь нээлттэй институци боловч хуралдаанд оролцож буй зочид, төлөөлөгчдийн хувьд тодорхой дэг журам үйлчилдэг. ОУ-ын практикт зочид танхимын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, үзэл бодлоо илэрхийлэхийг хатуу хориглодог бөгөөд алга таших, дуу чимээ гаргах зэрэг үйлдэл гаргасан тохиолдолд танхимаас болон парламентын ордны нутаг дэвсгэрээс албадан гаргах зохицуулалт үйлчилдэг.

Онцгой нөхцөл байдалд буюу танхимд ноцтой эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд спикер шуурхай арга хэмжээ авах бүрэн эрхтэй. Үүнд хуралдааныг түр завсарлуулах эсвэл бүрэн зогсоох шийдвэр багтдаг. Зарим улсын парламентын уламжлалд бэлгэдлийн шинжтэй зохицуулалт ч бий. Шинэ Зеландын парламентын практикт “Мэйс” буюу парламентын эрх мэдлийн бэлгэдлийг танхимын ширээнээс авах нь тухайн хуралдааны эрх зүйн чадамжийг зогсоосон гэж үзэх уламжлалтай.

ОУ-ын парламентын дэгийн шилдэг туршлагаас харахад хуралдааны дэг сахиулах тогтолцоо нь нэг талаас спикерийн шууд зохицуулах бүрэн эрх, нөгөө талаас Ёс зүйн хорооны хяналт гэсэн хоёр тулгуурын тэнцвэрт байдал дээр суурилдаг. Энэхүү зохицуулалт нь хууль тогтоох үйл ажиллагааг эмх замбараагүй байдлаас хамгаалж, парламентын засаглалын хэвийн, тогтвортой үйл ажиллагааг хангах үндсэн баталгаа болдог.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>15 дугаар зүйл.Хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлага</p> <p>15.1.Гишүүн хуралдааны дэг зөрчсөн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:</p> <p>15.1.1.сануулах;</p> <p>15.1.2.хуралдаанд үг хэлэх эрхийг хасах;</p> <p>15.1.3.хуралдааныг орхин гарахыг үүрэг болгох;</p> <p>15.1.4.хуралдаанд оролцох эрхийг хасах.</p>	<p>15 дугаар зүйл.Хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлага</p> <p>15.1.Гишүүн хуралдааны дэг зөрчсөн бол хуралдаан даргалагч, эсхүл Ёс зүйн дэд хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>15.2.Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуулт асуух, үг хэлэх, зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүний үгийг тасалж, сануулах арга хэмжээ авч хуралдааны тэмдэглэлд тусгана.</p> <p>15.3.Гишүүн энэ хуулийн 15.2-т заасан сануулгыг биелүүлээгүй бол хуралдаан даргалагч гишүүний үг</p>

<p>15.2.Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуулт асуух, үг хэлэх, зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүний үгийг тасалж, эхний удаа сануулж, дараагийн авах арга хэмжээний талаар анхааруулна.</p> <p>15.3.Гишүүн эхний удаа өгсөн сануулгыг биелүүлээгүй бол хуралдаан даргалагч гишүүний үг хэлэх эрхийг хасаж, тухайн асуудлын хэлэлцүүлгийн явцад дахин үг хэлэх эрх олгохгүй.</p>	<p>хэлэх эрхийг хасаж, тухайн асуудлын хэлэлцүүлгийн явцад дахин үг хэлэх эрх олгохгүй.</p>
<p>15.4.Гишүүн бусдад саад учруулсан, асуулт асуух, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэсэн шинжтэй үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүнд урьдчилан сануулахгүйгээр тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасна.</p>	<p>15.4.Хуралдаан даргалагч дараах тохиолдолд гишүүний тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасна:</p> <p>15.4.1.гишүүн бусдад саад учруулсан, асуулт асуух, үг хэлэхдээ бусдын нэр төрийг гутаах, гүтгэсэн шинжтэй үг хэлсэн;</p> <p>15.4.2.гишүүн хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахихыг сануулсан шаардлагыг үл биелүүлж, бусад гишүүний асуулт асуух, үг хэлэх, саналаа өгөх эрхэд саад учруулах зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн.</p>
<p>15.5.Гишүүн хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахихыг сануулсан шаардлагыг үл биелүүлж, бусад гишүүний асуулт асуух, үг хэлэх, саналаа өгөх эрхэд саад учруулах зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн бол түүнийг тухайн асуудлыг хэлэлцэж дуустал хуралдаанаас гаргана.</p> <p>15.6.Энэ хуулийн 15.5-д заасан хариуцлага хүлээсэн гишүүн хуралдааныг нэн даруй орхин гарах үүрэгтэй бөгөөд гишүүн хуралдааны танхимыг ийнхүү орхин гараагүй нь тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасах хариуцлага оногдуулах үндэслэл болно.</p>	
<p>15.7.Энэ хуулийн 15.6-д заасны дагуу тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүн Улсын Их Хурлын болон гишүүний нэр хүндийг гутаан доромжилсон, эмх замбараагүй байдал үүсгэсэн болон бусад хэлбэрээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хуралдаан даргалагч тухайн зөрчилтэй нь холбогдуулан уг гишүүний хуралдаанд оролцох эрхийг 3 хүртэл удаа хасаж болно.</p>	<p>15.7.Энэ хуулийн 15.3, 15.4-т заасны дагуу үг хэлэх эрхээ хасуулсан гишүүн Улсын Их Хурлын болон гишүүний нэр хүндийг гутаан доромжилсон, эмх замбараагүй байдал үүсгэсэн болон бусад хэлбэрээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол Ёс зүйн дэд хороо тухайн зөрчилтэй нь холбогдуулан гишүүний асуулт асуух, үг хэлэх эрхийг 30 хүртэл хоногоор хасна.</p>
<p>15.8.Зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэсэн хариуцлага нь нэгдсэн болон тухайн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хамаарна.</p>	<p>15.8.Энэ хуулийн 15.2, 15.3, 15.4, 15.7-д заасан зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэсэн хариуцлага нь нэгдсэн болон тухайн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хамаарна.</p>
<p>15.9.Гишүүн энэ хуулийн 15.1.4-т заасны дагуу хуралдаанд оролцох эрхээ хасуулсан тохиолдолд ирцийн бүртгэлээс хасна.</p>	
<p>15.10.Гишүүн энэ хуулийн 15.1-д заасан зөрчлийг удаа дараа давтан гаргасан бол тухайн асуудлыг</p>	<p>15.10.Гишүүн энэ хуулийн 15.2, 15.3, 15.4, 15.7-д заасан зөрчлийг тухайн жилд 3 ба түүнээс дээш</p>

<p>Төрийн байгуулалтын байнгын хороо авч хэлэлцэн санал, дүгнэлт гаргана.</p>	<p>удаа гаргасан бол тухайн асуудлыг Ёс зүйн дэд хороо хянан шийдвэрлэх бөгөөд гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах хариуцлага хүлээлгэнэ.</p>
<p>-</p>	<p>15.11.Ёс зүйн дэд хороо гишүүнд дараах тохиолдолд гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн зардлаас бусад гишүүний төсвийн нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлага хүлээлгэнэ:</p> <p>15.11.1.гишүүн энэ хуулийн 7.3, 7.5, 10.12-т зааснаас бусад тохиолдолд нэг сарын хугацааны нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд оролцоогүй;</p> <p>15.11.2.гишүүн ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн, эсхүл харьяалагдах Байнгын хорооны, эсхүл дэд хорооны хуралдаанд 5 ба түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй.</p> <p>15.12.Энэ хуулийн 15.19-д заасан мэдээлэлд үндэслэн Ёс зүйн дэд хороо энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-т заасан асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, гишүүнд хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>15.13.Энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-д заасан хариуцлага хүлээлгэсэн тухай Ёс зүйн дэд хороо тухайн гишүүнд, гишүүний харьяалагдах нам, эвслийн бүлэгт болон Улсын Их Хурлын даргад даруй мэдэгдэнэ.</p> <p>15.14.Энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-д заасан хариуцлага хүлээлгэсэн Ёс зүйн дэд хорооны шийдвэрийг гишүүн эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш холбогдох баримт, нотолгооны хамт ажлын 3 өдрийн дотор Ёс зүйн дэд хороонд уг шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргаж болно. Ёс зүйн дэд хороо дахин нэг удаа хянан хэлэлцэж, өмнөх шийдвэрийг өөрчлөх, хэвээр үлдээх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана.</p> <p>15.15.Ёс зүйн дэд хороо гишүүнд энэ хуулийн 15.7, 15.10, 15.11-д заасан хариуцлага хүлээлгэсэн талаар нэгдсэн хуралдаанд тухай бүрд мэдээлнэ.</p> <p>15.16.Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоёр ба түүнээс дээш удаа хуралдаанд биечлэн оролцоогүй бол ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс хасах тухай ажлын хэсгийн ахлагчийн ирүүлсэн саналыг ажлын хэсгийг Байнгын хорооноос байгуулсан бол тухайн хорооны хуралдаанд, Улсын Их Хурлын даргын</p>

	<p>захирамжаар байгуулсан бол нэгдсэн хуралдаанд танилцуулснаар хасагдсанд тооцно.</p> <p>15.17.Гишүүн хянан шалгах түр хорооны хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гурав ба түүнээс дээш удаа оролцоогүй бол түүнийг түр хорооны бүрэлдэхүүнээс хасах тухай түр хорооны даргын саналыг хуралдаан даргалагч нэгдсэн хуралдаанд танилцуулснаар тухайн түр хорооны бүрэлдэхүүнээс хасагдсанд тооцно.</p> <p>15.18.Энэ хуулийн 15.16, 15.17-д заасан үндэслэлээр гишүүнийг ажлын хэсгийн болон хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс хассан бол шийдвэр гаргахгүй.</p> <p>15.19.Тамгын газар гишүүний тухайн долоо хоногийн нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдал болон хуралдааны явцад гишүүнд энэ зүйлд заасан хариуцлага хүлээлгэсэн тухай мэдээллийг Ёс зүйн дэд хороонд дараа долоо хоногийн ажлын эхний өдөрт багтаан тус тус хүргүүлнэ.</p>
--	--

Тайлбар: Гишүүн хуралдааны явцад дэг зөрчсөн тохиолдолд сануулах, хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрхийг хасах хариуцлагыг хуралдаан даргалагч оногдуулна. Ингэхдээ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуулт асуух, үг хэлэх тохиолдолд сануулах, гишүүн бусдад саад учруулсан, асуулт асуух, үг хэлэхдээ бусдын нэр төрийг гутаах, гүтгэсэн шинжтэй үг хэлсэн, түүнчлэн хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахихыг сануулсан шаардлагыг үл биелүүлж, бусад гишүүний асуулт асуух, үг хэлэх, саналаа өгөх эрхэд саад учруулах зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн бол хурал үг хэлэх эрхийг хасах хариуцлага хүлээлгэнэ.

Ёс зүйн дэд хороо дээрх зөрчлийг давтан гаргавал цалинг тодорхой хувиар бууруулах хариуцлага хүлээлгэнэ. Хуралдааныг удаа дараа тасалсан, ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн, эсхүл харьяалагдах Байнгын хорооны, эсхүл дэд хорооны хуралдаанд 5 ба түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, нэг сарын хугацааны нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд нь оролцоогүй бол Ёс зүйн дэд хороо гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн зардлаас бусад гишүүний төсвийн нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлага хүлээлгэнэ.

Гишүүн ажлын хэсгийн хуралдаанд хоёр ба түүнээс дээш удаа биечлэн оролцоогүй, түр хорооны хуралдаанд 3 ба түүнээс дээш удаа оролцоогүй бол бүрэлдэхүүнээс нь хасах зохицуулалтыг нэмж тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын гишүүдийн хуралдааны дэг, ёс зүйн хэм хэмжээг сахиулах нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны легитим шинж чанарыг хадгалах, улмаар нийгмийн итгэлийг бэхжүүлэх үндсэн нөхцөл болдог. ОУ-ын туршлагад тулгуурлан сахилгын хариуцлагын тогтолцоог шаталсан, олон талт тогтолцооны хүрээнд хэрэгжүүлж байгааг дараах байдлаар ангилан дүгнэж болно.

Сахилгын арга хэмжээ нь зөрчлийн шинж, давтамжаас хамааран шаталсан байдлаар хэрэгждэг. Харьцангуй хөнгөн зөрчлийн үед гишүүнд сануулга өгөх, үг хэлэх эрхийг хязгаарлах арга хэмжээ авдаг. Хэлэлцэж буй асуудлаас хазайх, бусдын үгийг тасалдуулах зэрэг тохиолдолд тодорхой тооны сануулга авсны дараа Германы Бундестагт гурван удаа үг хэлэх эрхийг нь хасах зохицуулалт үйлчилдэг. Харин зөрчил давтагдах, эсхүл ноцтой шинжтэй бол спикер гишүүнийг тухайн өдрийн хуралдаан дуустал танхимаас гаргах эсвэл “нэр заах” журмаар сахилгын илүү хүнд

арга хэмжээ авах санал гаргах бүрэн эрхтэй байдаг бөгөөд Австрали, Энэтхэг¹⁷ зэрэг улсын практикт энэ нь түгээмэл хэрэглэгддэг.

Ноцтой болон давтагдсан зөрчлийн асуудлыг парламентын Ёс зүйн дэд хороо, холбогдох түвшинд шилжүүлэн хэлэлцэж, урт хугацааны сахилгын арга хэмжээ авдаг. Үүнд цалин хөлснөөс суутгал хийх, хуралдаанд оролцох эрхийг тодорхой хугацаагаар (ихэвчлэн 5-30 хоног) хасах, цаашлаад гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээнүүд багтдаг.

Хэрэв уг сануулгыг үл тоомсорловол гишүүний үг хэлэх, асуулт асуух эрхийг тухайн хуралдааны хүрээнд хязгаарлах арга хэмжээ авдаг. Ийм зохицуулалт Герман, Норвег¹⁸, Солонгос зэрэг улсуудад хэрэгжиж байна. Харин ноцтой зөрчил гаргасан, эсхүл эмх замбараагүй байдал үүсгэсэн тохиолдолд спикерийн шийдвэрээр гишүүнийг танхимаас албадан гаргах (Австрали, Канад, Шинэ Зеланд) улмаар тодорхой хугацаагаар хуралдаанд оролцох болон санал өгөх эрхийг нь түдгэлзүүлэх хатуу арга хэмжээ авч байна. Түдгэлзүүлэх хугацаа нь зөрчлийн хүндийн зэргээс шалтгаалан 5-аас 90 хүртэлх хоног байж болох бөгөөд энэ нь сахилгын хариуцлагын үр нөлөөг нэмэгдүүлдэг.

Ёс зүйн хариуцлагын хүрээнд илүү институцийн шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлдэг. Солонгос, Япон зэрэг улсад Ёс зүйн хорооны дүгнэлтийн үндсэн дээр гишүүн нээлттэй хуралдаан дээр уучлалт хүсэх, эсхүл Байнгын хорооны бүрэлдэхүүнээс хасах зэрэг арга хэмжээг авч, ёс зүйн зөрчлийг олон нийтийн өмнө ил тод хэлбэрээр шийдвэрлэдэг.

Сахилгын хариуцлагыг хэрэгжүүлэхэд эдийн засгийн болон нийгмийн хөшүүргийг ашиглах нь онцгой үр нөлөөтөйд тооцогддог. Германд дэг зөрчсөн гишүүнд 1000-2000 еврогийн торгууль ногдуулах, Өмнөд Африкт хуралдаан тасалсан хоног тутамд мөнгөн торгууль оногдуулах зохицуулалт нь сахилга батыг эдийн засгийн хариуцлагатай уялдуулж буйн илэрхийлэл юм. Мөн Франц, Их Британи¹⁹, Солонгос зэрэг улсад гишүүний ирц, санал хураалтад оролцсон байдлыг харгалзан цалин, нэмэгдэл тэтгэмжийг суутгах, бүр зогсоох хүртэл арга хэмжээ авах нь хариуцлагын бодит хэрэгжилтийг хангадаг.

Давтан зөрчил гаргасан тохиолдолд хариуцлагыг шатлан хүндрүүлэх нь хууль дээдлэх ёсны зарчимд нийцдэг. Шинэ Зеландын туршлагаас үзэхэд зөрчил давтагдах тусам түдгэлзүүлэх хугацааг нэмэгдүүлэх (24 цаг, 7 хоног, 28 хоног) зохицуулалт үйлчилдэг бөгөөд энэ нь сахилгын арга хэмжээний урьдчилан сэргийлэх болон засах нөлөөг давхар хангадаг. Түүнчлэн, Өмнөд Африк болон Энэтхэгт гишүүн хуралдаан болон Байнгын хорооны хуралдаанд удаа дараа оролцоогүй тохиолдолд бүрэн эрхийг нь дуусгавар болгох, эгүүлэн татах хүртэл хатуу арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Сахилгын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хараат бус, институцийн хяналтын механизмыг ашиглах нь ил тод, шударга байдлыг хангах чухал нөхцөл болдог. Солонгост Ёс зүйн тусгай хороо, Орост үйл ажиллагааны хэрэгжилт, үйл ажиллагааг дэмжих комисс зэрэг байгууллагууд гишүүдийн зөрчлийг хянан шалгаж, дүгнэлт гарган, улмаар нэгдсэн хуралдаанаар эцэслэн шийдвэрлүүлэх тогтолцоо бүрдсэн байна.

ОУ-ын парламентын туршлагаас харахад гишүүдийн сахилгын хариуцлагын тогтолцоо нь урьдчилан сэргийлэх (сануулга), эдийн засгийн (торгууль, суутгал), институцийн (түдгэлзүүлэх, бүрэн эрхийг дуусгавар болгох) гэсэн харилцан уялдаатай гурван түвшний тогтолцоод тулгуурладаг. Энэхүү тогтолцоо нь парламентын дэг журмыг сахиулахаас гадна гишүүдийн сонгогчдын өмнө хүлээх хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх, улмаар хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

¹⁷ Lok Sabha Secretariat (India). (2024). *Rules of procedure and conduct of business in Lok Sabha*. Parliament of India.

¹⁸ Norwegian Parliament (Storting). (2024). *Rules of procedure of the Storting*.

¹⁹ House of Commons (UK). (2026). *Standing orders: Public business*. UK Parliament.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>17 дугаар зүйл.Цахим хуралдааны дэг</p> <p>17.11.Цахим хуралдааны дэгээр хуралдаж байгаа үед асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүний саналаар нэг удаа 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах бөгөөд үг хэлэх хугацаа 3 минутаас илүүгүй байхаар тогтооно. Нам, эвслийн бүлэг, гишүүд шаардлагатай гэж үзвэл саналаа нэгтгэн асуулт асууж, саналаа илэрхийлж болно.</p>	<p>17 дугаар зүйл.Цахим хуралдааны дэг</p> <p>17.11.Цахим хуралдааны дэгээр хуралдаж байгаа үед асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүний саналаар нэг удаа 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах бөгөөд асуултад хариулах хугацаа 2 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байхаар, үг хэлэх хугацаа 3 минутаас илүүгүй байхаар тогтооно. Нам, эвслийн бүлэг, гишүүд шаардлагатай гэж үзвэл саналаа нэгтгэн асуулт асууж, саналаа илэрхийлж болно</p>
<p>17.4.Гишүүн товлосон цагт цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлэн хуралдаанд оролцох үүрэгтэй. Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр товлосон цагт ирцэд бүртгүүлээгүй бол энэ хуулийн 15.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>17.4.Гишүүн товлосон цагт цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлэн хуралдаанд оролцох үүрэгтэй.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Хууль тогтоох дээд байгууллагын хуралдааны дэг журам, тэр дундаа асуулт асуух, хариулах болон үг хэлэх хугацааг нарийвчлан тогтоох нь мэтгэлцээнийг ажил хэрэгч, үр ашигтай байлгах, парламентын цаг хугацааны нөөцийг оновчтой хуваарилах үндсэн тогтолцоо болдог. ОУ-ын парламентын туршлагаас үзэхэд цагийн менежмент нь хуралдааны чанар, сахилга бат, шийдвэр гаргах үр нөлөөг тодорхойлох чухал хүчин зүйл юм.

Асуулт асуух болон тодруулга авах хугацааг богино, оновчтой байхаар зохицуулах нь парламентын хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэдэг. ОУ-ын практикт асуултын хугацааг ихэвчлэн нэгээс хоёр минутын хооронд тогтоодог бөгөөд энэ нь гишүүдийг асуудлын гол агуулгад төвлөрч, тодорхой байдлаар илэрхийлэхийг шаарддаг. Австралид асуултыг 30-45 секундэд багтаан тавих, Эстонид 1 минутын хугацаанд асуулт тавих зохицуулалт үйлчилдэг бол Өмнөд Африк, Норвег зэрэг улсуудад 2 минут орчим хугацаа олгодог нь харьцангуй дундаж жишигт тооцогддог. Үүнтэй адил, нэмэлт тодруулга асуултад 1 минут орчим хугацаа олгох нь “шаталсан” асуулгын зохицуулалтын нийтлэг хэлбэр бөгөөд асуудлыг гүнзгийрүүлэн тодруулах боломжийг хангадаг.

Гүйцэтгэх засаглалын тайлагнах үүргийг хэрэгжүүлэх хүрээнд сайд нараас авах хариултын хугацааг мөн тодорхой хязгаарлах нь хуралдааны эрчмийг хадгалах ач холбогдолтой. Хариултын хугацааг 2 минут орчим байхаар тогтоох нь Эстони, Норвег зэрэг улсын парламентын жишигтэй нийцэж байгаа бөгөөд хариултыг товч, тодорхой, агуулгад чиглэсэн байлгах шаардлагыг бий болгодог. Харин Австрали, Өмнөд Африк зэрэг улсад 3-4 минутын хугацаа олгодог нь илүү дэлгэрэнгүй тайлбар өгөх боломжийг бүрдүүлдэг боловч цагийн хувьд илүү уян хатан зохицуулалтад тооцогдоно.

Мэтгэлцээний соёлыг төлөвшүүлэх үүднээс гишүүдийн үг хэлэх хугацааг хязгаарлах нь чухал ач холбогдолтой. Үг хэлэх хугацааг 3 минут орчим байхаар тогтоох нь олон улсын практикт “богино тайлбар” хэлбэрт хамаарах бөгөөд гишүүдийн байр суурийг товч, цэгцтэй илэрхийлэхэд чиглэдэг. Ийм зохицуулалт нь Герман, Эстони, Шинэ Зеланд зэрэг улсын парламентын гишүүдийн суудлаасаа үг хэлэх, богино мэдэгдэл хийх хугацаатай дүйцэж байна.

Парламентын хэлэлцүүлгийн зохион байгуулалтыг оновчтой болгохын тулд нийт үг хэлэх хугацааг нам, эвслийн бүлгүүдийн суудлын харьцаанд үндэслэн хуваарилах нь түгээмэл хэрэглэгддэг сайн туршлага юм. Швейцар, Итали зэрэг улсын парламентын дэгт энэхүү зарчмыг хэрэгжүүлснээр олонхын болон цөөнхийн бүлгүүдийн оролцоог тэнцвэртэй хангах, улс төрийн төлөөллийн зарчмыг бодитой хэрэгжүүлэх боломж бүрддэг.

Орчин үеийн парламентын үйл ажиллагаанд цахим хуралдааны зохион байгуулалт, эрх зүйн чадамж чухал байр суурь эзэлж байна. Онцгой нөхцөл байдалд цахим хуралдааныг албан ёсны хуралдаанд тооцох, зайнаас оролцож буй гишүүдийг ирц бүрдүүлсэнд хамааруулах, цахим системээр санал хураалт явуулах зохицуулалт нь олон улсад түгээмэл хэрэгжиж байна. Солонгос, Канад зэрэг улсад дүрст видео хэлбэрээр оролцож буй гишүүдийг “биеэр оролцсонтой” адилтган үзэж, санал хураалтад оролцуулах боломжийг хуульчлан баталгаажуулсан байна.

Асуулт асуух, хариулах болон үг хэлэх хугацааг нарийвчлан тогтоох нь парламентын үйл ажиллагааг үр ашигтай, сахилга баттай явуулах, мэтгэлцээний соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн чухал зохицуулалт юм. ОУ-ын туршлагаас харахад “товч, тодорхой, оновчтой” зарчимд тулгуурласан цагийн менежмент нь хууль тогтоох үйл явцын чанарыг дээшлүүлэх, шийдвэр гаргалтыг шуурхай, үр дүнтэй болгох үндсэн нөхцөл болж байна. Мөн цахим орчныг ашиглан хуралдааныг зохион байгуулах нь парламентын үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлж, орчин үеийн засаглалын шаардлагад нийцсэн шийдэл болж байна.

2.2.ГУРАВДУГААР БҮЛЭГ: АНХДУГААР ЧУУЛГАН

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
19 дүгээр зүйл.Улсын Их Хурлын даргыг сонгох 19.3.Улсын Их Хурлын даргыг сонгоход хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.	19 дүгээр зүйл.Улсын Их Хурлын даргыг сонгох 19.3.Улсын Их Хурлын даргыг сонгох нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт гишүүд нэр дэвшигч болон нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгээс асуулт асууж, хариулт авч, үг хэлсний дараа ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

Тайлбар: Хуульд Улсын Их Хурлын даргыг сонгохдоо хэлэлцүүлэггүйгээр санал хураалт явуулж шийдвэрлэхээр зохицуулсан. Үүнд өөрчлөлт оруулж хэлэлцүүлэг явуулах буюу гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлсний дараа санал хураалт явуулахаар зохицуулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: ОУ-д парламентын дарга буюу спикерийг сонгох үйл явц нь тухайн улсын засаглалын хэлбэр, тогтолцоо, эрх зүйн бүл, улс төрийн соёл, төлөвшил зэрэг олон хүчин зүйлээс хамааран харилцан адил бус зохицуулалттай байна.

Парламентын даргыг сонгох хэлэлцүүлэгт асуулт, хариулт өрнүүлэх болон үг хэлэх талаарх зохицуулалт ялгаатай. Австрали, Канад зэрэг улс орнуудад спикерийн албан тушаал нь намын харьяаллаас ангид, "парламентын шүүгч" байх зарчмыг баримталдаг тул нэр дэвшигчид өөрийн мөрийн хөтөлбөр, алсын хараагаа танилцуулж үг хэлэх, гишүүдтэй мэтгэлцэх боломжийг дэгийн хүрээнд олгодог байна. Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгээр нэр дэвшигчийг дэмжигч гишүүд 5 минутын хугацаанд үндэслэлээ тайлбарлаж үг хэлдэг бол Канадад нэр дэвшигч өөрөө мөрийн хөтөлбөрөө танилцуулдаг нь гишүүдэд сонголтоо ухамсартайгаар хийх нөхцөлийг бүрдүүлдэг. Нийтлэг чиг хандлага нь даргыг сонгох ажиллагааг улс төрийн мэтгэлцээнээс аль болох ангид байлгах явдал байна. Сингапур²⁰, Шинэ Зеланд зэрэг улсад нэр дэвшүүлэх үе шатанд мэтгэлцээн, асуулт, хариултыг шууд хориглох эсвэл маш хязгаарлагдмал байдлаар зөвшөөрдөг бөгөөд энэ нь Парламентын даргын бүтэц төвийг сахисан шинж чанарыг хамгаалах зорилготой байдаг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт

²⁰ Parliament of Singapore. (2017). *Standing orders of Parliament*.

<p>20 дугаар зүйл.Улсын Их Хуралд нам, эвслийн бүлэг байгуулагдсан тухай мэдээлэх</p> <p>20.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.1-д заасан суудал авсан нам, эвслийн гишүүд бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг бүлгийн дарга Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлэг байгуулсанд тооцно.</p> <p>20.2.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулна.</p>	<p>20 дугаар зүйл.Улсын Их Хуралд нам, эвслийн бүлэг байгуулагдсан тухай мэдээлэх</p> <p>20.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.1-д заасан суудал авсан нам, эвслийн гишүүд бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалт, бүлгийн даргыг сонгосон тухай бүлгийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлэг байгуулсанд тооцно.</p> <p>20.2.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрсийн жагсаалт, бүлгийн даргыг сонгосон тухай бүлгийн шийдвэрийг нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулна.</p>
--	---

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламент дахь нам, эвслийн бүлэг (фракц)-ийг албан ёсоор байгуулагдсанд тооцох хууль зүйн нөхцөл, шалгуур нь улс орнуудад харилцан адилгүй боловч ерөнхийдөө "бүртгүүлж, зарлан мэдээлсэн" үеэс хүчин төгөлдөр болдог зохицуулалттай байна.

Улс орнуудын жишгээс харахад парламент дахь нам, эвслийн бүлэг байгуулагдах үйл явц дараах 3 гол үе шатаар тодорхойлогдоно. Үүнд:

1.Бичгээр мэдэгдэл хүргүүлэх (Франц, Герман, Эстони): Ихэнх улсад парламентын бүлэг байгуулах хүсэлтэй гишүүд бичгээр үйлдсэн албан ёсны баримт бичгийг Парламентын даргад (Спикер) өгснөөр тус үйл явц эхэлдэг. Жишээлбэл, Франц Улсад парламентын гишүүд улс төрийн тунхаглал (Political declaration), бүлгийн бүрэлдэхүүний жагсаалтаа бүлгийн даргын нэрийн хамт Ассамблейн даргад өгснөөр албан ёсоор байгуулагдсанд тооцогддог. Эстони Улсад намын нэр дээр "фракц" гэсэн үг нэмж, бүлгийн дарга, түүний орлогч нарын мэдээллийг Спикерт бичгээр мэдэгддэг байна.

2.Спикер бүртгэх, эсвэл Танхимд зарлан мэдээлэх (Итали, Солонгос): Зарим улсад зөвхөн албан бичиг өгөх нь хангалтгүй байдаг. Тухайн баримт бичгийг парламентын дарга буюу спикер хүлээн авч, нэгдсэн хуралдаанд зарласнаар тус бүлэг эрх зүйн чадамжтай болдог. Тухайлбал, Итали Улсад парламентын бүлэг байгуулагдсан тухай мэдээллийг Төлөөлөгчдийн танхимын Ерөнхийлөгч мэдээлж, тэрхүү мэдээлэл нь хуралдааны протоколд тэмдэглэгдсэнээр албан ёсны болдог бол Солонгост Зөвшилцөгч бүлэг (negotiating party) буюу хэлэлцээний статустай намын бүлгийн төлөөлөгчийн бүрэлдэхүүний өөрчлөлт болон шинээр байгуулагдсан тухай мэдээллийг Үндэсний Ассамблейн даргад албан ёсоор хандаж бүртгүүлдэг байна.

3.Нам, эвслийн бүлгийн босго шалгуур хангасан эсэхийг хянан баталгаажуулах (Норвег, Герман): Зарим улсад бичиг өгөхөөс гадна тухайн бүлэг "бүлэг байх шалгуур"-ыг хангаж буй эсэхийг тодорхой институцийн түвшинд шалгадаг. Жишээлбэл, Герман Улсад хэрэв тухайн бүлэг 5 хувийн босго болон "нэг намынх байх" гэсэн ерөнхий шалгуурыг хангаагүй ч бүлэг болох хүсэлт гаргасан бол Бундестаг өөрөө хэлэлцэн зөвшөөрөл өгч байж албан ёсоор байгуулагдсанд тооцогддог. Харин Норвег Улсад Сонгуулийн төв байгууллагаас тухайн намын бүртгэл болон нэр дэвшүүлсэн мужуудын тоог баталгаажуулсны дараа л Стортинг (Парламент) тухайн бүлгийн албан ёсны статусыг нь олгодог байна.

Парламент дахь нам, эвслийн бүлэг албан ёсоор байгуулагдсанд тооцогдоход нийтлэг байдлаар дараах баримт бичгүүдийг шаарддаг байдаг. Үүнд:

- Бүлгийн дүрэм эсвэл тунхаглал: Тэдний баримтлах улс төрийн үзэл баримтлал, зорилго;
- Гишүүдийн гарын үсэгтэй жагсаалт: Доод хязгаарт хүрч байгааг батлах;
- Бүлгийн даргын нэр: Парламенттай харилцах албан ёсны төлөөлөгч;
- Бүлгийн нэр: Намын нэр дээр суурилсан эсвэл эвслийн нэр.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>21 дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэд даргыг сонгох</p> <p>21.1.Улсын Их Хурлын дэд даргыг тухайн Улсын Их Хурлын сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, ил санал хураалтаар сонгоно.</p>	<p>21 дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэд даргыг сонгох</p> <p>21.1.Улсын Их Хурлын дэд даргыг тухайн Улсын Их Хурлын сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, ийнхүү дэвшүүлснээс хойш 5 хоногийн дотор ил санал хураалтаар сонгоно.</p>

Тайлбар: Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлсэн бол 5 хоногийн дотор сонгохоор хугацааг тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын дэд даргыг сонгох үйл ажиллагаа нь хууль тогтоох байгууллагын тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах зорилгоор ихэвчлэн маш богино хугацаанд, нарийн дэгээр явагддаг онцлогтой. Олон улсын парламентын дэгийн зохицуулалтыг дараах гурван үндсэн чиглэлээр ангилан нэгтгэж болохоор байна. Үүнд:

1. Сонгууль зохион байгуулах хугацааны зохицуулалт:

Парламентын дэд даргыг сонгохдоо нэр дэвшүүлэхээс санал хураалт явуулах хоорондын хугацааг ихэнх улс оронд 24 цагаас хэтрэхгүй байхаар тогтоосон байна. Тухайлбал, Их Британи болон Энэтхэг улсын парламентын дэгээр нэр дэвшүүлэх хүсэлтийг санал хураалт болох өдрийн өмнөх өдөр бичгээр хүлээн авдаг бол Францад улс төрийн зөвшилцөл бүрдээгүй тохиолдолд санал хураалт эхлэхээс хагас цагийн өмнө ч нэр дэвшүүлж болдог байна. Харин Солонгосын хувьд "5 хоног"-ийн зохицуулалт нь нэр дэвшүүлснээс хойш бус, харин өмнөх албан тушаалтны бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө шинэ сонгуулийг товлон явуулах хугацааны баталгаа болдог нь институцийн залгамж чанарыг хадгалахад чиглэгддэг.

2. Төлөөллийн зарчим ба нэр дэвшүүлэх шалгуур:

Дэд дарга нарыг сонгохдоо парламентын олон ургалч үзэл, намын бүлгүүдийн оролцоог хангах зарчмыг баримталдаг. Герман улсын Бундестагийн жишээнээс харахад Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд бүлэг (нам) бүрээс дор хаяж нэг дэд ерөнхийлөгч багтаж, төлөөлөлтэй байх квотын зарчмыг хуульчилсан байдаг. Энэ нь парламентын удирдлага дан гагц олонхын хяналтад орохоос сэргийлдэг механизм юм. Францад ч мөн адил намын бүлгийн дарга нар нэр дэвшигчдийн жагсаалтаа өөрсдөө эрэмбэлж гаргадаг нь бүлгийн бие даасан байдлыг тодотгож байна.

3. Санал хураалтын нууцлал ба ил тод байдал:

Олон улсын нийтлэг жишигт (Солонгос, Их Британи, Герман, Япон, Эстони) хүний нөөцтэй холбоотой буюу тодорхой албан тушаалтныг сонгох сонгуулийг гол төлөв нууц санал хураалтаар (secret ballot) явуулж байна. Энэ нь гишүүд өөрийн намын болон фракцын шахалтаас ангид, нэр дэвшигчийн ур чадвар, хувийн ёс зүйд тулгуурлан сонголт хийх боломжийг бүрдүүлдэг. Харин зарим тохиолдолд (жишээ нь, Энэтхэг, Канад, Шинэ Зеланд) ил санал хураалтыг ашиглаж байгаа нь улс төрийн хариуцлагыг сонгогчдын өмнө ил тод байлгах зорилготой байдаг боловч энэ нь олон улсын түвшинд харьцангуй цөөн тохиолдох зохицуулалт юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
---	---------------

<p>23 дугаар зүйл.Байнгын болон дэд хорооны даргыг сонгох журам</p> <p>23.5.Дэд хорооны даргыг Дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар сонгоно.</p>	<p>23 дугаар зүйл.Байнгын болон дэд хорооны даргыг сонгох журам</p> <p>23.5.Дэд хорооны даргыг Дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоол баталсанд тооцно.</p>
---	---

Тайлбар: Дэд хорооны даргыг Байнгын хорооны нийт гишүүний олонх дэмжсэнээр сонгох бус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол сонгогдохоор зохицуулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын байнгын хороод нь тодорхой чиг үүргийн хүрээнд дэд хороодыг (Subcommittee) байгуулан ажиллуулахдаа удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнийг томилох өөр өөрийн засаглалын онцлогт тохирсон дэг, журмыг баримталдаг. ОУ-ын парламентын практикт дэд хорооны даргыг томилох дараах гурван үндсэн шинжээрээ ялгаатай байдал ажиглагдаж байна. Үүнд:

1. Зарим улс оронд дэд хороо нь бие даасан байдлаар удирдлагаа тодорхойлдог бол заримд нь "үндсэн байнгын хороо" (parent committee) нь шууд томилох эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Солонгост дэд хорооны даргыг тухайн хорооны гишүүдийн дундаас дотоод сонгуулиар тодруулж, үр дүнг нэгдсэн хуралдаанд тайлагнадаг ардчилсан зарчим давамгайлдаг. Харин Австрали болон Өмнөд Африк улсад үндсэн байнгын хороо нь дэд хорооны даргыг өөрийн үзэмжээр томилдог (designate) бөгөөд энэ нь босоо удирдлагын тогтолцоот шинжтэй.

2. Дэд хорооны удирдлагыг сонгох, томилохдоо парламентын бүлгүүдийн суудлын харьцааг харгалзан үзэх нь эх газрын системийн орнуудын нийтлэг шинж юм. Герман улсын Бундестагт дэд хорооны даргыг томилохдоо намуудын суудлын харьцааг заавал үндэслэл болгодог. АНУ (Америк гэх)²¹-ын Төлөөлөгчдийн танхимын мөрдөн шалгах дэд хороодын хувьд үндсэн байнгын хорооны дарга болон цөөнхийн бүлгийн ахлах гишүүн нь тус тусын удирдлагыг (chair and ranking member) томилдог нь хоёр намын хяналт-тэнцвэрийг хангах сонгодог жишээ юм.

3. Британийн Вестминстер системээс гаралтай орнуудад зарим дэд хорооны удирдлагыг тусгайлан сонгохгүйгээр үндсэн байнгын хорооны дарга шууд хавсран удирдах "Ex-officio" зарчим ажиглагддаг. Их Британид Хөтөлбөрийн болон Бизнесийн дэд хороодыг үндсэн хорооны дарга нь өөрөө даргалдаг бол Канадад зарим стратегийн ач холбогдол бүхий дэд хорооны (жишээ нь, Процедурын хорооны дэд хороо) даргыг эрх баригч намаас нэр цохон томилдог байна.

2.3.ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХУУЛИЙН ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>33 дугаар зүйл.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх</p> <p>33.1.Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар</p>	<p>33 дугаар зүйл.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх</p> <p>33.1.Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга</p>

²¹ House of Representatives (United States). (2025). *Rules of the House of Representatives (119th Congress)*. U.S. Government Publishing Office.

яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.	төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.
33.2.Нэгдсэн хуралдаан хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Улсын Их Хурлын дарга тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын нийт гишүүнд яаралтай хүргүүлж, энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцүүлнэ.	33.2.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх үндэслэлийн талаарх Ерөнхий сайдын, эсхүл холбогдох Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонссоны дараа хэлэлцүүлэг явуулахгүйгээр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжсэн тохиолдолд энэ хуулийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй.

Тайлбар: Хуулийн төслийг чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулж, тухайн төслийг яаралтай хэлэлцүүлэх болсон үндэслэлийг Ерөнхий сайд, эсхүл холбогдох Засгийн газрын гишүүн нэгдсэн чуулганд танилцуулсны дараагаар хэлэлцүүлэггүйгээр санал хураалт явуулахаар нэмж тусгана. Яаралтай хууль тогтоомжийн төсөл хэлэлцэхээр өргөн мэдүүлсэн тохиолдолд тухайн хууль тогтоомжийг яаралтай хэлэлцэх бодит хэрэгцээ, шаардлага байгаа эсэхээр гишүүд Засгийн газрын мэдээллийг авсны үндсэн дээр шийдвэр гаргадаг болно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд улс орны аюулгүй байдал, эдийн засгийн тогтворгүй болон онцгой нөхцөл байдал үүссэн үед хуулийн төслийг ердийн дэгээс богино хугацаанд хэлэлцэн батлах "яаралтай горим" (Urgency procedure)-ыг хэрэглэдэг. Энэхүү механизмыг хэрэгжүүлэх арга хэлбэрийг ОУ-ын туршлагад үндэслэн дараах гурван үндсэн чиглэлээр ангилан үзэж болно.

1. Гүйцэтгэх засаглалын санаачилга ба зарлан тунхаглах журам:

Ихэнх улс оронд (Австрали, Канад, Шинэ Зеланд, Сингапур) хуулийн төслийг яаралтай гэж үзэх (зарлах) давуу эрх нь Гүйцэтгэх засаглалд буюу ЗГ-ын гишүүдэд хадгалагддаг. Австрали болон Шинэ Зеланд улсад ЗГ-ын гишүүн, сайд хуулийн төслийг "яаралтай" гэж зарлан мэдэгдсэн тохиолдолд нэмэлт мэтгэлцээнгүйгээр шууд санал хурааж, хэлэлцүүлгийг тасралтгүй (оройн цагаар сунгаж) явуулах боломжтой байдаг. Сингапурт Ерөнхийлөгчийн гарын үсэг бүхий "Яаралтай байдлын гэрчилгээ"-г үндэслэн бүх шатны хэлэлцүүлгийг нэг өдөрт багтаан шууд баталдаг нь гүйцэтгэх засаглалын онцгой нөлөөг харуулж байна.

2. Хэлэлцүүлгийн шат дамжлагыг цөөлөх ба хугацааг богиносгох:

Яаралтай горимын гол зорилго нь хуулийн төслийг Байнгын хороогоор хэлэлцэх болон нэгдсэн хуралдааны шат дамжлагыг алгасах буюу хугацааг шахах явдал юм. Эстони улсад санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой хуулийн төслийг ганцхан хэлэлцүүлгээр баталдаг бол Өмнөд Африкт олон нийтээс санал авах зэрэг урьдчилсан шатны шаардлагуудыг алгасахыг зөвшөөрдөг. Италид яаралтай хуулийн төслийн хорооны санал, дүгнэлт гаргах хугацаа 2 дахин багасдаг бол Германд Засгийн газраас яаралтай гэж зарласан төслийг хэлэлцэх асуудлын дараалалд заавал оруулах хатуу дэг үйлчилдэг байна.

3. Парламентын хяналт ба өндөр босго бүхий "түргэвчилсэн журам":

Зарим улс оронд яаралтай горимыг хэрэгжүүлэхдээ парламентын цөөнхийн эрх ашгийг хамгаалах, нухацтай хэлэлцүүлгийг хадгалах үүднээс санал хураалтын өндөр босго тогтоодог. Тухайлбал, Солонгост "түргэвчилсэн боловсруулалт" хийх хүсэлтийг нийт гишүүдийн 3/5-аас доошгүйн саналаар баталдаг бол Эстонид Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг яаралтай горимд шилжүүлэхэд нийт гишүүдийн 4/5-ын санал шаардлагатай байдаг. Швейцар Улсад яаралтай горим хэрэглэх эсэх заалтыг хуулийн төслийг бүхэлд нь батлах санал хураалтаас тусад нь авч үздэг нь тухайн төслийн агуулга болон хэлэлцэх горимыг ялгаж үзэх боломжийг гишүүдэд олгодог.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>34 дүгээр зүйл. Хууль зүйн дүгнэлт гаргах болон зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх</p> <p><u>/Энэ зүйлийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./</u></p>	<p>34¹ дүгээр зүйл. Хууль зүйн дүгнэлт гаргах болон зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх</p> <p>34¹.1. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл болон төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар хэлэлцүүлгийн явцад Тамгын газраар хууль зүйн дүгнэлт гаргуулна.</p> <p>34¹.2. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналд Тамгын газраар зардлын тооцоо болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар дүн шинжилгээ /цаашид “төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ” гэх/ хийлгэнэ.</p> <p>34¹.3. Хууль зүйн дүгнэлтийг дараах асуудлын хүрээнд гаргаж, Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлнэ:</p> <p>34¹.3.1. тухайн төсөл, эсхүл төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй санал нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцсэн эсэх, хэрэв тухайн төсөл, эсхүл зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцээгүй бол нийцүүлэх хууль, түүний заалтыг тодорхойлж, үндэслэлийг тайлбарлах;</p> <p>34¹.3.2. тухайн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт нь хоорондоо, эсхүл зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь төслийн зүйл, хэсэг, заалттай зөрчилдсөн эсэх, хэрэв зөрчилтэй бол түүнийг тодорхойлж, залруулах аргыг санал болгох;</p> <p>34¹.3.3. тухайн төсөлтэй холбогдуулан хууль хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг шаардлагатай хууль, зүйл, хэсэг, заалтыг бүрэн хамруулсан эсэх;</p> <p>34¹.3.4. хамт өргөн мэдүүлсэн төсөл нь тухайн өргөн мэдүүлсэн хуулийн төслийн зохицуулалттай уялдсан эсэх.</p> <p>34¹.4. Хууль зүйн дүгнэлт гаргахад мэргэжлийн, хараат бус шинжээчийг татан оролцуулж болно.</p> <p>34¹.5. Хууль зүйн дүгнэлт, төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг Байнгын хорооны хуралдаанд Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан тэргүүн дэд, дэд дарга танилцуулна.</p> <p>34¹.6. Тамгын газар хууль зүйн дүгнэлт, төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг ажлын 10-15 өдрийн дотор гаргана.</p> <p>34¹.7. Хууль, тогтоолын төслийн зохицуулах харилцааны цар хүрээг харгалзан Ерөнхий нарийн</p>

бичгийн дарга энэ хуулийн 34¹.6-д заасан хугацааг өөрөөр тогтоож болно.

34¹.8.Хууль зүйн дүгнэлт гаргах болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

Тайлбар: Хуулийн 34 дүгээр зүйлд нэгдсэн хуралдаанаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн болон олон улсын гэрээ соёрхон батлахаас бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахын өмнө Тамгын газар хууль зүйн дүгнэлт гаргахаар зохицуулсан байсан. Энэ зохицуулалтыг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн Улсын Их Хурлын тухай хуулийн өөрчлөлтөөр хүчингүй болгож, хуулийн төслийн хэлэлцэх эсэх шатанд Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн зөвлөмж гаргахаар тусгасан.

Эдгээр зохицуулалтыг эргэн харж хууль зүйн дүгнэлт гаргах зохицуулалтыг сэргээхдээ хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн шатанд төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан саналын томъёоллын талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар Байнгын хороо шийдвэрлэсэн бол дүгнэлт гаргадаг байх, ийнхүү дүгнэлт гаргахдаа ямар хүрээг хамрах талаар нэмж тусгана.

Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл Тамгын газар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналд зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар дүн шинжилгээ хийх зохицуулалтыг төсөлд тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентаас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцсэн, дотоод зөрчилгүй, төсвийн бодит нөлөөллийг тооцсон байх нь эрх зүйт төрийн үндсэн шаардлага юм. Дэлхийн улс орнуудын парламентын практикт энэхүү чанарын хяналтыг дараах гурван түвшинд хэрэгжүүлж байна.

1.Хууль зүйн нийцлийн болон техникийн хяналтын механизм:

Хуулийн төслийн үзэл баримтлал болон үг хэллэг, хэл найруулгын нэгдмэл байдлыг хангах зорилгоор улс орнууд тусгайлан эрх олгогдсон хороо эсвэл редакцын бүтцийг ажиллуулдаг.

- Хууль зүйн хяналт: Солонгосын Хууль зүй, шүүхийн хороо (Legislation and Judiciary Committee), Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс (Бразил гэх)-ын Үндсэн хууль, хууль зүй, иргэний харьяаллын хороо (CCJC) зэрэг нь төслийг нэгдсэн хуралдаанд орохоос өмнө бусад хууль тогтоомжтой зөрчилдөж буй эсэхийг хянадаг "шүүлтүүр" болдог.
- Найруулга зүйн хяналт: Швейцар, Герман зэрэг улсад хуулийн төслийн утга санааг тодорхой болгох, олон хэл дээрх хувилбарын нийцлийг хангах Найруулгын хороо болон редакцын баг ажилладаг нь хууль хэрэглээний явцад үүсэж болох ойлгомжгүй байдлыг урьдчилан арилгадаг байна.
- Хүний эрхийн хяналт: Сингапур, Шинэ Зеланд зэрэг улсад цөөнхийн эрх болон хүний эрхийн стандартыг тусгайлан хянах механизм ажилладаг нь хууль тогтоомжийн ардчилсан шинжийг баталгаажуулдаг.

2. Төсөв, санхүүгийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ:

Хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх дарамтыг тооцоолох нь "мэдээлэлтэй шийдвэр" гаргахад чухал үүрэгтэй.

- Төрөлжсөн алба: Америкийн Конгрессын төсвийн алба (CBO) болон Солонгосын Үндэсний ассамблейн төсвийн алба (NABO) зэрэг бие даасан байгууллагууд хуулийн төслийн ирээдүйн 5 жилийн зардлын тооцооллыг гаргаж, макро эдийн засгийн нөлөөллийг үнэлдэг.
- Албан ёсны санамж бичиг: Их Британи, Энэтхэг, Япон зэрэг улсад зарлага шаардсан төсөл бүрд "Санхүүгийн санамж бичиг" заавал хавсаргадаг бөгөөд Шинэ Зеландад төсвийн

тогтвортой байдалд ноцтой нөлөөлөх төсөлд ЗГ-ын "Санхүүгийн хориг" (Financial veto) тавих эрхтэй байдаг.

3. Шинжээч болон судалгааны дэмжлэг авах тогтолцоо:

Байнгын хороодын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулахад хөндлөнгийн шинжээч, судалгааны институцуудын оролцоог хуульчлан баталгаажуулдаг. Ингэхдээ:

- Дотоод судалгааны нөөц: Солонгосын Үндэсний ассамблейн судалгааны алба (NARS), Францын шинжлэх ухаан, технологийн сонголтыг үнэлэх оффис (OPECST) зэрэг байгууллагууд хууль тогтоогчдод бодлогын мэдээлэл, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, дүгнэлтийг тогтмол бэлтгэж өгдөг.
- Гэрээт шинжээчид: Америк, Швейцар, Итали зэрэг улсад байнгын хороод нь статистикийн хүрээлэн, тусгай зөвлөхүүд болон парламентын бус нэмэлт ажлын хэсэг, хороодоор дамжуулан нарийн мэргэжлийн чиглэлээр (МТ, байгаль орчин, технологи) гүнзгийрүүлсэн судалгаа хийлгэх эрхтэй байдаг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>35 дугаар зүйл. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>35.2. Энэ хуулийн 35.1-д заасны дагуу хуулийн төсөл, түүнд хавсаргасан баримт бичгийг холбогдох Байнгын хороонд хуваарилснаас хойш 3 хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлэх ба эдгээр нь олон нийтэд нээлттэй байна.</p>	<p>35 дугаар зүйл. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>35.2. Энэ хуулийн 35.1-д заасны дагуу хуулийн төсөл, түүнд хавсаргасан баримт бичгийг холбогдох Байнгын хороонд хуваарилснаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлэх ба эдгээр нь олон нийтэд нээлттэй байна.</p>
<p>35.3. Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө тухайн хуулийн төсөлтэй 7-оос доошгүй хоногийн хугацаанд танилцах боломжийг гишүүдэд олгоно.</p>	<p>35.3. Энэ хуулийн 33.1-д заасан яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэснээс бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө тухайн хуулийн төсөлтэй 7-оос доошгүй хоногийн хугацаанд танилцах боломжийг гишүүдэд олгоно.</p>
<p>35.4. Байнгын хороо хүсэлт гаргасан бол Тамгын газар хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах бөгөөд хууль зүйн зөвлөмжийг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлсэн байна.</p>	<p>35.4. Байнгын хороо хүсэлт гаргасан бол Тамгын газар хуулийн төсөлд хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтийг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлнэ. Байнгын хороо хэлэлцүүлгийн явцад хууль зүйн дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бол хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг түр хугацаагаар хойшлуулна.</p>
<p>35.8. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахдаа дараах журмыг баримтална:</p> <p>35.8.1. хууль санаачлагч илтгэлээ 10 минутад багтаан танилцуулах;</p> <p>35.8.2. энэ хуулийн 35.5-д заасны дагуу нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол уг санал, дүгнэлтийг 5 минутад багтаан танилцуулах;</p> <p>35.8.3. энэ хуулийн 35.6-д заасны дагуу санал гаргасан бол уг саналыг 5 минутад багтаан танилцуулах;</p>	<p>35.8. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахдаа дараах журмыг баримтална:</p> <p>35.8.1. хууль санаачлагч илтгэлээ 10 минутад багтаан танилцуулах;</p> <p>35.8.2. энэ хуулийн 35.5-д заасны дагуу нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол уг санал, дүгнэлтийг 5 минутад багтаан танилцуулах;</p> <p>35.8.3. энэ хуулийн 35.6-д заасны дагуу санал гаргасан бол уг саналыг 5 минутад багтаан танилцуулах;</p>

<p>35.8.4.Тамгын газраас тухайн төсөлд хууль зүйн зөвлөмж гаргасан бол түүнийг 10 минутад багтаан танилцуулах;</p> <p>35.8.5.шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч Тамгын газраас хуулийн төсөлд хийсэн зөвлөмжтэй холбогдуулан 5 минутад багтаан тайлбар хийх;</p> <p>35.8.6.гишүүд хууль санаачлагчаас асуулт асуух;</p> <p>35.8.7.шаардлагатай бол тухайн салбарын эрдэмтэн, судлаачийн саналыг сонсох;</p> <p>35.8.8.гишүүд хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх.</p>	<p>35.8.4.Тамгын газраас тухайн төсөлд хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийсэн бол тэдгээрийг Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан тэргүүн дэд, дэд дарга тус бүр 10 минутад багтаан танилцуулах;</p> <p>35.8.5.шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч Тамгын газраас хуулийн төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээтэй холбогдуулан тус бүр 5 минутад багтаан тайлбар хийх;</p> <p>35.8.6.гишүүд хууль санаачлагчаас асуулт асуух ба хуулийн төслийг хамтран санаачилсан гишүүн асуулт асуухгүй;</p> <p>35.8.7.шаардлагатай бол тухайн салбарын эрдэмтэн, судлаачийн саналыг сонсох;</p> <p>35.8.8.гишүүд хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх.</p> <p>35.8.9.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө хууль санаачлагч хүсэлт гаргасан бол үг хэлэх.</p>
<p>35.9.Хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаггүй гишүүн оролцож, асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>35.10.Гишүүн хуралдаанд асуулт асууж, үг хэлэхдээ баримт, нотолгоонд суурилсан, үнэн, бодит мэдээлэлд тулгуурлах ба энэ журмыг зөрчсөн тохиолдолд хуралдаан даргалагч асуулт, үгийг тасалж болно.</p> <p>35.11.Энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна. Хэрэв энэ хуулийн 35.7-д заасны дагуу мэтгэлцээн явуулсан тохиолдолд энэ хуулийн 35.8.1, 35.8.2, 35.8.3, 35.8.4, 35.8.5-д заасны дагуу хэлэлцүүлгийг явуулсны дараа ил санал хураалтыг шууд явуулж болно.</p>	<p>35.9.Хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаггүй гишүүн оролцож, асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>35.10.Гишүүн хуралдаанд асуулт асууж, үг хэлэхдээ баримт, нотолгоонд суурилсан, үнэн, бодит мэдээлэлд тулгуурлах ба энэ журмыг зөрчсөн тохиолдолд хуралдаан даргалагч асуулт, үгийг тасалж болно.</p> <p>35.11.Энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна. Хэрэв энэ хуулийн 35.7-д заасны дагуу мэтгэлцээн явуулсан тохиолдолд энэ хуулийн 35.8.1, 35.8.2, 35.8.3, 35.8.4, 35.8.5-д заасны дагуу хэлэлцүүлгийг явуулсны дараа ил санал хураалтыг шууд явуулж болно.</p>
<p>-</p>	<p>35.12.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэхэд гишүүн горимын санал гаргасан тохиолдолд хууль зүйн нэр томъёог жигдлэх зорилгоор хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар багцлан нэг санал хураалт явуулж болно.</p>
<p>35.12.Санал хураалтын дүнгээр цөөнх болсон гишүүд үндэслэлээ тайлбарлаж дахин нэг удаа санал хураалгаж болох бөгөөд Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар санал, дүгнэлт гаргаж,</p>	<p>35.13.Санал хураалтын дүнгээр цөөнх болсон гишүүд үндэслэлээ тайлбарлаж дахин нэг удаа санал хураалгаж болох бөгөөд Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын</p>

<p>түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.</p> <p>35.13.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>35.14.Хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих эсэх асуудлаар цөөнх болсон гишүүн нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.</p>	<p>саналаар санал, дүгнэлт гаргаж, түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.</p> <p>35.14.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>35.15.Хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих эсэх асуудлаар цөөнх болсон гишүүн нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.</p>
<p>35.15.Байнгын хороо хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:</p> <p>35.15.1.хуулийн төслийн зардлын тооцоо;</p> <p>35.15.2.хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага;</p> <p>35.15.3.хууль зүйн зөвлөмжийн талаарх мэдээлэл;</p> <p>35.15.4.санал хураалтын дүн.</p>	<p>35.16.Байнгын хороо хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:</p> <p>35.16.1.хуулийн төслийн зардлын тооцоо;</p> <p>35.16.2.хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага;</p> <p>35.16.3.хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээний талаарх мэдээлэл;</p> <p>35.16.4.санал хураалтын дүн.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>36 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>36.4.Хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн танилцуулна.</p>	<p>36 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>36.4.Хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 35.6-д заасан Засгийн газрын гишүүн танилцуулна.</p>
<p>36.6.Энэ хуулийн 36.5-д заасан дараалалд орсон гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж болно.</p>	<p>36.5.Хуралдаан даргалагч энэ хуулийн 9.2-т заасны дагуу асуулт, хариултыг зохион байгуулна.</p>
<p>36.6.Энэ хуулийн 36.5-д заасан дараалалд орсон гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж болно.</p>	<p>36.6.Энэ хуулийн 36.5-д заасан дараалалд орсон гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж болно. Хуулийн төслийг хамтран санаачилсан гишүүн асуулт асуухгүй.</p>
<p>36.8.Гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй</p>	

хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.	
36.9.Гишүүний асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байна.	
36.10.Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаагаар үг хэлнэ. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэхдээ индрээс үг хэлнэ.	36.10.Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай тус бүр 4 хүртэл гишүүн үг хэлнэ. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэхдээ индрээс үг хэлнэ.
-	36.11.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө хууль санаачлагч хүсэлт гаргасан бол үг хэлж болно.
36.11.Гишүүн хуулийн төслийн үзэл баримтлалтай шууд холбогдолгүй асуудлаар үг хэлбэл хуралдаан даргалагч зогсоох эрхтэй.	36.12.Гишүүн хуулийн төслийн үзэл баримтлалтай шууд холбогдолгүй асуудлаар үг хэлбэл хуралдаан даргалагч гишүүний үгийг таслах эрхтэй.
36.12.Үг хэлж дууссаны дараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.	36.13.Үг хэлж дууссаны дараа хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Энэ хуулийн 35.12-т заасны дагуу Байнгын хорооноос багцлан хураах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар багцлан санал хураалт явуулж болно.-
	36.14.Энэ хуулийн 36.13-т заасан санал хураалт явуулахад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээгүйд тооцно.
36.13.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол тухайн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.	36.15.Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол тухайн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.
36.14.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.	36.16.Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.
36.15.Энэ хуулийн 36.14-т заасны дагуу үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг нэг жилийн дотор дахин өргөн мэдүүлэхгүй.	36.17.Энэ хуулийн 36.16-д заасны дагуу үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг нэг жилийн дотор дахин өргөн мэдүүлэхгүй.

Тайлбар: Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийхэд гишүүн горимын санал гаргасан бол хууль зүйн нэр томъёог жигдлэх зорилгоор хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар багцлан нэг санал хураалт явуулж болох

зохицуулалтыг тусгана. Хэрэв Байнгын хороо горимын санал гаргаж хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг багцлан хураасан бол нэгдсэн хуралдаан уг горимын саналаар санал хураалт явуулж, гишүүдийн олонх дэмжсэн бол хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг багцлан хурааж болохоор тусгана.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн хэлэлцэх эсэх санал хураалт явуулахдаа хуулийн эх төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслөөр санал хураахгүйгээр хэлэлцэхийг дэмжээгүйд тооцох зохицуулалт шинээр нэмж тусна.

Хууль санаачлагч хуулийн төслийн талаарх нэмэлт мэдээллийг өгөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай бол хууль санаачлагч Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө үг хэлж болох зохицуулалт нэмж тусгана.

Хуулийн төслийг гишүүд хамтран санаачилсан бол хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахад хамтран санаачилсан гишүүн асуулт асуухгүй байхаар тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлал буюу ерөнхий зарчмыг хэлэлцэх шат нь тухайн төслийг цаашид үргэлжлүүлэн хэлэлцэх шаардлагатай эсэхийг тодорхойлдог стратегийн ач холбогдолтой үйл явц юм. ОУ-ын парламентын практикт энэхүү асуудлыг Байнгын хорооны түвшинд хэрхэн шийдвэрлэж байгааг дараах хоёр үндсэн загварт хуваан үзэж болохоор байна. Үүнд:

1. Байнгын хороо төвтэй урьдчилсан хяналтын загвар:

Зарим улс оронд Байнгын хороо нь хуулийн төслийг зүйл, заалт бүрээр нарийвчлан хэлэлцэхээс өмнө түүний үзэл баримтлал, хэрэгцээ шаардлагад "шүүлтүүр" хийх бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Жишээлбэл:

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейд байнгын хороо нь "Хэлэлцэх нь зүйтэй эсэх тогтоол" (Motion of desirability)-ыг тусгайлан баталдаг. Хэрэв хороо хуулийн төслийн хэрэгцээтэй эсэхийг хүлээн зөвшөөрөхгүй бол нэгдсэн хуралдаанаас үл хамааран тус төслийг шууд буцаах эрхтэй байдаг.

Солонгост "Ерөнхий хэлэлцүүлэг" (General discussion), Японд "Зорилго, үндэслэлийг сонсох" шатуудыг заавал явуулдаг. Энэ нь зүйл бүрээр хэлэлцүүлэгт орохоос өмнө төслийн үзэл баримтлалын алдааг засах, хууль санаачлагчаас асуулт асуух замаар төслийн ач холбогдлыг тодруулах боломжийг гишүүдэд олгодог байна.

Италийн Төлөөлөгчдийн танхимын хороод "Урьдчилсан хэлэлцүүлэг"-ийн шатанд тухайн асуудлыг заавал хуулиар шийдэх шаардлагатай эсэх, өөр арга хэрэгсэл байгаа эсэхийг үнэлдэг нь "зохицуулалтын үр нөлөө"-г хорооны түвшинд урьдчилан хянаж буй хэлбэр юм.

2. "Нэгдсэн хуралдаан төвтэй" Вестминстер загвар:

Британийн Вестминстер системээс эхтэй Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг улсад хуулийн төслийн үзэл баримтлалыг "Хоёрдугаар хэлэлцүүлэг" (Second reading) шатанд Парламентын нэгдсэн хуралдаанаар эхлэн хэлэлцдэг.

Дараалал: Нэгдсэн хуралдаанаар үзэл баримтлалыг нь зарчмын хувьд дэмжсэн тохиолдолд л төсөл Байнгын хороонд шилждэг.

Чиг үүрэг: Иймээс эдгээр улсын Байнгын хороод үзэл баримтлалыг дахин хэлэлцдэггүй бөгөөд шууд "зүйл бүрээр хэлэлцэх" (Clause-by-clause consideration) нарийвчилсан шат руу шилждэгээрээ онцлогтой.

Парламентын нэгдсэн хуралдааны шатанд хуулийн төслийн ерөнхий үзэл баримтлалыг хэлэлцэх нь тухайн төсөл хууль зүйн болон улс төрийн хувьд цаашид үргэлжлэх боломжтой эсэхийг тодорхойлдог гол шүүлтүүр юм. Олон улсын туршлагаас үзэхэд энэхүү үйл ажиллагааг

хэлэлцүүлгийн үе шат болон мэтгэлцээний хэлбэрээс нь хамаарч дараах дөрвөн үндсэн загварт хуваан үзэж болно.

- Вестминстер систем буюу "Хоёрдугаар хэлэлцүүлэг"-ийн загвар:

Канад, Сингапур, Энэтхэг зэрэг Англо-Саксон эрх зүйн бүлийн орнуудад хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх үйл явц нь "Хоёрдугаар хэлэлцүүлэг" (Second Reading) дээр төвлөрдөг.

Зарчмын мэтгэлцээн: Энэ шатанд зөвхөн төслийн ерөнхий давуу тал, хэрэгцээ шаардлага (merits and principles)-ыг хэлэлцдэг бөгөөд нарийвчилсан зүйл заалт руу орох, нэмэлт өөрчлөлт оруулахыг хатуу хориглодог.

Стратегийн санал: Канадын жишээгээр, хэрэв үзэл баримтлал нь тодорхойгүй эсвэл буруу гэж үзвэл төслийг бүхэлд нь 6 сараар хойшлуулах буюу "няцаах" санал гаргах эрх зүйн механизм үйлчилдэг.

- "Оршил мэтгэлцээн" болон "Ерөнхий мэтгэлцээн"-ий загвар:

Эх газрын эрх зүйн тогтолцоотой Швейцар, Герман, Франц, Итали зэрэг улсад хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэхээс өмнө "Ерөнхий мэтгэлцээн" (General debate)-ийг бие даасан үе шат болгон явуулдаг.

Улс төрийн зөвшилцөл: Швейцар улсад "Оршил мэтгэлцээн"-ээр төслийг хэлэлцэх эсэхээ нэг мөсөн шийддэг бол Германд Ахмадын зөвлөл эсвэл гишүүдийн квотын шаардлагаар ерөнхий мэтгэлцээнийг нээдэг байна.

Үе шатны тусгаарлалт: Америк болон Италид ерөнхий агуулгын мэтгэлцээнийг бүрэн дуусгаж, хаасны дараа л зүйл заалтын хэлэлцүүлэг рүү шилждэг нь бодлогын болон техникийн хэлэлцүүлгийг зааглаж буй хэлбэр юм.

- Урьдчилсан мэтгэлцээн ба "Нэгдүгээр хэлэлцүүлэг":

Эстони болон Өмнөд Африкийн парламентад төслийн үзэл баримтлалыг "Нэгдүгээр хэлэлцүүлэг"-ийн шатанд явуулдаг. Хяналтын механизм: Эстонид үндсэн хороо болон фракцуудаас төслийг буцаах санал гаргаагүй бол санал хураалтгүйгээр дараагийн шатанд шилждэг нь үйл ажиллагааг шуурхай болгодог. Харин Өмнөд Африкт энэ шатыг зөвхөн мэдээлэл сонсох, байр сууриа илэрхийлэх хэлбэрээр ашигладаг байна.

- Процедурыг хялбарчлах механизм:

Солонгосын тухайд Байнгын хорооны хяналтыг нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгээс илүүд үздэг онцлогтой. Байнгын хороогоор урьдчилан шүүгдэж орж ирсэн төслийн хувьд нэгдсэн хуралдаанаар асуулт хариулт, мэтгэлцээнийг алгасаж (omitted by resolution), шууд санал хураалт явуулахыг зөвшөөрдөг нь парламентын цаг ашиглалтыг үр дүнтэй болгох зохицуулалт юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>37 дугаар зүйл.Төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах</p> <p>37.1.Холбогдох Байнгын хороо шаардлагатай бол анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзан 10 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.</p>	<p>37 дугаар зүйл.Төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах</p> <p>37.1.Холбогдох Байнгын хороо шаардлагатай бол анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзан 10 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.</p>

37.2.Шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж болно.	37.2.Улсын Их Хурлын дарга шаардлагатай гэж үзвэл хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзан 15 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.
37.5.Энэ хуулийн 37.1, 37.2, 37.3-т заасан ажлын хэсэгт хууль санаачлагч орохгүй.	37.5.Энэ хуулийн 37.1, 37.2, 37.3-т заасан ажлын хэсэгт хууль санаачлагч болон тухайн төслийг хамтран санаачилсны дараа нэрээ татаж авсан гишүүн орохгүй.
37.6.Ажлын хэсгийн хуралдааныг ажлын хэсгийн ахлагч товлон зарлаж хуралдуулах ба гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. Хуралдаанаар олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.	37.6.Ажлын хэсгийн хуралдааныг ажлын хэсгийн ахлагч товлон зарлаж хуралдуулах ба гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. Хуралдаанаар олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
37.7.Ажлын хэсгийн хуралдаанд холбогдох салбарын мэргэжилтэн, шинжээчдийг татан оролцуулж болох ба Тамгын газрын ажилтнуудыг чиг үүргийнх нь дагуу байлцуулна. 37.8.Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг энэ хуулийн 135 дугаар зүйлд заасны дагуу хөтөлж, хадгална. 37.9.Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхтэй холбоотойгоор энэ зүйлд зааснаас өөр ажлын хэсэг, ажлын хэсгийн доор ажлын дэд хэсэг байгуулахгүй.	37.7.Нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар ажлын хэсгийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг хэлэлцэхэд ажлын хэсгийн ахлагч, гишүүн оролцож гишүүдийн асуултад хариулна. 37.8.Ажлын хэсгийн хуралдаанд холбогдох салбарын мэргэжилтэн, шинжээчдийг татан оролцуулж болох ба Тамгын газрын ажилтнуудыг чиг үүргийнх нь дагуу байлцуулна. 37.10.Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг энэ хуулийн 135 дугаар зүйлд заасны дагуу хөтөлж, хадгална.

Тайлбар: Ажлын хэсэг байгуулахтай холбогдох хэсэгт өөрчлөлт оруулж, шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзан 15 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болохоор тусгана. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох гишүүний тоог заагаагүйгээс хэт олон гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж, гишүүдийн ирц бүрдэхгүйгээс ажлын хэсэг хуралдаж чадахгүй байдал үүсдэг тул дээрх өөрчлөлтийг тусгана.

Хуулийн төсөл санаачлагчаас нэрээ татаж авсан гишүүн ажлын хэсэгт орохгүй байхаар тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: ОУ-ын парламентын практикт хуулийн төслийг мэргэжлийн түвшинд боловсруулах, намын бүлгүүдийн зөвшилцлийг хангах зорилгоор хязгаарлагдмал бүрэлдэхүүн бүхий ажлын хэсэг, түр хороо эсвэл дэд хороодыг байгуулах механизм түгээмэл ажиглагддаг. Энэхүү зохицуулалтыг дараах үндсэн загваруудаар ангилан үзэж болно.

- "Хууль тогтоох хороо" буюу Канад загвар: Канад Улсын Нийтийн танхимын дэг дэх "Хууль тогтоох хороо" (Legislative Committee) нь тодорхой нэг төслийг боловсруулах эсвэл хэлэлцүүлэгт бэлтгэх зорилгоор 15-аас илүүгүй гишүүнтэйгээр байгуулагддаг. Ингэхдээ намуудын суудлын харьцааг хатуу баримтлан гишүүдийг томилдог нь төслийн шатанд улс төрийн тэнцвэрт байдлыг хадгалах ач холбогдолтой. Тус хорооны даргыг Парламентын дарга (Speaker) шууд томилдог нь хороог "Үндсэн байнгын хороо"-ны нөлөөллөөс ангид, бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг байна.
- Маргаан зохицуулах ба Текст боловсруулах дэд хороод: Солонгос болон Итали улсад хуулийн төслийн эх бичвэр дээр ажиллах, эсвэл санал зөрүүтэй асуудлыг шийдвэрлэх нарийвчилсан механизм үйлчилдэг. Солонгост маргаантай төслийг зохицуулах зорилгоор

олонх, цөөнхийн төлөөллийг яг тэнцүү (3:3) байхаар хуваарилсан 6 гишүүнтэй "Асуудал зохицуулах хороо"-г байгуулдаг нь улс төрийн мухардлаас гарах үр дүнтэй механизм юм. Италийн парламентад цөөнхийн оролцоог заавал хангасан "Хязгаарлагдмал дэд хороо" байгуулж, хуулийн үг хэллэг, найруулга дээр мэргэжлийн түвшинд ажиллах эрхийг олгодог байна.

- Түр хороо болон Судалгааны комисс: Герман, Өмнөд Африк зэрэг улсад зөвхөн тухайн нэг даалгаврыг гүйцэтгэх "Түр хороо" (Ad hoc committee) эсвэл "Судалгааны комисс" (Study commission)-ыг байгуулдаг. Эдгээр нь намуудын суудлын харьцаагаар хувь тэнцүүлэн бүрдэх бөгөөд даалгавраа гүйцэтгэж, тайлангаа нэгдсэн хуралдаанд танилцуулмагц татан буугддаг уян хатан шинжтэй. Их Британийн "Нийтийн хуулийн төслийн хороо" (16-50 гишүүн) нь намын суудлын харьцаанаас гадна гишүүдийн хувийн ур чадвар, мэргэшсэн салбарыг харгалзан үздэгээрээ онцлогтой.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>38 дугаар зүйл.Төслийн талаар олон нийтээс санал авч, хэлэлцэх журам</p> <p>38.1.Нэгдсэн хуралдаан хуулийн төслийн талаар олон нийтээс санал авахаар шийдвэрлэсэн бол холбогдох Байнгын хороо уг ажлыг анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө дараах журмаар зохион байгуулна:</p> <p>38.1.1.тухайн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэх, сонирхлын бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг аль нэг хэлбэрийг сонгох;</p>	<p>38 дугаар зүйл.Төслийн талаар олон нийтээс санал авч, хэлэлцэх журам</p> <p>38.1.Нэгдсэн хуралдаан хуулийн төслийн талаар олон нийтээс санал авахаар шийдвэрлэсэн бол холбогдох Байнгын хороо уг ажлыг анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө дараах журмаар зохион байгуулна:</p> <p>38.1.1.тухайн төслийн талаар Улсын Их Хурлын цахим хуудас, төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон харилцаа холбооны хэрэгслээр санал авах, сонирхлын бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах хэлбэрийн аль нэгийг сонгох;</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын засаглал дахь хууль тогтоох үйл явц нь зөвхөн институцийнхээ хүрээнд бус, иргэний нийгэм, сонирхогч талуудын идэвхтэй оролцоон дээр суурилан илүү төгөлдөржих хандлагатай байна. Олон улсын туршлагаас үзэхэд олон нийтийн саналыг авах, хэлэлцүүлэх ажиллагааг дараах дөрвөн үндсэн хэлбэрээр хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Мэдээллийн ил тод байдал ба урьдчилсан танилцуулга:

Хуулийн төслийг өргөн барихаас өмнө болон хэлэлцүүлгийн эхний шатанд олон нийтэд мэдээлэх нь оролцоог хангах анхны алхам юм. Швейцар улсад "Хэлэлцүүлгийн журмын тухай хууль"-иар санал авах хугацааг дор хаяж 3 сараар тогтоосон байдаг бол Өмнөд Африк (3 долоо хоног), Солонгос (10 хоногоос багагүй) зэрэг улсад урьдчилан танилцуулах доод хугацааг нарийн зааж өгсөн байдаг. Мөн Шинэ Зеланд улсад ЗГ-аас хуулийн төсөл бүрд "Хэлэлцүүлгийн төлөвлөгөө" (Engagement plan) гаргадаг нь олон нийттэй харилцах ажиллагааг системтэй, зорилтот түвшинд явуулж буй хэлбэр юм.

2. Зарлан мэдээлэх ба бичгээр санал авах механизм:

Парламентын зөвхөн дотоод хэлэлцүүлгээс гадна нийт сонгогчдын дунд төслийг түгээж, албан ёсны санал авах тогтолцоо үйлчилдэг. Жишээлбэл, Энэтхэгийн парламентад төслийг "санал авах зорилгоор нийтэд тараах" тусгай дэг үйлчилдэг бол Сингапур болон Норвегт Парламентын Тамгын газар болон цахим хуудсаар дамжуулан нээлттэй урилга гаргаж, сонирхогч талуудаас бичгээр санал (submissions) авдаг байна. Энэ нь алслагдсан бүс нутгийн иргэд болон мэргэжлийн холбоодын байр суурийг тусгахад чухал ач холбогдолтой.

3. Нээлттэй болон нийтийн сонсгол (Public Hearings):

Амаар мэдээлэл өгөх, нүүр тулсан хэлэлцүүлэг өрнүүлэх нь хуулийн төслийн практик үр нөлөөг тодорхойлоход шийдвэрлэх нөлөө үзүүлдэг. Германд хорооны гишүүдийн 1/4-ийн шаардлагаар, Солонгост шинэ болон бүрэн найруулгын төсөл дээр нийтийн сонсголыг заавал хийх үүрэг хүлээдэг.

Япон болон Эстони улсад сонсголд оролцогчдыг зөвхөн сайн дурын хүсэлт гаргагчдаас бус, хорооны зүгээс нэр зааж урьсан эрдэмтэн судлаач, шинжээчдээр бүрдүүлдэг нь мэтгэлцээнийг мэргэжлийн түвшинд хадгалах боломжийг олгодог байна.

4. Иргэдийн шууд санаачилга ба хамтын оролцоо:

Хамгийн дэвшилтэт хэлбэр нь иргэд өөрсдөө хууль тогтоох үйл ажиллагааны "санаачлагч" болох механизм юм. Бразилын парламентад иргэд, төрийн бус байгууллагуудаас боловсруулсан төслийг хүлээн авч, албан ёсны хэлэлцүүлэгт оруулдаг тусгайлсан хороо ажилладаг. Эстони улсад иргэдийн "Хамтын санал" (Collective proposals)-ыг заавал хэлэлцэх журам үйлчилдэг нь иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, шууд ардчиллын элементүүдийг төлөөллийн ардчилалтай хослуулж буй хэлбэр юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>39 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах</p> <p>39.1.Холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлт гаргана. Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо нам, эвслийн бүлгээс гаргасан саналын дагуу төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар энэ хуулийн 11.2.2-т заасны дагуу урьдчилан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хүрээнд мэтгэлцээн явуулна.</p> <p>39.9.Хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг хуулийн төслийн талаарх тусгайлсан саналаа танилцуулна.</p> <p>39.14.Гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 39.17-д заасан зарчмын зөрүүтэй саналаа хууль, тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байна.</p> <p>39.15.Гишүүн, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан бол түүнийхээ үндэслэлийг 5 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлаж болно.</p> <p>39.19.Энэ хуулийн 39.16-д заасан зарчмын зөрүүтэй саналын нэг томьёоллоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа олонхын дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны саналд тооцон нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд цөөнх болсон нам, эвслийн бүлгийг төлөөлөх гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд тэмдэглүүлж нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.</p> <p>39.21.Байнгын хорооны санал хураалтаар санал нь дэмжигдээгүй цөөнх болсон нам, эвслийн бүлгийг төлөөлөх гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд</p>	<p>39 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах</p> <p>39.1.Холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлт гаргана. Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо нам, эвслийн бүлгээс гаргасан саналын дагуу энэ хуулийн 11.2.2-т зааснаар, эсхүл хэлэлцүүлгийн явцад гишүүний гаргасан саналын дагуу энэ хуулийн 11.8-д зааснаар мэтгэлцээн явуулна.</p> <p>39.9.Хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар танилцуулж, саналын томьёоллыг хэлэлцүүлнэ.</p> <p>39.14.Гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 39.17-д заасан зарчмын зөрүүтэй саналаа хууль, тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байна.</p> <p>39.15.Гишүүн, энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан бол түүнийхээ үндэслэлийг 5 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлаж болно. Хууль санаачлагч зарчмын зөрүүтэй саналын талаар 5 минутад багтаан тодруулга, тайлбар хийж болно.</p> <p>39.19.Энэ хуулийн 39.16-д заасан зарчмын зөрүүтэй саналын нэг томьёоллоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа олонхын дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны саналд тооцон нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд цөөнх болсон гишүүн Байнгын хорооны санал,</p>

тэмдэглүүлж, нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

39.22.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн, тухайн Байнгын хорооны гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.

39.27.Холбогдох Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан санал нь улсын болон орон нутгийн төсөв, түүнчлэн санхүү, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд шууд ба шууд бус байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулж болно.

39.28.Тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан иргэн, байгууллагаас бичгээр болон цахим хэлбэрээр санал ирүүлсэн, Байнгын хорооноос олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулсан бол энэ тухай мэдээллийг сонсоно.

39.29.Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан саналтай холбогдуулан тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэсэн, хууль зүйн зөвлөмж гаргуулсан бол тэдгээрийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

39.30.Тамгын газар энэ хуулийн 39.28, 39.29-т заасан санал, судалгаа, хууль зүйн зөвлөмжийг Байнгын хорооны хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараасан байна.

39.31.Энэ хуулийн 39.28, 39.29-д заасны дагуу тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэх, хууль зүйн зөвлөмж гаргуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах бол анхны хэлэлцүүлгийг түр хугацаагаар хойшлуулж болно.

39.33.Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтэд дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:

39.33.2.хууль зүйн зөвлөмж гаргуулсан бол түүний талаарх мэдээлэл.

дүгнэлтэд тэмдэглүүлж нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

39.20.Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна.

39.21.Байнгын хорооны санал хураалтаар санал нь дэмжигдээгүй цөөнх болсон гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд тэмдэглүүлж, нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

39.22.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн, тухайн Байнгын хорооны гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж олонхын санал авсан, аваагүйгээр нь нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.

39.27.Холбогдох Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан санал нь улсын болон орон нутгийн төсөв, түүнчлэн санхүү, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд шууд ба шууд бус байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл олон нийтээс санал авах ажиллагаа, эсхүл нийтийн сонсгол зохион байгуулж болно.

39.28.Тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан иргэн, байгууллагаас бичгээр болон цахим хэлбэрээр санал ирүүлсэн, Байнгын хорооноос олон нийтээс санал авсан, нийтийн сонсгол зохион байгуулсан бол энэ тухай мэдээллийг сонсоно.

39.29.Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан саналтай холбогдуулан тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэсэн, хууль зүйн дүгнэлт гаргуулсан бол Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан тэргүүн дэд, дэд дарга тэдгээрийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

39.30.Тамгын газар энэ хуулийн 39.28, 39.29-т заасан санал, судалгаа, үр нөлөөний үнэлгээ, хууль зүйн дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаан болохоос ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд тараасан байна.

39.31.Энэ хуулийн 39.28, 39.29-д заасны дагуу тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэх, хууль зүйн дүгнэлт гаргуулах, олон

	<p>нийтээс санал авах, эсхүл нийтийн сонгог зохион байгуулах бол анхны хэлэлцүүлгийг түр хугацаагаар хойшлуулж болно.</p> <p>39.33.Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:</p> <p>39.33.2.хууль зүйн дүгнэлт гаргуулсан бол түүний талаарх мэдээлэл.</p> <p>39.34.Энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан бол Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, түүний эзгүйд ажлын хэсгийн гишүүн танилцуулна.</p>
--	---

Тайлбар: Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахад Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч хуулийн төслийн талаар тодруулга, тайлбар хийж болохоор зохицуулсан нь төслийн талаар хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн үе шатанд асууж болохуйц асуулт, хариулт явагдах тохиолдол байгаа тул хуулийн 39.8 дахь хэсгийг хасаж, гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан тайлбар хийх, хууль санаачлагч гарсан зарчмын зөрүүтэй саналын талаар тодруулга, тайлбар хийж болохоор тусгана.

Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан бол Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, түүний эзгүйд ажлын хэсгийн гишүүн танилцуулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Хууль тогтоох үйл ажиллагааны чанарыг хангахад Байнгын хорооны шатны хэлэлцүүлэг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын парламентын туршлагаас үзэхэд хуулийн төслийг хороогоор хэлэлцэх эхлэлийн цэг болон дэс дарааллыг дараах хоёр үндсэн загварт хуваан үзэж болно.

1. "Үзэл баримтлал-судалгаа" төвтэй урьдчилсан хэлэлцүүлэг:

Эх газрын эрх зүйн бүлийн орнууд болон Азийн зарим ардчилсан улсад (Солонгос, Япон, Итали) Байнгын хороо нь хуулийн төслийн зүйл, заалт руу орохоос өмнө түүний "үзэл баримтлал" болон "хууль зүйн хэрэгцээ"-г шүүн хэлэлцэх урьдчилсан шатыг заавал явуулдаг.

Өмнөд Африкийн парламентад "Хэлэлцэх нь зүйтэй эсэх тогтоол" (Motion of desirability) батлах замаар төслийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх эсэхийг шийддэг бол Солонгост "Ерөнхий хэлэлцүүлэг"-ээр дамжуулан хууль санаачлагчтай бодлогын мэтгэлцээн өрнүүлдэг.

Итали болон Швейцарын байнгын хороод "урьдчилсан хэлэлцүүлэг"-ийн шатанд Үндсэн хуулийн нийцэл, олон улсын гэрээ (ЕХ-ны хууль тогтоомж) болон өөр арга хэрэгслээр шийдвэрлэх боломжтой эсэхийг үнэлдэг байна. Солонгост хорооны мэргэжлийн албанаас (Deputy Chief of Staff) гаргасан хараат бус хяналтын тайланг сонсдог нь шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргахад чухал үүрэгтэй.

2. "Зүйл, заалт" төвтэй Вестминстер загвар

Британийн Вестминстер системээс эхтэй Канад, Сингапур зэрэг улсад хуулийн төслийн ерөнхий зарчмыг Парламентын нэгдсэн хуралдаанаар (Хоёрдугаар хэлэлцүүлэг) аль хэдийн баталсан байдаг тул энэ тохиолдолд Байнгын хорооны чиг үүрэг илүү техникийн шинжтэй болдог.

Байнгын хороо нь ерөнхий үзэл баримтлалыг дахин хэлэлцдэггүй бөгөөд шууд зүйл, заалт бүрээр (clause-by-clause consideration) хэлэлцэж, нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхээ шийдвэрлэдэг.

Канадын жишээгээр хуулийн төслийн оршил (preamble) болон гарчигтай холбоотой заалтуудыг хамгийн сүүлд хэлэлцэхээр хойшлуулж, агуулгын зүйл, заалтуудыг эхэнд нь хэлэлцэх дэг үйлчилдэг нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлдэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>41 дүгээр зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах</p> <p>41.3.Нэгдсэн хуралдаанд асуулт, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч нэг хүртэл цагаар сунгаж болно.</p> <p>41.4.Хуралдаан даргалагч энэ хуулийн 9.2, 9.3-т заасны дагуу нам, эвслийн бүлгээс болон аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүнээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт, хариултыг зохион байгуулна.</p> <p>41.5.Асуулт, хариулт дууссаны дараа Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол тус бүрээр дараах журмаар санал хураалт явуулна:</p> <p>41.5.1.хуулийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа санал хураалт явуулах;</p> <p>41.5.2.хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй санал тус бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.</p> <p>-</p>	<p>41 дүгээр зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах</p> <p>41.3.Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч нэг хүртэл цагаар сунгаж болно. Асуултад холбогдох Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч, түүний эзгүйд санал, дүгнэлт танилцуулсан гишүүн хариулна.</p> <p>41.4.Хуралдаан даргалагч энэ хуулийн 9.2-т заасны дагуу асуулт, хариултыг зохион байгуулна.</p> <p>41.5.Асуулт, хариулт дууссаны дараа Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор дараах журмаар санал хураалт явуулна:</p> <p>41.5.1.хуулийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай тус бүр 3 хүртэл гишүүн үг хэлсний дараа санал хураалт явуулах;</p> <p>41.5.2.хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй саналын томьёолол бүрээр Байнгын хороо дэмжсэн, дэмжээгүйг танилцуулж, уг зарчмын зөрүүтэй саналыг “дэмжинэ” гэсэн томьёоллоор санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.</p> <p>41.5.3.хуралдаан даргалагч Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагчийн саналаар тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлэх.</p>

Тайлбар: Ажлын хэсгийн ахлагч, гишүүн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд заавал оролцож асуултад хариулдаг байх, улмаар Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн санал дүгнэлтийг хэрэв хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулан ажиллуулсан бол ажлын хэсгийн ахлагч, эсхүл гишүүн танилцуулдаг байхаар тусгана. Асуултад Байнгын хорооны дарга, эсхүл ажлын хэсгийн ахлагч хариулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын нэгдсэн хуралдааны анхны шат буюу "Анхны хэлэлцүүлэг" (First Reading / Introductory Debate) нь тухайн хуулийн төслийг хэлэлцэх улс төрийн болон эрх зүйн үндэслэл байгаа эсэхийг баталгаажуулдаг гол шүүлтүүр юм. Олон улсын туршлагаас үзэхэд энэхүү үе шатыг хэрэгжүүлж буй хэлбэр, агуулгын хувьд дараах гурван үндсэн загварт хуваан үзэж болно.

- Вестминстер загвар: Формаль танилцуулга ба бүртгэлийн үе шат:

Их Британи, Канад, Сингапур зэрэг Англо-Саксон эрх зүйн бүлийн орнуудад хуулийн төслийн нэгдүгээр хэлэлцүүлэг нь цэвэр процедурын шинжтэй байдаг.

Шинж чанар: Энэ шатанд ямар нэгэн агуулгын мэтгэлцээн, асуулт хариулт эсвэл санал хураалт явагддаггүй бөгөөд зөвхөн хуулийн төслийн нэрийг уншиж танилцуулан, парламентад албан ёсоор бүртгэх үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү загвар нь хуулийн төслийг нийтэд зарлан мэдээлэх, гишүүдэд судлах хугацаа олгоход чиглэгддэг бөгөөд жинхэнэ үзэл баримтлалын мэтгэлцээн нь дараагийн буюу "Хоёрдугаар хэлэлцүүлэг"-ийн шатанд өрнөдөг онцлогтой.

- Концепцын загвар: Үзэл баримтлал, ерөнхий зарчмыг хэлэлцэх:

Герман, Эстони, Өмнөд Африк, Шинэ Зеланд зэрэг улсад анхны хэлэлцүүлэг нь төслийн ерөнхий агуулга, үзэл баримтлалыг шүүн хэлэлцэх бодлогын мэтгэлцээн болдог. Энэ шатанд нарийвчилсан зүйл заалт, техникийн нэмэлт өөрчлөлт оруулахыг хатуу хориглох бөгөөд зөвхөн "хууль гаргах хэрэгцээ шаардлага" болон "үндсэн зарчим"-д төвлөрдөг. Шинэ Зеландад мэтгэлцээний дараа санал хурааж, дэмжигдсэн тохиолдолд холбогдох хороонд шилжүүлдэг бол Эстони, Өмнөд Африкт зарчмын зөрүүтэй санал гараагүй тохиолдолд санал хураалтгүйгээр дараагийн шатанд шилжүүлдэг уян хатан дэг үйлчилдэг.

- Холимог болон "Урьдчилсан мэтгэлцээн"-ий загвар:

Швейцар, Итали, Солонгос зэрэг орнуудад нэгдсэн хуралдааны эхний шат нь байнгын хорооны дүгнэлттэй нягт уялдаатай байдаг. Швейцар Улсын "Оршил мэтгэлцээн" (Introductory debate) нь тухайн асуудлыг хэлэлцэх эсэхийг шууд шийддэг бол Италид ерөнхий агуулгын мэтгэлцээнийг заавал дуусгаж байж техникийн хэлэлцүүлэг рүү шилждэг. Солонгост хороогоор урьдчилан хэлэлцэгдсэн төслийн хувьд нэгдсэн хуралдааны мэтгэлцээнийг алгасаж, шууд санал хураалт руу шилжих замаар үйл ажиллагааг шуурхайлах боломжийг хуульчилсан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>42 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах</p> <p>42.1.3.энэ хуулийн 42.1.1-д заасан танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуух.</p> <p>42.2.2.анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо, эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх хууль зүйн зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо дэмжиж санал, дүгнэлт гаргасан;</p> <p>42.4.Байнгын хороогоор хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дүнд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, танилцуулгыг санал хураалгах томьёоллын хамт Улсын Их Хурлын нийт гишүүнд тараана.</p> <p>42.5.Анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно.</p> <p>42.6.Энэ хуулийн 42.5-д заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол</p>	<p>42 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах</p> <p>42.1.3.энэ хуулийн 42.1.1-д заасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуух.</p> <p>42.2.2.анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо, эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх Тамгын газрын хууль зүйн дүгнэлтийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо дэмжиж санал, дүгнэлт гаргасан;</p> <p>42.4.Гишүүн горимын санал гаргаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хүрээнд энэ хуулийн 11.8, 11.9-д заасныг баримтлан мэтгэлцээнийг зохион байгуулна.</p> <p>42.5.Байнгын хороогоор хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дүнд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, танилцуулгыг санал хураалгах томьёоллын хамт Улсын Их Хурлын нийт гишүүнд тараана.</p>

<p>тухайн Байнгын хороо уг төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн байна.</p> <p>42.7.Төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх болон энэ хуулийн 42.5-д заасан төслийг боловсруулах ажлыг холбогдох Байнгын хороо хариуцан гүйцэтгэнэ.</p> <p>42.8.Энэ хуулийн 42.5-д заасны дагуу боловсруулсан төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн батална.</p> <p>-</p>	<p>42.6.Анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно.</p> <p>42.7.Энэ хуулийн 42.6-д заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол тухайн Байнгын хороо уг төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн байна.</p> <p>42.8.Төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх болон энэ хуулийн 42.6-д заасан төслийг боловсруулах ажлыг холбогдох Байнгын хороо хариуцан гүйцэтгэнэ.</p> <p>42.9.Энэ хуулийн 42.6-д заасны дагуу боловсруулсан төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн батална.</p>
--	---

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>43 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах</p> <p>43.2.Гишүүн энэ хуулийн 9.2, 9.3-т заасан журмын дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асууж болно.</p> <p>43.3.Байнгын хороо энэ хуулийн 42.4-т заасны дагуу санал хураалгах томъёолол оруулсан бол уг саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа хуралдаан даргалагч саналын томъёолол тус бүрийг уншиж сонсон санал хураалт явуулна.</p> <p>43.4.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 43.3-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа тухайн хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.</p>	<p>43 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах</p> <p>43.2.Гишүүн энэ хуулийн 9.2-т заасан журмын дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асууж болно.</p> <p>43.3.Байнгын хороо энэ хуулийн 42.4-т заасны дагуу санал хураалгах томъёолол оруулсан бол уг саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай тус бүр 3 хүртэл гишүүн үг хэлсний дараа хуралдаан даргалагч саналын томъёолол тус бүрийг уншиж сонсон санал хураалт явуулна.</p> <p>43.4.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 43.3-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа тухайн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.</p>
<p>44 дүгээр зүйл.Хуулийн төслийг эцэслэн батлах</p> <p>44.1.Байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүнд үндэслэн эцэслэн батлуулах төслийн хувилбарыг бэлтгэж, нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө гишүүдэд тараасан байна.</p> <p>-</p>	<p>44 дүгээр зүйл.Хуулийн төслийг эцэслэн батлах</p> <p>44.1.Байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүнд үндэслэн эцэслэн батлах төслийн хувилбарыг бэлтгэж, нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө гишүүдэд тараасан байна.</p> <p>44.7.Энэ хуулийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн баталсны дараа хуралдаан</p>

даргалагч батлагдсан хуулийн агуулга, ач холбогдлын талаар үг хэлж болно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн баталсны дараах үйл ажиллагаа нь олон улсын практикт голчлон процедурын болон захиргааны шинжтэй байдаг. Судалгаанд хамрагдсан 17 улсын парламентын дэгийн зохицуулалтаас үзэхэд хууль батлагдсаны дараа хуралдаан даргалагч (Спикер) тухайн хуулийн агуулга, ач холбогдлыг дүгнэн танилцуулдаг тусгайлсан дэг байхгүй бөгөөд энэхүү чиг үүрэг нь хэлэлцүүлгийн өмнөх болон дунд шатанд бусад субъектуудаар дамжин хэрэгждэг байна.

Хуулийн ач холбогдлыг танилцуулах өөр төрлийн механизмууд:

Хуулийн ач холбогдлыг тайлбарлах үйл явц нь олон улсад хууль батлагдсаны дараа бус, харин шийдвэр гаргахын өмнөх шатуудад дараах хэлбэрээр тусгагддаг:

- Байнгын хорооны даргын тайлан (Ex-ante): Солонгос, Япон болон Өмнөд Африкт хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эхлэх үед Хорооны дарга нь тухайн төслийн агуулга, үзэл баримтлал, хэлэлцүүлгийн үр дүнг нэгдсэн хуралдаанд тайлагнадаг. Энэ нь гишүүдэд батлах гэж буй хуулийнхаа ач холбогдлыг урьдчилан таних боломжийг олгодог.
- Саналын үндэслэлийн тайлбар (Justification): Европын эх газрын системийн орнуудад (Франц, Герман, Итали, Швейцар) эцсийн санал хураалтын өмнөхөн намын бүлгүүд болон гишүүдэд тухайн хуулийн ач холбогдлыг дүгнэж, өөрсдийн байр суурийг тайлбарлах (Explanation of vote) тусгай цаг олгодог.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
45 дугаар зүйл.Тогтоолын төслийг хэлэлцэх 45.1.Улсын Их Хурал энэ хуулийн Арван нэгдүгээр бүлэгт зааснаас бусад асуудлаарх тогтоолын төслийг хэлэлцэх эсэх, анхны болон эцсийн хэлэлцүүлгийн үе шаттайгаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хуулийн төслийг хэлэлцэх журмыг баримтална. 45.3.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргана.	45 дугаар зүйл.Тогтоолын төслийг хэлэлцэх 45.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх, анхны болон эцсийн хэлэлцүүлгийн үе шаттайгаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хуулийн төслийг хэлэлцэх журмыг баримтална. 45.3.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны, хуульд заасан тохиолдолд дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын үйл ажиллагааны хүрээнд тогтоолын төсөл (Resolution/Bill) нь хууль тогтоомжийн адил эрх зүйн ач холбогдолтой шийдвэр байдаг тул олон улсын практикт үүнийг хэлэлцэх үйл явцыг хуулийн төсөлтэй ижил буюу ижил төстэй шат дамжлагаар дамжуулан чанаржуулдаг байна. Олон улсын парламентын туршлагыг дараах үндсэн гурван чиглэлээр системчлэн дүгнэж болно.

1. Тогтоолын төслийг хуулийн төсөлтэй ижил үе шаттайгаар хэлэлцэх журам:

Тогтоолын төсөл нь хууль тогтоох байгууллагын бодлогын болон захиргааны шийдвэрийн үндэс болдог тул түүнийг "уншлага" (reading) буюу үе шат бүхий хэлэлцүүлэгт оруулдаг.

Эстони улсын практикт тогтоолын төслийг хуулийн төслийн 2 болон 3 дугаар уншлагатай ижил горимоор хэлэлцдэг нь уг баримт бичгийн эрх зүйн үнэ цэнийг хуультай дүйцүүлж буй хэрэг юм.

Солонгосын Үндэсний Ассамблейд хууль болон тогтоолын төслийг "Bill" (Төсөл) хэмээх нэгдсэн ойлголтод багтаан, хэлэлцүүлгийн нэг ижил дэгийг мөрдүүлдэг нь парламентын үйл ажиллагааг нэгдмэл, системтэй болгодог байна.

2. Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны тайлан, санал дүгнэлтийг сонсох дэг:

Парламентын эцсийн шийдвэр гаргах түвшин буюу Нэгдсэн хуралдаанд мэргэжлийн Байнгын хорооны дүгнэлт "шүүлтүүр" болж оролцдог.

Солонгосын дэгийн 93 дугаар зүйлд зааснаар аливаа төслийг хэлэлцэхэд хамгийн түрүүнд Хорооны даргын "хяналтын тайлан" (report on the examination)-г сонсох ёстой байдаг. Энэ нь МУ-ын УИХ-ын дэгийн 45.3 дахь заалттай агуулгын хувьд бүрэн нийцэж буй нийтлэг жишиг юм.

Канад болон Өмнөд Африкийн парламентад тогтоолыг батлахдаа хорооны гаргасан зөвлөмж, тайланг хэлэлцүүлгийн суурь болгон ашигладаг. Энэ нь Нэгдсэн хуралдаан дээрх улс төрийн мэтгэлцээнийг мэргэжлийн хорооны бэлтгэсэн баримт, өгөгдөл дээр төвлөрүүлэх ач холбогдолтой.

3. Хорооны санал дүгнэлтийн халдашгүй байдал ба зөвлөмжийн шинж:

Байнгын хорооны санал дүгнэлт нь Нэгдсэн хуралдаанаар орохдоо тухайн төслийн "хувь заяа"-г тодорхойлох бодит хүчин зүйл болдог.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейд хорооны тайланд тусгагдсан "батлуулах санал, зөвлөмж"-өөс бусад агуулгад Нэгдсэн хуралдааны үеэр өөрчлөлт оруулахыг хориглодог. Энэ нь мэргэжлийн хорооны ажлыг хүндэтгэх, хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулах эрх зүйн хамгаалалт болдог байна.

Канадын парламентад "Парламентын бүх гишүүдийн хороо"-гоор тогтоолын төслийг урьдчилан хэлэлцэж, зөвшилцөлд хүрсний дараа Нэгдсэн хуралдаан дээр тэрхүү үр дүнгээ тайлагнадаг нь хамтын шийдвэр гаргах үйл явцыг баталгаажуулж буй хэлбэр юм.

2.4.ТАВДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ: ТОГТООЛЫН ЭЦСИЙН НАЙРУУЛГА ХИЙХ, ЁСЧЛОХ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>46 дугаар зүйл.Хууль, тогтоолын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулах, ёсчлох</p> <p>46.3.Хуулийн эцсийн найруулгыг энэ хуулийн 46.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно.</p> <p>46.4.Энэ хуулийн 46.3-т заасны дагуу ёсчилсон хуулийг Тамгын газар ажлын 2 өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээнэ.</p> <p>46.5.Энэ хуулийн 46.4-т заасны дагуу илгээсэн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>46.7.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы чөлөө цагт хууль, тогтоолд хориг тавьсан бол уг хоригийг ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш энэ хуулийн 46.6-д заасан хугацаанд хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>	<p>46 дугаар зүйл.Хууль, тогтоолын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулах, ёсчлох</p> <p>46.3.Хууль, тогтоолын эцсийн найруулгыг энэ хуулийн 46.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно.</p> <p>46.4.Энэ хуулийн 46.3-т заасны дагуу ёсчилсон хууль, тогтоолыг Тамгын газар ажлын 2 өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээнэ.</p> <p>46.5.Энэ хуулийн 46.4-т заасны дагуу илгээсэн хууль, тогтоолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>46.7.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы чөлөө цагт хууль, тогтоолд хориг тавьсан бол уг хоригийг ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш ажлын 10 өдрийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>

Тайлбар: Хуулийн нэр томъёог жигдлэх өөрчлөлтийг тусгана. Монгол Улсын Ерөнхийлөгч хууль, тогтоолд хориг тавихтай холбогдох зохицуулалт буюу 46 дугаар зүйл, 90 дүгээр зүйлд хугацаа зөрүүтэй байгааг нийцүүлж өөрчилнө.

2.5.ДОЛООДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>57 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>57.4.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг дэмжээгүй бол Байнгын хороо тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг тогтоолын төсөлд буцаах үндэслэлийг тусгасан байна.</p>	<p>57 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>57.4. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг дэмжээгүй бол Байнгын хороо тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг тогтоолын төсөлд буцаах үндэслэлийг тусгасан байна.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>58 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>58.4.Гишүүн үг хэлсний дараа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар холбогдох Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.</p> <p>58.5.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.</p> <p>58.6.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн үзэл баримтлалыг дэмжээгүй бол тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.</p>	<p>58 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>58.4.Гишүүн үг хэлсний дараа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулна.</p> <p>58.5.Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол <i>төслийг</i> анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.</p> <p>58.6.Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Хууль тогтоох дээд байгууллагын нэгдсэн хуралдаанаар асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах ирцийг тогтоох, мөн үзэл баримтлалын түвшинд мэтгэлцэх зохицуулалт нь парламентын ардчиллын легитим шинж чанарыг хангах суурь нөхцөл болдог. ОУ-ын парламентын практикт эдгээр үйл явцыг институцийн удирдлага, бодит оролцоонд суурилсан ирц, бодлогын концепцын хэлэлцүүлэг гэсэн харилцан уялдаатай чиглэлүүдээр зохицуулж байна.

Хэлэлцэх асуудлын тов, дарааллыг тогтоох нь парламентын үйл ажиллагааны стратегийн удирдлагын чухал хэсэг юм. ОУ-ын жишгээс харахад уг шийдвэрийг дан ганц нэг хорооны саналд тулгуурлах бус, парламентын удирдлагын хамтын байгууллагаар дамжуулан баталгаажуулдаг.

Германы Бундестагт “Ахмадын зөвлөл”, Франц Улсад “Ерөнхийлөгчдийн зөвлөл”, Швейцарт “Товчоо” зэрэг байгууллагууд хэлэлцэх асуудлын жагсаалтыг намын бүлгүүдтэй зөвшилцөн баталдаг нь институцийн зохицуулалтын өндөр түвшнийг илэрхийлдэг. Ийм хамтын удирдлагын тогтолцоо нь парламентын үйл ажиллагааг улс төрийн болон цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн уян хатан төлөвлөх боломжийг бүрдүүлдэг.

Нөгөө талаас, шийдвэр гаргах ирцийг зөвхөн санал өгсөн гишүүдээр бус, хуралдаанд бодитоор оролцсон бүрэлдэхүүнээр тодорхойлох нь гишүүдийн оролцоог илүү бодитой үнэлэх үндэс болдог. Солонгос болон Умард Македоны жишгээр нийт гишүүдийн тодорхой босго ирц бүрдсэн тохиолдолд хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэр гаргах зохицуулалт үйлчилж байна. Энэ нь гишүүдийг зөвхөн санал өгөх төдий бус, хэлэлцүүлгийн үйл явцад идэвхтэй оролцох хариуцлагыг нэмэгдүүлдэг. Үүнтэй уялдан, Швейцарын парламент гишүүн бүрийн ирцийн төлөвийг (оролцсон, оролцоогүй, түдгэлзсэн гэх мэт) нарийвчлан бүртгэж, олон нийтэд мэдээлдэг нь ил тод байдлыг хангах, сонгогчдын хяналтыг бодитой хэрэгжүүлэх чухал механизм болж байна.

Мөн баримт бичгийг нарийвчилсан зүйл заалтын шатанд шилжүүлэхээс өмнө үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь хууль тогтоох үйл явцын чанарыг тодорхойлох стратегийн ач холбогдолтой үе шат юм. Оросын Төрийн Думын туршлагаас харахад анхны хэлэлцүүлгээр хуулийн төслийн үзэл баримтлал, Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд голлон анхаарч, төслийн суурь үндэслэлийг тодорхойлдог. Харин Финланд, Солонгос, Япон зэрэг улсад төслийн зорилго, хэрэгжүүлэх арга замыг ерөнхий түвшинд хэлэлцэж, зарчмын хувьд дэмжих эсэхийг шийдвэрлэсний үндсэн дээр дараагийн шатны нарийвчилсан хэлэлцүүлгийг үргэлжлүүлдэг байна.

Хэлэлцүүлгийн үйл явцад оруулсан эдгээр зохицуулалтууд нь парламентын үйл ажиллагааг хамтын удирдлага, бодит оролцоонд суурилсан ирц, бодлогын концепцын түвшний хэлэлцүүлэг гэсэн гурван үндсэн тулгуур дээр хөгжүүлэхэд чиглэж байна. Энэ нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг олон улсын сайн засаглалын зарчимд нийцүүлж, шийдвэр гаргах үйл явцыг илүү чанартай, хариуцлагатай, ил тод болгоход чиглэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>59 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах</p> <p>59.2.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.</p> <p>59.5.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн талаар тайлбар хийж болно.</p>	<p>59 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах</p> <p>59.2.Бусад Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.</p> <p>59.5.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч гишүүн, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан тайлбар хийж болно.</p>

Тайлбар: Тус зүйлээр бодлого, төлөвлөлийн баримт бичгийн анхны хэлэлцүүлгийг явуулах журмыг хуульчилсан. Анхны хэлэлцүүлгийн шатанд Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн талаар тайлбар хийж болохоор заасан тухайн хэсгийг хэрэглэх явцад анхны хэлэлцүүлгийн бус хэлэлцэх эсэхийн чанартай асуулт, хариулт явагдаж байгааг өөрчилнө.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын Байнгын хороо нь хууль тогтоомжийн төслийг нарийвчлан хэлэлцэх үндсэн институцийн талбарын хувьд хууль санаачлагчийн тайлбар, илтгэлийг сонсох нь төслийн зорилго, хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг нэг мөр ойлгоход зайлшгүй шаардлагатай нөхцөл болдог. ОУ-ын парламентын практикт хууль санаачлагчийн оролцоо нь хэлэлцүүлгийн чанар, ил тод байдал, хариуцлагын түвшнийг тодорхойлох чухал хүчин зүйл гэж үздэг.

Хууль санаачлагчийн илтгэлийг хэлэлцүүлгийн эхлэл цэг болгон үзэх нь парламентын дэгийн нийтлэг стандарт юм. Эстони, Япон зэрэг улсын парламентын жишгээр хэлэлцүүлэг нь санаачлагч этгээдийн албан ёсны илтгэлээр эхэлж, төслийн үзэл баримтлал, зорилго, зохицуулах хүрээг танилцуулах институцийн механизм болж үйлчилдэг. Энэ нь гишүүдэд хэлэлцэж буй асуудлын суурь ойлголтыг нэгэн жигд хүргэх ач холбогдолтой.

Үүнтэй уялдан, хууль санаачлагч нь зөвхөн тайлбар өгөх төдийгүй төслөө хамгаалах, асуултад хариулах үүрэг хүлээдэг. Солонгос болон Францын парламентын туршлагаас харахад санаачлагч нь хэлэлцүүлгийн явцад идэвхтэй оролцож, гишүүдийн асуултад хариулан, төслийн үндэслэл, хэрэгжилтийн боломжийг тодруулж өгдөг. Энэ нь парламентын хяналтын чиг үүргийг бодитой хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй. Мөн Германы Бундестагт хууль санаачлагч тухайн Байнгын хорооны гишүүн биш байсан ч хуралдаанд оролцож, тайлбар хийх эрхээр хангагддаг нь парламентын дотоод ардчилал, нээлттэй байдлын илэрхийлэл болдог.

Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэлэлцүүлгийн хувьд аман илтгэл, тайлбар нь бичмэл материалын мэдээллийг гүнзгийрүүлж, асуудлын мөн чанарыг илүү тодорхой болгох ач холбогдолтой. Өмнөд Африк болон Умард Македоны парламентын жишгээс үзэхэд санаачлагчийн товч танилцуулга нь гишүүдийн дунд илүү идэвхтэй, “амьд” мэтгэлцээнийг өрнүүлэх, асуудлыг олон өнцгөөс хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлдэг байна.

ОУ-ын парламентын туршлагад хууль санаачлагчийн тайлбар, илтгэлийг хэлэлцүүлгийн салшгүй, чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>63 дугаар зүйл.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэх</p> <p>63.11.Холбогдох Байнгын хороо нь гишүүн, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналуудыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн, нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>63.13.Нэгдсэн хуралдаан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх Байнгын хороодын санал, дүгнэлтийг хэлэлцэн санал хураалт явуулна.</p>	<p>63 дугаар зүйл.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэх</p> <p>63.11.Холбогдох Байнгын хороо нь гишүүн, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналуудыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.</p> <p>63.13.Нэгдсэн хуралдаан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн санал хураалт явуулна.</p>
<p>64 дүгээр зүйл.Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх</p> <p>64.1.Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн батална:</p> <p>64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, гишүүд Төсвийн</p>	<p>64 дүгээр зүйл.Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх</p> <p>64.1.Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн батална:</p> <p>64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, гишүүд Төсвийн</p>

<p>тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно. Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хүргүүлнэ. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар Байнгын хороодын санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах</p>	<p>тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно. Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэгтгэн, санал хураалтын дүнгийн хамт санал, дүгнэлтэд хавсарган Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хүргүүлнэ. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар тухайн Байнгын хороодын гишүүд болон бусад Байнгын хороодын санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгах;</p>
--	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр нь салбар дундын шинжтэй, өргөн хүрээний бодлогын баримт бичиг байдаг тул түүнийг парламентын түвшинд хэлэлцэхдээ төрөлжсөн буюу холбогдох Байнгын хороодод хуваарилан авч үзэх нь хяналтын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болдог. ОУ-ын парламентын практикт асуудлыг бүх хороогоор ерөнхий байдлаар хэлэлцүүлэхээс илүүтэйгээр тухайн салбарын мэдлэг, мэргэшил бүхий хороонд хариуцуулан шийдвэрлэх зарчим давамгайлж байна.

Асуудлын харьяаллыг оновчтой тогтоох нь парламентын үйл ажиллагааны зохион байгуулалтын чухал хэсэг юм. Олон улсын жишгээс харахад асуудлыг “чадамжтай” (competent) буюу холбогдох Байнгын хороонд шилжүүлэх нь шийдвэр гаргах үйл явцын чанарыг дээшлүүлэхэд чиглэдэг. Солонгос болон Швейцарт Парламентын дарга, эсхүл Товчоо нь хороодын хоорондын харьяаллын маргааныг эцэслэн шийдвэрлэж, тухайн асуудлыг хариуцах Байнгын хороог тодорхойлон тогтоодог. Энэ нь хууль тогтоох үйл ажиллагаанд эрх зүйн тодорхой байдал, зохион байгуулалтын нэгдмэл байдлыг хангах чухал тогтолцоо юм.

Нөгөө талаас салбарын мэргэшсэн хяналт нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг илүү бодитой үнэлэх боломжийг бүрдүүлдэг. Шинэ Зеландын “Асуудал эрхэлсэн хороод” болон Италийн парламентын туршлагаас үзэхэд хороо бүр өөрийн хариуцсан чиглэлийн хүрээнд бодлогын зорилт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг. Энэ нь хэлэлцүүлгийг ерөнхий, тойм байдлаас илүү мэргэжлийн, гүнзгий түвшинд явуулах нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд бодлогын алдаа, нөөцийн хуваарилалтын зөрчлийг илрүүлэхэд өндөр ач холбогдолтой.

Цогц шинжтэй, олон салбарын эрх ашиг хөндсөн асуудлыг хэлэлцэхдээ хороод хоорондын хамтын ажиллагааны зохион байгуулалт онцгой чухалд тооцогддог. Энэ хүрээнд “голлон хариуцах хороо” болон “санал хүргүүлэх хороо”-ны ялгамжийг тогтоох нь олон улсын нийтлэг практик юм. Германы Бундестагт тодорхой асуудлыг нэг Байнгын хороонд голлон хариуцуулж, бусад холбогдох хороод нь өөрсдийн чиглэлээр санал, дүгнэлт боловсруулан хүргүүлдэг. Энэхүү зохицуулалт нь саналын зөрүүг зохистой нэгтгэх, эцсийн дүгнэлтийг нэгдмэл байдлаар боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Финланд Улсын туршлагаас харахад тухайн асуудлыг хариуцсан хороо нь өөрт шилжүүлсэн баримт бичгийг хугацаанд нь хэлэлцэж, шийдвэрлэх үүрэг хүлээдэг бөгөөд ингэснээр асуудал эзэнгүйдэх, удаашрах эрсдэл буурдаг. Мөн хороодын чиг үүрэг тодорхой болсноор парламентын хяналтын үйл ажиллагаа давхцах, эсхүл орхигдох нөхцөл үүсэхээс сэргийлдэг.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг “холбогдох Байнгын хороо”-нд хуваарилан хэлэлцүүлэх зохицуулалт нь парламентын үйл ажиллагааг системтэй, салбарын мэргэшилд тулгуурласан, үр ашигтай болгоход чиглэсэн олон улсын шилдэг туршлагад нийцсэн дэвшилтэт

шийдэл юм. Энэхүү хандлага нь парламентын хяналтын механизмыг чанаржуулж, ЗГ-ын үйл ажиллагаанд тавих хариуцлагыг бэхжүүлэх эрх зүйн чухал баталгаа болж байна.

2.6.НАЙМДУГААР БҮЛЭГ: ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, МӨНГӨНИЙ БОДЛОГО, ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТӨСӨВ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>65 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>65.1.Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл /цаашид “жилийн төлөвлөгөөний төсөл” гэх/-ийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй уялдуулан хэлэлцэнэ.</p> <p>65.3.Байнгын хорооны хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлт гарган, түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.</p> <p>65.5.Гишүүн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, тодруулах асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.</p> <p>65.6.Улсын Их Хурал энэ зүйлд заасны дагуу жилийн төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-т заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулна.</p> <p>65.7.Энэ хуулийн 65.6-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол жилийн төлөвлөгөөний төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.</p> <p>65.8.Хуралдаан даргалагч жилийн төлөвлөгөөний төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ. Энэ талаар санал хураалт явуулахгүй.</p>	<p>65 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлэг явуулах</p> <p>65.1.Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл /цаашид “жилийн төлөвлөгөөний төсөл” гэх/-ийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан хэлэлцэнэ.</p> <p>65.3.Холбогдох Байнгын хорооны хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-т заасан шаардлага хангасан эсэх талаар санал, дүгнэлт гарган, түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.</p> <p>65.5.Гишүүн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>65.6.Нэгдсэн хуралдаанаар энэ зүйлд заасны дагуу жилийн төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-т заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулна.</p> <p>65.7.Энэ хуулийн 65.6-д заасан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол жилийн төлөвлөгөөний төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.</p> <p>65.8.Энэ хуулийн 65.6-д заасан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуралдаан даргалагч жилийн төлөвлөгөөний төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ. Энэ талаар санал хураалт явуулахгүй.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (65.1): ОУ-ын туршлагаас үзэхэд засгийн газрын хөгжлийн бодлогыг төсөвтэй салшгүй уялдуулан хэлэлцдэг тусгайлсан дэгүүд үйлчилж байна.

Швейцарт "хууль тогтоох болон санхүүгийн нэгдсэн төлөвлөлт"-ийн талаар Парламентын тухай хуулийн (ParlA) 143 дугаар зүйлийн 2, 146 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тусгасан бөгөөд хөгжлийн төлөвлөгөө нь санхүүгийн төлөвлөгөөтэй нягт уялдсан байхыг шаарддаг.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 118-bis дүгээр зүйлд заасан "Эдийн засаг, санхүүгийн төлөвлөлтийн баримт бичиг"-ийг, мөн дэгийн 119 дүгээр зүйлд заасан Төсвийн хуулийг

үндэсний эдийн засгийн бодлогын бусад баримт бичгийн хамт төсвийн тусгай чуулганаар (төсөв хэлэлцэхэд зориулж хуулиар тогтоосон 45 хоногийн тусгайлсан хугацаа) хэлэлцэж баталдаг.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 340 дүгээр зүйлд зааснаар "Төсвийн бодлогын мэдэгдэл"-ийг төсвийн төслөөс өмнө хороогоор хянуулан хэлэлцүүлдэг байна.

(65.3.):

Италийн Депутатуудын танхимын дэгийн 118-bis дүгээр зүйлийн 1-д зааснаар Эдийн засаг, санхүүгийн төлөвлөлтийн баримт бичгийг Төсвийн хороо хэлэлцэж, нэгдсэн хуралдаанд илтгэл танилцуулдаг. Мөн дэгийн 79 дүгээр зүйлийн 12-т "Хэлэлцүүлгийн төгсгөлд Хороо илтгэгчийг томилох бөгөөд түүнд өөрийн бэлтгэсэн илтгэлийг нэгдсэн хуралдаанд илтгэх мандат олгоно" хэмээн хорооны оролцоог нарийвчлан заажээ.

Үүнтэй адил Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 156 дүгээр зүйлийн 2-т зааснаар Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан үзэж, тайлан бэлтгэх тэргүүлэх хороог (lead committee) томилдог. Мөн хуулийн 23-1 дүгээр зүйлийн 1-д хороо тайлан бэлтгэх илтгэгчийг гишүүдийнхээ дундаас томилохоор зохицуулсан.

Норвегийн Стортингийн дэгийн 24 дүгээр зүйлд хороо хэлэлцэж буй асуудал бүрдээ нэг, шаардлагатай бол хэд хэдэн төлөөлөгч (spokesperson) сонгох ба санал, дүгнэлтээ (recommendation) бичгээр боловсруулж, хорооны даргатай хамт гарын үсэг зурдаг туршлагатай байна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 1-д хороо хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан бичгээр гаргасан тайланг Спикерт хүргүүлнэ гэж заасан бол 67 дугаар зүйлийн 1, 2-т хорооны дарга эсвэл түүний шийдвэрээр хорооны өөр гишүүн нэгдсэн хуралдаанд тайланг илтгэхээр тусгажээ.

Түүнчлэн Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 166 дугаар зүйлийн 3-т хорооны тайланг хорооны дарга эсвэл хорооноос томилсон өөр гишүүн Ассамблейд танилцуулж, тайлбарлаж болохоор заасан байна.

Эдгээр улсуудын дэгийн зохицуулалтууд нь стратегийн төлөвлөлтийн баримт бичгийг хорооны түвшинд мэргэжлийн үүднээс хянан хэлэлцэж, нэгдсэн хуралдаанд нэгдсэн байр суурийг илэрхийлэх илтгэгчийг томилдог нийтлэг туршлагыг харуулж байна.

(65.5.):

Канадын Нийтийн танхимын дэгд асуулт асуух, хариулт өгөх хугацааг Монгол Улсынхтай төстэй буюу "4+1" гэсэн зарчмаар зохицуулсан байдаг. Дэгийн 38 дугаар зүйлийн (5)-д "Асуудал хөндөж буй гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлнэ. ЗГ-ын гишүүн мөн 4 минутаас илүүгүй хугацаанд хариулт өгнө. Үүний дараа гишүүн 1 минутаас илүүгүй хугацаанд хариу тайлбар хийж, сайд мөн 1 минутаас илүүгүй хугацаанд эцсийн хариултыг өгнө" гэж заажээ. Дэгийн 43 дугаар зүйлийн (1)(b)-д 20 минутын илтгэлийн дараа гишүүдэд асуулт асуух, товч тайлбар хийхэд нь зориулж 10 минутын хугацаа олгохоор заасан байна.

Норвегийн Стортингийн дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлд "Асуултад хариулахдаа сайд 3 минутаас илүүгүй хугацаанд ярина. Хариулт өгсний дараа асуулт асуугч болон сайд тус бүр 1 минутын хугацаатай хоёр удаа нэмэлт тайлбар хийх эрхтэй" гэж заасан. Хуулийн 52 дугаар зүйлд ерөнхий тохиолдолд гишүүний эхний үг хэлэх хугацаа 15 минут, хоёр дахь үг 10 минут, дараагийнх нь 3 минут байхаар заажээ.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 135-bis дүгээр зүйлийн 4-т яаралтай хариу авах асуултыг хэлэлцэхдээ "Асуулт асуугч асуултаа тайлбарлахад 1 минут, Засгийн газрын төлөөлөгч хариулт өгөхөд 3 минут, үүний дараа асуулт асуугч эсвэл тухайн бүлгийн өөр нэг депутат хариу хэлэхэд 2 минутын хугацаа" олгохоор зохицуулсан. Дэгийн 132 дүгээр зүйлийн 2-т Засгийн газрын хариултын дараа асуулт асуугч сэтгэл хангалуун байгаа эсэхээ илэрхийлж үг хэлэх хугацааг 5 минутаар тогтоосон байна.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн (3)-т "Асуулт асуух хугацаа 1 минутаар хязгаарлагдана" гэж заасан. Хуулийн 146 дугаар зүйлийн (3), (5)-д зааснаар асуулт асуухад 1 минут, хариулт өгөхөд 2 минут зарцуулах бөгөөд хуралдаан даргалагч тодруулах зорилгоор нэмэлт асуулт асуухыг зөвшөөрч болно.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 142 дүгээр зүйлийн (3)-т "Асуултын хариулт 4 минутаас хэтрэхгүй байх бөгөөд хэрэв асуудал чухал гэж үзвэл хуралдаан даргалагч нэмэлт 2 минут олгож болно" гэж заасан.

Эдгээр орнуудын туршлагаас үзэхэд асуулт хариултын хугацааг ихэвчлэн 1-4 минутын хооронд хязгаарлаж, хариулт хангалтгүй тохиолдолд 1-2 минутын "тодруулга" эсвэл "нэмэлт асуулт" асуух боломжийг олгодог нийтлэг зарчим үйлчилдэг байна.

(65.7.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 1, 3-т "Парламентын Зөвлөл хуулийн төслийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор хэлэлцүүлэг явуулах эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв төсөл нь хууль тогтоох техникийн шаардлага хангаагүй гэж үзвэл Зөвлөл уг төслийг холбогдох хороонд шилжүүлэхгүйгээр санаачлагчид нь буцаана" гэж заажээ.

Швейцарын Парламентын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 5-д "Хэрэв төсөв эсвэл жилийн тайланг (accounts) нийтэд нь санал хураахад парламент татгалзсан бол энэ нь тухайн баримт бичгийг Холбооны Зөвлөлд (ЗГ) эргүүлэн шилжүүлсэнтэй (referral back) ижил агуулгатай байна" гэж заасан.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 411 дүгээр зүйлд "Удирдамж, үндсэн зарчмыг тусгасан бүх саналууд татгалзсан хариу авбал... Хороо нэгдсэн хуралдааны шийдвэрийг тусгасан шинэ эх бичвэрийг (new text) танилцуулах үүрэгтэй" хэмээн заажээ.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 132 дугаар зүйлд "Хэрэв нэмэлт, өөрчлөлт болон үндсэн төсөл аль аль нь олонхын дэмжлэг авч чадаагүй боловч Танхим тухайн асуудлыг хэлэлцэх асуудлаас хасахгүй гэж шийдвэл, Танхим холбогдох хороонд шинэ төсөл боловсруулах (draft a new bill) үүрэг өгч болно" гэж заасан.

(65.8.):

Төслийн нэг дэх хэлэлцүүлгийг дэмжсэний дараа хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр хороонд шилжүүлдэг механизм нь олон улсын парламентын дэгийн зохицуулалтад нийтлэг байдаг.

Германы Бундестагийн дэгийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нэг дэх хэлэлцүүлгийн дараа хуулийн төслийг хороонд шилжүүлнэ" гэж заасан.

Мөн Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 29 дүгээр зүйлд "Танхимын Ерөнхийлөгч (спикер) тухайн арга хэмжээг холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ" хэмээн зааж, асуудлыг нарийвчлан хэлэлцэх үүргийг хороонд шилжүүлэхээр зохицуулжээ.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 156 дугаар зүйлийн 2-т стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэхэд "Парламентын Ерөнхийлөгч (спикер) Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан үзэж, тайлан бэлтгэх тэргүүлэх хороог томилно" гэж заасан. Мөн хуулийн 166 дугаар зүйлийн 2-т төслийн хэлэлцүүлгийг явуулах шийдвэр гарсны дараа Зөвлөл тэргүүлэх хороог заавал томилж шилжүүлэхээр зохицуулжээ.

Швейцарын Парламентын тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт парламент төслийн хэлэлцүүлгийг дэмжсэн тохиолдолд түүнийг нарийвчлан хянах, засварлах зорилгоор хороонд эсвэл ЗГ-т эргүүлэн шилжүүлж болохоор тусгасан.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 307 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Спикер тухайн асуудлыг тайлан бэлтгүүлэх, зөвлөмж гаргуулахаар холбогдох хороонд шилжүүлдэг зохицуулалттай байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>66 дугаар зүйл.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах</p> <p>66.1.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.</p> <p>66.3.Гишүүд энэ хуулийн 66.2-т заасан ажлын хэсгийн саналтай холбогдуулан асуулт асууж болно.</p>	<p>66 дугаар зүйл.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах</p> <p>66.1.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг жилийн төлөвлөгөөний төслийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцсэн бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.</p> <p>66.3.Гишүүд энэ хуулийн 66.2-т заасан ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асууж болно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (66.1.): Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 2-т "Хорооны тайланд тэргүүлэх хорооны зөвлөмж, түүний үндэслэлээс гадна цөөнхийн санал (minority opinion) болон холбогдох бусад хороодын тайлбарыг (comments of the committees concerned) заавал тусгана" гэж заасан.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 301 дүгээр зүйлд "Төслийг хэлэлцэж буй хороо нь бусад хороодоос санал авч болох бөгөөд тэдгээр хороод нь төслийн тодорхой заалт, хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй" хэмээн зохицуулжээ.

Норвегийн Стортингийн дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлд "Парламент нь асуудлыг нэг хороонд шилжүүлж, тухайн хорооны санал, дүгнэлтийн төслийг (draft recommendation) өөр хороонд илгээж санал авахаар шийдвэрлэж болно" гэж заасан.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 2-т "Хорооны тайланд цөөнхийн санал болон холбогдох хорооны саналын хураангуйг тусгана" гэж заасан.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 118-bis дүгээр зүйлийн 1-д "Эдийн засаг, санхүүгийн төлөвлөлтийн баримт бичгийг Төсвийн хороо бусад Байнгын хороодын саналыг сонссоны үндсэн дээр хэлэлцэнэ" гэж зохицуулжээ.

(66.3.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн (3)-т "Төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр гишүүн бүр тэргүүлэх хорооны илтгэгчээс хоёр хүртэл асуулт асуух эрхтэй" гэж заасан.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 108 дугаар зүйлд "Гишүүд хорооны дарга, цөөнхийн санал танилцуулагч, төсөл санаачлагч нараас асуулт асууж болно" гэж заажээ.

Норвегийн Стортингийн дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд "Хэрэв Ерөнхийлөгч (спикер) хэлэлцүүлэгт ач холбогдолтой гэж үзвэл шууд асуулт асуух эсвэл үл ойлголцлыг залруулах зорилгоор 1 минут үг хэлэхийг зөвшөөрч болно" гэж заасан.

Канадын Нийтийн танхимын дэгийн 43 дүгээр зүйлийн (1)(b)-д илтгэлийн дараа асуулт асуух, товч тайлбар хийхэд зориулж 10 минутын хугацаа олгохоор тусгасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заал
<p>68 дугаар зүйл.Мөнгөний бодлого, Монголбанкны Эрдэнэсийн сангийн төсвийн төслийг хэлэлцэх</p> <p>68.5.Гишүүн тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно. Байнгын</p>	<p>68 дугаар зүйл.Мөнгөний бодлого, Монголбанкны Эрдэнэсийн сангийн төсвийн төслийг хэлэлцэх</p>

хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, тодруулах асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.	68.5.Гишүүн тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.
---	---

2.7.ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: УЛСЫН ТӨСӨВ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 2024	Төслийн заалт
<p>69 дүгээр зүйл.Улсын төсвийн төслийг хэлэлцэх үе шат</p> <p>69.1.Улсын төсөв /цаашид “төсөв” гэх/-ийн төслийг Улсын Их Хурал намрын ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хэлэлцэж эхлэх ба 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дараах таван үе шаттайгаар хэлэлцэн батална:</p> <p>69.1.1.төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлтэй танилцах;</p> <p>69.1.2.төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөл нь энэ хуулийн 70.5-д нийцсэн эсэх талаар санал хураалт явуулах;</p> <p>69.1.3.төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;</p> <p>69.1.4.төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах;</p>	<p>69 дүгээр зүйл.Улсын төсвийн төслийг хэлэлцэх үе шат</p> <p>69.1.Улсын төсөв /цаашид “төсөв” гэх/-ийн төслийг Улсын Их Хурал 10 дугаар сарын эхний долоо хоногт хэлэлцэж эхлэх бөгөөд 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн батална:</p> <p>69.1.1.төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулах;</p> <p>69.1.2.төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;</p> <p>69.1.3.төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах;</p> <p>69.1.4.төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг эцэслэн батлах.</p>
<p>69.2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төсөлд хяналтын сонсгол явуулах бол гурав дахь хэлэлцүүлгийн өмнө төсвийн төслийн цаглаварт нийцүүлэн Төсвийн байнгын хороо сонсгол зохион байгуулж болно.</p>	<p>69.2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төсөлд хяналтын сонсгол явуулах бол хоёр дахь хэлэлцүүлгийн өмнө төсвийн төслийн цаглаварт нийцүүлэн Төсвийн байнгын хороо сонсгол зохион байгуулж болно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (69.1.):

Австрали: Нэг дэх хэлэлцүүлэг (танилцуулга), хоёр дахь хэлэлцүүлэг (зарчим), нарийвчилсан хэлэлцүүлэг (засвар оруулах), гурав дахь хэлэлцүүлэг (эцэслэн батлах) гэсэн үе шатаар баталдаг.

Канад: 9 дүгээр сараас төсвийн бодлогыг хороогоор хэлэлцэж эхлэх ба төсвийн илтгэл танилцуулснаас хойш 4 хоногийн мэтгэлцээнээр ерөнхий бодлогыг баталж, 5 дугаар сарын 31-ний дотор зардлын төсөөллийг хороод тайлагнадаг.

Эстони: Төсвийн төслийг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө өргөн мэдүүлэх ба зарчим, өөрчлөлт, эцсийн батлах гэсэн 3 хэлэлцүүлгээр батална.

Франц: 10 дугаар сард төслийг өргөн барьж, 40 хоногийн дотор нэг дэх хэлэлцүүлгийг дуусгах ба Орлого (1-р хэсэг) болон Зарлагыг (2-р хэсэг) тус тусад нь баталдаг.

Герман: Төсвийн хуулийг 3 хэлэлцүүлгээр батлах ба 2 дахь хэлэлцүүлгийг өргөн барьснаас хойш 6 долоо хоногийн дараа явуулж, зарчмын зөрүүтэй саналыг Төсвийн хороо хянадаг.

Энэтхэг: Төсвийг танилцуулах, ерөнхий хэлэлцүүлэг хийх, зардлын заалт бүрээр (Demands for Grants) санал хураах, Төсвийн болон Санхүүгийн хуулийг эцэслэн батлах гэсэн үе шаттай.

Солонгос: Төсвийг 9 дүгээр сард өргөн барьж, Байнгын хороо ба Төсвийн тусгай хороогоор хэлэлцүүлж 11 дүгээр сарын 30-ны дотор батална.

Өмнөд Африк: Төслийг өргөн барьж Санхүүгийн хороонд шилжүүлэх, нэг дэх хэлэлцүүлэг (зарчим), заалт бүрээр санал хураах, хоёр дахь хэлэлцүүлгээр эцэслэн баталдаг.

Америк Зарлагын төслүүдийг эхлээд Нэгдсэн хороогоор (Committee of the Whole) хэлэлцэж, нэг ба хоёр дахь хэлэлцүүлэг (засвар оруулах) хийж баталдаг.

(69.2.):

Солонгост төсвийн төсөлд заавал нийтийн сонсгол хийхээр заасан байдаг. Үндэсний Ассамблейн тухай хуулийн 84-3 дугаар зүйлд "Төсөв, зардлын тусгай хороо нь төсвийн төсөл, сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн асуудлаар заавал нийтийн сонсгол (public hearing) зохион байгуулна" гэж заасан.

Италийн парламент төсвийн тусгай чуулган эхлэхээс өмнө мэдээлэл цуглуулах сонсгол хийдэг. Дэгийн 119 дүгээр зүйлийн 3-т "Төсвийн чуулган эхлэхээс өмнө Байнгын хороод өөрсдийн хариуцах салбарын төсвийн төсөөлөлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээлэл цуглуулах зорилгоор сонсголын хөтөлбөр (programme of hearings) хэрэгжүүлнэ." хэмээн зохицуулсан. Дэгийн 118-bis дүгээр зүйлийн 3-т Эдийн засаг, санхүүгийн төлөвлөлтийн баримт бичгийг хэлэлцэх үед Төсвийн хороо мэдээлэл цуглуулах зорилгоор сонсгол (hearings) явуулна гэж заасан.

Өмнөд Африкийн Дэгийн 325 дугаар зүйлийн 3(a)-д "Санхүүгийн хороо нь төсвийн хүрээний мэдэгдэл болон орлогын саналаар хамтарсан нийтийн сонсгол (joint public hearings) зохион байгуулна" гэж заасан. Дэгийн 286 дугаар зүйлийн 6(c)-д Төслийг хороогоор хэлэлцэх шатанд агуулгын талаар нийтийн санал авах, сонсгол (oral submissions) явуулах үе шаттай байхаар тусгажээ.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 338C зүйлд Төсвийн төсөөллийг (Estimates) хянан шалгах зорилгоор парламентад тусгайлсан "Хяналт шалгалтын долоо хоногууд" (Scrutiny weeks)-ийг товлодог ба энэ үеэр хороод зөвхөн хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний дотор сонсгол явуулахад анхаардаг. Дэгийн 338A зүйлд сонсгол болон хяналт шалгалтын зорилго нь гүйцэтгэх засаглалын стратеги, бодлого, зардал, удирдлагын үйл ажиллагаанд парламентын хяналт тогтоох (hold the executive to account) зорилготой болохыг тодорхойлсон байна.

Бундестагийн дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1-д "Хороо хэлэлцэж буй асуудлаар мэдээлэл цуглуулах зорилгоор шинжээчид, ашиг сонирхлын бүлгүүдийн төлөөлөл болон бусад этгээдийг оролцуулсан нийтийн сонсгол (public hearings) явуулж болно" гэж заасан. Төсвийн хороо төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ ийм сонсгол явуулах эрхтэй байдаг.

ОУ-ын туршлагаас үзэхэд төсвийн төслийг хэлэлцэн батлах явцад хяналтын сонсгол эсвэл нийтийн сонсгол явуулах нь төсвийн зардлыг бодитой тогтоох, парламентын хяналтыг хэрэгжүүлэх чухал үе шат гэж үзэн, түүнийг явуулах хугацааг (голдуу нэг болон хоёр дахь хэлэлцүүлгийн өмнө) тусгайлан зааж өгдөг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>70 дугаар зүйл.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг</p> <p>70.1.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон бусад Байнгын хороо төсвийн төсөлтэй танилцаж, хуралдаанаар хэлэлцэнэ.</p> <p>70.2.Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль</p>	<p>70 дугаар зүйл.Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг</p> <p>70.1.Ерөнхий сайд төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай</p>

<p>санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.</p> <p>70.3.Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар танилцуулга боловсруулж, Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.</p> <p>70.4.Төсвийн байнгын хороо энэ хуулийн 70.3-т заасан танилцуулгыг хүлээн авч нэгтгэн, нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>70.5.Нэгдсэн хуралдаанд Төсвийн байнгын хороо танилцуулга хийсний дараа төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна.</p> <p>70.6.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол төсвийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлнэ.</p> <p>70.7.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол төсвийн төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.</p>	<p>хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг тус тус танилцуулна. Төсвийн төслийн танилцуулгад төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хэрхэн хангаж ажилласан тухай болон гарсан үр дүнг төсвийн төсөлд хэрхэн тусгасан талаар танилцуулна.</p> <p>70.2.Төсвийн төсөлтэй холбогдуулан гаргасан төрийн аудитын дээд байгууллагын болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ.</p> <p>70.3.Нэг дэх хэлэлцүүлэгт Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нар оролцоно.</p> <p>70.4.Гишүүд энэ хуулийн 70.1-д заасан танилцуулгатай холбогдуулан Ерөнхий сайдаас, энэ хуулийн 70.2-т заасан дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас, төсвийн төсөлтэй холбогдуулан энэ хуулийн 70.3-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.</p> <p>70.5.Улсын Их Хурал энэ зүйлд заасны дагуу асуулт асууж, үг хэлсний дараа төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна.</p> <p>70.6.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол төсвийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлнэ.</p> <p>70.7.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол төсвийн төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.</p>
---	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (70.1.):

1. ЗГ-ын төсвийн танилцуулга (Executive Presentation)

ОУ-ын практикт төсвийн төслийг гүйцэтгэх засаглалын тэргүүн эсвэл Сангийн сайд парламентад биечлэн танилцуулдаг нийтлэг журамтай. Шинэ Зеландад Төлөөлөгчдийн танхимын дэгийн 341 дүгээр зүйлийн (3)-т зааснаар Сангийн сайд Төсвийн хуваарилалтын тухай хуулийн төсөл (Appropriation Bill)-ийн хоёр дахь хэлэлцүүлгийг нээхдээ "Төсвийн мэдэгдэл" (Budget statement) танилцуулдаг.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 204 дүгээр зүйлийн (1)-д заасны дагуу Ерөнхийлөгч (спикер)-ийн товлосон өдөр Сангийн сайд төсвийн төслийг парламентад танилцуулна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн (1)-д зааснаар төсвийн төслийг хэлэлцэхийн өмнө Засгийн газрын бодлогын илтгэлийг нэгдсэн хуралдаанаар заавал сонсохоор хуульчилжээ.

2. Аудитын болон хөндлөнгийн хяналтын дүгнэлт (Audit and Fiscal Oversight)

Төсвийн төсөлд хөндлөнгийн хяналт тогтоох механизмыг дараах байдлаар зохицуулсан байна. Францад Үндэсний Ассамблейн дэгийн 146-1 дүгээр зүйлийн 1-д зааснаар Аудитын шүүхийн тэргүүн аудитын жилийн тайланг Ассамблейд биечлэн танилцуулна.

Шинэ Зеландад Төлөөлөгчдийн танхимын дэгийн 344 дүгээр зүйлд зааснаар "Эдийн засаг, төсвийн төлөв байдлын тайлан" болон "Төсвийн стратегийн тайлан"-г Санхүү, зардлын хороонд шилжүүлж, тус хороо төсөв хүргүүлснээс хойш 10 долоо хоногийн дотор тайлагнах үүрэгтэй.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 215 дугаар зүйлийн (с)-д зааснаар байнгын хороод Аудитын ерөнхий газрын (Auditor-General) тайланг хүлээн авч, хянан шалгалт явуулах эрхтэй.

3. Олон нийтийн оролцоог хангах ба тайлагнах (Public Participation)

Төсвийн хэлэлцүүлэгт олон нийтийн оролцоог хангах үйл явцыг дараах дэгээр зохицуулдаг. Шинэ Зеландад Төлөөлөгчдийн танхимын дэгийн 280 дугаар зүйлийн (2)(b)-д зааснаар ЗГ хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа холбогдох бүлгүүд болон олон нийттэй хэрхэн хамтран ажиллах төлөвлөгөөгөө парламентад мэдээлэх чиглэлтэй байдаг.

Солонгост Үндэсний Ассамблейн тухай хуулийн 84-3 дугаар зүйлд Төсөв, зардлын тусгай хороо төсвийн төслийн асуудлаар заавал нийтийн сонсгол (public hearing) зохион байгуулж, сонирхогч талуудын саналыг сонсохоор заажээ.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 325 дугаар зүйлийн (3)(a)-д зааснаар Төсвийн байнгын хороо төсвийн хүрээний мэдэгдэл болон орлогын саналд нийтийн нээлттэй сонсгол зохион байгуулахаар тусгасан байна.

Эдгээр зохицуулалтаас үзэхэд төсвийн төслийг парламентаар хэлэлцэж эхлэхдээ гүйцэтгэх засаглалын тайлбараас гадна хараат бус аудитын болон эдийн засгийн дүн шинжилгээг зэрэгцүүлэн сонсох нь төсвийн бодит байдлыг хангах, парламентын хяналтыг чанаржуулах гол хөшүүрэг болдог байна.

(70.2.):

1. Төрийн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах (Audit Reports)

Парламентын гишүүдийг төсвийн төсөл болон гүйцэтгэлтэй холбоотой мэргэжлийн хараат бус аудитын дүгнэлтээр хангах нь олон улсад нийтлэг хэрэгжиж байна.

Францын Үндэсний Ассамблейн дэгийн 146-1 дүгээр зүйлийн 1-д зааснаар Аудитын шүүхийн тэргүүн жилийн тайланг Ассамблейд биечлэн танилцуулдаг. Тус байгууллага нь Франц Улсын Үндсэн хуулийн 47-2 дугаар зүйлд заасны дагуу төсвийн хуулийн хэрэгжилт болон төсвийн хяналтын хүрээнд парламентад туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 149 дүгээр зүйлийн 1-д зааснаар Аудитын шүүхээс парламентад ирүүлсэн тайлангуудыг холбогдох Байнгын хороодод хэлэлцүүлэхээр шилжүүлдэг. Хорооны дарга нар мөн дэгийн 148 дугаар зүйлийн 1-д зааснаар өөрсдийн

хариуцсан салбарын хүрээнд аудитын байгууллагаас мэдээлэл, тодруулга, баримт бичиг шаардах эрхтэй.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын 215 дугаар зүйлийн (с)-д зааснаар ерөнхий чиг үүргийн байнгын хороод Танхимд өргөн мэдүүлсэн Ерөнхий аудиторын (Auditor-General) тайланг хүлээн авч, түүний дагуу хянан шалгалт явуулж, тайлагнах үүрэг хүлээдэг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн (5)-д зааснаар Үндэсний Ассамблейн Тамгын газар нь гишүүд болон хороодыг төсөв хэлэлцэхэд шаардлагатай материалаар хангах үүрэгтэй. Хуулийн 66 дугаар зүйлийн 4-т зааснаар Хороо тайлангаа бэлтгэж ирүүлсний дараа уг тайланг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээс өмнө нийт гишүүдэд тараана.

2. Төсвийн тогтвортой байдал, стратегийн дүн шинжилгээ (Fiscal Stability & Strategy)

Парламентын хяналтыг бодитой болгох зорилгоор макро эдийн засгийн төсөөлөл, төсвийн хүрээний хяналтын мэргэжлийн дүгнэлтийг дараах байдлаар ашигладаг:

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 344 дүгээр зүйлийн (1)-д зааснаар "Төсвийн стратегийн тайлан" (Fiscal strategy report) болон "Эдийн засаг, төсвийн төлөв байдлын тайлан" (Economic and fiscal update)-г Санхүү, зардлын хороонд шууд шилжүүлж, гишүүдэд хяналт тавих боломж олгодог. Мөн дэгийн 404 дүгээр зүйлийн (1)(а)-д заасны дагуу Ерөнхий аудиторын тайланг тус хороонд хянуулахаар шилжүүлнэ.

Швейцарын Парламентын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 2-т зааснаар Парламентын Санхүүгийн төлөөлөгчийн газар (Finance Delegation) нь төсвийн бүх үйл явцад нарийвчилсан хяналт тавьж, дүгнэлтээ танилцуулдаг. Парламентын үйлчилгээний алба нь хуулийн 149 дүгээр зүйлийн 2-т зааснаар Холбооны Зөвлөлөөс ирүүлсэн бүх бичиг баримтыг гишүүдэд хүргэх үүрэгтэй.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 10 дугаар дүрмийн 4(b)(1)-д зааснаар Төсвийн хороо Конгрессын Төсвийн албаны үйл ажиллагаанд хяналт тавьж, тэндээс гаргасан макро эдийн засгийн тооцооллыг хэлэлцүүлэгт ашигладаг. Түүнчлэн дэгийн 13 дугаар дүрмийн 3(c)(3)-т зааснаар Конгрессын Төсвийн албанаас бэлтгэсэн төсвийн зардлын тооцоолол, харьцуулсан дүн шинжилгээг хорооны тайланд заавал тусгахаар зохицуулсан байна. Хяналт, засгийн газрын шинэчлэлийн хороо нь дэгийн 10 дугаар дүрмийн 4(c)(1)(A)-д зааснаар Ерөнхий хянан шалгагчийн (Comptroller General) тайланг хүлээн авч, зөвлөмж боловсруулан Танхимд танилцуулдаг.

Эдгээр зохицуулалт нь төсвийн төслийг хэлэлцэх үед гишүүдийг зөвхөн гүйцэтгэх засаглалын мэдээллээр хязгаарлахгүй, хараат бус аудитын болон төсвийн шинжилгээний дүгнэлтээр хангах замаар парламентын хяналтыг бодитой болгоход чиглэж байна.

(70.3.):

1. Гүйцэтгэх засаглал болон төрийн аудитын байгууллагын оролцоо

ОУ-ын практикт төсвийн хэлэлцүүлэгт Засгийн газрын тэргүүн болон аудитын байгууллагын удирдлага оролцох нь нийтлэг байдаг. Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 1-д зааснаар төсвийн төслийг хэлэлцэхийн өмнө ЗГ-ын бодлогын илтгэлийг (speech on the administrative policy) нэгдсэн хуралдаанаар заавал сонсдог. Мөн хуулийн 121 дүгээр зүйлийн 5-д тусгайлсан асуудлаар асуулга явуулах үед Хянан шалгах, аудитын зөвлөлийн (Board of Audit and Inspection) даргыг оролцуулахаар заасан.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 1-д хуралдааны танхимд байж, хэлэлцүүлэгт оролцох эрхтэй хүмүүст Засгийн газрын гишүүдээс гадна Ерөнхий аудитор (Auditor General) болон Төрийн нарийн бичгийн даргыг заавал оролцуулдаг.

Францын Үндэсний Ассамблейн дэгийн 146-1 дүгээр зүйлийн 1-д Аудитын шүүхийн (Court of Accounts) тэргүүн аудитын жилийн тайланг Ассамблейд биечлэн танилцуулахаар тусгажээ.

2. Шүүх засаглал болон бусад өндөр албан тушаалтнуудын оролцоо

Төсвийн болон бодлогын чухал хэлэлцүүлэгт шүүх засаглалын тэргүүнүүд оролцох дэг дараах улсуудад байна. Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 5-д зааснаар асуулга явуулах зорилгоор Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн (Constitutional Court) дарга, Сонгуулийн ерөнхий хорооны даргыг парламентын хуралдаанд оролцохыг шаардаж болдог. Мөн хуулийн 120 дугаар зүйлийн 2-т Шүүхийн захиргааны албаны захирал, Үндсэн хуулийн цэцийн Ерөнхий нарийн бичгийн дарга нар өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд парламентын хуралдаанд үг хэлж болохоор зохицуулжээ.

Швейцарын Парламентын тухай хуулийн 162 дугаар зүйлийн 2-т Холбооны Дээд шүүх нь төсөв, данс тооцоо, жилийн тайлангийн асуудлаар парламент болон хороодод ажиллах хариуцлагатай гишүүнээ (шүүгч) томилж оролцуулахаар заасан.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 4 дүгээр дүрмийн 2 дахь заалтад хуралдааны танхимд байх онцгой эрхтэй (floor privileges) хүмүүсийн жагсаалтад Дээд шүүхийн шүүгчид, яамдын сайдууд болон мужийн амбан захирагч нарыг оруулсан байдаг.

3. Хяналтын болон бусад байгууллагын оролцоо

Норвег улсад Үндсэн хуулийн 75 дугаар зүйлийн (h) хэсэгт зааснаар Стортинг нь төрийн албан үүргийн хүрээнд хэнийг ч (Хааны гэр бүлээс бусад) ирүүлж мэдүүлэг авах бүрэн эрхтэй байдаг. Энэ нь төсөв, бодлогын хяналтыг өргөн хүрээг хангадаг.

Энэ нь МУ-ын дэгийн "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нар" оролцох зарчимтай агуулга нэг юм. Эдгээр дэгүүд нь улс орны төсөв, санхүүгийн стратегийг хэлэлцэхэд засаглалын бүх салаа мөчрийн удирдлагууд мэдээлэл өгөх, парламентын өмнө тайлагнах нэгдсэн боломжийг бүрдүүлдэг байна.

(70.4.):

1. Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдээс асуулт асуух

Төсвийн бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбогдуулан гүйцэтгэх засаглалын тэргүүнээс асуулт асуух эрхийг дараах байдлаар хуульчилсан байна:

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 156 дугаар зүйлийн 4-т "Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх явцад Засгийн газрын төлөөлөгч болон тэргүүлэх хорооны илтгэгч нараас гишүүн бүр нэг асуулт асуух эрхтэй" гэж заасан. Мөн хуулийн 139 дүгээр зүйлийн 1-д Ерөнхий сайдад хандан асуулга (interpellation) тавих эрхийг баталгаажуулсан байдаг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 122-2 дугаар зүйлийн 1, 2-т Танхимын нэгдсэн хуралдааны үеэр Засгийн газраас асуулт асуух (interpellation) хугацааг товлох ба асуулт, хариултын хэлбэрээр явуулахаар заажээ.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 340 дүгээр зүйлийн 3-т Төсвийн бодлогын мэдэгдлийг (Budget policy statement) хэлэлцэх үед холбогдох сайд нь хорооны хуралдаанд биечлэн оролцож, асуултад хариулах үүрэгтэй байхаар тусгасан байна.

2. Ерөнхий аудитораас асуулт асуух, дүгнэлтийг хэлэлцэх

Аудитын байгууллагын дүгнэлттэй холбогдуулан Ерөнхий аудитораас тайлбар авах, асуулт асуух механизмыг дараах байдлаар зохицуулсан:

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 155 дугаар зүйлийн 4-т "Үндсэн хууль болон бусад хуулийн дагуу илтгэл, тайлан танилцуулж буй нийтийн албан тушаалтнаас (Ерөнхий аудитор гэх мэт) гишүүд тус бүр нэг асуулт асуух эрхтэй" гэж заасан байна. Мөн хуулийн 139 дүгээр зүйлийн 1-д зааснаар Ерөнхий аудиторт (Auditor General) хандан асуулга тавьж, хариулт авах эрх нээлттэй байдаг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 5-д зааснаар тусгайлсан асуудлаар асуулга явуулах зорилгоор Хянан шалгах, аудитын зөвлөлийн (Board of

Audit and Inspection) даргыг (Ерөнхий аудитортай дүйцэх албан тушаалтан) парламентын хуралдаанд оролцохыг шаардах эрхтэй.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 149 дүгээр зүйлийн 2-т зааснаар гишүүдийн тавны нэг нь хүсэлт гаргавал Аудитын шүүхээс нэмэлт мэдээлэл, дүгнэлт шаардаж, сонсож болохоор зохицуулсан.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 42-II дүгээр зүйлд зааснаар хорооны хэлэлцүүлэг, мөрдөн шалгах ажиллагааны үеэр гишүүд Төрийн сайд, сайд нарын танхимын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч болон Парламентын дэд сайд нараас асуулт асууж, хариулт авахаар заасан.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 236 дугаар зүйлийн (а)-д зааснаар хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гэрчүүдийг (сайд, агентлагийн дарга нар) дуудаж мэдүүлэг авах бүрэн эрхтэй.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 10 дугаар дүрмийн 4(b)(2)-т зааснаар Төсвийн хороо нь төсвийн төслийг хэлэлцэхдээ сангийн сайд, Төсвийн асуудал эрхэлсэн агентлагийн дарга болон бусад холбогдох албан тушаалтнуудыг оролцуулж, тэдний мэдүүлгийг сонсохоор хуульчилжээ.

Эдгээр олон улсын зохицуулалтаас үзэхэд төсвийн төслийг хэлэлцэж эхлэх шатанд гүйцэтгэх засаглалын бодлого боловсруулагч нараас гадна хараат бус хяналтын (аудит) байгууллагын удирдлагуудаас шууд асуулт асуух, тэдний дүгнэлтийг нягтлах замаар парламентын хяналтыг бодитой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг байна.

(70.5.):

Төсвийн төслийн үзэл баримтлал, нийцлийг хэлэлцэж санал хураах.

ОУ-ын практикт төсвийн төслийг нарийвчлан хэлэлцэхийн өмнө түүний ерөнхий бодлого, зарчмыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, санал хураадаг нийтлэг дэг үйлчилдэг.

Канадын Нийтийн танхимын дэгийн 84 дүгээр зүйлийн (1)-д зааснаар Сангийн сайд төсвийн илтгэл тавьсны дараа "Танхим Засгийн газрын төсвийн ерөнхий бодлогыг дэмжиж байна" гэсэн агуулгатай санал хураалт явуулдаг.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 123 дугаар зүйлийн 2-т төсвийн төслийн ерөнхий хэлэлцүүлгийн үеэр эдийн засаг, санхүүгийн бодлогын ерөнхий чиглэл болон үндэсний эдийн засгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөхөөр заасан.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 341 дүгээр зүйлийн (3)-т зааснаар Сангийн сайд төсвийн илтгэл (Budget statement) тавьснаар төсвийн хуулийн хоёр дахь хэлэлцүүлэг эхэлдэг.

(70.6.):

Төслийг хороодод шилжүүлж, дараагийн хэлэлцүүлэгт бэлтгэх.

Төсвийн үзэл баримтлалыг дэмжсэн тохиолдолд түүнийг заалт бүрээр нь нягтлан хянахаар мэргэжлийн хороодод шилжүүлдэг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн (1)-д зааснаар төсвийн төслийг эхлээд холбогдох Байнгын хороодод урьдчилсан хяналт (pre-examination) хийлгэхээр шилжүүлж, үр дүнг нь Спикерт тайлагнадаг.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн (1)-д зааснаар нэг дэх хэлэлцүүлгийн дараа хуулийн төслийг (түүний дотор төсвийн хуулийг) хороонд шилжүүлдэг.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 346 дугаар зүйлийн (1)-д зааснаар төсвийн илтгэлийн дараа төсвийн зардлын төсөөлөл (Estimates)-ийг Төсвийн хорооноос хуваарилсан салбар хороодод шууд шилжүүлдэг.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 147 дугаар зүйлд зааснаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн (үзэл баримтлал) дараа Спикер хөрөнгө олгох тухай мэдэгдлийг танилцуулж, нарийвчилсан хэлэлцүүлэгт шилжүүлдэг.

(70.7.):

Төсөл олонхын дэмжлэг аваагүй эсвэл хууль зүйн шаардлага хангаагүй бол буцаах механизмыг дараах улсууд дэгийн зохицуулалтын хүрээнд тодорхой заасан байна.

Эстониин Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн (3)-т "Хэрэв Зөвлөл хуулийн төслийг шаардлага хангаагүй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор хороонд шилжүүлэхгүйгээр санаачлагчид нь ЗГ-т буцаана" гэж заажээ.

Швейцарын Парламентын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 5-д "Хэрэв төсөв эсвэл жилийн тайланг нийтэд нь санал хураахад парламент татгалзсан бол энэ нь тухайн баримт бичгийг Холбооны Зөвлөлд (ЗГ) эргүүлэн буцаахтай (referral back) ижил агуулгатай байна" гэж заасан.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 146 дугаар зүйлд зааснаар, хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр 'төслийг одоо хэлэлцэхгүй' (not now read) гэсэн утга бүхий нэмэлт, өөрчлөлт орох санал дэмжигдвэл, тухайн төслийг хэлэлцэхээс татгалзсанд тооцно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>71 дүгээр зүйл.Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг</p> <p>71.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг энэ хуулийн 71.1-д заасан эрхлэх асуудлын хүрээг баримтлан Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна.</p> <p>71.4.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж болно.</p> <p>71.5.Бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт гаргана.</p> <p>71.6.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ хуулийн 71.5-д заасан санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.</p> <p>71.7.Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага, нам, эвслийн бүлгийн гаргасан санал дараах шаардлагыг хангасан байна:</p>	<p>71 дүгээр зүйл.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг</p> <p>71.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг энэ хуулийн 71.1-д заасан эрхлэх асуудлын хүрээг баримтлан, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна.</p> <p>71.4.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төрийн аудитын дээд байгууллагын дүгнэлтийг хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж болно.</p> <p>71.5.Бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг саналаа зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт гаргана. Уг санал нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан бүсийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх бол тухайн бүс доторх бусад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах ба бусад тохиолдолд тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэх бол тухайн салбарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зардлыг мөн хэмжээгээр бууруулна.</p> <p>71.6.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ хуулийн 71.5-д заасан санал тус бүрээр санал хураалт явуулж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэгтгэн, санал хураалтын дүнгийн хамт санал,</p>

<p>71.8.Нам, эвслийн бүлэг, гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно. Санал хураалт явуулахын өмнө тухайн саналтай холбогдуулан Засгийн газрын тайлбарыг сонсож болно.</p> <p>71.9.Төсвийн байнгын хороо энэ хуулийн 71.6-д заасан болон Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага, нам, эвслийн бүлгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>71.10.Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн шатанд гарсан төсвийн санал Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг баримтлахгүй байх нөхцөлийг үүсгэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар энэ талаар нэгдсэн хуралдаанд тайлбар хийж болно.</p> <p>71.11.Нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно.</p> <p>71.12.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 71.9-д заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна.</p> <p>71.14.Нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно. Чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.</p> <p>-</p>	<p>дүгнэлтэд хавсарган Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.</p> <p>71.7.Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүд, нам, эвслийн бүлгийн гаргасан санал дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>71.8.Нам, эвслийн бүлэг, гишүүн тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр энэ хуулийн 71.5-д заасны дагуу бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно. Санал хураалт явуулахын өмнө тухайн саналтай холбогдуулан Засгийн газрын тайлбарыг сонсоно.</p> <p>71.9.Төсвийн байнгын хороо төсвийн төслийн талаарх ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулах бөгөөд түүний дараа энэ хуулийн 71.6-д заасны дагуу ирүүлсэн санал, Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан нам, эвслийн бүлгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.</p> <p>71.10.Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан дэд дарга Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 24.2-т заасан дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>71.11.Төсвийн төслийн <u>хоёр</u> дахь хэлэлцүүлгийн шатанд гарсан төсвийн санал Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг баримтлахгүй байх нөхцөлийг үүсгэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар энэ талаар нэгдсэн хуралдаанд тайлбар хийж болно.</p> <p>71.12.Нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүд гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно.</p> <p>71.14.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 71.9-д заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна.</p> <p>71.15.Байнгын хорооны дарга болон ажлын хэсгийн ахлагчийн саналыг үндэслэн хуралдаан даргалагч төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно. Чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.</p>
---	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (71.2.):

Сангийн сайд болон Ерөнхий аудитор хороодод танилцуулга хийх.

Хороо, бүлгийн түвшинд гүйцэтгэх засаглал болон аудитын дүгнэлтийг сонсох механизмыг дараах улсууд хэрэгжүүлдэг.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 10 дугаар дүрмийн 4(b)(2)-т Төсвийн хороо төсвийн төслийг хэлэлцэхдээ Сангийн сайд болон Төсвийн асуудал эрхэлсэн агентлагийн даргын мэдүүлгийг (testimony) сонсохоор заасан.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 340 дүгээр зүйлийн 3-т Төсвийн бодлогын мэдэгдлийг хэлэлцэхэд холбогдох Сайд хорооны хуралдаанд биечлэн оролцож танилцуулга хийх үүрэгтэй.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 120 дугаар зүйлийн 8-д тухайн асуудал хариуцсан Сайд нар хорооны хуралдаанд заавал оролцох ба тэдгээрийн хэлэлцүүлгийн протоколыг нийтлэхээр заасан.

Францын Үндэсний Ассамблейн дэгийн 146 дүгээр зүйлийн 1-д яамдын төсвийн хяналтад зориулсан баримт бичгийг Сангийн комиссын тусгай илтгэгч нарт хүргүүлж, тэдгээрийг хянах явцад аудитын туслалцаа авдаг.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн (1)-д хороо Засгийн газрын гишүүнээс өөрийн бүрэн эрхийн хүрээнд мэдээлэл авах зорилгоор хорооны хуралдаанд оролцохыг шаардах эрхтэй.

Швейцарын Парламентын тухай хуулийн 143 дүгээр зүйлийн 1-д Холбооны Зөвлөлөөс (ЗГ) ирүүлсэн тайлангуудыг хороодод танилцуулах үйл явцыг зохицуулсан.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэг, 215 дугаар зүйлийн (с)-д байнгын хороод Ерөнхий аудиторын тайланг хүлээн авч, түүнтэй холбогдуулан хянан шалгалт явуулахыг заасан.

Сингапурын Парламентын дэг, 100 дугаар зүйлийн (3)-т Төсвийн хороо зардлын хэмнэлт болон төсвийн асуудлыг хэлэлцэх явцдаа Засгийн газрын тайлбарыг нягтлахаар тусгасан байна.

Эдгээр зохицуулалт нь төсвийн төслийг Байнгын хороодын түвшинд хэлэлцэхдээ гүйцэтгэх засаглалын бодлогын тайлбар болон аудитын байгууллагын хараат бус дүгнэлтийг зэрэгцүүлэн ашиглах замаар хяналтын чанарыг хангахад чиглэдэг байна.

(71.5):

1. Төсвийн зардлыг нөхөн тэнцвэржүүлэх зохицуулалт (Offsetting Adjustments)

ОУ-ын парламентын практикт гишүүдийн гаргасан төсөв нэмэх саналыг заавал бууруулах саналтай хамт оруулдаг "төсвийн сахилга батыг хангах" механизм түгээмэл байдаг.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 121 дүгээр зүйлийн 1-д зааснаар тухайн Байнгын хороо өөрийн хариуцах салбарын төсөвт өөрчлөлт оруулахдаа холбогдох зардлыг нөхөн тэнцвэржүүлэх (offsetting adjustments) зарчмыг баримтлан, зардлын заалтуудыг өөрчлөх санал гаргахаар зохицуулжээ. Мөн хуулийн 121 дүгээр зүйлийн 5-д шинээр зардал нэмэх эсвэл орлого бууруулахтай холбоотой шалгуурыг хангаагүй нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхгүй байхаар заасан.

Норвегийн Стортингийн дэгийн тухай хуулийн 43 дугаар зүйлд төсвийн хороо болон салбар хороодоос гаргаж буй төсвийн зардлын саналууд нь Стортингоос тогтоосон төсвийн нийт зардлын таазнаас (budget ceilings) хэтрэхгүй байх, тухайн салбар доторх зардлын хязгаарыг заавал мөрдөхөөр зохицуулсан.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 3-т зааснаар төсөвт оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал нь Улсын төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд (зардлыг нөхөх эх үүсвэрийг заах шаардлага) нийцсэн байхаас гадна орлого, зарлага болон хөрөнгө оруулалтын зүйл заалт бүрд оруулах өөрчлөлтийг тодорхой томъёолсон байхыг шаарддаг.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 46 болон 125 дүгээр зүйлд зааснаар төсөв нэмэгдүүлэх санал гаргаж буй гишүүн уг өөрчлөлтийн үр дүнд шаардагдах зардлыг тодорхойлж, бичгээр гаргасан тайлбарыг (written statement) заавал хавсаргахаар зохицуулжээ.

2. Зардал нэмэх саналыг хязгаарлах болон зөвшөөрөл авах журам.

Зарим улс оронд гишүүдийн төсөв нэмэх эрхийг шууд хязгаарлах эсвэл Засгийн газрын зөвшөөрөлтэйгөөр хэрэгжүүлдэг.

Сингапурын Парламентын дэгийн 92 дугаар зүйлийн 5-д зааснаар төсвийн аль нэг заалтын зардлыг нэмэгдүүлэх саналыг зөвхөн Сайд гаргах эрхтэй бөгөөд гишүүн зөвхөн зардал бууруулах санал (token cut) гаргахыг зөвшөөрдөг.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээний хүрээнд гаргаж буй аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн зардлыг бууруулахад (cut in expenditure) чиглэсэн байх ёстой.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 95 дүгээр зүйлийн 1-д зааснаар төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналд хамгийн багадаа 50 гишүүн гарын үсэг зурж дэмжсэн байх өндөр босго тогтоосон. Мөн тус хуулийн 84 дүгээр зүйлийн 5-д Төсвийн тусгай хороо нь Байнгын хорооны хассан зардлыг эргүүлэн нэмэх эсвэл шинэ зардлын зүйл нэмэх тохиолдолд холбогдох Байнгын хорооноос заавал зөвшөөрөл авахаар зохицуулсан байна.

Эдгээр зохицуулалтууд нь Монгол Улсын дэгийн нэгэн адил парламент төсвийг хэлэлцэх явцад зардлыг хяналтгүй нэмэгдүүлэхээс сэргийлж, аливаа нэмэлт зардлыг салбарын эсвэл нийт төсвийн хүрээнд нөхөн тэнцвэржүүлэх замаар төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэж байна.

(71.6.):

1. Саналыг бүлэглэх болон шийдвэрийг жагсаах (Grouping and Listing)

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 1-д Төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ тэргүүлэх хороо нь нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудын жагсаалтыг (list of motions) бэлтгэдэг бөгөөд үүнд саналын томьёолол, санаачлагчийн нэр болон хорооны шийдвэрийг заавал тусгахаар заасан байна. Мөн хорооны тайлбар бичигт саналыг хүлээж авсан эсвэл татгалзсан үндэслэлийг тайлбарладаг.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 300 дугаар зүйлийн 6-д Хорооны тайланд нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг тусгахдаа хорооны гишүүд санал нэгтгэйгээр баталсан (unanimously) болон олонхын саналаар (majority) дэмжсэн саналуудыг заавал зааглаж, ялгаж тусгахаар зохицуулсан.

2. Санал хураалтын дүн болон цөөнхийн байр суурийг хавсаргах (Voting Results and Minority Views)

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 13 дугаар дүрмийн 3(b) заалтад Олон нийтийн шинжтэй асуудлаарх хорооны тайланд нэмэлт, өөрчлөлт бүрээр явуулсан санал хураалтын нийт дүн (total number of votes cast for and against) болон санал өгсөн гишүүдийн нэрсийг заавал багтаахаар тусгасан байна. Мөн цөөнхийн болон нэмэлт байр суурийг (minority, additional views) тайланд заавал хавсаргадаг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 2-т Хорооны хэлэлцүүлгийн тайланд цөөнхийн санал (summary of the minority opinions) болон холбогдох бусад хороодын саналын хураангуйг заавал тусгахаар заажээ.

3. Төсвийн хороонд санал, дүгнэлтийг нэгтгэн шилжүүлэх (Consolidation and Transmission)

Италийн Депутатуудын танхимын дэгийн 121 дүгээр зүйлийн 1-д Салбар хороод өөрсдийн хариуцсан төсвийн хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах ба батлагдсан (approved)

нэмэлт, өөрчлөлтүүдийг Төсвийн хороонд (Budget Committee) хүргүүлэх тайланд заавал оруулахаар зохицуулсан байна.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 74-IV дүгээр зүйлд Төсвийн хорооноос салбар хороодод төсвийн тодорхой хэсгийг хянуулахаар шилжүүлсэн тохиолдолд тухайн хороод нь хэлэлцүүлэг дууссаны дараа хэлэлцүүлгийн үр дүнгийн хураангуйг (summary of consideration) Төсвийн хороонд тайлагнахаар заажээ.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 1-д Төсвийн хуулийн төслийг хэлэлцэх явцад салбар хороод өөрсдийн саналыг гаргах эрхтэй ба Төсвийн хороо нь холбогдох хороодын ирүүлсэн тайлбар, саналын (comments of the committees concerned) талаар нэгдсэн тайланд тусгахаар заасан байна.

Эдгээр зохицуулалтууд салбар хороод болон Төсвийн үндсэн хорооны хоорондын ажлын уялдааг хангаж, санал хураалтын дүн болон зарчмын зөрүүтэй байр суурийг албан ёсны тайланд нэг бүрчлэн тусгах замаар хяналтын ил тод, бодитой байдлыг баталгаажуулдаг байна.

(71.9.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 1-д зааснаар Тэргүүлэх хороо нь нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудын жагсаалтыг бэлтгэж, түүндээ санаачлагчийн нэр болон хорооны шийдвэрийг (дэмжсэн, эсвэл татгалзсан) заавал тусгаж нэгдсэн хуралдаанд оруулна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 66 дугаар зүйлийн (2)-д заасны дагуу Хороо төслийг хэлэлцэж дуусаад үр дүнгээ бичгээр тайлагнахдаа цөөнхийн санал болон холбогдох бусад хороодын саналын хураангуйг заавал хавсаргана.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 288 дугаар зүйлийн 3(d)-д заасны дагуу Хороо тайландаа батлагдсан нэмэлт, өөрчлөлт бүрийг нарийвчлан заахаас гадна хорооны шатанд хэлэлцээд татгалзсан саналуудыг бас нэг бүрчлэн тусгана.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 13 дугаар дүрмийн 3(b)-д зааснаар Хорооны тайланд олон нийтийн шинжтэй асуудлаарх нэмэлт, өөрчлөлт бүрээр явуулсан санал хураалтын нийт дүн (дэмжсэн, эсрэг) болон санал өгсөн гишүүдийн нэрсийг заавал оруулна.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 1, 83 дугаар зүйлийн 1-д заасны дагуу Төсвийн хороо нь холбогдох бусад хороодоос ирүүлсэн тайлбар, саналыг нэгтгэн ерөнхий тайландаа тусгаж, нэгдсэн хуралдааны өмнө саналуудыг бүлэглэдэг.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 121 дүгээр зүйлийн 1-2-т зааснаар Салбар хороодоос батлагдсан нэмэлт, өөрчлөлтүүдийг Төсвийн хороо нэгтгэж, нэгдсэн хуралдаанд оруулах эцсийн дүгнэлтээ бэлтгэдэг.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 49 болон 106 дугаар зүйлийн дагуу Төсвийн хорооны шатанд бүх асуулт хариулт, мэтгэлцээн дууссаны дараа хорооны дарга хэлэлцүүлгийн үр дүнг нэгдсэн хуралдаанд илтгэх ба үүнд цөөнхийн саналыг заавал тусгана.

Швейцарын Үндэсний зөвлөлийн дэгийн 16 дугаар зүйлд заасны дагуу Тэргүүлэх хороо нь хэлэлцүүлгийн явцад гарсан бүх саналыг болон цөөнхийн саналыг нэг бүрчлэн Танхимд танилцуулж, санал хураалтын дарааллыг тодорхойлдог.

Канадын Нийтийн танхимын дэгийн 81 дүгээр зүйлийн 9-д зааснаар Хороо төсвийн зардлын төсөөллийг хэлэлцээд Танхимд тайлагнахдаа зөвхөн дэмжигдсэн асуудлаар тогтоол гаргах санал оруулдаг.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 152-153 дугаар зүйлийн дагуу Хороо төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг нэг бүрчлэн хэлэлцэж, батлагдсан засваруудыг нэгтгэн Танхимд тайлагнана.

Эдгээр зохицуулалтууд нь хорооны түвшинд хийгдсэн санал хураалтын үр дүнг ил тод болгох, цөөнхийн байр суурийг орхигдуулахгүйгээр нэгдсэн хуралдаанд танилцуулах замаар төсвийн хяналтыг чанаржуулдаг нийтлэг шинжтэй байна.

(71.10.):

Солонгос Үндэсний Ассамблейн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 6-д зааснаар Тамгын газрын дэд дарга нар (Deputy Chiefs of Staff) нь нэгдсэн хуралдааны шийдвэрээр эсвэл Спикерийн зөвшөөрлөөр нэгдсэн хуралдаанд үг хэлэх (speak at the plenary session) эрхтэй байдаг. Мөн тус хуулийн 58 дугаар зүйлийн 1-д зааснаар хорооны шатанд аливаа төслийг хэлэлцэх үед Тамгын газрын дэд даргын хийсэн хянан шалгах тайланг заавал сонсохоор хуульчилсан байна.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 157-2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар Тамгын газар (Chancellery) нь Рийгикогу болон түүний байгууллагуудад хууль тогтоох асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, мэдээллээр хангах (advise in legislative matters) үндсэн чиг үүргийг хүлээдэг.

Канадын Нийтийн танхимын дэгийн 156 дүгээр зүйлийн 2-т зааснаар Хуулийн Клерк (Law Clerk) нь хуулийн төсөлд хийсэн техникийн залруулга, дүгнэлтийн талаарх тайлангаа Танхимын Ерөнхий нарийн бичгийн даргад (Clerk of the House) хүргүүлж, хэлэлцүүлэгт бэлтгэдэг.

Эдгээр олон улсын туршлагаас парламентын Тамгын газар болон түүний дэд дарга (Deputy Chief of Staff) нарыг зөвхөн захиргааны ажилтан биш, харин хууль тогтоох үйл явцад мэргэжлийн хяналт тавьж, дүгнэлтээ нэгдсэн хуралдаан болон хороодод танилцуулах эрх бүхий мэргэшсэн институци гэж үзэн, тэдний оролцоог хуульчлан баталгаажуулсан нь нийтлэг харагдаж байна.

(71.11.):

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 50 дүгээр зүйлд зааснаар хороо төсөвт нөлөөлөхүйц хуулийн төсөл өргөн барих, эсвэл гишүүний өргөн барьсан төсөвт нөлөөлөх хуулийн төслийг хороогоор хэлэлцэхдээ санал хураалт явуулахын өмнө Засгийн газарт саналаа илэрхийлэх боломжийг заавал олгоно. Мөн тус хуулийн 107-II-т нэгдсэн хуралдааны үеэр төсвийн нийт хэмжээг нэмэгдүүлэх эсвэл төсвийн арга хэмжээ шаардсан нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэхэд Засгийн газарт саналаа хэлэх боломжийг олгохоор заажээ.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 7-д зааснаар хэрэв хуулийн төсөл нь төсвийн ямар нэгэн арга хэмжээтэй холбоотой байвал хороо уг асуудлаар Засгийн газрын саналыг заавал сонсохоор хуульчилсан байна.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 334 дүгээр зүйлийн 1-д зааснаар Засгийн газар тухайн хуулийн төсөл, нэмэлт, өөрчлөлт эсвэл санал нь Засгийн газрын төсвийн нэгтгэсэн үзүүлэлтүүдэд (fiscal aggregates) багагүй хэмжээний нөлөө үзүүлэхээр бол түүнийг дэмжихгүй байгаагаар албан ёсоор мэдэгдэх (financial veto) эрхтэй. Мөн дэгийн 335 дугаар зүйлийн 4-т зааснаар татгалзсан тайлбарыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж болохоор зохицуулсан.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 74 дүгээр зүйлийн 1-д зааснаар орлого, зарлагатай холбоотой бүх төслийг Төсөв, төлөвлөлтийн хороонд хүргүүлж, "Эдийн засаг, санхүүгийн төлөвлөлтийн баримт бичиг"-т заасан хязгаарлалт, зарчмуудтай нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргуулдаг. Мөн дэгийн 121 дүгээр зүйлийн 5-д төсвийн болон санхүүгийн хуулийн үндсэн агуулгад нийцэхгүй, төсвийн зарчмыг зөрчсөн нэмэлт, өөрчлөлтүүдийг хэлэлцэхгүй байх зохицуулалтыг тусгажээ

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 5-д зааснаар Засгийн газраас дэмжээгүй, эсвэл тэргүүлэх хорооноос төсөлд нэгтгээгүй нэмэлт, өөрчлөлтийн саналыг санал хураалтад оруулахгүй байхаар зааж, Засгийн газрын байр суурийг төсвийн хэлэлцүүлэгт гол үндэслэл болгохоор хуульчилсан байна

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 180 дүгээр зүйлийн (d)-д зааснаар төсвийн зарлагыг нэмэгдүүлэх, эсвэл зориулалтыг нь өөрчлөх аливаа нэмэлт, өөрчлөлтийг оруулахаас өмнө Ерөнхий амбан захирагчийн (Governor-General) мэдэгдлийг (Засгийн газрын саналыг үндэслэсэн) заавал хүлээн авсан байхыг шаарддаг нь Засгийн газарт тайлбар хийх, хяналт тавих боломж олгодог байна.

Эдгээр олон улсын дэгүүд нь Засгийн газарт төсвийн сахилга батыг хамгаалах, төсвийн үндсэн зарчмууд алдагдахаас сэргийлж нэгдсэн хуралдаан болон хороодод байр сууриа илэрхийлэх эрх зүйн баталгаа олгодог нийтлэг механизмтай болохыг харуулж байна.

(71.12.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 2-т зааснаар хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр тэргүүлэх хорооны төлөөлөгч илтгэл тавих ба төсөл санаачлагч өөрөө хүсвэл эсвэл хороо шийдвэрлэсэн бол мөн адил илтгэл тавьж тайлбар хийнэ. Мөн хуулийн 105 дугаар зүйлийн 4-т гишүүд, хороод болон фракцын төлөөлөгчид төслийн зүйл заалттай холбоотойгоор байр сууриа илэрхийлэн үг хэлж болохоор заасан байна.

Швейцарын Үндэсний зөвлөлийн дэгийн 48 дугаар зүйлийн 1-д зааснаар хэлэлцүүлгийн үед фракцын төлөөлөгчид (spokespersons) болон нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргасан гишүүд үг хэлэх эрхтэй. Мөн дэгийн 52 дугаар зүйлийн 2-т фракцын төлөөлөгчид үг хэлж, гаргасан бүх саналынхаа үндэслэл, шалтгааныг тайлбарлахаар заасан.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 83 дугаар зүйлийн 1-д зааснаар ерөнхий хэлэлцүүлгийн үед олонх болон цөөнхийн илтгэгч нар, Засгийн газар болон фракц бүрээс нэг гишүүн үг хэлэх эрхтэй. Мөн дэгийн 85 дугаар зүйлийн 4-т зааснаар төслийн заалт, нэмэлт өөрчлөлт бүрээр фракц бүрээс нэг гишүүн 5 хүртэл минут "санал хураалтын үндэслэлээ" (explanation of vote) тайлбарлан үг хэлж болохоор тусгасан.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 101 дүгээр зүйлд зааснаар хорооны дарга эсвэл цөөнхийн санал гаргагчаар томилогдсон гишүүн хорооны илтгэлд нэмэлт тайлбар хийх (supplement a report) зорилгоор бусад гишүүдээс давуу эрхтэйгээр үг хэлж болдог.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 18 дүгээр дүрмийн 5(a) заалтад заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргасан гишүүн бүрд тухайн саналаа тайлбарлахад (explain it) нь зориулж 5 минут үг хэлэх эрх олгодог.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 105 дугаар зүйлийн 5-д зааснаар төсвийн зардлын асуудлаар (budget votes) шийдвэр гаргахын өмнө фракцууд өөрсдийн байр сууриа тайлбарлан үг хэлэх (declarations of vote) боломжийг олгодог. Мөн дэгийн 289 дүгээр зүйлд хорооны тайланг танилцуулж буй гишүүн уг тайлангийн агуулгыг тайлбарлан үг хэлэх эрхийг баталгаажуулсан байна.

Эдгээр дэгүүд нь төсөв болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр санал гаргагч талууд (хороо, фракц, гишүүн) өөрсдийн саналын үндэслэлээ нэгдсэн хуралдаанд тайлбарлах замаар мэтгэлцээнийг бодитой, мэдээлэлд суурилсан болгоход чиглэдэг байна.

(71.14.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 1, 2-т зааснаар нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг мэтгэлцээн дууссаны дараа санал хураалтад оруулна. Хуралдаан даргалагч нь санал гаргагч эсвэл фракц шаардсан тохиолдолд тухайн санал бүрээр заавал санал хураалт явуулахаар хуульчилсан байна.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 315 дугаар зүйлийн 2-т зааснаар тухайн зүйл, заалтын талаар мэтгэлцэж дууссаны дараа нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулсан нэмэлт, өөрчлөлт бүрээр санал хураалт явуулдаг. Мөн тус дэгийн 313 дугаар зүйлийн 1-д зааснаар заалт бүрийг төсөлд хэвээр үлдээх эсэхээр (that each provision stand part of the bill) тус бүрд нь санал хураахаар зохицуулжээ.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 87 дугаар зүйлийн 1-д зааснаар нэмэлт, өөрчлөлт оруулах санал бүрээр болон тухайн зүйл, заалтыг бүхэлд нь батлах санал хураалтыг тус тусад нь явуулдаг. Мөн дэгийн 87 дугаар зүйлийн 3-т зааснаар хэрэв нэг заалтад олон санал гарвал тэдгээрийг логик дарааллаар (хасах, өөрчлөх, нэмэх гэх мэт) нэг бүрчлэн хураахаар нарийвчлан заажээ.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 1-д зааснаар нэг асуудалд хэд хэдэн нэмэлт, өөрчлөлтийн санал ирүүлсэн бол тэдгээрийг тогтоосон дарааллын дагуу тус бүрчлэн санал хураалт явуулж шийдвэрлэнэ.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 91 дүгээр зүйлд зааснаар хэрэв гишүүн хүсэлт гаргавал хуралдаан даргалагч зүйл, заалт эсвэл нэмэлт, өөрчлөлт бүрээр тус тусад нь санал хураалт явуулахаар заасан байна.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 286 дугаар зүйлийн (1)(e)-д хуулийн төслийг заалт бүрээр (clause by clause), түүнд холбогдох нэмэлт, өөрчлөлтийн саналуудын хамт хэлэлцэж, шийдвэр гаргахаар тусгасан байна.

Сингапурын Парламентын дэгийн 74 дүгээр зүйлийн 1-д зааснаар заалт бүрийн дугаарыг дуудаж, хэрэв нэмэлт санал байхгүй бол тухайн заалтыг төсөлд үлдээх эсэхээр тус бүрд нь санал хураалт явуулна. Мөн дэгийн 74 дүгээр зүйлийн 11-д шинээр нэмэх заалт (new clause) бүрийг тусад нь хэлэлцэж, санал хураахаар зохицуулжээ.

Канадын Нийтийн танхимын дэгийн 75 дугаар зүйлийн 1-д хуулийн төслийн заалт бүрийг (every other clause) зохих дарааллын дагуу нэг бүрчлэн хянаж, шийдвэрлэхээр заасан байна.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 149 дүгээр зүйлийн (a)-д зааснаар хуулийн төслийн заалт болон хавсралт бүрийг тоон дарааллын дагуу (in numerical order) нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураахаар хуульчилжээ.

Эдгээр олон улсын дэгүүд нь хууль тогтоох үйл ажиллагааны нарийвчлалыг хангах үүднээс төслийн бүх хэсэг, нэгж болон тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг нэг бүрчлэн авч хэлэлцэн, тус бүрд нь шийдвэр гаргуулдаг нийтлэг механизмтай болохыг харуулж байна.

(71.15.):

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 154 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг эхлэхийн өмнө гишүүн ямар нэгэн мэдэгдэлгүйгээр төслийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь (in whole or in part) нарийвчлан дахин хэлэлцүүлэх (reconsidered in detail) санал гаргаж болно.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар төслийн эцсийн заалтаар санал хураах хүртэлх хугацаанд хуулийн төслийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь анхны хороонд эсвэл өөр хороонд буцаан шилжүүлж (referred back) болох бөгөөд энэ нь хэлэлцэж, санал хураасан заалтуудад ч хамаарахаар зохицуулжээ.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 319 дүгээр зүйлд зааснаар төслийг гурав дахь хэлэлцүүлгийн өмнө дахин хэлэлцүүлэхээр (recommittal) хороонд шилжүүлж болно. Мөн дэгийн 177 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хороонд чиглэл өгөхдөө түүний эрх мэдлийг өргөтгөх эсвэл хязгаарлах (extending or restricting its powers), эсхүл тодорхой асуудлыг тухайлан хэлэлцэхийг даалгаж болно. Дэгийн 177 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тухайн чиглэлтэй холбоотой мэтгэлцээн нь зөвхөн тухайн асуудлын хүрээнд (restricted to the subject matter of the motion) явагдахаар хязгаарласан байна.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 309 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Ассамблей төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө уг төсөл эсвэл тодорхой нэмэлт, өөрчлөлтийн саналыг дахин хэлэлцүүлэхээр (recommit) хороонд буцааж болохоор хуульчилсан байна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 94 дүгээр зүйлд нэгдсэн хуралдаанаас шаардлагатай гэж үзвэл тогтоолоор төслийг үндсэн хороонд эсвэл өөр хороонд дахин хэлэлцүүлэхээр шилжүүлж (re-refer) болохоор заасан байна.

Их Британийн Нийтийн танхимын дэгийн 72 болон 74 дүгээр зүйлд зааснаар хуулийн төслийг бүхэлд нь эсвэл тодорхой заалтуудын хүрээнд хороонд дахин шилжүүлж болно (re-committal).

Эдгээр олон улсын дэгүүд нь төслийг эцэслэн батлахаас өмнө гарсан техникийн болон агуулгын зөрүүг арилгах зорилгоор төслийг бүхэлд нь биш, зөвхөн шаардлагатай тэрхүү хэсэгт нь хорооны мэргэжлийн дүгнэлтийг дахин гаргуулах, ингэхдээ хэлэлцүүлгийн хүрээг тодорхой заалт, чиглэлээр хязгаарлах замаар хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг нийтлэг механизмтай болохыг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>72 дугаар зүйл.Төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг</p> <p>72.1.Төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, хэрэгжих хугацаа, байршилтай холбоотой залруулгыг хийж, төсвийн төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>72.2.Нэгдсэн хуралдаанаар дөрөв дэх хэлэлцүүлэг явуулахад зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар гишүүд тайлбар хийх, түүнтэй холбогдуулан асуулт асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй.</p> <p>72.3.Хуралдаан даргалагч төсвийн төслийг тав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.</p> <p>72.4.Төсвийн төслийн дөрөв, тав дахь хэлэлцүүлгийг хамтатган явуулж болно.</p>	<p>72 дугаар зүйл.Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг</p> <p>72.1.Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, хэрэгжих хугацаа, байршилтай холбоотой залруулгыг хийж, төсвийн төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>72.2.Нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлэг явуулахад зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар гишүүд тайлбар хийх, түүнтэй холбогдуулан асуулт асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй.</p> <p>72.3.Хуралдаан даргалагч төсвийн төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.</p> <p>72.4.Төсвийн төслийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хамтатган явуулж болно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

(72.1.):

1. Хэлэлцүүлгийн явцад төслийн эцсийн хувилбарыг бэлтгэх, залруулга хийх

Эстониин Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 1-д зааснаар төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ тэргүүлэх хороо нь хоёр дахь хэлэлцүүлэг дууссаны дараа хэл найруулгын болон техникийн шинжтэй залруулга (linguistic and technical rectifications) хийж төслийн эцсийн хувилбарыг бэлтгэхээр хуульчилсан байна.

Солонгост Үндэсний Ассамблейн тухай хуулийн 97 дүгээр зүйлд төслийг санал хураасны дараа хоорондоо зөрчилдсөн заалтууд, үг хэллэг, тоо баримт болон бусад асуудлыг зохицуулах (adjust) шаардлагатай бол нэгдсэн хуралдаанаас төсөлд засвар оруулах эрхийг Спикер эсвэл холбогдох хороонд шилжүүлж болохоор заасан.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1-д Бундестагийн Ерөнхийлөгч (Спикер) хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр батлагдсан аливаа нэмэлт, өөрчлөлтүүдийг нэгтгэн бүлэглэхийг зохион байгуулах ба тус хуулийн 83 дугаар зүйлийн 2-т зааснаар хоёр дахь хэлэлцүүлгийн шийдвэрүүд нь гурав дахь хэлэлцүүлгийн үндэс суурь болно хэмээн тусгасан.

Швейцарын Парламентын тухай хуулийн 56 дугаар зүйлд зааснаар хоёр Танхимын хамтарсан Төслийг бэлтгэх хороо (Drafting Committee) нь төслийн эцсийн хувилбарыг бэлтгэхдээ агуулгыг өөрчлөхгүйгээр хэл найруулгын болон хууль зүйн техникийн нэгдмэл байдлыг хангах үүрэг хүлээдэг.

2. Гурав дахь хэлэлцүүлэгт төслийг танилцуулгатай хамт оруулах.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 308 дугаар зүйлд зааснаар хоёр дахь хэлэлцүүлгийн дараа хорооноос санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг баталж, төслийг дараагийн шатны хэлэлцүүлэгт бэлтгэдэг.

Их Британийн Нийтийн танхимын дэгийн 77 дүгээр зүйлийн 1-д зааснаар гурав дахь хэлэлцүүлгийн шатанд төслийн агуулгад зөвхөн хэл найруулгын чанартай залруулга (merely verbal) хийхийг зөвшөөрдөг ба энэ нь төслийн үндсэн зарчмыг өөрчлөхгүй байх баталгаа болдог.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 104 дүгээр зүйлд хорооноос шилжүүлсэн асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хорооны дарга эхлээд хэлэлцүүлгийн явц, үр дүнг заавал тайлагнахаар тусгасан байна.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 288 дугаар зүйлийн 3(п)-д зааснаар хороо нь нэгдсэн хуралдаанд танилцуулахын өмнө хуулийн төслийн эцсийн хувилбарыг (final version of the Bill), танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулдаг.

Эдгээр олон улсын дэгүүд нь төсвийн төслийг эцэслэн батлахын өмнө парламентын хороод мэргэжлийн түвшинд ажиллаж, гишүүдийн олонхын дэмжсэн саналыг алдаагүй нэгтгэн тусгах, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр техникийн засвар хийх замаар хуулийн төслийн чанарыг хангах нийтлэг механизмыг хэрэгжүүлдэг болохыг харуулж байна.

(72.2.):

Францын Үндэсний Ассамблейн дэгийн 133 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Засгийн газрын тодорхой мэдэгдэл эсвэл мэдээлэлтэй холбогдуулан цөөн тооны гишүүд хариу тайлбар хийхийг зөвшөөрч болох ба энэ үед "ямар нэг санал хураалт явуулахгүй" байхаар тусгасан байна.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 402 дүгээр зүйлийн 2-т ерөнхий хэлэлцүүлэг (general debate) хийхдээ ямар нэг асуудлаар санал хураалт явуулахгүй (without any question being put) байхаар заасан. Мөн дэгийн 400 дүгээр зүйлийн 3-т зааснаар яаралтай хэлэлцүүлэг (urgent debate)-ийг мөн адил санал хураалтгүйгээр явуулдаг.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 104 дүгээр зүйлд зааснаар хорооноос шилжүүлсэн асуудлыг хэлэлцэхэд хорооны дарга эхлээд агуулгыг тайлбарлаж, хэлэлцүүлгийн явц, үр дүнг (progress and results) тайлагнах бөгөөд үүний дараа асуулт асуух үйл ажиллагаа эхэлдэг.

Канадын Нийтийн танхимын дэгийн 35 дүгээр зүйлийн 1-д хорооны тайланг танилцуулж буй гишүүн уг тайлангийн агуулгын талаар товч тайлбар (succinct explanation) хийхийг зөвшөөрч болохоор заасан.

Эдгээр дэгүүд нь парламентын хэлэлцүүлгийн тодорхой үе шатуудад, ялангуяа хорооны дүгнэлтийг сонсох болон мэдээлэл авах шатанд санал хураалтаар шийдвэр гаргахаас илүүтэй гишүүдэд мэдээлэл өгөх, асуулт хариулт явуулах боломжийг олгоход чиглэдэг байна.

(72.3.):

1. Хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр хороонд шилжүүлэх (Referral for preparation/report)

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 313 дугаар зүйлийн 3-т зааснаар Спикер тухайн төслийн хэлэлцүүлгийг үр дүнтэй болгохын тулд хорооны дүгнэлт шаардлагатай гэж үзвэл уг төслийг нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд оруулахын өмнө "эхлээд холбогдох хороонд тайлан бэлтгүүлэхээр шилжүүлэх" (must first refer the Bill to the committee for a report) үүрэгтэй.

Эстониин Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 1-д зааснаар гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ тэргүүлэх хороо (lead committee) хоёр дахь хэлэлцүүлгийн дараах засвар, залруулгыг тусган төслийн эцсийн хувилбарыг бэлтгэх үүрэг хүлээдэг.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 83 дүгээр зүйлийн 1-д зааснаар Бундестагийн Ерөнхийлөгч (Спикер) хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр батлагдсан аливаа нэмэлт, өөрчлөлтүүдийг нэгтгэн бүлэглэх, мөн төслийг дараагийн шатны хэлэлцүүлэгт бэлтгүүлэх ажлыг зохион байгуулна.

2. Дахин хэлэлцүүлэхээр хороонд буцаах (Recommittal/Referral back)

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 319 дүгээр зүйлд зааснаар төслийн гурав дахь хэлэлцүүлгийн өмнө гишүүн уг төслийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг дахин хэлэлцүүлэх (recommittal) зорилгоор хороонд шилжүүлэх санал гаргах эрхтэй.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 309 дүгээр зүйлийн 3-т зааснаар Ассамблей төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө уг төсөл болон нэмэлт өөрчлөлтийн саналыг дахин хэлэлцүүлэхээр хороонд (recommit) шилжүүлж болно.

Их Британийн Нийтийн танхимын дэгийн 72 болон 74 дүгээр зүйлд зааснаар хуулийн төслийг бүхэлд нь эсвэл зарим заалтын хүрээнд дахин хэлэлцүүлэхээр хороонд шилжүүлж (re-committal) болно.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 77 дүгээр зүйлийн (1)(b)-д зааснаар хорооны тайлан ирсний дараа төслийг ямар нэг хязгаарлалтгүйгээр эсвэл зөвхөн тодорхой заалтуудын хүрээнд дахин хэлэлцүүлэхээр хороонд шилжүүлж (re-committed) болно.

3. Техникийн засвар хийхээр шилжүүлэх (Adjustment/Rectification)

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 97 дүгээр зүйлд зааснаар төсөлд техникийн болон үг хэллэгийн засвар хийх шаардлагатай бол нэгдсэн хуралдаанаас төслийг Спикер эсвэл холбогдох хороонд шилжүүлж, дахин хянуулж болно.

Канадын Нийтийн танхимын дэгийн 156 дүгээр зүйлийн 1-д зааснаар Танхимын Хуулийн Клерк нь төслийн үг үсэг, техникийн шинжтэй залруулгуудыг хийх эрхтэй бөгөөд энэ нь төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх нэг хэлбэр болдог.

Эдгээр дэгүүд нь хуралдаан даргалагч эсвэл Танхимын шийдвэрээр төслийг эцсийн хэлэлцүүлэгт орохоос өмнө хорооны түвшинд техникийн болон агуулгын хувьд гүйцэд боловсруулах, дахин нягтлах боломжийг олгодог нийтлэг механизмтай болохыг харуулж байна.

(72.4.):

Канадын Нийтийн танхимын дэгийн 71 дүгээр зүйлд заасны дагуу аливаа хуулийн төслийг батлахаас өмнө гурван тусдаа хэлэлцүүлгээр орох ёстой боловч "яаралтай болон онцгой тохиолдолд төслийг хоёр эсвэл гурван удаа хэлэлцэх, эсвэл нэг өдөрт хоёр болон түүнээс дээш шатны хэлэлцүүлгийг хамтатган явуулж" болохоор зохицуулсан байна.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нэмэлт төсвийн тухай хуулийн төслийг "Council of Elders" удирдах зөвлөлийн саналаар эхний хэлэлцүүлгийг алгасаж, "нэг хэлэлцүүлгээр эцэслэн шийдвэрлэж" (be dealt with conclusively in one reading) болохоор зохицуулсан байна.

Сингапурын Парламентын дэгийн 93 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Төсвийн байнгын хорооны (Committee of Supply) хэлэлцүүлгийн дараа төсвийн хуулийн төслийн (Supply Bill) "хоёр болон гурав дахь хэлэлцүүлгийг нэг өдөрт" (one day allotted) хамтатган явуулахаар тусгасан байна.

Эстониин Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зарим төрлийн хууль, тогтоолын төслийг "нэг хэлэлцүүлгээр" (deliberated in a single reading) шийдвэрлэхээр заасан бөгөөд тус хуулийн 1182 дугаар зүйлийн 1-д зааснаар Засгийн газрын хүсэлтээр санхүүгийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой яаралтай асуудлыг мөн адил нэг хэлэлцүүлгээр шийдвэрлэж болдог.

Эдгээр дэгүүд нь төсвийн болон яаралтай хэлэлцэх шаардлагатай асуудлаар хэлэлцүүлгийн үе шатуудыг хамтатган явуулах замаар парламентын шийдвэр гаргах ажиллагааг шуурхай болгох нийтлэг механизмтай болохыг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>73 дугаар зүйл.Төсвийн төслийн тав дахь хэлэлцүүлэг</p> <p>73.3.Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуульд тодотгол хийх асуудлыг энэ хуулийн 69, 69¹, 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>	<p>73 дугаар зүйл.Төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг</p> <p>73.3.Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуульд тодотгол хийх асуудлыг энэ хуулийн 69, 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>74 дүгээр зүйл.Төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэх</p> <p>74.5.Нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлэг явуулах үед гишүүд энэ хуулийн 74.4.1-д заасан илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн энэ хуулийн 74.3-т заасан албан тушаалтнаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд үүний дараа төсвийн гүйцэтгэлийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлнэ.</p>	<p>74 дүгээр зүйл.Төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэх</p> <p>74.5.Нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлэг явуулах үед гишүүд энэ хуулийн 74.4.1-д заасан илтгэл болон дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн энэ хуулийн 74.3-т заасан албан тушаалтнаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд үүний дараа төсвийн гүйцэтгэлийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлнэ.</p>

2.8.АРАВДУГААР БҮЛЭГ: ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ САНАЛ, ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ, ГАДААД ХАРИЛЦААТАЙ ХОЛБОГДОХ АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>75 дугаар зүйл.Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг зөвшилцөх</p> <p>75.3.2.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн олон улсын гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах,</p>	<p>75 дугаар зүйл.Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг зөвшилцөх</p> <p>75.3.2.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн олон улсын гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах,</p>

<p>эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээний төслийг Хууль зүйн байнгын хороо;</p> <p>75.3.3.хүний салшгүй эрх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээний төслийг Хууль зүйн байнгын хороо.</p> <p>75.5.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, холбогдох баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороодын, эсхүл бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.</p> <p>75.12.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нь Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороодын санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.</p> <p>75.13.Энэ хуулийн 75.9, 75.12-т заасны дагуу хэлэлцүүлсэн олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн гишүүдийн олонхын саналаар энэ хуулийн 75.8.1, 75.8.2, 75.8.3-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.</p>	<p>эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээний төслийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо;</p> <p>75.3.3.хүний салшгүй эрх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээний төслийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо.</p> <p>75.5.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, холбогдох баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хороодын, эсхүл бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.</p> <p>75.12.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нь Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хороодын санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.</p> <p>75.13.Нэгдсэн хуралдаан олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, энэ хуулийн 75.9, 75.12-т заасны дагуу гарсан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт бичгээр мэдэгдэнэ.</p>
---	--

Тайлбар: Олон улсын гэрээг зөвшилцөх, гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, дипломат харилцаа тогтоох зэрэг асуудлаарх дэгийн зарим /75, 76, 77, 80, 82 дугаар зүйл/ зарим зохицуулалтыг тодруулж тусгана. Үүнд нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн олонхын саналаар шийдвэрлэсэн бол гарсан үр дүнг хэрхэн мэдэгдэх талаарх зохицуулалт тодорхойгүй байгаа тул үр дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт бичгээр мэдэгдэхээр тусгана.

Олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, гэрээг зөвшилцөх хэлэлцүүлэх дэгийн зохицуулалтад гишүүдийн олонх дэмжээгүй бол буцаах тогтоол баталсанд тооцох зохицуулалтыг тусгана. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, дипломат харилцаа тогтоох, цуцлах, хилийн чанадад дипломат төлөөлөгчийн газар нээх талаарх дэгийн зохицуулалтад нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн тогтоолыг батлах, эсхүл буцаах тогтоол батлах зохицуулалтыг нэмж тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (75.13):

1. Хэлэлцүүлгийг тодорхой асуудлаар хязгаарлан буцаах (Instructions & Specific Issues)

ОУ-ын практикт төслийг бүхэлд нь биш, зөвхөн тодорхой заалт, асуудлын хүрээнд хороонд буцааж, хэлэлцүүлгийг тэрхүү хүрээнд хязгаарлах механизмыг дараах дэгээр зохицуулдаг:

Швейцарын Парламентын тухай хуулийн 75 дугаар зүйлийн 2, 3-т зааснаар Танхим нь хуулийн төслийн тодорхой хэсэг, заалтыг дараагийн шатны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр буцааж болох ба ингэхдээ "юуг дахин нягтлах, өөрчлөх, нэмэх тухай чиглэлийг заавал заана" хэмээн зохицуулсан.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 77 дугаар зүйлийн (1)(b)-д хорооны тайлан ирсний дараа төслийг дахин хэлэлцүүлэхээр хороонд буцааж болох ба ингэхдээ "ямар нэг хязгаарлалтгүйгээр эсвэл зөвхөн тодорхой заалтууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн хүрээнд" хэлэлцэх чиглэл өгөхөөр заасан байна.

Сингапурын Парламентын дэгийн 76 дугаар зүйлийн (1)(а)-д зааснаар төслийг эцэслэн батлахаас өмнө "зөвхөн зарим нэг тусгайлсан заалтуудын хүрээнд" хороонд буцааж хэлэлцүүлэхээр зохицуулжээ.

Канадын Нийтийн танхимын дэгийн 83 дугаар зүйлийн (13)-т зааснаар Танхим тайланг хэлэлцэж дуусахаас өмнө "тусгай чиглэл өгөх замаар дахин хэлэлцүүлэхээр" буцаах эрхтэй.

2. Төслийг хороонд буцаах ерөнхий журам (Referral Back/Recommittal)

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн (3)-т зааснаар хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр төслийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь үндсэн хороонд эсвэл өөр хороонд буцаан шилжүүлж болох бөгөөд энэ нь хэлэлцүүлж санал хураасан заалтуудад ч хамаатай байна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар Танхим нэгдсэн хуралдааны үеэр төслийг холбогдох хороонд эсвэл өөр хороонд дахин хэлэлцүүлэхээр шилжүүлэх шийдвэр гаргаж болно.

Норвегийн Стортингийн дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд төслийг хороонд буцаах саналыг хэлэлцүүлэг дуусахаас өмнө гаргах ба хуралдаан даргалагч уг саналыг санал хураалтаар шийдвэрлэхээр заажээ.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 309 дүгээр зүйлийн (3)-т зааснаар Ассамблей төсөл болон нэмэлт, өөрчлөлтийн саналыг эцсийн шийдвэр гаргахаас өмнө дахин хэлэлцүүлэхээр хороонд буцаах эрхтэй.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 154 дүгээр зүйлд зааснаар төслийн гурав дахь хэлэлцүүлгийн өмнө гишүүн төслийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нарийвчлан дахин хэлэлцүүлэх (reconsideration in detail) санал гаргах эрхтэй.

Эдгээр олон улсын туршлагаас үзэхэд төслийг хороонд буцаахдаа "чиглэл өгөх" замаар хэлэлцэх хүрээг хязгаарлах нь парламентын цаг хугацааг хэмнэх, хэлэлцүүлгийн үр дүнг хангах чухал механизм болдог байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>76 дугаар зүйл.Зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан зөвшилцөх</p> <p>76.10.Энэ хуулийн 76.7-д заасны дагуу хэлэлцүүлсэн олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн гишүүдийн олонхын саналаар энэ хуулийн 76.6.1, 76.6.2, 76.6.3-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.</p>	<p>76 дугаар зүйл.Зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан зөвшилцөх</p> <p>76.10.Нэгдсэн хуралдаан олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, энэ хуулийн 76.7, 76.8-д заасны дагуу гарсан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт бичгээр мэдэгдэнэ.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (76.10):

1. ОУ-ын гэрээг хэлэлцэх, санал хураах журам

ОУ-ын практикт гэрээ, хэлэлцээрийг хороогоор дамжуулан нэгдсэн хуралдаанаар баталгаажуулахдаа дараах дэгийн зохицуулалтыг мөрдөж байна:

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлд зааснаар олон улсын гэрээний төслийг хоёр хэлэлцүүлгээр хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлгийн дараа эцсийн санал хураалт явуулдаг. Мөн хуулийн 92 дугаар зүйлийн (4)-т гэрээний төслийг эх хэл болон гадаад хэлээрх эх бичвэрийн хамт өргөн мэдүүлэхээр заасан байна.

Францын Үндэсний Ассамблейн дэгийн 128 дугаар зүйлийн 1-д зааснаар олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэхдээ тухайн гэрээний зүйл, заалт бүрээр санал хураадаггүй бөгөөд зөвхөн соёрхон батлах эсэхээр бүхэлд нь шийдвэр гаргадаг.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн (1)-д зааснаар гадаад улстай байгуулсан гэрээг зарчмын хувьд хоёр хэлэлцүүлгээр шийдвэрлэх ба Бундестаг шийдвэрлэсэн тохиолдолд гурван хэлэлцүүлэг явуулж болохоор зохицуулжээ.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 405-408 дугаар зүйлд зааснаар ЗГ олон улсын гэрээг "үндэсний ашиг сонирхлын дүн шинжилгээ"-ний хамт парламентад өргөн барьж, Гадаад хэрэг, батлан хамгаалахын хороо дүгнэлт гаргаж Танхимд танилцуулахаар заасан.

2. Шийдвэрийн дүнг Ерөнхийлөгч болон ЗГ-т мэдэгдэх

Парламентаас гаргасан шийдвэрийг гүйцэтгэх засаглалд бичгээр мэдэгдэх, баталгаажуулах механизмыг дараах байдлаар зохицуулж байна:

Италийн Депутатуудын танхимын дэгийн 127 дүгээр зүйлийн (4)-т зааснаар олон улсын болон зохицуулалтын баримт бичгийг хянан хэлэлцсэн хорооны эцсийн баримт бичгийг (дүгнэлт) Танхимын дарга Сенатын болон Сайд нарын зөвлөлийн даргад (ЗГ) бичгээр мэдэгдэх үүрэгтэй байна.

Сингапурын Парламентын дэгийн 96 дугаар зүйлийн (1)-д зааснаар Парламент баталгаа гаргах эсвэл зээл авахтай холбоотой тогтоол баталсан тохиолдолд Танхимын даргаар баталгаажуулсан тогтоолын хувийг Ерөнхийлөгчид хүргүүлэхээр заажээ.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 98-2 дугаар зүйлийн (5)-д зааснаар Ассамблей хэлэлцсэн асуудлын үр дүнг нэгдсэн хуралдааны тогтоолоор шийдвэрлэж, ЗГ-т илгээхээр зохицуулсан.

Норвегийн Стортингийн дэгийн тухай хуулийн 65 дүгээр зүйлд зааснаар асуудлыг шийдвэрлэсний дараа Стортингийн захиргаа шаардлагатай албан бичгийн төслийг боловсруулж, Стортингийн дарга баталснаар холбогдох этгээдэд (Хаан/ЗГ) хүргүүлдэг.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 183 дугаар зүйлд зааснаар Танхимаас баталсан тогтоол бүрийн хувийг холбогдох Сайдад (ЗГ-т) хүргүүлэхээр тусгасан байна.

Эдгээр зохицуулалт нь парламентын шийдвэрийг гүйцэтгэх засаглалд албан ёсоор мэдэгдэх (Communication of resolutions) замаар төрийн залгамж чанар болон засаглал хоорондын мэдээлэл солилцоог хангадаг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>77 дугаар зүйл.Олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, гэрээг урьдчилан зөвшилцөх, хэлэлцүүлэх</p> <p>77.4.Дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээг Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ:</p> <p>77.6.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төсөл, баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын</p>	<p>77 дугаар зүйл.Олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, гэрээг урьдчилан зөвшилцөх, хэлэлцүүлэх</p> <p>77.4.Дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ:</p> <p>77.6.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төсөл, баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хороонд, эсхүл бусад Байнгын</p>

<p>хороонд, эсхүл бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.</p> <p>77.14.Энэ хуулийн 77.9.2, 77.13-т заасны дагуу хэлэлцүүлэх олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:</p> <p>-</p>	<p>хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.</p> <p>77.14.Энэ хуулийн 77.9.2, 77.13-т заасны дагуу хэлэлцүүлэх олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:</p> <p>77.16.Энэ хуулийн 77.14.2-т заасан хуулийн төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.</p>
---	---

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (77.16.):

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 87 дүгээр зүйлийн 2-т зааснаар хорооноос нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн төслийн талаар гишүүд тогтоосон хугацаанд (7 хоног) нэгдсэн хуралдаанд оруулах хүсэлт гаргаагүй бол тухайн төслийг "хүчингүй болсонд тооцно" (repealed).

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 112 дугаар зүйлийн 1-д зааснаар төслийг хэлэлцэх эсвэл дараагийн шатанд шилжүүлэх тухай саналыг Танхим дэмжээгүй бол тухайн төслөөр дахин санал гаргахгүй бөгөөд төслийг хэлэлцэж буй төслийн бүртгэлээс хасахаар (removed from the Register of Bills) зохицуулжээ.

Швейцарын Парламентын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 5-д хуулийн төслийг бүхэлд нь санал хураахад дэмжигдээгүй бол энэ нь тухайн төслийг "хэлэлцэхийг дэмжээгүйтэй адил" (equivalent to non-approval of introduction) үр дагавартай гэж заасан байна.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 300 дугаар зүйлийн 2-т зааснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд Ассамблей дэмжээгүй бол төсөл "хүчингүй болно" хэмээн зохицуулсан.

Канадын Нийтийн танхимын дэгийн 97.1 дүгээр зүйлийн (d)-д зааснаар төслийг цаашид хэлэлцэхгүй байх тухай хорооны тайланг Танхим дэмжсэн бол уг төслийг хэлэлцэх бүх ажиллагаа дуусгавар болдог.

Эдгээр зохицуулалтууд нь парламентын олонхын дэмжлэг авч чадаагүй хуулийн төслийг хэлэлцэх ажиллагааг шууд зогсоох, хүчингүй болгох эсвэл санаачлагчид нь буцаах замаар хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөөг хангахад чиглэдэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>80 дугаар зүйл.Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх</p> <p>80.4.Засгийн газар гадаад улстай дипломат харилцаа тогтоох, эсхүл цуцлах асуудлаар тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг энэ хуулийн 80.1-д заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>-</p>	<p>80 дугаар зүйл.Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх</p> <p>80.4.Засгийн газар гадаад улстай дипломат харилцаа тогтоох, эсхүл цуцлах асуудлаар тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг энэ хуулийн 80.1-д заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>80.5.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын</p>

	<p>хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>80.6.Энэ хуулийн 80.1, 80.4-т заасан тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.</p>
--	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (80.5.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 5-д зааснаар ЗГ-т санал хүргүүлэх тогтоолын төслийг хэлэлцэхэд уг төслийг санаачлагч болон тэргүүлэх хорооны төлөөлөгч илтгэл тавих бөгөөд гишүүд илтгэгч бүрээс нэг асуулт асуух эрхтэй. Мөн хуулийн 98 дугаар зүйлийн 3, 4-т аливаа төслийн нэг дэх хэлэлцүүлэг санаачлагчийн болон хорооны илтгэлээр эхлэх ба гишүүн бүр хоёр хүртэл асуулт асуухаар зохицуулжээ.

Солонгос Үндэсний Ассамблейн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 1-д зааснаар хороо төслийг хэлэлцэхдээ түүний зорилгын талаарх тайлбар болон мэргэжлийн ажилтны дүгнэлтийг сонсож, ерөнхий хэлэлцүүлэг буюу санаачлагчаас асуулт асууж хариулт авах үйл явцыг явуулна. Мөн хуулийн 93 дугаар зүйлд нэгдсэн хуралдааны үеэр хорооны даргын илтгэлийг сонсож, асуулт хариулт болон мэтгэлцээн явуулсны дараа санал хураахаар тусгасан байна.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 104 дүгээр зүйлд зааснаар хорооноос шилжүүлсэн асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хорооны дарга эхлээд агуулгыг тайлбарлаж, явц, үр дүнг тайлагнах ба үүний дараа асуулт асууж эхэлнэ. Мөн дэгийн 108 дугаар зүйлд гишүүд хорооны дарга, цөөнхийн санал гаргагч болон төсөл санаачлагчаас асуулт асууж болохоор заажээ.

Швейцарын Үндэсний зөвлөлийн дэгийн 19 дүгээр зүйлийн 1-д зааснаар хороо нь төслийг Танхимд танилцуулж, хорооны саналыг хамгаалах илтгэгч томилно. Мөн дэгийн 52 дүгээр зүйлд зааснаар бүх гишүүд үг хэлж дууссаны дараа Засгийн газрын төлөөлөгч болон хорооны илтгэгч нар хариу тайлбар (response) хийх эрхтэй байдаг.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 282 дүгээр зүйлийн 2-т зааснаар төслийн нэг дэх хэлэлцүүлэг санаачлагчийн танилцуулга болон түүний дараах мэтгэлцээнээс бүрдэнэ. Мөн дэгийн 289 дүгээр зүйлд хорооны тайланг танилцуулж буй гишүүн уг тайлангийн агуулгыг тайлбарлан Танхимд хандан үг хэлж болохоор тусгасан байна.

Канадын Нийтийн танхимын дэгийн 35 дүгээр зүйлийн 1-д зааснаар хорооны тайланг танилцуулж буй гишүүн уг тайлангийн агуулгын талаар товч тайлбар хийхийг зөвшөөрдөг. Мөн дэгийн 95 дугаар зүйлийн 1-д зааснаар гишүүний гаргасан саналыг хэлэлцэх үед 15 минут үг хэлсний дараа 5 минутын асуулт хариулт, тайлбарын хугацаа олгохоор зохицуулжээ.

Сингапурын Парламентын дэгийн 66 дүгээр зүйлийн 3-т зааснаар хууль, тогтоолын төслийг өргөн мэдүүлж буй гишүүн уг төслийн талаар товч тайлбар хийх бөгөөд эсэргүүцэж буй гишүүд мөн адил байр сууриа илэрхийлдэг.

Эдгээр зохицуулалт нь тогтоолын төслийг хэлэлцэж эхлэхдээ санаачлагчийн бодлогын үндэслэл болон хорооны хяналтын дүгнэлтийг зэрэгцүүлэн сонсож, тэдгээртэй холбогдуулан гишүүд асуулт тавих замаар мэдээлэл авах, байр сууриа илэрхийлэх боломжийг баталгаажуулдаг байна.

(80.6.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 1-д зааснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл шаардлагатай олонхын санал авч чадаагүй бол тухайн хуулийг "татгалзсанд тооцно". Мөн хуулийн 125 дугаар зүйлийн 6-д зааснаар ард нийтийн

санал асуулга явуулах тогтоолын төсөл шаардлагатай олонхын дэмжлэг аваагүй бол холбогдох хуулийн төслийг мөн адил татгалзсанд тооцдог байна.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 3-т хэрэв хуулийн төслийн бүх заалтыг хоёр дахь хэлэлцүүлгээр татгалзсан бол уг төслийг "татгалзсанд тооцож, цаашид хэлэлцүүлэг явуулахгүй" хэмээн заажээ.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 112 дугаар зүйлийн 1-д төслийг хэлэлцэх эсвэл дараагийн шатанд шилжүүлэх тухай саналыг Танхим дэмжээгүй бол тухайн төслөөр дахин санал гаргахгүй бөгөөд төслийг хэлэлцэгдэж буй төслийн бүртгэлээс хасахаар зохицуулсан байна.

Швейцарын Парламентын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 5-д хуулийн төслийг бүхэлд нь санал хураахад дэмжигдээгүй бол энэ нь тухайн төслийг "хэлэлцэхийг дэмжээгүйтэй ижил" үр дагавартай байхаар хуульчилжээ. Мөн хуулийн 95 дугаар зүйлд зааснаар хоёр Танхимын шийдвэр зөрсөн асуудлыг аль нэг Танхим нь хоёр дахь удаагаа татгалзвал уг шийдвэр эцсийнх байна.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 306 дүгээр зүйлийн (b) хэсэгт зааснаар Ассамблей хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дэмжээгүй бол төсөл "хүчингүй болно". Мөн дэгийн 300 дугаар зүйлийн 2-т Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд Ассамблей дэмжээгүй бол төсөл мөн адил хүчингүй болохоор тусгажээ.

Канадын Нийтийн танхимын дэгийн 97.1 дүгээр зүйлийн (d) хэсэгт зааснаар төслийг цаашид хэлэлцэхгүй байх тухай хорооны тайланг Танхим дэмжсэн бол уг төслийг хэлэлцэх бүх ажиллагаа дуусгавар болдог байна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 87 дүгээр зүйлийн 2-т зааснаар хорооноос нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн төслийн талаар гишүүд тогтоосон хугацаанд нэгдсэн хуралдаанд оруулах хүсэлт гаргаагүй бол тухайн төслийг "хүчингүй болсонд тооцно".

Сингапурын Парламентын дэгийн 70 дугаар зүйлийн 3-т зааснаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дэмжээгүй бол уг төслийг "татгалзсанд тооцно" хэмээн хуульчилсан байна.

Эдгээр зохицуулалтууд нь парламентын олонхын дэмжлэг авч чадаагүй төслийг хэлэлцэх ажиллагааг шууд зогсоох, хүчингүй болгох эсвэл санаачлагчид нь буцаах замаар хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөөг хангахад чиглэдэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
---	---------------

<p>82 дугаар зүйл.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг нь тогтоох тухай тогтоолын төсөл хэлэлцэх</p> <p>82.1.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална.</p> <p>-</p>	<p>82 дугаар зүйл.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг нь тогтоох тухай тогтоолын төсөл хэлэлцэх</p> <p>82.1.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргана.</p> <p>82.2.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>82.3.Нэгдсэн хуралдаан хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, Байнгын хорооноос оруулсан саналын томьёоллоор ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүний олонх дэмжсэн бол тогтоолыг баталсанд тооцно.</p> <p>82.4.Нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.</p>
--	---

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (82.2.):

1. Илтгэл, дүгнэлтийг сонсож асуулт асуух (Questioning the Report and Presentation)

ОУ-ын практикт аливаа төслийг хэлэлцэхдээ санаачлагч болон хорооны тайланг сонссоны дараа гишүүд асуулт асуух боломжийг дэгийн зохицуулалтаар олгодог.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хууль, 98 дугаар зүйлийн 3, 4-т зааснаар хууль болон тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлэгт санаачлагчийн илтгэл, дараа нь тэргүүлэх хорооны төлөөлөгчийн илтгэлээр эхлэх бөгөөд гишүүн бүр илтгэгч нараас хоёр хүртэл асуулт асуух эрхтэй. Мөн хуулийн 105 дугаар зүйлийн 2, 3-т хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр хорооны илтгэлийг сонсож, гишүүд хоёр хүртэл асуулт асуухаар зохицуулсан. ЗГ-т санал хүргүүлэх тогтоолын төслийн хувьд ч санаачлагч болон хорооны илтгэл бүрээс гишүүд нэг асуулт асуух эрхтэй болохыг хуулийн 154 дүгээр зүйлийн 5-д заажээ.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэг, 104 дүгээр зүйлд зааснаар хорооноос шилжүүлсэн асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд эхлээд хорооны дарга агуулгыг тайлбарлаж, явц, үр дүнг тайлагнах ба үүний дараа асуулт асууна. Мөн дэгийн 108 дугаар зүйлд гишүүд хорооны дарга, цөөнхийн санал гаргагч болон төсөл санаачлагчаас асуулт асууж болохоор тусгасан байна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хууль, 58 дугаар зүйлийн 1-д зааснаар хороо аливаа төслийг хэлэлцэхдээ түүний зорилгын талаарх тайлбар болон мэргэжлийн ажилтны дүгнэлтийг сонсож, ерөнхий хэлэлцүүлэг (үүнд санаачлагчаас асуулт асууж хариулт авах үйл явц багтана) явуулна. Мөн хуулийн 93 дугаар зүйлд нэгдсэн хуралдааны үеэр хорооны даргын илтгэлийг сонсож, асуулт хариулт болон мэтгэлцээн явуулсны дараа санал хураахаар заажээ.

2. Илтгэгч нарт үг хэлэх, тайлбар хийх боломж олгох (Speaking and Explanations)

Төслийн талаарх нэмэлт тайлбар хийх, мэтгэлцэх эрхийг дараах байдлаар зохицуулсан байна.

Швейцарын Үндэсний зөвлөлийн дэгийн 19 дүгээр зүйлд зааснаар хороо нь төслийг Танхимд танилцуулж, хорооны саналыг хамгаалах илтгэгч томилно. Мөн дэгийн 46 дугаар зүйлийн 3, 4-т зааснаар хэлэлцүүлгийн хэлбэрээс үл хамааран хорооны илтгэгч болон Холбооны Зөвлөлийн (ЗГ) төлөөлөгч үг хэлэх эрхтэй ба төсөл санаачлагч гишүүн тайлбар хийх боломжтой. Мөн дэгийн 52 дугаар зүйлд зааснаар бүх гишүүд үг хэлж дууссаны дараа Засгийн газрын төлөөлөгч болон хорооны илтгэгч нар хариу тайлбар хийж болохоор заажээ.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 282 дүгээр зүйлийн 2-т зааснаар төслийн нэг дэх хэлэлцүүлэг санаачлагчийн танилцуулга болон түүний дараах мэтгэлцээнээс бүрдэнэ. Мөн дэгийн 289 дүгээр зүйлд зааснаар хорооны тайланг танилцуулж буй гишүүн уг тайлангийн агуулгыг тайлбарлан үг хэлж болохоор тусгасан байна.

Канадын Нийтийн танхимын дэгийн 35 дугаар зүйлийн 1-д зааснаар хорооны тайланг танилцуулж буй гишүүн уг тайлангийн агуулгын талаар товч тайлбар (succinct explanation) хийхийг зөвшөөрдөг. Мөн дэгийн 68 дугаар зүйлийн 2-т хуулийн төслийг танилцуулахдаа товч тайлбар хийж болохоор заасан байна.

Эдгээр зохицуулалтууд нь төслийг хэлэлцэж эхлэхдээ санаачлагчийн бодлогын үндэслэл болон хорооны хяналтын дүгнэлтийг зэрэгцүүлэн сонсож, тэдгээртэй холбогдуулан гишүүд асуулт тавих замаар мэдээлэл авах, байр сууриа илэрхийлэх боломжийг баталгаажуулдаг байна.

(82.3.):

1. Хорооны илтгэлийг хэлэлцэж, санал хураах журам

ОУ-ын практикт хорооны шатанд боловсруулсан саналын томъёолол, тайланг үндэслэн нэгдсэн хуралдаанаар эцсийн шийдвэр гаргах үйл явцыг дэгээр зохицуулдаг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 93 дугаар зүйлд зааснаар нэгдсэн хуралдаан нь тухайн асуудлыг хянасан хорооны даргын илтгэлийг сонсож, асуулга, мэтгэлцээн явуулсны дараа санал хураалт явуулдаг.

Эстонийн Рийгикоогийн дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлд зааснаар хоёр дахь хэлэлцүүлэг дууссаны дараа тогтоолын төслийг эцсийн санал хураалтад оруулж шийдвэрлэхээр тусгасан байна. Мөн хуулийн 117 дугаар зүйлийн 3-т зааснаар томилгоо болон бусад асуудлаарх тогтоолын төслийг хэлэлцэхдээ хорооны илтгэлийг сонсож, мэтгэлцээн дараа эцсийн санал хураалт явуулж баталдаг.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 153 дугаар зүйлийн (b)-д хорооноос нэмэлт, өөрчлөлт оруулсан төслийн хувьд "хорооноос оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг зөвшөөрөх" тухай нэгдсэн саналыг хураалгахаар зохицуулжээ.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 306 дүгээр зүйлийн 1-д зааснаар хорооны тайланг хэлэлцэх шатанд Спикер хорооноос олонхын саналаар дэмжигдсэн нэмэлт, өөрчлөлтүүдийг батлах санал хураалтыг эхэлж явуулдаг.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 104 дүгээр зүйлд зааснаар хорооноос шилжүүлсэн асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хорооны дарга эхлээд явц, үр дүнг тайлагнах ба үүний дараа асуулт хариулт, мэтгэлцээн явуулж санал хураалтаар шийдвэрлэдэг.

Швейцарын Парламентын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д хорооноос томилогдсон илтгэгч хорооны саналыг Танхимд танилцуулж, хамгаалахаар заасан байна.

2. Олонхын саналаар батлах болон эцсийн шийдвэр гаргах (Majority Vote)

Шийдвэр батлагдсанд тооцох босго болон үр дагаврыг дараах байдлаар хуульчилжээ.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 2-т зааснаар өөрөөр тусгайлан заагаагүй бол аливаа шийдвэрийг оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар (simple majority) баталсанд тооцно.

Канадын Нийтийн танхимын дэгийн 103 дугаар зүйлд зааснаар хорооноос танилцуулсан тогтоолын төслийг батлах саналыг ямар нэг мэтгэлцээн, нэмэлт, өөрчлөлтгүйгээр шууд санал хураалтаар батлахаар заажээ.

Норвегийн Стортингийн дэгийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар хэлэлцүүлэг дууссаны дараа Ерөнхийлөгч (Спикер) асуудлыг логик дарааллаар санал хураалтад оруулах ба дэгийн 61 дүгээр зүйлд зааснаар энгийн олонхын саналаар шийддэг.

Швейцарын Парламентын тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 2-т зааснаар хэлэлцүүлэг дуусаж, танхим бүр эцсийн санал хураалт явуулж, дэмжсэн тохиолдолд уг төсөл парламентаар батлагдсанд тооцно.

Эдгээр зохицуулалт нь нэгдсэн хуралдааны шатанд хорооны мэргэжлийн хяналтын үр дүнг гол үндэслэл болгож, гишүүдийн олонхын саналаар төслийг эцэслэн батлах замаар хууль тогтоох үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангадаг.

(82.4.):

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 1-д зааснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл олонхын санал авч чадаагүй бол тухайн хуулийг "татгалзсанд тооцно". Мөн хуулийн 125 дугаар зүйлийн 6-д зааснаар бүх ард түмний санал асуулга явуулах тогтоолын төсөл шаардлагатай олонхын дэмжлэг аваагүй бол холбогдох хуулийн төслийг мөн адил татгалзсанд тооцдог.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 3-т зааснаар хэрэв хоёр дахь хэлэлцүүлгээр хуулийн төслийн бүх заалтад татгалзсан бол "татгалзсанд тооцож, цаашид хэлэлцүүлэг явуулахгүй".

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 112 дугаар зүйлийн 1-д төслийг хэлэлцэх эсвэл дараагийн шатанд шилжүүлэх тухай саналыг дэмжээгүй бол тухайн төслөөр дахин санал гаргахгүй бөгөөд төслийг хэлэлцэж буй төслийн бүртгэлээс хасахаар зохицуулсан.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 300 дугаар зүйлийн 2-т зааснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд дэмжээгүй бол төсөл хүчингүй болно. Мөн дэгийн 310 дугаар зүйлийн (b) хэсэгт зааснаар Ассамблей хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дэмжээгүй бол төсөл мөн адил хүчингүй болохоор тусгажээ.

Канадын Нийтийн танхимын дэгийн 97.1 дүгээр зүйлийн (d) хэсэгт зааснаар төслийг цаашид хэлэлцэхгүй байх тухай хорооны тайланг дэмжсэн бол уг төслийг хэлэлцэх бүх ажиллагаа дуусгавар болдог.

Эдгээр дэгүүд нь парламентын олонхын дэмжлэг авч чадаагүй хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийг зогсоох, хүчингүй болгох эсвэл санаачлагчид нь буцаах замаар хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөөг хангахад чиглэдэг байна.

2.9.АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>83 дугаар зүйл.Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хэлэлцэх</p> <p>83.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хороод урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p>	<p>83 дугаар зүйл.Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хэлэлцэх</p> <p>83.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг Төрийн байгуулалтын болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хороод урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>84 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журам</p> <p>84.2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан маргаантай асуудлаар Цэц дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулсан бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:</p> <p>84.2.1. Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь /хэсэгчлэн/ хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах;</p> <p>84.2.2. энэ хуулийн 84.2.1-д заасны дагуу Байнгын хороод Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах;</p> <p>84.2.4. Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүйн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл нэгдсэн хуралдаанд Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтээр эхэлж санал хураалгах бөгөөд энэ санал дэмжигдээгүй бол холбогдох Байнгын хорооны санал дэмжигдсэн гэж үзэх;</p> <p>84.3. Хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна.</p>	<p>84 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журам</p> <p>84.2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан маргаантай асуудлаар Цэц дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулсан бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:</p> <p>84.2.1. Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүй, хүний эрхийн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь /хэсэгчлэн/ хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах;</p> <p>84.2.2. энэ хуулийн 84.2.1-д заасны дагуу Байнгын хороод Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтад нийцээгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах;</p> <p>84.2.4. Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүй, хүний эрхийн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл нэгдсэн хуралдаанд Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны санал, дүгнэлтээр эхэлж санал хураалгах бөгөөд энэ санал дэмжигдээгүй бол холбогдох Байнгын хорооны санал дэмжигдсэн гэж үзэх;</p> <p>84.3. Хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол 60 хоногийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна.</p>

Тайлбар: Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхтэй холбоотой дэгийн зохицуулалтад нэр томьёог жигдлэх өөрчлөлтийг тусгана.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>85 дугаар зүйл. Албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх</p> <p>85.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан асуудлаар Цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:</p>	<p>85 дугаар зүйл. Албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх</p> <p>85.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан асуудлаар Цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:</p>

<p>85.1.1.Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;</p> <p>85.1.4.нэгдсэн хуралдаан энэ хуулийн 85.1.2-т заасан албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;</p>	<p>85.1.1.Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;</p> <p>85.1.4.нэгдсэн хуралдаан энэ хуулийн 85.1.2-т заасан албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;</p>
---	---

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>86 дугаар зүйл.Албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх</p> <p>86.1.1.Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;</p> <p>86.1.3.Цэц Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа дүгнэлтийг зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;</p>	<p>86 дугаар зүйл.Албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх</p> <p>86.1.1.Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;</p> <p>86.1.3.Цэц Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа дүгнэлтийг зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүй, хүний эрхийн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>88 дугаар зүйл.Цэцэд хүсэлт гаргах</p> <p>88.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Улсын Их Хурлаас Цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг Хууль зүйн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж саналд дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна.</p>	<p>88 дугаар зүйл.Цэцэд хүсэлт гаргах</p> <p>88.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Улсын Их Хурлаас Цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж саналд дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>90 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг хэлэлцэх</p> <p>90.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг тухайн асуудлыг анх хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан холбогдох Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p> <p>90.7.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар Хууль зүйн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна.</p>	<p>90 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг хэлэлцэх</p> <p>90.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг тухайн асуудлыг анх хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан холбогдох Байнгын хороо болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p> <p>90.7.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар Хууль зүй, хүний эрхийн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>95 дугаар зүйл.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх</p> <p>95.3.Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>95.4.Холбогдох Байнгын хороо саналыг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 7 хоногийн дотор хэлэлцэж эхэлнэ.</p> <p>95.8.Энэ хуулийн 95.5-д заасан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсох ажиллагааг сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар энэ хуулийн 112.1-д заасан Улсын Их Хурлын асуулгын дараа нэг цагийн хугацаанд багтаан зохион байгуулна.</p> <p><u>/Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p> <p>95.9.Энэ хуулийн 95.8-д заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцсаны дараа гишүүд асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>-</p>	<p>95 дугаар зүйл.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх</p> <p>95.3.Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>95.4.Холбогдох Байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороо саналыг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 7 хоногийн дотор хэлэлцэж эхэлнэ.</p> <p>95.8.Энэ хуулийн 95.5-д заасан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсох ажиллагааг сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар энэ хуулийн 112.1-д заасан Улсын Их Хурлын асуулгын дараа нэг цагийн хугацаанд багтаан зохион байгуулна.</p> <p>95.9.Нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс цахим системээр гаргасан нийт өргөдлийн талаарх мэдээллийг Өргөдлийн байнгын хороо ээлжит чуулганы хугацаанд нэг удаа нэгдсэн хуралдаанд хийнэ.</p> <p>95.10.Энэ хуулийн 95.8-д заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлт, 95.9-д заасан мэдээлэлтэй танилцсаны дараа гишүүд асуулт асууж, үг хэлж болно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын үйл ажиллагаанд иргэдийн шууд оролцоог хангах, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хууль тогтоох түвшинд авч үзэх нь төрийн шийдвэр гаргах үйл явцын легитим шинж чанарыг баталгаажуулах үндсэн нөхцөл болдог. ОУ-ын парламентын практикт өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тогтолцоог институцийн бүтэц, цахим орчин, ил тод тайлагнал, мөн парламентын хяналтын механизмтай уялдуулан хөгжүүлж байна.

Иргэдийн өргөдлийг хүлээн авч, бодит үр дүнд хүргэхийн тулд тусгайлсан хянан шалгах бүтэц байгуулах нь нийтлэг жишиг юм. Солонгос болон Шинэ Зеланд Улсад өргөдлийг хянан шалгах дэд хороо, ажлын хэсгийг байгуулж, тэдгээрт газар дээр нь очиж ажиллах, нотлох баримт цуглуулах, холбогдох байгууллагуудаас мэдээлэл шаардах зэрэг өргөн эрх мэдлийг олгосон байдаг. Германы Бундестагт өргөдөл гаргагч, хөндлөнгийн шинжээчдийг оролцуулсан сонсгол зохион байгуулах замаар асуудлыг олон талт, мэргэжлийн түвшинд хэлэлцдэг нь парламентын хяналтын чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

Цахим технологийн хөгжилтэй уялдан өргөдлийн системийг цахимжуулах нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, парламентын хариуцлагыг дээшлүүлэх чухал хэрэгсэл болж байна. Солонгос болон Бразилын “e-Chamber” системийн туршлагаас харахад өргөдөл, гомдлыг зөвхөн бүртгэх бус түүний шийдвэрлэлтийн явцыг бүхэлд нь олон нийтэд ил тод харуулах боломжийг бүрдүүлсэн байна. Энэ нь иргэдийн оролцооны босгыг бууруулж, төр иргэний харилцаанд ил тод, хариуцлагатай механизмыг бий болгож байна.

Мөн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар парламентын түвшинд тогтмол тайлагнах нь ил тод байдлыг хангах чухал хэлбэр юм. Германы туршлагаас үзэхэд Өргөдлийн байнгын хороо сар бүр болон жил бүр нэгдсэн тайлан боловсруулж, чуулганы хуралдаанд танилцуулдаг. Ийнхүү нэгдсэн тайлагнал хийх нь парламентын хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхээс гадна иргэдийн итгэлийг бэхжүүлэх чухал баталгаа болдог.

Байнгын хорооны танилцуулсан өргөдлийн асуудлаар гишүүд асуулт асууж, байр сууриа илэрхийлэх боломжийг хангах нь парламентын хяналтын чадавхыг бэхжүүлдэг. Эстони болон Шинэ Зеландын парламентын практикт илтгэгчид асуулт тавих, нам, эвслийн бүлгүүд байр сууриа илэрхийлэхэд тодорхой хугацаа (жишээлбэл, 10 минут) олгодог нь өргөдлийн асуудлыг улс төрийн түвшинд хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн Германд гишүүдийн тодорхой хувь (ойролцоогоор 5 хувь) шаардсан тохиолдолд өргөдлийг нэгдсэн чуулганаар тусгайлан хэлэлцэх зохицуулалт үйлчилдэг нь парламент дахь цөөнхийн хяналтын тогтолцоог баталгаажуулсан чухал арга хэрэгсэл юм.

Иргэдийн өргөдөл, гомдлыг парламентын түвшинд хэлэлцэх тогтолцоо нь хяналтын бүтэц, цахим орчин, ил тод тайлагнал, парламентын мэтгэлцээний тогтолцоо гэсэн харилцан уялдаатай элементүүд дээр суурилдаг. Ийм зохицуулалт нь парламентын үйл ажиллагааг илүү нээлттэй, хариуцлагатай, иргэдэд ойр болгох, улмаар төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог бодитой хангах чухал ач холбогдолтой юм.

2.10.АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ: АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ОГЦРУУЛАХ, ЭГҮҮЛЭН ТАТАХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>99 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэх</p> <p>99.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулсан, эсхүл огцорсонд тооцсон бол шинэ</p>	<p>99 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэх</p> <p>99.1.Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн, эсхүл Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу</p>

Ерөнхий сайдыг томилох асуудлыг энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.	Ерөнхий сайдыг огцруулсан, эсхүл огцорсонд тооцсон бол шинэ Ерөнхий сайдыг томилох асуудлыг энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.
--	--

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 2024	Төслийн заалт
100 дугаар зүйл.Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх -	100 дугаар зүйл.Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх 100.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд үг хэлж болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 2024	Төслийн заалт
101 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх 101.3.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулна.	101 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх 101.3.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Ерөнхий сайдыг огцруулах саналаар ил санал хураалт явуулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын засаглалтай орнуудад хууль тогтоох байгууллагаас гүйцэтгэх засаглалд хяналт тавих хамгийн хүчтэй механизм нь "Итгэл үл үзүүлэх санал" (Motion of no confidence) юм. ОУ-ын парламентын практикт энэхүү асуудлыг хэлэлцэх үндэслэл, хугацаа болон санал хураалтын хэлбэрийг дараах үндсэн гурван чиглэлээр ангилан үзэж болно.

1. Санал гаргах шалгуур ба Урьдчилсан нөхцөл:

ЗГ-ыг огцруулах асуудлыг тогтворгүй байдал үүсгэхээс сэргийлж, тодорхой квот болон үндэслэл шаарддаг.

- Гишүүдийн квот: Францад нийт гишүүдийн 1/10, Эстони 1/5-ээс доошгүй нь бичгээр санал гаргах шаардлагатай байдаг бол Өмнөд Африкт Ерөнхийлөгчийг огцруулахад нийт гишүүдийн 2/3-ын дэмжлэг шаардлагатай байгаа нь гүйцэтгэх засаглалын тэргүүний статусыг хамгаалсан өндөр босго юм.
- Үндэслэл заах: Эстони зэрэг улсад огцруулах болсон шалтгаанаа заавал тодорхой заасан байхыг шаарддаг бол Францад нэгэнт өгсөн гарын үсгийг буцаан татахыг хориглодог нь улс төрийн хариуцлагыг нэмэгдүүлж байна.

2. Хэлэлцүүлгийн хугацаа ба "Түр завсарлага"-ын зарчим:

Улс орнууд энэхүү эмзэг асуудлыг "халуун дээр нь" эсвэл хэт яаран шийдвэрлэхээс сэргийлсэн хугацааны нарийн зохицуулалттай байдаг.

- Хатуу хугацаа: Солонгосын Үндэсний Ассамблейд огцруулах саналыг тайлагнаснаас хойш 24-өөс 72 цагийн дотор шийдвэрлэх ёстой бөгөөд энэ хугацаа хэтэрвэл санал автоматаар хүчингүйд тооцогддог.
- Бодох хугацаа: Эстони уг саналыг өргөн барьснаас хойш 2 дахь өдрөөс өмнө хэлэлцэхийг хориглодог нь талуудад зөвшилцөх, нөхцөл байдлыг нухацтай үнэлэх "тайвшрах" хугацаа олгож буй хэлбэр юм.

3. Мэтгэлцээний дэг ба Санал хураалтын нууцлал:

ЗГ-т итгэх эсэх асуудал нь гишүүдийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон улс төрийн намын өмнө хариуцлага хүлээх зарчмын уулзвар дээр өрнөдөг.

- Мэтгэлцээн: Австрали болон Эстонид Ерөнхий сайд заавал байлцаж, талууд 20-30 минутын хугацаанд зарчмын мэтгэлцээн өрнүүлдэг.
- Санал хураалтын хэлбэр: Солонгост нууц санал хураалт (Secret vote) явуулж гишүүдийн бие даасан сонголтыг хангадаг бол Италид ямагт "нэр дуудах" (Roll-call) хэлбэрээр ил тод явуулдаг нь намын хариуцлага, сонгогчдын өмнөх тайлагналыг чухалчилж буй хэрэг юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>104 дүгээр зүйл.Цэцийн гишүүнийг томилох асуудлыг хэлэлцэх журам</p> <p>104.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхээс Цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлсэн саналыг хүлээн авснаас хойш энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгогч зохион байгуулна. Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчийн сонгогчын тайлан гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн тайлан, эрх бүхий этгээдийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p> <p>104.2.Нэгдсэн хуралдаан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор хуралдаж нэр дэвшүүлсэн байгууллагын танилцуулга, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож нэр дэвшигч тус бүрээр ил санал хураалт явуулж олонхын санал авсан нэр дэвшигчийг Цэцийн гишүүнээр томилох тухай тогтоол баталсанд тооцно.</p>	<p>104 дүгээр зүйл.Цэцийн гишүүнийг томилох асуудлыг хэлэлцэх журам</p> <p>104.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхээс Цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлсэн саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Төрийн байгуулалтын болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар эрх бүхий этгээдийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p> <p>104.2.Нэгдсэн хуралдаан Төрийн байгуулалтын болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор хуралдаж нэр дэвшүүлсэн байгууллагын танилцуулга, хамтарсан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож нэр дэвшигч тус бүрээр ил санал хураалт явуулж олонхын санал авсан нэр дэвшигчийг Цэцийн гишүүнээр томилох тухай тогтоол баталсанд тооцно.</p>

Тайлбар: Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох хэсэгт нэр дэвшигчийн сонгогч зохион байгуулахаар заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж тогтоосон тул уг хэсгийг өөрчлөн найруулж, нэр дэвшигчийн сонгогч зохион байгуулахгүй байхаар тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахын зэрэгцээ ардчилсан хяналт-тэнцвэрийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс дэлхийн улс орнуудын парламент шүүгчдийг томилох үйл явцад өөр өөрийн онцлог бүхий дэг, журмаар оролцдог. Судалгаанд хамрагдсан улсуудын туршлагаас үзэхэд энэхүү оролцоог дараах гурван үндсэн түвшинд ангилан үзэж болно.

- "Сонсгол-Хяналт" төвтэй мэргэшсэн шалгалтын загвар:

Солонгосын Үндэсний Ассамблейн жишээ нь шүүгчдийг томилоход парламентын хяналтыг хамгийн өндөр түвшинд хэрэгжүүлж буй загвар юм. Дээд шүүхийн болон Үндсэн хуулийн шүүхийн удирдлагуудыг томилоход "Хүний нөөцийн сонгогчын тусгай хороо" (Special Committee on Personnel Hearing) байгуулж, нэр дэвшигчийн ур чадвар, ёс зүйг нээлттэй сонгогчлоор шүүн хэлэлцдэг. Төрөлжсөн Байнгын хороод болон Тусгай хороод нь нэр дэвшигчийн статусаас хамааран сонгогчлыг зааглан эсвэл нэгтгэн зохион байгуулдаг нь томилгооны ач холбогдлыг институцийн түвшинд баталгаажуулж байна.

- "Шүүхийн хороо" төвтэй мэргэжлийн шалгаруулалтын загвар:

Швейцарын Ассамблейд шүүгчдийг томилох бэлтгэл ажлыг хангах "Шүүхийн хороо" (Judiciary Committee) ажилладаг нь мэргэжлийн шалгуур болон улс төрийн зөвшилцлийг

хослуулсан хэлбэр юм. Тус хороо нь шүүгчийн сул орон тоонд нийтэд зарлах замаар нэр дэвшигчдийг урьж, урьдчилан шалгаруулдаг. Шүүхийн хорооны боловсруулсан саналыг хоёр танхимын хамтарсан Нэгдсэн Холбооны Ассамблей эцэслэн шийдвэрлэдэг нь шүүх эрх мэдлийн дээд томилгоог парламентын бүрэн бүрэлдэхүүний өндөр легитим чанараар баталгаажуулдаг байна.

- Нууц санал хураалт ба "Хууль зүйн баталгаажуулалт"-ын загвар:

Зарим улс оронд шүүгчдийг томилох үйл явц нь улс төрийн нөлөөллөөс ангид байх үүднээс нууцлалын өндөр зэрэгтэй явагддаг. Эстони улсад Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийг томилохдоо нэгдсэн хуралдаанаар заавал нууц санал хураалт (secret ballot) явуулдаг нь гишүүдэд намын болон фракцын шахалтгүйгээр чөлөөт сонголт хийх боломжийг олгодог.

Өмнөд Африкийн жишээнээс харахад шүүгчийг томилохоос гадна түүнийг огцруулах, эргүүлэн татах асуудалд нийт гишүүдийн 2/3-ын дэмжлэгийг шаарддаг нь шүүх эрх мэдлийн халдашгүй байдал, тогтвортой байдлыг хангах эрх зүйн чухал баталгаа болдог байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>105 дугаар зүйл.Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх</p> <p>105.1.Цэцийн гишүүн бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ анх илгээсэн байгууллагаар уламжлан гаргасныг, эсхүл Төрийн албаны тухай хуульд^[13] заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэнтэй холбогдуулж гишүүнийг чөлөөлүүлэх саналыг анх илгээсэн байгууллага Улсын Их Хуралд ирүүлсэн бол Хууль зүйн байнгын хороо энэ асуудлыг 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>105.2.Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол баталсанд тооцно.</p>	<p>105 дугаар зүйл.Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх</p> <p>105.1.Цэцийн гишүүн бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ анх илгээсэн байгууллагаар уламжлан гаргасныг, эсхүл Төрийн албаны тухай хуульд³ заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэнтэй холбогдуулж гишүүнийг чөлөөлүүлэх саналыг анх илгээсэн байгууллага Улсын Их Хуралд ирүүлсэн бол Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо энэ асуудлыг 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна.</p> <p>105.2.Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол баталсанд тооцно.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>106 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулах журам</p> <p>106.2.Энэ хуулийн 106.1-д заасан танилцуулгыг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт ирүүлсэн бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p>	<p>106 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулах журам</p> <p>106.2.Энэ хуулийн 106.1-д заасан танилцуулгыг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт ирүүлсэн бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p>

106.4.Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.	106.4.Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.
106.5.Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулахгүй.	106.5.Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулахгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>107 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх</p> <p>107.2.Холбогдох Байнгын хороо энэ хуульд заасан журмын дагуу явуулсан нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн тайлан, Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p> <p>107.3.Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.</p>	<p>107 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх</p> <p>107.2.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 107.1-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p> <p>107.3.Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.</p>

Тайлбар: Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд Улсын Их Хуралтай зөвшилцөх, танилцах албан тушаалтанд нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахаар заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж шийдвэрлэсэн.

Үүнтэй холбогдуулан Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг зөвшилцөх, Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг зөвшилцөх, Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг зөвшилцөхтэй холбоотой хэсгээс нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахтай холбогдох хэсгийг хасахаар тусгана.

Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг зөвшилцөх хэлэлцүүлгийг хаалттай хуралдаанаар хэлэлцдэг болно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Хууль дээдлэх зарчмыг хангах, гүйцэтгэх засаглалын зүгээс хууль хяналтын байгууллагын удирдлагыг томилох үйл явцад ардчилсан хяналт тогтоох зорилгоор олон улсын парламентын практикт "Томилгооны сонсгол" (Personnel/Confirmation Hearing)-ийг өргөнөөр ашиглаж байна. Энэхүү үйл ажиллагааг зохион байгуулах арга хэлбэрийг дараах үндсэн загваруудаар ангилан үзэж болно.

1. Мэргэшсэн сонсгол ба Хяналтын механизм (Солонгос загвар):

Солонгосын Үндэсний Ассамблейд Ерөнхийлөгчөөс Улсын дээд прокурорын газрын Ерөнхий прокурорыг томилохдоо холбогдох Байнгын хороогоор заавал "Хүний нөөцийн сонсгол" хийлгэдэг нь томилгооны чанар, нэр дэвшигчийн хараат бус байдлыг шалгах үндсэн шүүлтүүр болдог. Энэхүү процесс нь нэр дэвшигчийн мэргэжлийн ур чадвараас гадна хувийн ёс зүй, улс төрийн төвийг сахисан байдлыг олон нийтийн өмнө нээлттэй шүүн хэлэлцдэгээрээ онцлогтой.

2. Шалгаруулалт ба Бэлтгэл ажлын механизм (Швейцар загвар):

Швейцарын Ассамблейд Холбооны Ерөнхий прокурор болон түүний орлогч нарыг томилох бэлтгэл ажлыг "Шүүхийн хороо" (Judiciary Committee) бие даан хариуцдаг. Тус хороо нь зөвхөн

нэр дэвшигчийг батлаад зогсохгүй, сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг тогтоох зэрэг "хүний нөөцийн менежмент"-ийн чиг үүргийг хэрэгжүүлж, саналыг Нэгдсэн Ассамблейд оруулдаг нь томилгоог улс төрөөс ангид, мэргэжлийн түвшинд явуулах баталгаа болдог.

3. Хугацааны хатуу хязгаарлалт ба Шуурхай байдал (Канад загвар):

Томилгооны сонсголыг улс төрийн зорилгоор сунжруулахаас сэргийлж, олон улсад хугацааны хатуу дэг баримталдаг. Канад улсын парламентад нэр дэвшигчийн асуудлыг Байнгын хороонд шилжүүлснээс хойш 30 хоногийн дотор хэлэлцэх, үүнээс 10 хоногийн дотор сонсгол явуулах хатуу график үйлчилдэг. Энэ нь төрийн өндөр албан тушаалтны томилгоог тодорхой бус хугацаагаар гацаахаас сэргийлж, институцийн тогтвортой байдлыг хангахад чиглэгддэг байна.

4. Хялбаршуулсан журам ба Илтгэгчийн үүрэг (Эстони загвар):

Эстони улсад нийтийн албан тушаалтныг томилох асуудлыг ганцхан хэлэлцүүлгээр шийдвэрлэдэг бөгөөд нэр дэвшигч өөрөө 5 минут хүртэл үг хэлж, гишүүдийн асуултад хариулдаг. Энэ нь томилгооны үйл явцыг хэт нүсэр биш, харин үр ашигтай, тодорхой байлгах зорилготой "хялбаршуулсан сонсгол"-ын хэлбэр юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>108 дугаар зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэх журам</p> <p>108.2.Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигч болон холбогдох бусад этгээдээс асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>108.3.Нэгдсэн хуралдаан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх, огцруулах саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.</p> <p>108.4.Хууль зүйн байнгын хороо хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно.</p>	<p>108 дугаар зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэх журам</p> <p>108.2.Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигч болон холбогдох бусад этгээдээс асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>108.3.Нэгдсэн хуралдаан Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх, огцруулах саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.</p> <p>108.4.Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно.</p>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>109 дүгээр зүйл.Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх</p> <p>109.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ хуулийн 109.1-д заасан саналыг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлснээс хойш ажлын 3 өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Хэрэв нэр дэвшигчийн сонсгол</p>	<p>109 дүгээр зүйл.Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх</p> <p>109.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ хуулийн 109.1-д заасан саналыг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлснээс хойш ажлын 3 өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p>

<p>явуулах санал гарсан бол сонсголын тайлан гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд сонсголын тайланг хавсаргана.</p> <p>109.6.Энэ хуулийн 109.1-д заасан нэр дэвшигчийн сонсгол явуулахаар бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Нийтийн сонсголын тухай хуулийн 6.3-т заасан үндэслэлээр сонсголыг хаалттай явуулж болно.</p>	<p>109.6.Гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг энэ хуулийн 8.2-т заасан хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ.</p>
---	---

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Гадаад харилцааны салбар дахь томилгоо нь үндэсний аюулгүй байдал, дипломат харилцааны эмзэг асуудлуудыг хөнддөг тул олон улсын парламентын практикт үүнийг хэлэлцэх тусгайлсан дэг, нууцлалын горимыг баримталдаг. Судалгаанд хамрагдсан улс орнуудын туршлагаас үзэхэд энэхүү зохицуулалтыг дараах байдлаар ангилан үзэж болно.

1. Гүйцэтгэх засаглалын давуу эрх ба Институцийн зааг:

Ихэнх ардчилсан улс орнуудад (Норвег, Эстони, Энэтхэг г.м) Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах бүрэн эрх нь Гүйцэтгэх засаглалын тэргүүн (Хаан, Ерөнхийлөгч, ЗГ)-д хадгалагддаг.

Норвег загвар: Үндсэн хуулийн дагуу Хаан нь дипломат төлөөлөгчдийг томилох, чөлөөлөх асуудлыг шүүх болон парламентын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр шууд шийдвэрлэх давуу эрхтэй. Энэ нь дипломат албаны шуурхай байдал, гүйцэтгэх засаглалын гадаад бодлогоо тодорхойлох бие даасан байдлыг баталгаажуулдаг байна.

2. Төрөлжсөн хорооны хаалттай хяналтын механизм:

Парламент гадаад бодлогын хэрэгжилтэд хяналт тавихдаа төрөлжсөн хороодоор дамжуулан "хаалттай" горимыг ашигладаг. Норвегийн Стортинг дахь "Гадаад хэрэг, батлан хамгаалахын өргөтгөсөн хороо" нь ЗГ-тай зөвлөлдөхдөө ямагт хаалттай (in camera) хуралддаг дэгтэй. Энэ нь дипломат харилцааны нууцыг хадгалахын зэрэгцээ парламентын хяналтыг хэрэгжүүлэх "алтан дундаж" механизм болдог. Хэрэв хаалттай хорооноос асуудлыг нэгдсэн хуралдаанд оруулбал, тухайн асуудлыг үргэлжлүүлэн хаалттай хэлэлцэх эсэхийг Парламент эхлээд нууц санал хураалтаар шийдвэрлэдэг нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах давхар хяналт юм.

"Хаалттай хуралдаан" (Secret Sitting) зарлах нийтлэг механизмын тухайд Монгол Улсын адил "Элчин сайдын томилгоог заавал хаалттай хэлэлцэх" гэсэн хатуу зохицуулалт олон улсад ховор боловч үндэсний аюулгүй байдлын үүднээс хуралдааныг хаалттай явуулах ерөнхий дэгүүд үйлчилдэг. Солонгос, Эстони, Энэтхэг зэрэг улсад Спикер эсвэл нийт гишүүдийн олонхын саналаар хуралдааныг хаалттай (Closed sitting) горимд шилжүүлж болно.

Томилгооны сонсголын үеэр нэр дэвшигчийн хувийн нууц, үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг хэлэлцэх тохиолдолд олон улсын практикт хаалттай горимыг "уян хатан" ашигладаг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>110 дугаар зүйл.Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх</p> <p>110.1.Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг 72 цагийн дотор гишүүдэд хүргүүлнэ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо ийнхүү хүргүүлснээс хойш ажлын 3 өдрийн дараа</p>	<p>110 дугаар зүйл.Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх</p> <p>110.1.Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг 72 цагийн дотор гишүүдэд хүргүүлнэ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо ийнхүү хүргүүлснээс хойш ажлын 3</p>

тухайн саналыг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана. Хэрэв нэр дэвшигчийн сонголт явуулах санал гарсан бол сонголын тайлан гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд сонголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.	өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана.
--	---

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Батлан хамгаалах салбарын иргэний хяналтыг (Civilian control of the military) бэхжүүлэх хүрээнд Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилоход Парламенттай зөвшилцөх, нэр дэвшигчийн нээлттэй сонголт явуулах нь ардчилсан засаглалын чухал механизм юм. Судалгаанд хамрагдсан улс орнуудын туршлагаас үзэхэд энэхүү зохицуулалтыг дараах хоёр үндсэн загварт хуваан үзэж болно.

Солонгосын Үндэсний Ассамблейн жишээ нь гүйцэтгэх засаглалаас томилдог цэргийн дээд албан тушаалтанд Парламентын зүгээс тавих хяналтыг хамгийн өндөр түвшинд хэрэгжүүлж буй загвар юм. Ерөнхийлөгчөөс томилох "Штабуудын нэгдсэн хорооны дарга"-ыг (ЗХЖШ-ын даргатай дүйцэх) батламжлахын өмнө Батлан хамгаалахын байнгын хороо "Нэр дэвшигчийн сонголт" (Personnel hearing)-ийг заавал зохион байгуулдаг. Энэхүү сонголоор нэр дэвшигчийн мэргэжлийн чадвар, батлан хамгаалах салбарын алсын хараанаас гадна улс төрийн төвийг сахисан байдал, хувийн ёс зүйг нээлттэй шүүн хэлэлцдэг нь Монгол Улсын ЗХЖШ-ын даргыг томилох зөвшилцөх процесстэй үзэл баримтлалын хувьд ижил юм.

Швейцарын парламентын тогтолцоонд Зэвсэгт хүчний дээд удирдлагын томилгоо нь гүйцэтгэх засаглал буюу Холбооны Зөвлөлд бус, харин Парламентад хадгалагддаг өвөрмөц онцлогтой. Дайны болон онцгой нөхцөл байдал үүссэн үед Холбооны Ассамблей (Хоёр танхимын нэгдсэн хуралдаан) нь Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч буюу Генералыг шууд сонгож томилдог. Энэ нь цэргийн хүчийг гүйцэтгэх засаглалын нэг талын нөлөөллөөс ангид байлгах, ард түмний төлөөллийн дээд байгууллагын хяналтад байлгах дээд хэлбэр юм.

Судалгаанд хамрагдсан бусад орнуудын (Франц, Герман, Канад, Япон г.м) парламентын дэгт цэргийн дээд удирдлагыг томилоход парламентаас заавал зөвшөөрөл авах эсвэл сонголт хийх зохицуулалт ховор байна. Ихэнх улсад цэргийн дээд командлал нь Гүйцэтгэх засаглалын (Ерөнхийлөгч эсвэл Хаан) онцгой бүрэн эрхэд хадгалагддаг бөгөөд Парламент нь томилгооны дараах хяналт болон төсөв батлах замаар салбарын бодлогод нөлөөлдөг нийтлэг жишиг ажиглагдаж байна.

2.11.АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ, УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГА, ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТЫН ХАРИУ СОНСОХ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
112 дугаар зүйл.Улсын Их Хурлын асуулгын цаг 112.10.Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан гишүүн асуулт асуух, үг хэлэхэд энэ хуулийн 9.17-д заасныг баримтална.	112 дугаар зүйл.Улсын Их Хурлын асуулгын цаг 112.10.Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан гишүүн асуулт асуух, үг хэлэхэд энэ хуулийн 9.18-д заасныг баримтална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт

<p>113 дугаар зүйл.Гишүүний асуулгын хариуг хэлэлцэх</p> <p>113.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:</p> <p>113.3.3.нэгдсэн хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах ба гишүүд асуулгын хариутай холбогдуулж асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, түүнд хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;</p> <p>113.4.Асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно.</p>	<p>113 дугаар зүйл.Гишүүний асуулгын хариуг хэлэлцэх</p> <p>113.1.Гишүүн нэгдсэн хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа Улсын Их Хурлын даргад ирүүлнэ.</p> <p>113.3.3.нэгдсэн хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах ба гишүүд асуулгын хариутай холбогдуулж асуулт асууж, хариулт авах;</p> <p>113.4.Асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн 1, 3 дахь долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно.</p>
---	--

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>114 дүгээр зүйл.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх</p> <p>114.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:</p> <p>114.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;</p>	<p>114 дүгээр зүйл.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх</p> <p>114.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ээлжит чуулганы хугацаанд ирүүлсэн бол хүлээн авснаас хойш, чуулганы чөлөө цагт ирүүлсэн бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэх бөгөөд дараах журмыг баримтална:</p> <p>114.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд асуулт асууж, хариулт авах;</p>

Тайлбар: Улсын Их Хурлын хяналтын арга хэрэгслийг үр дүнтэй болгох хүрээнд Улсын Их Хурлын гишүүний асуулгыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхгүйгээр нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг зохицуулалтыг тусгана.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын хяналтын үр нөлөө нь гүйцэтгэх засаглалд тавьсан асуулгын хариуг хэр шуурхай, чанартайгаар хэлэлцэж байгаагаас шууд хамаардаг. ОУ-ын парламентын эрх зүйн практикт чуулганы завсарлагааны үед ч хяналтын тогтолцоог тасралтгүй хадгалах, хариуг цаг алдалгүй хэлэлцэхэд чиглэсэн нарийвчилсан зохицуулалтууд төлөвшсөн байна.

Чуулганы чөлөө цагийн үед парламентын хяналтын чиг үүрэг тасалдах ёсгүй гэсэн зарчим олон улсад нийтлэг үйлчилдэг. Энэ хүрээнд завсарлагааны хугацаанд ирсэн асуулгын хариуг ээлжит чуулган эхэлмэгц богино хугацаанд хэлэлцэхийг институцийн үүрэгт тооцдог. Оросын

Төрийн Думын практикт завсарлагааны үед ирсэн асуулгын хариуг чуулган эхэлснээс хойш 14 хоногийн дотор хэлэлцдэг. Үүнтэй харьцуулахад “ажлын 10 өдөр”-ийн дотор хэлэлцэх зохицуулалт нь илүү шуурхай, үр ашигтай хандлагад тооцогдох бөгөөд Францын парламентын бэлтгэл ажлын хугацааны жишигтэй ижил байна.

Асуулгын хариу өгөх болон хэлэлцэх хугацааны хувьд олон улсын парламентын практикт тодорхой стандарт тогтсон байдаг. Солонгост 10 хоног, ОХУ болон Умард Македонд 15 хоногийн дотор асуулгын хариуг бичгээр ирүүлэх хатуу хугацааг хуульчилсан байдаг. Үүний зэрэгцээ хариу ирсэн даруйд нь хамгийн ойрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулах нь парламентын хяналтыг нэн тэргүүний ач холбогдолтой асуудалд эрэмбэлж буйн илэрхийлэл юм.

Хугацааг “ажлын өдөр”-өөр тооцох нь эрх зүйн тодорхой байдлыг хангах чухал хэрэгсэл болдог. Европын олон улсын парламентууд, тухайлбал Германы Бундестагийн туршлагаас харахад хугацааг ажлын өдрөөр тооцох нь амралтын болон баярын өдрүүдээс үүдэх хугацааны маргаан, хожимдлыг арилгаж, үйл ажиллагааны тодорхой байдлыг баталгаажуулдаг.

Мөн асуулгын хариуг хэлэлцэх бүтэц нь хэлэлцүүлгийн чанарт шууд нөлөөлдөг. Олон улсын практикт хариуг шууд нэгдсэн хуралдаанд хэлэлцэхээс өмнө холбогдох Байнгын хороогоор урьдчилан хэлэлцүүлж, мэргэжлийн дүгнэлт гаргуулах нь түгээмэл байна. Солонгос болон Германы жишгээр асуулгын хариуг эхлээд салбарын хороогоор хэлэлцэж, шаардлагатай тохиолдолд гишүүдийн тодорхой хувь шаардсанаар нэгдсэн чуулганаар дахин хэлэлцэх зохицуулалт үйлчилдэг. Энэхүү “хоёр шатлалт” тогтолцоо нь асуудлыг гүнзгийрүүлэн шинжлэх, парламентын хяналтын чанарыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Асуулгын хариуг чуулганы завсарлагааны дараа богино хугацаанд хэлэлцэх, хугацааг ажлын өдрөөр тодорхойлох, мөн Байнгын хорооны түвшинд урьдчилан хэлэлцэх зэрэг зохицуулалтууд нь парламентын хяналтын тогтолцоог тасралтгүй, системтэй, үр нөлөөтэй болгоход чиглэсэн олон улсын шилдэг туршлагад нийцэж байна. Ийм хандлага нь гүйцэтгэх засаглалын тайлагнах үүргийг чангатгахын зэрэгцээ парламентын “хянан шалгах” чиг үүргийг бодитой хэрэгжүүлэх эрх зүйн баталгааг бүрдүүлдэг байна.

2.12.АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ИЛТГЭЛ СОНСОХ, ХЭЛЭЛЦЭХ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 2024	Төслийн заалт
<p>115 дугаар зүйл.Хуулиар тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээлэл сонсох, хэлэлцэх</p> <p>115.2.Дараах тайлан, илтгэл, мэдээллийг Байнгын хороо дараах харьяаллаар хэлэлцэнэ:</p> <p>115.2.2.төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо тухай бүр;</p> <p>115.2.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүйн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд;</p> <p>115.2.7.Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн</p>	<p>115 дугаар зүйл.Хуулиар тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээлэл сонсох, хэлэлцэх</p> <p>115.2.Дараах тайлан, илтгэл, мэдээллийг Байнгын хороо дараах харьяаллаар хэлэлцэнэ:</p> <p>115.2.2.төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо, холбогдох бусад байнгын хороо тухай бүр;</p> <p>115.2.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд;</p>

<p>гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хууль зүйн байнгын хороо жил бүрийн эхний улиралд;</p> <p>115.2.8.жөндөрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жөндөрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болон жөндөрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2 жил бүр;</p> <p>115.2.12.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо жил бүр;</p> <p>115.2.13.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороо жил бүр;</p> <p>115.2.15.Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хоёр жил тутам;</p> <p>115.2.16.Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг Хүний хөгжил, нийгмийн бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар тухай бүр;</p> <p>-</p> <p>115.3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.2-т заасан мэдээллийг холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хэлэлцэнэ.</p> <p>115.4.Энэ хуулийн 115.2, 115.3-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, энэ хуулийн 115.2-т заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.</p> <p>115.8.Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14.1.1-д заасан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хаалттай мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын гурав дахь долоо хоногт багтаан нэгдсэн хуралдаанаараа сонсоно. Нэгдсэн хуралдааны үеэр гишүүд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.</p>	<p>115.2.7.Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо жил бүрийн эхний улиралд;</p> <p>115.2.8.жөндөрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жөндөрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болон жөндөрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2 жил бүр;</p> <p>115.2.12.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороо жил бүр;</p> <p>115.2.13.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг Төсвийн байнгын хороо 3 жил тутам;</p> <p>115.2.15.Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хоёр жил тутам;</p> <p>115.2.16.Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг Эрүүл мэнд, нийгмийн бодлогын болон Хууль зүй, хүний эрхийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар тухай бүр;</p> <p>115.2.19.Хууль тогтоомжийн тухай хуулийн 52.1-д заасны дагуу хийсэн Засгийн газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний нэгдсэн дүнг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо жил бүр;</p> <p>115.2.20.авлигатай тэмцэх хууль тогтоомжийн биелэлт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх Авлигатай тэмцэх газрын мэдээллийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо жил бүр;</p> <p>115.2.21.эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо жилд нэгээс доошгүй удаа.</p> <p>115.3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.2-т заасан мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцэнэ.</p> <p>115.4.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.4-т заасны дагуу Тамгын газраас</p>
---	--

	<p>ирүүлсэн дүн шинжилгээг Байнгын хороо гишүүдэд хүргүүлнэ.</p> <p>115.8.Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14.1.1-д заасан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хаалттай мэдээллийг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн хуралдаанаараа сонсоно. Нэгдсэн хуралдааны үеэр гишүүд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.</p>
--	---

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

(115.2.2.): Төрийн аудитын байгууллагын тайлан, дүгнэлтийг хэлэлцэх.

Парламентын хяналтын хороод төрийн аудитын дүгнэлтийг заавал хэлэлцэх дэг олон улсад нийтлэг байна. Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 215 дугаар зүйлийн (с)-д зааснаар ерөнхий чиг үүргийн байнгын хороод Ерөнхий аудиторын (Auditor-General) тайлангуудыг хянан шалгах бүрэн эрхтэй.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 245 дүгээр зүйлийн (1)-д зааснаар Нийтийн дансны байнгын хороо нь төрийн байгууллагуудын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт болон Ерөнхий аудиторын ирүүлсэн аливаа тайланг хянан хэлэлцэх үүрэгтэй.

Францын Үндэсний Ассамблейн дэгийн 146-1 дүгээр зүйлийн 1-д Аудитын шүүхийн жилийн тайланг тус шүүхийн тэргүүн Ассамблейд биечлэн танилцуулахаар тусгасан байна.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 10 дугаар дүрмийн 4(с)(1)(А)-д зааснаар Хяналт, засгийн газрын шинэчлэлийн хороо нь Ерөнхий хянан шалгагчийн (Comptroller General) тайланг хүлээн авч, холбогдох зөвлөмжийг Танхимд танилцуулах үүрэг хүлээдэг.

(115.2.13): Өрийн удирдлага болон санхүүгийн стратегийн тайланг хэлэлцэх.

Төсвийн болон санхүүгийн дунд хугацааны төлөвлөлтийг хянах механизмыг дараах байдлаар зохицуулсан байна.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 344 дүгээр зүйлд "Төсвийн стратегийн тайлан", "Эдийн засаг, төсвийн төлөв байдлын тайлан" зэрэг баримт бичгүүдийг Санхүү, зардлын хороонд шууд шилжүүлэн хянуулахаар зохицуулсан.

Швейцарын Парламентын тухай хуулийн 143 дүгээр зүйлд зааснаар Холбооны Зөвлөл нь төсвийн төсөлтэй хамт 3 жилийн хугацаатай "Санхүүгийн төлөвлөгөө" (Financial Plan) баримт бичгийг парламентад өргөн барьж, хэлэлцүүлэх үүрэгтэй.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 10 дугаар дүрмийн 4(b)-д Төсвийн хороо нь төсвийн зарлага, өр төлбөр болон макро эдийн засгийн төсөөллийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, тайлангаа Танхимд тогтмол танилцуулахаар заасан.

Норвегийн Стортингийн дэгийн 14 дүгээр зүйлийн 4-т зааснаар Санхүү, эдийн засгийн байнгын хороо нь өр болон хөрөнгийн удирдлага, санхүүгийн зах зээлийн асуудлыг хариуцан хэлэлцдэг.

(115.1.19.): Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх.

ЗГ-ын хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг дараах байдлаар зохицуулсан байна.

Францын Үндэсний Ассамблейн дэгийн 145-7 дугаар зүйлийн 1-д зааснаар Байнгын хороод нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн үүрэгтэй бөгөөд хууль батлагдсанаас хойш тодорхой хугацааны дараа хэрэгжилтийн үр дагаврын тайланг хэлэлцдэг.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 10 дугаар дүрмийн 2(а)-д Байнгын хороод нь холбооны хуулиудын хэрэглээ, удирдлага, хэрэгжилт болон үр нөлөөнд (effectiveness) дүн шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнахаар заажээ.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 98-2 дүгээр зүйлийн 3-т Байнгын хороо нь Засгийн газраас ирүүлсэн Ерөнхийлөгчийн зарлиг, Сайд нарын тушаал зэрэг нь хуулийн зорилго, агуулгад нийцэж байгаа эсэхийг тогтмол хянан шалгах аар зохицуулсан.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 79 дүгээр зүйлийн 4-т зааснаар хороо нь хуулийн төслийг хэлэлцэхдээ тухайн хууль хэрэгжсэнээр төрийн захиргаа, иргэд болон бизнест үзүүлэх зардал, үр нөлөөний үнэлгээг хийх, мэдээлэл цуглуулах эрхтэй байдаг.

Эдгээр зохицуулалт нь парламентыг зөвхөн хууль батлах биш, батлагдсан хуулийн хэрэгжилт, төсвийн үр ашигтай зарцуулалт болон өрийн тогтвортой байдалд мэргэжлийн түвшинд хяналт тавих тогтолцоогоор хангаж байна.

(115.4.):

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 98-2 дугаар зүйлийн 9-д зааснаар Тамгын газрын холбогдох албан тушаалтнууд (Deputy Chiefs of Staff) Ерөнхийлөгчийн зарлиг, Сайд нарын тушаал зэрэгт хууль тогтоомжийн нийцлийн дүн шинжилгээ хийж, үр дүнг нь холбогдох хорооны гишүүдэд хүргүүлэхээр (provide the results thereof to the members of the relevant committees) тусгайлан заасан. Мөн тус хуулийн 22-2 дугаар зүйлийн 5-д зааснаар Тамгын газар нь гишүүд болон хороодын хүсэлтээр хууль тогтоох үйл ажиллагаа, төсөв болон улсын дансны тооцоог хянахад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээний материалаар хангах үүрэгтэй.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 157-2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар Тамгын газар нь Рийгикогу, түүний байгууллага болон гишүүдэд хууль тогтоох болон бусад чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээдэг. Мөн хуулийн 152-2 дугаар зүйлийн 4-т зааснаар Тамгын газраас ирүүлсэн Европын Холбооны хууль тогтоомжийн төсөл болон холбогдох дүн шинжилгээний талаарх мэдээллийг нийт гишүүдэд шууд мэдэгдэхээр (Members shall be notified) зохицуулжээ.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 10 дугаар дүрмийн 4(b) заалтад зааснаар Төсвийн хорооны дарга нь хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөө, төсвийн зарлага болон өр төлбөрийн асуудлаарх мэргэжлийн удирдамж, дүн шинжилгээгээр гишүүдийг хангах үүрэгтэй.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 199 дүгээр зүйлийн (b)-д зааснаар Ерөнхий нарийн бичгийн даргад (Clerk) хүргүүлсэн бүх баримт бичгүүдийг албан ёсоор бүртгэж, парламентад танилцуулсанд тооцон гишүүдэд мэдээлдэг.

Эдгээр зохицуулалт нь парламентын Тамгын газрыг зөвхөн захиргааны нэгж биш, харин гишүүдийг хараат бус дүн шинжилгээ, мэргэжлийн судалгаа мэдээллээр тасралтгүй хангах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага болохыг хуульчлан баталгаажуулсан нийтлэг шинжтэй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>116 дугаар зүйл. Байнгын хорооны хуралдаанаар мэдээлэл сонсох</p> <p>116.1. Хуульд заасны дагуу, эсхүл Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно.</p> <p>116.2. Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцэхэд асуулт асууж, үг хэлж болно.</p>	<p>116 дугаар зүйл. Байнгын хорооны хуралдаанаар мэдээлэл сонсох</p> <p>116.1. Хуульд заасны дагуу, эсхүл Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно.</p> <p>116.2. Олон нийтийн анхаарал татсан, цаг үеийн тулгамдсан асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах зорилгоор мэдээлэл сонсох саналаа</p>

<p>116.3.Байнгын хороо энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно.</p> <p>-</p>	<p>холбогдох Байнгын хорооны дарга Зөвлөлд танилцуулж, энэ хуулийн 6.6-д заасан хэлэлцэх асуудлын тов, дараалалд оруулна.</p> <p>116.3.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцэхэд асуулт асууж, үг хэлж болно.</p> <p>116.4.Байнгын хороо энэ хуулийн 116.1, 116.2-т заасан мэдээллийг хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох шийдвэрийн төслийг санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.</p>
<p>117 дугаар зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайлан, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх</p> <p>117.1.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ.</p> <p>117.2.Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.2-т заасан шалгуурыг хангаж, хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ.</p> <p>117.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын 18.2-т 18.1 заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.</p> <p>117.4.Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:</p> <p>117.4.1.жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл тухайн жилийнхээ зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг бүлэг тус бүрээр болон нэгдсэн дүнгээр;</p> <p>117.4.2.тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтын хэдэн хувьд хүрснийг бүлэг тус бүрээр;</p>	<p>117 дугаар зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх</p> <p>117.1.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнгийн тайланг хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ.</p> <p>117.2.Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.1-д заасан шалгуурыг хангаж, хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ.</p> <p>117.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын 18.2-т 18.1 заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.</p> <p>117.4.Байнгын хороо Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.1-д заасан хүрээнд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.1-д заасан хүрээнд гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>117.5.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.1-д заасны дагуу хэлэлцэнэ.</p>

<p>117.4.3.жилийн төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийн талаар.</p> <p>117.4.Байнгын хороо Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.1-д заасан хүрээнд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.1-д заасан хүрээнд гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>117.5.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.</p> <p>117.6.Энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланг Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>117.7.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.4-т заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.</p> <p>117.10.Нэгдсэн хуралдаан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.8, 18.10-т заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Улсын Их Хурал уг тогтоолыг 04 дүгээр сарын 01-ний дотор батална.</p>	<p>Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.</p> <p>117.6.Энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланг Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.</p> <p>117.7.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.3-т заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.</p> <p>117.10.Нэгдсэн хуралдаан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.6-д заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Улсын Их Хурал уг тогтоолыг 04 дүгээр сарын 01-ний дотор батална.</p>
<p>118 дугаар зүйл.Урт хугацааны бодлогын баримт бичиг болон Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх</p> <p>118.1.Улсын Их Хурал Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг урт хугацааны бодлогын баримт бичгийн явцын тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ.</p>	<p>118 дугаар зүйл.Урт хугацааны бодлогын баримт бичиг болон Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлан хэлэлцэх</p> <p>118.1.Улсын Их Хурал Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.1-д заасны дагуу хянан хэлэлцэнэ.</p>

<p>118.5.Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороод болон нэгдсэн хуралдаанд энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.3, 20.3-т заасан зарчмын дагуу танилцуулна.</p>	<p>118.5.Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороод болон нэгдсэн хуралдаанд энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.1, 20.2-т заасан зарчмын дагуу танилцуулна.</p>
<p>118.6.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.7, 20.7-д заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.</p>	<p>118.6.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.5, 20.7-д заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.</p>
<p>118.9.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.10 , 20.12-т заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу уг тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулна.</p>	<p>118.9.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.6, 20.8-д заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу уг тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулна.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

Эстониин Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 1-д хороод нь ЗГ-т санал хүргүүлэх тухай Рийгикогугийн тогтоолын төслийг санаачлан оруулж болохоор заасан байна. Мөн хуулийн 23-1 дүгээр зүйлийн 1-д хороо нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хяналт тавих зорилгоор тайлан бэлтгэж, түүнийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулж болно гэж заасан.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 117 дугаар зүйлийн 1-д Байнгын хороо бүр өөрийн хариуцсан салбарын хүрээнд тодорхой чиглэл тогтоох эсвэл удирдамж гаргах зорилгоор тогтоолын төсөл баталж болох бөгөөд Засгийн газрын төлөөлөгчийг уг хэлэлцүүлэгт заавал оролцуулахаар тусгасан. Хэрэв ЗГ хүсэлт гаргавал уг асуудлыг нэгдсэн хуралдаанд шилжүүлэн шийдвэрлэдэг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1-д зааснаар хороо нь өөрийн харьяалах асуудлын хүрээнд хуулийн төсөл болон бусад тогтоол, шийдвэрийн төслийг санаачлан өргөн барих эрхтэй. Мөн хуулийн 98-2 дүгээр зүйлийн 5-д хорооноос хийсэн хянан шалгалтын үр дүнг нэгдсэн хуралдааны тогтоолоор баталгаажуулж, ЗГ-т хүргүүлэхээр заажээ.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 316D дүгээр зүйлийн 1-д хорооны зөвлөмжийг тайлан хэлбэрээр танилцуулах ба 316E дүгээр зүйлийн 1, 3-т уг тайланг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Танхим хорооны зөвлөмжийг дэмжих, татгалзах эсвэл нэмэлт, өөрчлөлттэй батлах шийдвэр гаргахаар хуульчилсан.

Канадын Нийтийн танхимын дэгийн 108 дүгээр зүйлийн 1(а)-д зааснаар Байнгын хороод нь өөрт хамаарах яамдын хөтөлбөр, бодлогын зорилт болон тэдгээрийн хэрэгжилтийн үр нөлөөг (effectiveness) хянан үзэж, нэгдсэн хуралдаанд тайлагнах байнгын бүрэн эрхтэй. Мөн дэгийн 35 дүгээр зүйлийн 1-д хорооны тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах журмыг тодорхойлжээ.

Эдгээр улсуудын дэгийн зохицуулалт нь Байнгын хороог зөвхөн хэлэлцүүлэг хийхээр хязгаарлахгүй, хяналтын үр дүнгээ албан ёсны шийдвэрийн төсөл болгон нэгдсэн хуралдаанаар батлуулах замаар гүйцэтгэх засаглалд шаардлага хүргүүлэх, бодлогын чиглэл өгөх бодит боломжийг олгодог нийтлэг шинжтэй байна.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>120 дугаар зүйл. Сонсгол зохион байгуулах харьяалал</p> <p>120.1.2. тухайн жилийн төсвийн төсөл болон төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл, төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх хяналтын сонсгол явуулах бол Төсвийн байнгын хороо, эсхүл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, тухайн жилийн төсөв болон жилийн хөгжлийн төлөвлөгөөний уялдааны талаарх хяналтын сонсголыг Эдийн засгийн байнгын хороо.</p> <p>-</p> <p>120.6. Байнгын хороо энэ хуулийн 120.4, 120.5-д заасны дагуу сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10.1-д заасан асуудлаар холбогдох тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.</p>	<p>120 дугаар зүйл. Сонсгол зохион байгуулах харьяалал</p> <p>120.1.2. тухайн жилийн төсвийн төсөл болон төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл, төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх хяналтын сонсгол явуулах бол Төсвийн байнгын хороо, эсхүл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо</p> <p>120.1.3. улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн төсвийн уялдааны талаарх хяналтын сонсголыг Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороо хамтран.</p> <p>120.6. Байнгын хороо энэ хуулийн 120.4, 120.5-д заасны дагуу сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан асуудлаар холбогдох тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын засаглалд Байнгын хороод нь хууль тогтоох болон хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн нэгж болдог. ОУ-ын туршлагаас үзэхэд хороодын үйл ажиллагааны үр нөлөө нь тэдгээрийн чиг үүргийн тодорхой зааг ялгаа (jurisdiction) болон тухайн харьяаллын хүрээнд явуулах төрөл бүрийн сонсголын механизмаас шууд хамаарч байна.

1. Чиг үүргийн харьяалал ба "Салбар - Яамд" хослол:

Ихэнх ардчилсан улс орнуудад (Их Британи, Өмнөд Африк, Америк) Байнгын хороодыг Гүйцэтгэх засаглалын бүтэц буюу яамдын чиг үүрэгтэй уялдуулан байгуулдаг (Portfolio/Select committees). Бүх хуулийн төсөл, тогтоол, бодлогын баримт бичгийг тухайн асуудлыг хариуцсан байнгын хороонд (within the jurisdiction) шууд хуваарилдаг нь мэргэшсэн хэлэлцүүлэг өрнөх үндэс болдог. Тухайн хороо нь өөрийн харьяалах салбарын хүрээнд хууль тогтоох, төсөв хянах, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх "бүрэн эрх"-ийг (plenary oversight) хэрэгжүүлдэг байна.

2. Төсөв, санхүүгийн хяналтын төрөлжсөн сонсгол:

Төсвийн үйл явцад олон нийтийн оролцоог хангах, зардлын үр ашгийг хянах нь Байнгын хороодын тэргүүлэх чиг үүрэг юм. Солонгос болон Өмнөд Африкт Төсвийн тусгай хороо эсвэл Төсвийн байнгын хороо ажиллаж, төсвийн төсөл дээр заавал нийтийн сонсгол (public hearing) хийх үүрэг хүлээдэг.

Шинэ Зеланд Улсад Санхүү, зарлагын хороо нь төсвийн ерөнхий задаргааг хариуцах боловч нарийвчилсан хяналтыг (Estimates) салбарын бусад хороодод харьяаллынх нь дагуу хуваарилж, хэлэлцүүлдэг нь хяналтын "сүлжээ"-г бий болгож байна.

3. Томилгооны болон Хууль тогтоох сонсгол:

Байнгын хороод нь өөрийн харьяалах асуудлын хүрээнд боловсон хүчний болон хууль зүйн чанарын хяналтыг "сонсгол" хэлбэрээр хэрэгжүүлдэг. Солонгост албан тушаалтныг томилох "Нэр дэвшигчийн сонсгол"-ыг тухайн салбар хариуцсан Байнгын хороо өөрийн харьяаллын хүрээнд зохион байгуулдаг нь нэр дэвшигчийн мэргэжлийн чадамжийг тухайн салбарын

экспертүүдээр (гишүүдээр) шүүлгэх боломжийг олгодог. Их Британи болон Америкт хороод нь шинжээч, сонирхогч талуудыг дуудах, баримт бичиг шаардах замаар хуулийн төслийн практик үр нөлөөг үнэлдэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>121 дүгээр зүйл. Сонсголын бэлтгэл хангах</p> <p>121.2. Сонсгол явуулах сэдэв, он, сар, өдөр, байр, оролцогч, ажиглагчийг бүртгэх ажиллагаа, бүртгэл эхлэх, дуусах хугацаа, саналыг хүлээн авах цахим болон шуудангийн хаяг, холбогдох бусад мэдээллийг агуулсан зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол давтамж, хүртээмжтэйгээр нийтэд мэдээлнэ.</p> <p>121.4. Байнгын, дэд хороо хүсэлтийг дэмжиж шийдвэрлэсэн бол хойшлуулах үндэслэл, шалтгаанаас хамааран хойшлуулах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байна. Энэ тохиолдолд сонсголын товыг нийтэд зарласан арга хэрэгслээр дахин зарлана.</p> <p>121.6. Энэ хуулийн 120.3-т заасан ажлын хэсэг тухайн асуудлаар сонсгол явуулахад шинжээч шаардлагатай гэж үзсэн бол үндэслэл бүхий хүсэлтээ энэ хуулийн 121.1-д заасан Байнгын, дэд хороонд ирүүлнэ. Байнгын, дэд хороо хүсэлтийг дэмжсэн бол Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.7, 9.10-т заасны дагуу шийдвэрлэнэ.</p> <p>121.7. Сонсголд оролцох иргэн, хуулийн этгээд, ажиглагч /цаашид “оролцогч” гэх/ сонсгол болохоос ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө Байнгын хороо, Хянан шалгах түр хороонд бүртгүүлнэ.</p> <p>121.8. Сонсголд оролцогчийн тооны дээд хязгаарыг сонсгол болох танхимын багтаамж, тухайн асуудлын хүрээнээс хамааран сонсгол даргалагч тогтооно.</p>	<p>121 дүгээр зүйл. Сонсголын бэлтгэл хангах</p> <p>121.2. Сонсгол явуулах сэдэв, он, сар, өдөр, байр, оролцогч, ажиглагчийг бүртгэх ажиллагаа, бүртгэл эхлэх, дуусах хугацаа, саналыг хүлээн авах цахим болон шуудангийн хаяг, холбогдох бусад мэдээллийг агуулсан зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол давтамж, хүртээмжтэйгээр нийтэд мэдээлнэ. Сонсголд оролцогч нь бүртгүүлэхдээ тухайн асуудлыг “дэмжсэн”, “дэмжээгүй”, “хөндлөнгийн” байр суурийн аль нэгийг тодорхой илэрхийлсэн байна.</p> <p>121.4. Сонсгол хойшлуулах хүсэлтийг Байнгын, дэд хороо дэмжиж шийдвэрлэсэн бол сонсголын товыг нийтэд зарласан арга хэрэгслээр дахин зарлана.</p> <p>121.6. Энэ хуулийн 120.3-т заасан ажлын хэсэг, эсхүл сонсгол даргалагч тухайн асуудлаар сонсгол явуулахад шинжээч шаардлагатай гэж үзсэн бол үндэслэл бүхий хүсэлтээ энэ хуулийн 121.1-д заасан Байнгын, дэд хороонд ирүүлнэ. Байнгын, дэд хороо хүсэлтийг дэмжсэн бол Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.7, 9.10-т заасны дагуу шийдвэрлэнэ.</p> <p>121.7. Шинжээч нь тухайн асуудлын талаар тавьсан асуулт нэг бүрээр, тал бүрээс нь бүрэн, бодитой, хараат бусаар шинжлэн судалсан дүгнэлтийг тогтоосон хугацаанд бичгээр гаргаж ажлын хэсэг, эсхүл сонсгол даргалагчид хүргүүлнэ.</p> <p>121.8. Сонсголд оролцогчийн тооны дээд хязгаарыг тухайн асуудлын цар хүрээ, сонсгол болох танхимын багтаамжийг харгалзан сонсгол даргалагч тогтоох бөгөөд энэ хуулийн 121.2-т заасан байр суурийг илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийг тэнцвэртэй оролцуулах зарчим баримтална.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын хорооны сонсгол нь гүйцэтгэх засаглалд хяналт тавих, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах болон томилгооны ил тод байдлыг хангах үндсэн механизм юм. Сонсголыг амжилттай зохион байгуулах гол үндэс нь түүний урьдчилсан бэлтгэл ажил бөгөөд олон улсын туршлагаас үзэхэд энэхүү үйл ажиллагааг дараах дөрвөн үндсэн чиглэлээр системчлэн зохицуулдаг байна.

- Мэдээллийн ил тод байдал ба зарлан мэдээлэх хугацаа:

Сонсголын бэлтгэл ажлын хамгийн эхний шат нь олон нийт болон оролцогч талуудад мэдээллийг урьдчилан хүргэх явдал юм.

-Зарлан мэдээлэх босго: Америкт 1 долоо хоногийн өмнө, Солонгост 5 хоногийн өмнө огноо, байршил, сэдэв болон гэрчүүдийн нэрийг нийтэд зарлах хатуу журам үйлчилдэг.

-Зөвшөөрлийн механизм: Япон улсад нээлттэй сонсгол хийхээс өмнө Парламентын даргаас урьдчилан зөвшөөрөл авдаг нь сонсголын ач холбогдлыг институцийн түвшинд баталгаажуулдаг.

- Хөтөлбөр боловсруулах ба мэргэжлийн судалгаа

Сонсголын үр дүнг хангахын тулд хороо өөрөө дотооддоо бэлтгэл хангах, шинжлэх ухааны үндэслэлтэй асуултууд бэлтгэх шаардлагатай байдаг.

-Бэлтгэл хуралдаан: Норвег улсын Стортингт "тусгай бэлтгэл хуралдаан" (preparatory meeting) хийж, асуултын жагсаалт, хөтөлбөрийг нарийвчлан баталдаг бол Германд гэрчүүдэд асуултыг урьдчилан мэдэгдэж, бичгээр тайлбар авах замаар мэтгэлцээний фокусыг тодорхойлдог.

-Судалгааны дэмжлэг: Солонгост Парламентын тамгын газар болон Судалгааны албаны (NARS) шинжээчдийг татан оролцуулж, урьдчилсан судалгаа (preliminary investigation) хийлгэдэг нь хорооны гишүүдийг бодит баримт, өгөгдлөөр хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байна.

- Гэрч, шинжээчийг сонгох ба мэдээллийн аюулгүй байдал

Сонсголд оролцох гэрч, шинжээчдийн "ашиг сонирхлын зөрчил"-ийг хянах нь сонсголын хараат бус байдлыг баталгаажуулдаг.

-Мэдээллийн ил тод байдал: Америкийн Төлөөлөгчдийн танхимд гэрчүүд өөрийн намтар (CV) болон гадаадын санхүүжилтийн мэдээллээ 24 цагийн өмнө цахимаар байршуулах үүрэг хүлээдэг.

-Тэнцвэрт байдлын зарчим: Японы парламентад "дэмжсэн" болон "эсэргүүцсэн" байр суурьтай талуудыг тэнцвэртэй сонгож, ижил цаг олгохыг эрхэмлэдэг. Швейцарт гэрчийг "албан ёсны" (formal witness) эсвэл "мэдээлэл өгөгч" гэж ангилах замаар хууль зүйн хариуцлагыг нь урьдчилан сануулдаг байна.

- Оролцогчдын эрх ба хууль зүйн хамгаалалт

Сонсголд дуудагдсан этгээдүүдийн эрхийг хангах нь ардчилсан парламентын үндсэн зарчим юм.

-Хууль зүйн зөвлөгөө: Норвег болон Шинэ Зеландад гэрчүүд өөрийн зөвлөхийг дагуулж ирэх, санаа зовоосон асуудлаа урьдчилан хорооны нарийн бичгийн даргад уламжлах эрхтэй байдаг.

-Хариу тайлбар гаргах: Австралид хэрэв гэрчийн эсрэг буруутгал гарвал түүнд хариу тайлбар бэлтгэх хангалттай хугацаа заавал олгодог нь сонсголыг "шүүх" биш, харин "үнэнийг тогтоох" талбар болгодог байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>122 дугаар зүйл. Сонсгол даргалагч</p> <p>122.1. Холбогдох Байнгын болон дэд хорооны хуралдаанаар сонсгол даргалагч /цаашид "сонсгол даргалагч" гэх/-ийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.</p>	<p>122 дугаар зүйл. Сонсгол даргалагч</p> <p>122.1. Сонсгол даргалагчийг холбогдох Байнгын болон дэд хорооны гишүүдээс хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар сонсгол даргалагч эзгүй бол холбогдох Байнгын, эсхүл дэд хорооны дарга сонсголыг даргална.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын хянан шалгах болон хууль тогтоох үйл ажиллагааны чухал хэлбэр болох "Сонсгол"-ыг (Hearing) хэн даргалах, хуралдаан даргалагч эзгүй үед хэрхэн орлох асуудал нь парламентын дотоод ардчилал болон үйл ажиллагааны тасралтгүй байдлыг

хангахад чухал үүрэгтэй. Олон улсын парламентын практикт энэхүү зохицуулалтыг дараах хоёр үндсэн загварт хуваан үзэж болно. Үүнд:

1. Гишүүдийн оролцоотой "Сонгох" загвар:

Вестминстер системийн болон хамтын удирдлагын зарчмыг баримталдаг улс орнуудад (Сингапур, Шинэ Зеланд, Энэтхэг, Өмнөд Африк, Австрали) сонсгол даргалагч эзгүй тохиолдолд орлон даргалагчийг тухайн хуралдаанд оролцож буй гишүүд өөрсдийн дундаас сонгох зарчмыг баримталдаг. Хорооны үндсэн дарга эзгүй үед гишүүд тухайн өдрийн хуралдааныг удирдах гишүүнийг олонхын саналаар сонгодог (elect/choose). Энэ нь Монгол Улсын УИХ-ын дэгийн "Сонсгол даргалагчийг сонгох" үзэл баримтлалтай процедурын хувьд ижил боловч олон улсад энэ нь зөвхөн "орлон даргалах" үед хэрэглэгддэг тусгай горим юм. Австрали зэрэг улсад дэд хорооны (Subcommittee) түвшинд ч энэхүү сонгох зарчмыг ашиглаж байгаа нь хэлэлцүүлэг даргалагчийн легитим чанарыг гишүүдийн дундаас баталгаажуулж буй хэлбэр юм.

2. Институцийн "Автомат" болон "Томилох" загвар:

Парламентын хатуу шатлал болон намын бүлгийн төлөөллийг чухалчилдаг орнуудад (Америк, Солонгос, Канад) орлон даргалагчийг сонгох бус, харин урьдчилан тогтоосон дарааллаар эсвэл томилгоогоор шийдвэрлэдэг. Америкийн Төлөөлөгчдийн танхимд олонхын намын хамгийн өндөр албан тушаалтай гишүүн (ranking majority member) автоматаар даргалах эрхийг шилжүүлж авдаг нь хуралдааныг сааталгүй үргэлжлүүлэх давуу талтай. Солонгос болон Канад улсад хорооны дарга өөрийн эзгүйд орлон ажиллах гишүүнийг урьдчилан томилдог (designate) бөгөөд энэ нь удирдлагын залгамж чанарыг хангах захиргааны шийдэл болдог байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>123 дугаар зүйл. Сонсголд оролцогч</p> <p>123.1. Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд, шинжээч, ажиглагчийг сонсголд оролцогч гэнэ.</p>	<p>123 дугаар зүйл. Сонсголд оролцогч</p> <p>123.1. Энэ хуулийн 121.5-д заасан этгээд болон хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд, ажиглагчийг сонсголд оролцогч гэнэ.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын сонсгол нь хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргах болон хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгддэг. ОУ-ын парламентын туршлагаас үзэхэд сонсголд оролцогчдыг тэдний гүйцэтгэх үүрэг, эрх зүйн байдлаас нь хамааран Гэрч, Шинжээч, Сонирхогч тал хэмээн зааглаж, дараах байдлаар ангилан зохицуулж байна.

1. Сайн дурын оролцогчид болон сонирхогч талууд (Interested Parties)

Хуулийн төсөл болон бодлогын асуудлаар иргэд, төрийн бус байгууллагуудын байр суурийг сонсох нь ардчилсан парламентын үндсэн зарчим юм. Тэнцвэрт байдлыг хангахын тулд Япон болон Сингапур улсад сонирхогч талуудаас "дэмжсэн" болон "эсэргүүцсэн" байр суурийг урьдчилан бичгээр авч, тэдгээрээс тэнцвэртэйгээр сонгон "илтгэгч" (speaker) хэлбэрээр оролцуулдаг.

Мөн Норвег, Эстони болон Өмнөд Африкийн парламентын хороод олон нийтээс бичгээр санал (submissions) хүлээн авах замаар аман сонсголыг баяжуулдаг. Энэ нь оролцооны хүрээг тэлж, цаг хугацаа болон зардлыг хэмнэх давуу талтай.

2. Гэрч (Witness): Мэдээлэл болон баримт гаргагч:

Сонсголд албан ёсоор дуудагдаж, баримт нотолгоо гаргаж буй этгээдийг "Гэрч" хэмээн тодорхойлдог. Австрали болон Шинэ Зеландын хууль тогтоомжид "гэрч"-ийг Танхим болон хорооны өмнө нотлох баримт, мэдээлэл өгөх этгээд гэж нарийвчлан тодорхойлсон. Гэрч нь өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс Энэтхэгийн жишгээр хуульч, өмгөөлөгчтэйгөө (counsel) сонсголд оролцох эрхээр хангагдсан байдаг нь хүний эрхийг хамгаалах баталгаа болдог.

3. Шинжээч (Expert) ба Мэргэжлийн зөвлөхүүд

Мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах, шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдээлэл өгөх хүмүүсийг тусгайлан ангилдаг. Германы Бундестагт "мэдээлэл өгөх чадвартай шинжээчид"-ийг

нийтийн сонголд урьдаг бол Солонгост "санал хэлэх этгээд" (persons stating opinion) хэмээн тодорхойлж, тэдний үг хэлэх хүрээг зөвхөн мэргэжлийн асуудлаар нь хязгаарладаг.

Шинэ Зеландад байнгын хороод нь хөндлөнгийн "зөвлөхүүд" (advisers)-ийн туслалцааг авах замаар хэлэлцүүлгийн мэргэжлийн чанарыг хангадаг байна.

4. Оролцооны дижитал хэлбэрүүд:

Мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглан зайнаас оролцуулах нь орчин үеийн парламентын нийтлэг хандлага болж байна. Канад болон Япон улсын дэгт гэрч, оролцогчид нь зайнаас цахимаар (remotely) оролцох, мэдүүлэг өгөх эрхийг тусгайлан заасан байдаг. Энэ нь газар зүйн алслагдсан байдлаас үл хамааран иргэд, шинжээчдийн оролцох боломжийг нэмэгдүүлж буй дэвшилтэт хэлбэр юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
125 дугаар зүйл. Сонсгол даргалагчийн эрх, үүрэг 125.2.4. сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах;	125 дугаар зүйл. Сонсгол даргалагчийн эрх, үүрэг 125.2.4. сонсголын тайланг хянаж, албажуулах, эрх бүхий этгээдэд танилцуулах;

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын сонсгол нь бодлогын мэтгэлцээн болон хянан шалгах ажиллагааны онцгой хэлбэр тул хуралдаан даргалагч нь ердийн хуралдааныг удирдахаас гадна гэрч, шинжээч болон олон нийтийн оролцоог зохицуулах тусгайлсан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. ОУ-ын туршлагаас үзэхэд сонсгол даргалагчийн чиг үүргийг дараах гурван үндсэн хүрээнд ангилан зохицуулж байна.

1. Дэг сахиулах болон хэлэлцүүлгийн фокусыг хадгалах эрх мэдлийн хүрээнд: Сонсголын үр нөлөө нь оролцогчдын сахилга бат, хэлэлцэж буй асуудлын төвлөрлөөс шууд хамаардаг.

- Техникийн хяналт: Эстони болон Солонгосын хорооны дарга нар оролцогчдыг сэдвээс халих, хугацаа хэтрүүлэх эсвэл зүй бус үг хэллэг хэрэглэх тохиолдолд микрофоныг таслах, танхимаас гаргах хүртэл албадлагын арга хэмжээ авах эрхтэй.
- Шийдвэрийн хүчин төгөлдөр байдал: Сингапур улсад даргын дэгийн талаарх шийдвэр нь эцсийнх бөгөөд давж заалдах эрхгүй байдаг бол Канадад зөрчил гаргагчид шийтгэл оногдуулах асуудлыг нэгдсэн хуралдаанд тайлагнаж шийдвэрлүүлдэг нь парламентын дээд институцийн хяналтыг харуулж буй хэлбэр юм.
- Хуралдааныг зогсоох эрх: Германы Бундестагт хуралдааны хэвийн үйл ажиллагаа алдагдвал дарга дангаар бус, намын бүлгүүдтэй зөвшилцөн сонсголыг цуцлах эрх эдэлдэг байна.

2. Төлөөлөх болон шийдвэрлэх онцгой эрх мэдэл (Casting Vote): Сонсгол даргалагч нь хамтын шийдвэр гаргах үйл явцыг мухардалд орохоос сэргийлэх "тэнцвэржүүлэгч" үүргийг гүйцэтгэдэг.

- Шийдвэрлэх санал: Өмнөд Африк болон Энэтхэгийн парламентын хорооны дарга нар санал тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэр гаргах "шийдвэрлэх санал" (casting vote) өгөх эрхтэй.
- Төвийг сахих зарчим: Япон улсын парламентад даргалагч нь мэтгэлцээнд оролцож байр сууриа илэрхийлэхийг хүсвэл даргын суудлаа түр орхиж, жирийн гишүүний суудалд суух ёстой байдаг нь "хуралдаан даргалагч улс төрийн хувьд төвийг сахих" ардчилсан зарчмын сонгодог жишээ юм.

3. Захиргаа, зохион байгуулалт болон протоколын хариуцлагын хүрээнд: Сонсголын бэлтгэл ажил болон баримт бичгийн үнэн зөв байдлыг даргалагч хариуцдаг.

- Зөвшилцөл ба Төлөвлөлт: Солонгост сонсголын товыг нарийн бичгийн дарга нартай зөвшилцөн тогтоодог бол Эстонид Засгийн газрын гишүүдийг сонсголд дуудан ирүүлэх эрх нь хорооны даргад хадгалагддаг.

- Архив ба Тайлагнал: Норвег болон Солонгосын хорооны дарга нар сонсголын тэмдэглэл, ирүүлсэн нотлох баримтуудыг архивлах, нийтлэх үүргийг хүлээдэг. Энэ нь парламентын хяналтын ажиллагааг баримтжуулж, түүхэн болон эрх зүйн ач холбогдлыг нь хадгалахад чиглэгддэг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>126 дугаар зүйл. Сонсгол явуулах журам</p> <p>126.1. Сонсголыг дараах журмаар явуулна:</p> <p>126.1.1. сонсгол даргалагч сонсголын зорилго, ирц, дэгийг танилцуулах;</p> <p>126.1.2. сонсгол даргалагч оролцогчийн санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах, асуулт асуух дарааллыг тогтоох;</p> <p>126.1.3. сонсголд дуудаж ирүүлсэн албан тушаалтан нь тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан мөн эсэх талаар тодруулга авах;</p> <p>126.1.4. оролцогчийн санал, мэдээлэл, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байх;</p> <p>126.1.5. гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно;</p> <p>126.1.6. гишүүн оролцогчоос асуулт асууж, хариулт авч дууссаны дараа 5 минутад багтаан үг хэлж болно;</p> <p>126.1.7. сонсгол даргалагч сонсож байгаа асуудалтай холбогдуулан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийн агуулгыг уншиж танилцуулан сонсголын тэмдэглэлд тусгуулна;</p> <p>126.1.8. сонсгол даргалагч болон гишүүн бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.</p> <p>126.2. Энэ хуулийн 126.1.5, 126.1.6-д заасан үйл ажиллагаанд олонх, цөөнхийн төлөөлөлд ээлжлэн асуулт асуух, үг хэлэх боломж олгоно.</p> <p>126.3. Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй.</p> <p>126.4. Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.</p> <p>126.5. Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална.</p> <p>-</p>	<p>126 дугаар зүйл. Сонсгол явуулах журам</p> <p>126.1. Сонсгол даргалагч дараах байдлаар сонсголын дарааллыг тогтооно:</p> <p>126.1.1. сонсголын зорилго, ирц, дэгийг танилцуулах;</p> <p>126.1.2. эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл сонсох;</p> <p>126.1.3. холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны мэдээлэл сонсох;</p> <p>126.1.4. сонсгол даргалагч энэ хуулийн 126.1.2, 126.1.3-т зааснаас бусад бичгээр ирсэн санал, хүсэлт, тайлбар, мэдээллийн агуулгыг уншиж танилцуулах;</p> <p>126.1.5. шинжээч томилсон бол шинжээчийн дүгнэлтийг сонсох;</p> <p>126.1.6. сонсгол даргалагч болон гишүүд сонсголд оролцогчдоос асуулт асууж, хариулт авах;</p> <p>126.1.7. тухайн асуудлаар дэмжсэн, дэмжээгүй, хөндлөнгийн байр суурийг илэрхийлж оролцогчид үг хэлэх;</p> <p>126.1.8. гишүүн байр сууриа илэрхийлж үг хэлэх.</p> <p>126.2. Сонсгол даргалагч болон гишүүн бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.</p> <p>126.3. Энэ хуулийн 126.1.2, 126.1.3-т заасан мэдээлэл, 126.1.5-д заасан дүгнэлтийг тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд танилцуулна.</p> <p>126.4. Гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.</p> <p>126.5. Гишүүн, сонсголд оролцогч байр сууриа илэрхийлж үг хэлэх хугацаа 5 хүртэл минут байна.</p> <p>126.6. Энэ хуулийн 126.1.6, 126.1.7-д заасан үйл ажиллагаанд олонх, цөөнхийн төлөөлөлд ээлжлэн асуулт асуух, үг хэлэх боломж олгоно.</p> <p>126.7. Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй.</p> <p>126.8. Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын сонсгол нь хууль тогтоох байгууллагын мэдээлэл цуглуулах, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх болон гүйцэтгэх засаглалд хяналт тавих хамгийн үр дүнтэй ардчилсан механизм юм. ОУ-ын туршлагаас үзэхэд сонсголын үйл ажиллагааг дараах үндсэн системчлэлээр зохицуулж байна.

1. Сонсголын төрөлжсөн ангилал ба зорилго:

Парламентын хэрэгцээ шаардлагаас хамааран сонсголыг чиг үүргийн хувьд гурван үндсэн бүлэгт хуваадаг.

- Нийтийн сонсгол (Public hearings): Хуулийн төсөл болон бодлогын баримт бичгийг боловсруулах шатанд сонирхлын бүлгүүд, иргэд, шинжээчдийн саналыг тусгах зорилготой.
- Хяналт шалгалтын сонсгол (Oversight hearings): Засгийн газрын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтад аудит хийх, хуулийн хэрэгжилтийг шалгахад чиглэгддэг. Их Британи, Шинэ Зеландын парламентын хороод энэ хүрээнд гэрч дуудах, баримт бичиг шаардах (power to send for persons, papers, records) онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.
- Томилгооны сонсгол (Personnel hearings): Төрийн өндөр албан тушаалд нэр дэвшигчийн ур чадвар, ёс зүйн хариуцлагыг шүүн хэлэлцдэг. Солонгосын жишгээр шүүх, гүйцэтгэх засаглалын тэргүүнүүдийг томилоход "Тусгай хороо" байгуулан мэргэшсэн сонсгол явуулдаг байна.

2. Бэлтгэл ажил ба Албадлагын механизм:

Сонсголын үр дүнг хангахын тулд оролцогчдыг дуудан ирүүлэх эрх зүйн баталгааг бүрдүүлдэг.

- Зарлан дуудах хуудас (Summons): Хороо нь нэр бүхий этгээдийг биечлэн ирүүлэх эсвэл нотлох баримт гаргуулахаар албан ёсны дуудах хуудас илгээдэг. Хэрэв этгээд татгалзвал Спикерийн тушаалаар албадан ирүүлэх дэг үйлчилдэг.
- Урьдчилсан мэдээлэл: Оролцогч талуудад хэлэлцэх асуудлын сэдвийг урьдчилан танилцуулж, тэднээс бичгээр тайлбар (written submissions) авснаар аман сонсголын үр нөлөөг нэмэгдүүлдэг.

3. Сонсголын үе шат ба Мэдүүлэг өгөх горим:

Сонсгол нь тогтоосон дэс дарааллын дагуу, хууль зүйн хариуцлагатайгаар өрнөдөг.

- Тангараг ба Мэдүүлэг: Гэрчээс мэдүүлэг авахын өмнө тангараг (oath) өргүүлдэг нь өгч буй мэдээллийн үнэн зөв байдлыг хуулиар баталгаажуулж буй хэрэг юм. Гэрч нь өөрийн аюулгүй байдал болон хууль зүйн эрх ашгийн үүднээс мэдүүлэг өгөхөөс өмнө "санаа зовоосон асуудал"-аа илэрхийлэх эрхтэй.
- Дижитал шилжилт: Орчин үеийн практикт зайнаас (remote) оролцож мэдүүлэг өгөх цахим хэлбэрийг албан ёсны дэгт тусган хэрэгжүүлж байна.

4. Нууцлалын зэрэглэл ба Баримтжуулалт:

Сонсгол нь нээлттэй байх зарчимтай боловч тодорхой тохиолдолд хаалттай горимд шилждэг.

- Горим шилжүүлэх: Үндэсний аюулгүй байдал, хувь хүний нууцад хамааралтай асуудлыг "хаалттай" (in camera) хэлэлцэнэ. Шинэ Зеландын туршлагаар гэрчийн хүсэлтээр мэдээллийг "нууц" (secret) ангилалд оруулж, олон нийтэд дэлгэхийг хязгаарлаж болдог.
- Тайлагнал: Сонсголын үйл явцыг албан ёсны протоколд (minutes of evidence) нэг бүрчлэн тэмдэглэж, үүний үндсэн дээр хорооны санал дүгнэлтийг боловсруулан Нэгдсэн хуралдаанд танилцуулснаар эцсийн шийдвэр гардаг.

Зарим улс оронд сонсголын үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй явуулах үүднээс оролцогчийн үг хэлэх хугацааг дэгээрээ шууд нарийвчлан тогтоосон байдаг. Тухайлбал, Норвег улсын Стортингт хяналтын сонсголын оролцогч байр сууриа танилцуулахад 10 минут, дүгнэлт

хийхэд 5 минут олгодог нь хэлэлцүүлгийг системтэй явуулахад тусалдаг. Хэдийгээр хатуу хугацаа заасан ч асуудлыг тодруулах шаардлагаар хуралдаан даргалагч цагийг сунгах эрхтэй байдаг нь бодит үнэнийг тогтоох парламентын үндсэн зорилготой нийцдэг байна.

ОУ-д хамгийн түгээмэл ажиглагдаж буй дараагийн жишиг нь үг хэлэх хугацааг тухайн хэлэлцэж буй асуудлын цар хүрээнээс хамааруулан Хороо өөрөө бие даан тогтоох явдал юм. Япон улсын парламентын дэгд дэмжсэн болон эсэргүүцсэн талуудад (impartial) яг ижил хугацаа олгохыг хатуу шаарддаг нь "ардчилсан сонсгол"-ын үндсэн зарчим болох талуудын тэнцвэрийг хангахад чиглэгддэг. Солонгост хугацааг хороо тогтоохын зэрэгцээ оролцогчийн үг хэлэх хүрээг зөвхөн шаардсан асуудлаар хязгаарлаж, "сэдвээс халихгүй байх" сануулгыг байнга өгдөг байна.

Америкийн тухайд, гэрчээс асуулт асуух үйл явцыг гишүүн бүрийн оролцоон дээр суурилж зохион байгуулдаг онцлогтой.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын "5 минутын дүрэм" (five-minute rule) нь хорооны гишүүн бүрд гэрчтэй харилцах тэгш боломж олгодог. Хэрэв асуулт асуух хугацааг сунгахаар болбол олонх болон цөөнхийн намд цагийг яг тэнцүү хуваарилж, нийт мэтгэлцээнийг 1 цагаас хэтрүүлэхгүй байхаар хязгаарладаг нь цөөнхийн дуу хоолойг боомилохгүй байх эрх зүйн баталгаа болдог байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>129 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол</p> <p>129.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцуулах саналаа Улсын Их Хуралд албан ёсоор ирүүлнэ. Саналд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэл бүхий нэр дэвшигчийн танилцуулга, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.</p>	<p>129 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол</p> <p>129.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтныг томилуулах саналаа Улсын Их Хуралд албан ёсоор ирүүлнэ. Саналд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэл бүхий нэр дэвшигчийн танилцуулга, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Төрийн өндөр албан тушаалд нэр дэвшигчийн мэдлэг боловсрол, мэргэшил, ёс зүй болон ашиг сонирхлын байдлыг парламентын түвшинд хянан шалгах нь томилгооны чанар, хариуцлагыг хангах үндсэн нөхцөл болдог. Судалгаанд хамрагдсан улс орнууд дотроос онцлон Канад, Солонгосын туршлагаас үзэхэд энэхүү хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн техник, баримт бичгийн бүрдэлд тавих шаардлагыг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

Канад улсын Нийтийн танхимын дэг нь нэр дэвшигчийн хувийн намтраас гадна түүний тухайн албан тушаалд тэнцэх "бодит чадамж"-ийг нотлоход чиглэгддэг.

- Баримт бичгийн шаардлага: Сайд буюу томилох санал гаргагч этгээд нь нэр дэвшигчийн "curriculum vitae" буюу дэлгэрэнгүй намтар, танилцуулгыг хороонд заавал ирүүлэх үүрэгтэй. Энэ нь зөвхөн ажил эрхлэлтийн түүх бус, нэр дэвшигчийн боловсрол, туршлага, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг илтгэх үндсэн баримт бичиг болдог.
- Шалгуурын агуулга: Хороо нь нэр дэвшигчийг сонсголд оролцуулахдаа "мэргэшил, ур чадвар болон чадамж" (qualifications and competence) гэсэн гурван тулгуурт шалгуураар үнэлдэг. Энэ нь баримт бичигт дурдсан мэдээллийг аман сонсголоор дамжуулан баталгаажуулах замаар томилгоог "мэргэшсэн" (merit-based) байх зарчимд нийцүүлж буй хэрэг юм.

Солонгосын Үндэсний Ассамблейд томилгооны асуудлыг хэлэлцэх процесс нь бүтцийн хувьд хамгийн нарийн системчлэгдсэн байдаг.

- Албан ёсны санал (Approval Bill): Ерөнхийлөгч болон Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс томилгооны асуудлыг "Батлах тухай хуулийн төсөл" хэлбэрээр парламентад өргөн мэдүүлдэг. Энэ нь томилгоог цэвэр захиргааны акт бус, хууль тогтоох байгууллагын зөвшөөрөл (consent)-өөр баталгаажих улс төрийн өндөр хариуцлагатай үйл ажиллагаа болгон хувиргадаг.
- Хууль зүйн зохицуулалтын техник: Солонгосын парламент баримт бичгийн бүрдэл (боловсрол, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг г.м)-ийг парламентын дэгдээ нэг бүрчлэн тоочих бус, харин бие даасан "Нэр дэвшигчийн сонсголын тухай хууль" (Personnel Hearing Act)-д тусгадаг. Энэ нь томилгооны хяналтыг илүү мэргэшсэн, нарийвчилсан аргачлалаар явуулах эрх зүйн уян хатан орчныг бүрдүүлдэг байна.

2.13.АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ: БУСАД АСУУДАЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Төслийн заалт
<p>135 дугаар зүйл.Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журам</p> <p>135.1.Чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /цаашид “хуралдааны тэмдэглэл” гэх/-ийг бичгээр болон цахим мэдээлэл тээгчид нэгэн зэрэг дуу, дүрсний бичлэгийн хэрэгсэл ашиглан хадгалах ба хуралдааны тэмдэглэл дэлгэрэнгүй ба товч гэсэн хэлбэртэй байна.</p> <p>135.2.Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлд дараах баримт бичгийг хавсарган хадгална:</p> <p>135.2.1.тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдаанд урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;</p> <p>135.2.5.хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал, гишүүдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал;</p> <p>135.2.7.гишүүдийн ирцийн мэдээ.135.3.Хуралдааны товч тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:</p> <p>135.3.3.санал хураалтын дүн /тоо, хувиар/, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналын тоо;</p> <p>135.3.4.хуралдааны ирцийн мэдээ /тоо, хувиар/, хуралдаанд ирээгүй гишүүний нэр, шалтгаан /томилолттой байсан, хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан/;</p> <p>-</p>	<p>135 дугаар зүйл.Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журам</p> <p>135.1.Чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /цаашид “хуралдааны тэмдэглэл” гэх/-ийг бичгээр болон цахим мэдээлэл тээгчид нэгэн зэрэг дуу, дүрсний бичлэгийн хэрэгсэл ашиглан хадгалах ба хуралдааны тэмдэглэл дэлгэрэнгүй ба товч тэмдэглэлээс бүрдэнэ.</p> <p>135.2.Хуралдааны тэмдэглэлд дараах баримт бичгийг хавсарган хадгална:</p> <p>135.2.1.хуралдаанд урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;</p> <p>135.2.5.хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл;</p> <p>135.2.7.гишүүдийн ирцийн мэдээ, гишүүний хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцоогүйг нотлох баримт бичиг, түүний хуулбар.</p> <p>135.3.3.санал хураалтын дүн /тоо, хувиар/, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй түүний нэрээр;</p> <p>135.3.4.хуралдааны ирцийн мэдээ /тоо, хувиар/, хуралдаанд ирээгүй гишүүний нэр, шалтгаан /томилолттой байсан, хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан/;</p> <p>135.3.9.хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлсэн талаарх хуралдаан даргалагчийн мэдээлэл.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (135.1.):

1. Хуралдааны тэмдэглэлийн хэлбэр (Бичгээр болон дуу, дүрсний бичлэгээр хадгалах)

ОУ-ын практикт хуралдааны явцыг албан ёсны бичмэл тэмдэглэлээс гадна дуу, дүрсний бичлэгийн хэрэгсэл ашиглан баримтжуулах дэг нийтлэг байна.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 11 дүгээр дүрмийн 2(е)(5)-д зааснаар хороод боломжтой бүх тохиолдолд хуралдааны дуу, дүрсний бичлэгийг хийж, тэдгээр бичлэгийг олон нийтэд нээлттэй байхаар хадгалах үүрэг хүлээдэг.

Германы Бундестагийн дэгийн 116 дүгээр зүйлийн 3-т хуралдааны явцын бүх тэмдэглэл, жишээлбэл, дуу хураагуурын бичлэг (tape recordings) зэргийг парламентын архивд хадгалахаар тусгайлан зохицуулсан.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 364 дүгээр зүйлийн (b)-д зааснаар Танхимын архивд хуралдааны албан ёсны тэмдэглэлээс гадна бүх транскрипт болон бичлэгүүдийг (any transcripts and recordings) хадгалдаг.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 8 дугаар зүйлийн (1)-д зааснаар "албан ёсны дамжуулалт" (official coverage) гэдэгт шууд болон дараа нь үзэх боломжтой бичлэг, дамжуулалтыг ойлгох бөгөөд Хавсралт D-д эдгээр бичлэгийг хадгалах журмыг тодорхойлсон байна.

2. Тэмдэглэлийн агуулга (Дэлгэрэнгүй ба товч тэмдэглэл)

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 1, 2-т нэгдсэн хуралдааны явцыг стенографийн (stenography) аргаар дэлгэрэнгүй хөтлөхөөр, харин 69 дүгээр зүйлд хорооны хурлын тэмдэглэлд оролцсон гишүүдийн нэрс, хэлэлцсэн асуудал зэрэг товч мэдээллийг заавал тусгахаар заасан.

Эстонийн Рийгикогугийн дэгийн 61 дүгээр зүйлийн 1-д зааснаар хуралдааны явцыг стенографийн аргаар дэлгэрэнгүй (verbatim records) болон товч тэмдэглэл (minutes) хэлбэрээр зэрэг хөтөлдөг.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 9-д Ерөнхий нарийн бичгийн дарга товч тэмдэглэлийг (Journals) хөтлөхөөр, дэгийн 10-т Hansard буюу дэлгэрэнгүй тэмдэглэлийг албан ёсны тайлан болгон нийтлэхээр тус тус заажээ.

Сингапурын Парламентын дэгийн 29 дүгээр зүйлд хэлсэн үгийг нэг бүрчлэн тусгасан дэлгэрэнгүй тайлан (Official Report - Hansard) бэлтгэхээр, 30 дугаар зүйлд хурлын шийдвэр, санал хураалтын дүнг тусгасан товч тэмдэглэл (Votes and Proceedings) хөтлөхөөр заасан байна.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 34 дүгээр зүйлийн 1-д нэгдсэн хуралдаан болон хороодын товч тэмдэглэлийг (Minutes) хөтлөхөөр, 65 дугаар зүйлийн 2-т хорооны хуралдааныг дэлгэрэнгүй (verbatim report) хэлбэрээр тэмдэглэхээр заажээ.

Эдгээр зохицуулалт нь парламентын үйл ажиллагааг баримтжуулахдаа бичмэл болон цахим хэлбэрийг хослуулах, мөн товч болон дэлгэрэнгүй тэмдэглэлийг зэрэг хөтлөх замаар түүхэн архив болон хяналтын баримт бичгийг бүрэн бүрдүүлдэг болохыг харуулж байна.

(135.2.1.): Хуралдаанд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаалыг тэмдэглэх.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5-д хорооны хуралдааны тэмдэглэлд оролцсон Төрийн зөвлөлийн гишүүд, Засгийн газрын төлөөлөгчид, гэрч, шинжээч, зөвлөхүүдийн нэрийг заавал тусгахаар заасан. Мөн хуулийн 115 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д оролцсон Төрийн зөвлөлийн гишүүд болон Засгийн газрын төлөөлөгчдийн нэрсийг нэгдсэн хуралдааны тэмдэглэлд оруулахаар тусгажээ.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т хорооны хуралдааны тэмдэглэлд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаалыг бичихээр, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 6-д Зөвлөлийн хуралдаанд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаалыг тэмдэглэлд тусгахаар тус тус заасан байна.

Их Британийн Нийтийн танхимын дэгийн 130 дугаар зүйлд зааснаар түр хорооны (select committee) хуралдаан бүрийн тэмдэглэлд оролцсон гишүүдийн нэрс болон нотлох баримт өгсөн хүмүүсийн нэрийг заавал оруулахаар зохицуулжээ.

(135.2.5.): Ажлын хэсэг болон дэд хорооны хуралдааны тэмдэглэл.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 239 дүгээр зүйлийн (а)-д зааснаар нарийн бичгийн дарга нь хороо болон дэд хорооны үйл ажиллагааг протоколд тэмдэглэж, түүнийг дарга баталгаажуулан гарын үсэг зурахаар заасан.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 68 дугаар зүйлд зааснаар дэд хороо хэлэлцүүлгээ дуусгаад хороондоо тайлагнахдаа дэд хорооны хэлэлцүүлгийн тэмдэглэл эсвэл түүний хураангуйг заавал хавсаргахаар тусгажээ.

Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейн дэгийн 364 дүгээр зүйлийн (а)-д зааснаар Танхимын архивд нэгдсэн хуралдаанаас гадна хороо болон бусад форумуудын албан ёсны тэмдэглэлийг нэгтгэн хадгалахаар заасан.

(135.2.7.): Ирцийн мэдээ болон чөлөөний баримт

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 49-3 дугаар зүйлд зааснаар хорооны хуралдаан дууссаны дараа гишүүдийн ирцийн байдлыг (status of attendance) дараа өдөрт нь багтаан цахим хуудас болон албан ёсны сэтгүүлд нийтлэх ёстой.

Японы Зөвлөхүүдийн танхимын дэгийн 187 дүгээр зүйлд зааснаар гишүүн хуралдаанд оролцох боломжгүй бол шалтгаан болон хугацаа (application in writing for leave of absence)-г урьдчилан мэдэгдэх ба өвчин, хүүхэд төрүүлэх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцоогүй бол түүнийг нотлох бичгийг заавал ирүүлнэ.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 40 дүгээр зүйлд зааснаар гишүүний хүндэтгэн үзэх шалтгаантай болон шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бүх тохиолдлыг Бүртгэлийн тэмдэглэлд заавал бүртгэж хадгалдаг.

Эдгээр зохицуулалт нь парламентын хуралдааны тэмдэглэлийг зөвхөн хэлсэн үгээр хязгаарлахгүй, хэлэлцүүлгийн бүх оролцогчид, гишүүдийн тусгай байр суурь болон тэдний ирц, чөлөөний баримтыг албан ёсны архивын бүрдэл хэсэг болгон хадгалдаг болохыг харуулж байна.

(135.3.3.):

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 болон 14-т зааснаар нэгдсэн хуралдааны тэмдэглэлд санал хураалтад оролцсон гишүүдийн тоо болон илээр, цахимаар эсвэл нэрээр санал хураахад "дэмжсэн", "татгалзсан" гишүүн бүрийн нэрийг заавал тусгахаар хуульчилсан байна. Мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8-д хорооны хуралдааны тэмдэглэлд санал хураасан гишүүдийн тоог оруулахаар тусгажээ.

Эстониин Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-т хорооны хуралдааны тэмдэглэлд санал хураалтын дүнг тусгахаар, мөн зүйлийн 4-т санал хураалтын дүнг гишүүн бүрийн нэрээр (nominally) тэмдэглэлд бүртгэхээр нарийвчлан заасан байна.

Швейцарын Үндэсний зөвлөлийн дэгийн 57 дугаар зүйлийн 3-т санал хураалтын дүнг нэрсийн жагсаалт хэлбэрээр нийтлэхээр, 4-т уг жагсаалтад гишүүн бүр "тийм", "үгүй", "түдгэлзсэн" эсвэл "оролцоогүй" санал өгснийг нэр бүрийн ард тусгахаар заажээ.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэгийн 143 дугаар зүйлийн 2 болон 145 дугаар зүйлийн 5-д зааснаар намын болон хуваагдсан саналын үед дэмжсэн, татгалзсан гишүүдийн нэрсийг Тэмдэглэл (Journals) болон Hansard-д заавал тэмдэглэдэг. Мөн дэгийн 153-т гишүүдийн хувийн санал (personal votes) бүрээр нэрсийг нь Тэмдэглэлд бүртгэхээр заасан байна.

Сингапурын Парламентын дэгийн 30 дүгээр зүйлийн 3-т зааснаар Ерөнхий нарийн бичгийн дарга (Clerk) нь хуралдааны тэмдэглэлд (Votes and Proceedings) гишүүн бүрийн өгсөн санал болон түдгэлзсэн гишүүдийн нэрсийг бүртгэх үүрэгтэй. Мөн дэгийн 63 дугаар зүйлийн 3 болон 7-д ийм бүртгэл хийхийг баталгаажуулсан байна.

Америкийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 11 дүгээр дүрмийн 2(e)(1)(B)(i) заалтад хорооны санал хураалтын дүнг (дэмжсэн, татгалзсан, оролцоогүй гишүүдийн нэрийг агуулсан) 48 цагийн дотор цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй мэдээлэхээр заасан. Мөн дэгийн 13 дүгээр дүрмийн 3(b) заалтад хорооны тайланд санал хураалтын нийт дүн болон гишүүдийн нэрсийг тусгахаар зохицуулсан байна.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 135 дугаар зүйлийн (a)-д зааснаар Ерөнхий нарийн бичгийн дарга (Clerk) санал хураалтын жагсаалтыг Votes and Proceedings-д заавал тэмдэглэнэ.

Эдгээр олон улсын дэгүүд нь парламентын шийдвэр гаргах үйл явц дахь гишүүн бүрийн хариуцлагыг өндөржүүлэх, санал хураалтыг олон нийтэд шилэн, нээлттэй болгох зорилгоор санал хураалтын дүнг нэрээр нь албан ёсны архивд баримтжуулдаг нийтлэг стандарттай болохыг харуулж байна.

(135.3.8): Хуралдаан завсарласан болон түр зогсоосон тухай тэмдэглэх ОУ-ын практикт хуралдааны тэмдэглэлд (Minutes/Votes and Proceedings) хуралдаан эхэлсэн, завсарласан болон дууссан цаг хугацааг нарийвчлан тусгахыг шаарддаг.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д нэгдсэн хуралдааны тэмдэглэлд хуралдаан эхэлсэн, түр зогсоосон (suspension) болон хуралдаан хаасан цагийг заавал тэмдэглэхээр хуульчилсан.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд хуралдаан эхэлсэн болон дууссан цаг, оролцсон хүмүүс болон баталсан шийдвэрүүдийг (завсарлага авах зэрэг процедурын шийдвэрүүд багтана) тусгахаар заажээ.

Сингапурын Парламентын дэгийн 30 дүгээр зүйлийн 1-д зааснаар Ерөнхий нарийн бичгийн дарга (Clerk) нь хуралдааны тэмдэглэлийг (Votes and Proceedings) хөтлөх бөгөөд үүнд хуралдааны явцад гарсан бүх шийдвэр, ирцийн мэдээг баримтжуулж хадгалдаг.

(135.3.9): Төслийг Байнгын хороонд хуваарилсан тухай мэдээлэх.

Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр хороодод хуваарилж, түүнийг албан ёсоор бүртгэх үйл явцтай дараах дэгийн зохицуулалтууд үйлчилж байна.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 2 болон 4-т Зөвлөл хуулийн төслийг хэлэлцэхээр хүлээн авахдаа түүнийг хэлэлцүүлэгт бэлтгэх тэргүүлэх хороог (lead committee) томилох ба уг шийдвэрээ нийт гишүүдэд албан ёсоор мэдээлэхээр заасан байна.

Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 1-д зааснаар Спикер хуулийн төслийг хүлээн авмагц нэгдсэн хуралдаанд тайлагнаж, зохих Байнгын хороонд шилжүүлэх (referral) үүрэгтэй. Мөн хуулийн 76 дугаар зүйлийн 1-д долоо хоног бүр парламентад өргөн мэдүүлсэн төслүүдийн жагсаалтыг дарааллын дагуу бэлтгэж нийтлэхээр заажээ.

Канадын Нийтийн танхимын дэгийн 32 дугаар зүйлийн 5-д зааснаар парламентад өргөн мэдүүлсэн тайлан, баримт бичгүүдийг холбогдох Байнгын хороонд шууд шилжүүлсэнд тооцох ба энэ тухай Journals (Тэмдэглэл)-д заавал тэмдэглэхээр хуульчилсан байдаг.

Австралийн Төлөөлөгчдийн танхимын дэгийн 199 дүгээр зүйлийн (b)-д зааснаар Ерөнхий нарийн бичгийн даргад (Clerk) хүргүүлсэн баримт бичгүүдийг хүлээн авсан өдрөөр нь хуралдааны товч тэмдэглэл (Votes and Proceedings)-д тэмдэглэж, парламентад танилцуулсанд тооцдог байна.

Эдгээр зохицуулалт нь хуралдааны товч тэмдэглэлд (Votes and Proceedings/Journals) хуралдааны цаг хугацааны хэмнэл болон хууль тогтоох үйл ажиллагааны анхны шат болох хороодын хуваарилалтыг албан ёсоор баримтжуулж, гишүүдэд мэдээлэл хүргэх нийтлэг механизмтай болохыг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 2024	Төслийн заалт
<p>136 дугаар зүйл.Хуралдааны тэмдэглэл ашиглах, хадгалах журам</p> <p>136.4.Хуралдааны тэмдэглэлийг Тамгын газрын архивд хадгалах бөгөөд түүнийг ашиглах, хадгалах нарийвчилсан журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.</p>	<p>136 дугаар зүйл.Хуралдааны тэмдэглэл ашиглах, хадгалах журам</p> <p>136.4.Хуралдааны тэмдэглэлийг Тамгын газрын архивд холбогдох журмын дагуу хадгална.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

Канадын Нийтийн танхимын дэгийн 151-д зааснаар Танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга (Clerk) нь Танхимын бүх баримт бичиг, тэмдэглэлийг хадгалах, хамгаалах асуудлыг хариуцах ба энэ нь Спикер эсвэл Танхимаас өгсөн чиглэлийн дагуу хэрэгждэг.

Эстонийн Рийгикогугийн дэгийн тухай хуулийн 158-2 дугаар зүйлийн 1-д зааснаар Рийгикогугийн архивд нэгдсэн хуралдаан, байнгын хороод, фракц, Зөвлөл болон Тамгын газрын баримт бичгүүдийг төвлөрүүлэн хадгалдаг. Мөн архив хадгалах журмыг Рийгикогугийн Зөвлөл баталдаг талаар тус хуулийн 158-2 дугаар зүйлийн 2-т заажээ.

Германы Бундестагийн дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 3-т хуралдааны явцын бусад бүх тэмдэглэл, тухайлбал, дуу хураагуурын бичлэг зэргийг парламентын архивд хадгалахаар тусгайлан зохицуулсан байна.

Энэтхэгийн Лок Сабхагийн дэгийн 383 дугаар зүйлд зааснаар Ерөнхий нарийн бичгийн дарга нь Танхим болон түүний хороод, эсхүл Лок Сабхагийн хэрэг эрхлэх газарт (Secretariat) хамаарах бүх архив, баримт бичиг, тэмдэглэлийг хадгалж, Спикерийн зөвшөөрөлгүйгээр гадагш гаргахыг хориглодог.

Италийн Депутатуудын танхимын дэгийн 34 дүгээр зүйлийн 2-т нэгдсэн хуралдаан болон хороодын хуралдааны тэмдэглэлийг баталж, Спикер болон нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурсны дараа Танхимын архивд хадгалахаар заажээ.

Эдгээр зохицуулалт нь парламентын хуралдааны тэмдэглэлийг зөвхөн хөтлөх бус, түүнийг төрийн албан ёсны архив болгон баталгаажуулах, хадгалах, хамгаалах нэгдсэн тогтолцоотой болохыг харуулж байна.

-----oOo-----

2.14. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Australian House of Representatives. (2025). *Standing and sessional orders*. Department of the House of Representatives.
- Brazilian Chamber of Deputies. (2006). *The Brazilian legislative branch: Chamber of Deputies*. Center for Documentation and Information.
- Canadian House of Commons. (2025). *Standing orders of the House of Commons*. Parliament of Canada.
- Estonian Parliament (Riigikogu). (2016). *Riigikogu rules of procedure and internal rules act*.
- French National Assembly. (2025). *Règlement de l'Assemblée nationale*.
- German Bundestag. (2022). *Rules of procedure of the German Bundestag*. Deutscher Bundestag.
- House of Commons (UK). (2026). *Standing orders: Public business*. UK Parliament.
- House of Representatives (United States). (2025). *Rules of the House of Representatives (119th Congress)*. U.S. Government Publishing Office.
- Italian Chamber of Deputies. (2025). *Rules of procedure of the Chamber of Deputies*.
- Japanese House of Councillors. (n.d.). *Rules of the House of Councillors*. National Diet of Japan.
- Lok Sabha Secretariat (India). (2024). *Rules of procedure and conduct of business in Lok Sabha*. Parliament of India.
- National Assembly of the Republic of Korea. (2020). *National Assembly Act*.
- New Zealand House of Representatives. (2023). *Standing orders of the House of Representatives*. New Zealand Parliament.
- Norwegian Parliament (Storting). (2024). *Rules of procedure of the Storting*.
- Parliament of Singapore. (2017). *Standing orders of Parliament*.
- Swiss Federal Assembly. (2016). *Rules governing parliamentary procedures*.
- The State Duma of the Russian Federation. (1998 [2023]). *Reglament of the State Duma of the Federal Assembly of the Russian Federation*.
- The National Assembly of South Africa. (2016). *The Rules of the National Assembly*.